



МОНГОЛБАНК

Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжил, санхүүжилтийн байдал

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТАЛААРХ ТҮҮВЭР
СУДАЛГАА 2011 ОН

Оршил	i
Монгол улс дахь ЖДҮ-ийн хөгжлийн товч хураангуй	iii
Бүлэг 1. Судалгааны зорилго, аргачлал, түүвэрлэлт	1
Бүлэг 2. Ерөнхий мэдээлэл	3
2.1. Аж ахуйн нэгжийн хэлбэр	4
2.2. Аж ахуйн нэгжийн өмчлөлийн хэлбэр	4
2.3. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны төрөл	5
2.4. Бараа, үйлчилгээг хаана борлуулдаг эсэх	5
2.5. Түүхий эд, материалаа хаанаас авдаг эсэх	6
2.6. Үйл ажиллагаа эрхэлж буй хугацаа	6
2.7. Ажиллагсдын тоо	7
2.8. Борлуулалтын орлого	8
2.9. Зардлын төрөл	8
2.10. Тайлан тэнцэл гаргадаг эсэх	9
Бүлэг 3. ЖДҮ-д үзүүлж буй дэмжлэгүүд	10
3.1. Жижиг дунд үйлдвэрлэлийг хамгийн ихээр дэмждэг байгууллагууд	11
3.2. ЖДҮ эрхлэгчдэд үзүүлж буй дэмжлэгүүд	12
3.3. Бодлого, үйл ажиллагааны хүрээнд цаашид авбал зохих арга хэмжээнүүд	13
Бүлэг 4. ЖДҮ-ийн хөгжилд нөлөөлөгч хүчин зүйлс	15
4.1. Макро эдийн засгийн орчин	16
4.2. Нийгмийн орчин	18
4.3. Бизнесийн орчин	21
4.3.1 Бизнесийн орчны ерөнхий индекс	22
4.3.2 Санхүүжилтийн орчин	23
4.3.3 Хууль, эрх зүйн зохицуулалтын орчин	26
4.3.4 Зах зээлийн орчин	29
4.3.5 Дэд бүтцийн байдал	30
4.4. Зардлын байдал	33
4.5. Дотоод орчин	35
Бүлэг 5. ЖДҮ-ийн санхүүжилтийн байдал	37
5.1. Санхүүгийн анхны эх үүсвэр	38
5.2. Өнгөрсөн хугацаанд санхүүжилтэнд хамрагдсан байдал	39
5.3. ЖДҮ-ийн санхүүжилттэй холбоотой үүсч буй хүндрэл	44
5.4. Санхүүжилт авах хэрэгцээ, зээлийн үндсэн нөхцөл	47
5.5. Дүгнэлт	49

Дүгнэлт	50
Хавсралт Судалгааны үр дүн (нийслэл хот, аймгуудаар)	52
1.1. Улаанбаатар хот	52
1.2. Архангай аймаг	57
1.3. Баянхонгор аймаг	62
1.4. Баян-Өлгий аймаг	67
1.5. Булган аймаг	72
1.6. Говь-Алтай аймаг	77
1.7. Говь-Сүмбэр аймаг	82
1.8. Дархан-Уул аймаг	86
1.9. Дорнод аймаг	90
1.10. Дорноговь аймаг	95
1.11. Дундговь аймаг	100
1.12. Завхан аймаг	105
1.13. Орхон аймаг	110
1.14. Өвөрхангай аймаг	116
1.15. Өмнөговь аймаг	121
1.16. Сүхбаатар аймаг	126
1.17. Сэлэнгэ аймаг	132
1.18. Төв аймаг	134
1.19. Увс аймаг	143
1.20. Ховд аймаг	148
1.21. Хөвсгөл аймаг	153
1.22. Хэнтий аймаг	158

Жижиг, дунд үйлдвэрлэл (ЖДҮ)-ийг эрчимтэй дэмжиж, бодлогоор хөгжүүлэх нь дэлхийн улс орнуудын эдийн засгийн нэн тэргүүний зорилго болсон хэвээр байна. ЖДҮ-ийг хөгжүүлэх нь ядуурал, ажилгүйдлийг бууруулахын зэрэгцээ эдийн засгийн өсөлтөнд чухал үүргийг гүйцэтгэдэг. Түүнчлэн ЖДҮ-ийг хөгжүүлснээр орлогын тэгш бус хуваарилалтыг бууруулах, нийгмийн тогтвортой байдалд дэмжлэг үзүүлэх болон хувийн секторын хөгжлийг хангахад онцгой хувь нэмрийг үзүүлдэг.

Монголбанкны Мөнгөний бодлого, судалгааны газар “МЭК” ХХК-тай хамтран Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй ЖДҮ-ийн өнөөгийн хөгжил, тулгарч буй саад бэрхшээл болон санхүүжилтийн нөхцөл байдлыг тогтоох зорилготой түүвэр судалгааг орон даяар 2011 оны 3 дугаар сараас 4 дүгээр сарын хооронд явууллаа. Энэхүү судалгааны ажлын хүрээнд “Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль”-ийн 5 дугаар зүйлд заасны дагуу ЖДҮ эрхлэгчдийг ангилж, түүвэрчлэн хамрууллаа. Үйл ажиллагаа явуулж байгаа эдийн засгийн салбар, газар зүйн байршил, ажилчдын тоо зэргийг харгалзан үзэж санамсаргүй түүврийн аргаар судалгааны нэгжийг сонгон авлаа.

Энэхүү судалгааны ажлын зорилго нь Улаанбаатар хот болон хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулдаг ЖДҮ эрхлэгчдэд макро эдийн засгийн орчин, нийгмийн орчин, бизнесийн ерөнхий орчин болон зардлын талаас ЖДҮ эрхлэхэд ямар хүчин зүйлс хамгийн их бэрхшээл болж байгааг тогтоох, төрөөс баримталж буй бодлого хэр хүртээмжтэй байгааг тандах, ЖДҮ-ийн санхүүжилтийн байдал, цаашдын хэрэгцээ шаардлагыг тодорхойлоход оршино.

ЖДҮ эрхлэгчдийн дунд явуулсан энэхүү судалгаанд хүн амын тал хувь нь оршин суудаг, ААН-ийн дийлэнх хувь нь үйл ажиллагаа явуулдаг Улаанбаатар хотоос 1000, хүн ам ихээр суурьшсан Сэлэнгэ, Орхон болон Дархан-Уул аймгуудаас тус бүр 100, бусад аймгуудаас тус бүр 50 түүврийг сонгож, нийт улсын хэмжээнд 2,100 ЖДҮ эрхлэгчдийг хамруулах төлөвлөгөөтэй ажиллаа. Судалгаанд Улаанбаатар хот, аймгийн төвүүдээс 2011 оны 3 дугаар сараас 4 дүгээр сарын хугацаанд эдийн засгийн идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй нийт 2,224 ЖДҮ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж хамрагдсан болно. Судалгааны мэдээллийг түүвэрлэлтэнд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдээс санал асуулга бөглүүлэх, ярилцлага авах хэлбэрээр бүрдүүлсэн. Түүвэр судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгч хувиараа хөдөлмөр эрхлэгч болон аж ахуйн нэгжийн удирдлагын түвшнээс (эзэн, гүйцэтгэх захирал, ерөнхий менежер, нягтлан бодогч зэрэг гүйцэтгэх удирдлага) авсан нь судалгааны үр дүн бодитой гарах боломжийг нэмэгдүүлсэн гэж үзэж байна.

Төрөөс ЖДҮ-ийн талаар баримтлах бодлого, үндсэн чиглэлийг тогтоож, тэдгээрийг дэмжих талаар авах арга хэмжээний хүрээнд “Жижиг, дунд үйлдвэрийн тухай” хуулийг 2007 оны 7 дугаар сарын 27-ны өдөр, “Жижиг, дунд үйлдвэрийн тоног төхөөрөмжийг гаалийн болон НӨАТ-аас чөлөөлөх” тухай хуулийг 2009 онд батлан гаргаж, мөрдүүлж байна. Мөн ЖДҮ-ийн үйл ажиллагааг дэмжих зорилго бүхий ХХААХҮЯ-ын харьяа байгууллагууд болон Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санг байгуулан ажиллаж байна.

Гэвч манай оронд ЖДҮ эрхлэхэд макро эдийн засгийн байдал, нийгэм, хууль эрх зүйн хэрэгжилт, дэд бүтэц болон санхүүжилттэй холбоотой зарим асуудлууд хүндрэл учруулсан хэвээр байна. Иймд ЖДҮ эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжүүдэд чухамхүү ямар төрлийн хүндрэл, бэрхшээл хамгийн ихээр тулгарч байгааг улсын

хэмжээнд, нийслэл хот болон аймаг, үйл ажиллагаа эрхэлж буй эдийн засгийн салбаруудаар нь тогтоож, түүнд нөлөөлж буй шалтгаануудыг илрүүлэхийг зорилоо.

“Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль”-ийн 5 дугаар бүлгийн 15.1.4-т жижиг, дунд үйлдвэрийг санхүүгийн талаар дэмжих, тэдгээрийн өөрийн хөрөнгийн хангалттай байдлыг сайжруулах талаар тусгажээ. Уг судалгааны ажлаар ЖДҮ эрхлэгчдийн санхүүгийн өнөөгийн байдал, зээл авахад болон төлөхөд үүсч буй хүндрэл, цаашдын шаардлагатай санхүүжилтийн хүү, хэмжээ болон хугацааг тогтоох зорилт тавин ажиллалаа.

Судалгааны ажил нь үндсэн 5 бүлгээс бүрдэх бөгөөд нэгдүгээр бүлэгт судалгааны ажлын зорилго, аргачлал болон түүвэрлэлтийн талаар дэлгэрэнгүй тусгасан. Хоёрдугаар бүлэг буюу Ерөнхий мэдээлэл бүлэгт түүвэр судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжүүдийг хэлбэр, үйл ажиллагааны төрөл, үйл ажиллагаа эрхэлж буй хугацаа (*насжилт*), ажиллагсдын тоо, жилийн борлуулалтын орлогын хэмжээ болон зардлын зарцуулалтын байдлаар нь ангилж судаллаа. Гуравдугаар бүлэг буюу ЖДҮ-д үзүүлж буй дэмжлэгүүд бүлэгт ЖДҮ-ийг ямар байгууллага, яаж дэмжиж байгаа талаар дурьдсаны зэрэгцээ цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээнүүдийг нэгтгэн дүгнэлээ. Дөрөвдүгээр бүлэг буюу ЖДҮ-ийн хөгжилд нөлөөлөгч хүчин зүйлс бүлэгт ЖДҮ-ийн хөгжилд макро эдийн засгийн орчин, нийгмийн орчин, бизнесийн орчин (санхүүжилт, хууль эрх зүй, зохицуулалт, зах зээл, дэд бүтцийн байдал) зэрэг гадаад хүчин зүйлс, болон зардлын төрөл, менежмент зэрэг дотоод хүчин зүйлсийн нөлөөллийг судалж, хамгийн их саад бэрхшээл болж байгаа хүчин зүйлсийг тодорхойлохыг зорилоо. Тавдугаар бүлэг бүлэг буюу ЖДҮ-ийн санхүүжилтийн байдал бүлэгт ЖДҮ эрхлэгчдийн санхүүгийн анхны эх үүсвэр, зээлд хамрагдсан байдал, санхүүжилттэй холбоотой үүсч буй хүндрэл, бэрхшээл болон цаашид санхүүжилт авах хэрэгцээ, хүсч буй зээлийн үндсэн нөхцлийн талаар авч үзлээ. Судалгааны дүнг нийслэл хот, аймаг тус бүрээр нь гаргаж хавсралтанд тусгав.

- 1994 онд Монгол улсын Засгийн газар Дэлхийн Банктай хамтран “Ядуурлыг бууруулах төсөл”-ийг хэрэгжүүлж эхэлсэн.
- 1996 онд Бичил санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч гол байгууллагуудын нэг Хадгаламж зээлийн хоршоо байгуулагдсан.
- 1997 онд Нэгдсэн Үндэсний байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрөөс (НҮБХХ) Монгол улсын төрийн бус 6 байгууллагаар дамжуулан “Микростарт” төслийг хэрэгжүүлж эхэлсэн.
- 1998 оноос хойш бичил санхүү нь ядуурлыг бууруулах, хөрөнгөтэй болох, орлогоо нэмэгдүүлэх хүчтэй арга хэрэгсэл болон хөгжиж эхэлсэн.
- 1999 онд анхны Банк бус санхүүгийн байгууллага байгуулагдсан.
- 2002 онд анхны “Банк бус санхүүгийн үйл ажиллагаа”-ны тухай хууль батлагдсан.
- 2004 онд Монгол улсад “Бичил зээл ба бизнес” үндэсний чуулган зохион байгуулагдсан.
- 2005 оныг Монгол улсын Засгийн газраас “Бичил санхүүгийн жил” болгон зарласан.
- 2005 онд “ЖДҮ-ийг дэмжих хөтөлбөрийг” Засгийн газраас баталсан.
- 2005-2006 онуудад ЖДҮ-ийг дэмжих зорилгоор тус бүр 1 тэрбум төгрөгийг улсын төсвөөс гаргасан.
- 2006 онд бичил санхүүгийн үйл ажиллагааг хянан зохицуулах зорилгоор Санхүүгийн зохицуулах хороог байгуулсан.
- 2007 онд “Жижиг дунд үйлдвэр”-ийн тухай хууль батлагдсан.
- 2008 онд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болох Жижиг, дунд үйлдвэрийн газар шинээр байгуулагдсан.
- 2009 онд Жижиг, дунд үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмжийг Гааль болон НӨАТ-аас 2012 оныг дуустал чөлөөлөх тухай хуулийг УИХ баталсан.
- 2009 онд “ЖДҮ-ийг дэмжих хөтөлбөр”-ийг Засгийн газар шинэчлэн баталсан.
- 2009 онд “Орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэл”-ийг Засгийн газраас баталсан.
- 2009 онд “Монгол улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөр”-ийг Засгийн газраас баталсан.
- Санхүүжилтийн эх үүсвэрийг хөрөнгийн зах зээлээр дамжуулан бий болгох нөхцөл боломжийг бүрдүүлэх, хөрөнгө оруулалтын сан байгуулахаар Монголын Хөрөнгийн Биржтэй хамтарч ажиллахаар болсон.
- Засгийн газраас ЖДҮ-ийг дэмжих инкубатор төвүүдийг нийслэл хот болон аймгуудад байгуулж эхэлсэн.
- 2009-2010 онуудад ЖДҮ-ийг дэмжих зориулалтаар 60.8 тэрбум төгрөгийг улсын төсвөөс хуваарилж зээлдүүлсэн.
- 2010 онд ЖДҮ-үүдэд зориулж олгох 25 сая ам.долларын зээлд АНУ-ын “Олон улсын хамтын ажиллагааны хөгжлийн зээлийн хөтөлбөр” –өөс баталгаа гаргасан.
- 2010 оны байдлаар нийт ААН-үүдийн 90 орчим хувийг ЖДҮ эзэлж, 300 мянга орчим хүн ажиллаж байна.

- 2010 онд Европын комиссоос манай улсын жижиг дунд үйлдвэрийн салбарын хөгжлийг дэмжих, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхээр 4 сая еврогийн буцалтгүй тусламжийг олгохоор болсон.
- 2010 онд Монгол улсын ЖДҮ-ийг хөгжүүлэх үүднээс Япон улсын Засгийн газраас 75 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 2 үе шаттайгаар хийхээр боллоо.
- 2011 оны 1 дүгээр улирлын эцсийн байдлаар ЖДҮ эрхлэх зориулалтаар арилжааны банкуудаас 48 мянга гаруй зээлдэгчдийг санхүүжүүлж, зээлийн өрийн үлдэгдлийн дүн нь 690 тэрбум (нийт зээлийн өрийн үлдэгдлийн 19%) төгрөг болж 2010 оны эцсээс 65 тэрбум төгрөгөөр буюу 9 хувиар өссөн байна.

1. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, АРГАЧЛАЛ, ТҮҮВЭРЛЭЛТ

Зорилго

Энэхүү судалгааны үндсэн зорилго нь Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй жижиг дунд үйлдвэрлэл (ЖДҮ)-ийн үйл ажиллагааны өнөөгийн байдал, санхүүжилт, тулгарч буй саад бэрхшээлийг тодорхойлж, бодлогын шийдвэр гаргалтанд ашиглах, үнэн зөв мэдээллээр хангахад оршино.

Санал асуулга авах зорилтот бүлэг нь ЖДҮ эрхлэгч аж ахуйн нэгжийн эзэн/гүйцэтгэх удирдлага (захирал, гүйцэтгэх захирал, ерөнхий менежер, нягтлан гэх мэт) ба хувиараа хөдөлмөр эрхлэгч нар байв.

Аргачлал

Судалгааны мэдээллийн санг санал асуулга явуулах замаар цуглуулсан бөгөөд судалгаанд хамрагдсан ЖДҮ-ийн эзэн, гүйцэтгэх удирдлага, холбогдох албан тушаалтнаас¹ ярилцлагын аргаар мэдээлэл авсан болно.

Судалгааны санал асуулгыг бусад орнуудын хийсэн ижил төстэй судалгааны санал асуулгууд дээр үндэслэн боловсруулж, туршилтын судалгааг явуулан сайжрууллаа.

Түүвэрлэлт

Судалгааны түүвэрлэлтийн нэгжийг сонгохдоо ААН-үүдийн байршил, ажиллагсдын тоо болон үйл ажиллагааны чиглэлийг харгалзан үзэж, эх олонлогийг төлөөлөхүйц түүврийг санамсаргүйгээр сонголоо. Оновчтой түүврийн хэмжээг тодорхойлохдоо түүврийн харьцаа ба дунжийн хувьд 95%-ийн итгэх интервалд (хамгийн багадаа 5%-ийн ач холбогдлын түвшинд) статистикийн хувьд найдвартай байх, хамгийн бага хангалттай хэмжээний түүврийг үүсгэхээр сонголоо².

Түүврийн эх олонлогт 2010 оны эцсийн байдлаар Үндэсний Статистикийн Хороо (ҮСХ)-ны Бизнес регистрийн санд³ бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж буй 40,921 аж ахуйн нэгжүүдийг хамрууллаа.

Статистик тооцооллоос оновчтой түүврийн хэмжээг Улаанбаатар хотоос 1000, Дархан-Уул, Сэлэнгэ, Орхон аймгуудаас тус бүр 100, бусад аймгуудаас тус бүр 50 буюу нийт 2200 байхаар төлөвлөв. Санал асуулгын хариулалтын чанараас хамааран зарим газраас илүү эсвэл дутуу тооны санал асуулга авах магадлалтай байсан бөгөөд нийт дүнгээр төлөвлөсөн хэмжээнээс 1.2%-иар илүү буюу 2,227 түүвэр санамсаргүйгээр сонгов.

Санал асуулгад оролцогчдыг аймаг, нийслэлээр авч үзвэл нийт оролцогчдын 46.3%-ийг Улаанбаатар хотын, 53.7%-ийг орон нутгийн ЖДҮ эрхлэгчид эзэлж байгаа бөгөөд хувийн жинг харвал Орхон, Дархан-Уул, Сэлэнгэ аймгуудад 4.1-4.5 хувь, бусад аймгуудад 2.1-2.3 хувийн хооронд жигд тархалттайгаар хамрагдав /Хүснэгт 1/.

Харин идэвхитэй үйл ажиллагаа явуулж буй нийт 40,921 ААН-үүдийн 5.4% нь судалгаанд хамрагдсан бөгөөд Улаанбаатар хотын 3.8%, Орхон, Дархан-Уул, Сэлэнгэ аймгуудад 6.5-9.0%, Говьсүмбэр аймгийн 37.8%, бусад аймгуудад 4.7-11.6% нь хамрагдсан байна.

Хүснэгт 1.1 Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн тоо

Аймаг, нийслэлээр	Үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн тоо		Судалгаанд хамрагдсан ААН-ийн тоо			
	Тоо	Хувийн жин	Төлөвлөсөн	Ажсан	Хувийн жин	Нийт ААН-д эзлэх хувь
Баян-Өлгий	702	1.72%	50	52	2.3%	7.41%
Говь-Алтай	435	1.06%	50	50	2.2%	11.49%
Завхан	586	1.43%	50	50	2.2%	8.53%
Увс	614	1.50%	50	51	2.3%	8.31%
Ховд	1057	2.58%	50	49	2.2%	4.64%
Архангай	545	1.33%	50	51	2.3%	9.36%
Баянхонгор	588	1.44%	50	50	2.2%	8.50%
Булган	498	1.22%	50	51	2.3%	10.24%
Орхон	1291	3.15%	100	101	4.5%	7.82%
Өвөрхангай	694	1.70%	50	50	2.2%	7.20%
Хөвсгөл	559	1.37%	50	50	2.2%	8.94%
Говьсүмбэр	156	0.38%	50	59	2.6%	37.82%
Дархан	1028	2.51%	100	92	4.1%	8.95%
Дорноговь	459	1.12%	50	51	2.3%	11.11%
Дундговь	401	0.98%	50	50	2.2%	12.47%
Өмнөговь	608	1.49%	50	50	2.2%	8.22%
Сэлэнгэ	1561	3.81%	100	101	4.5%	6.47%
Төв	619	1.51%	50	51	2.3%	8.24%
Дорнод	664	1.62%	50	56	2.5%	8.43%
Сүхбаатар	421	1.03%	50	49	2.2%	11.64%
Хэнтий	584	1.43%	50	51	2.3%	8.73%
Улаанбаатар	26851	65.62%	1,000	1,032	46.3%	3.84%
Нийт	40921	100.00%	2,200	2,227	100.0%	5.44%

Эх үүсвэр: ҮСХ, Монголбанк ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Бизнес регистрийн санд бүртгэлтэй ААН-үүдийн 85% нь 1-9 ажиллагсадтай, 12% нь 10-49 ажиллагсадтай, 13% нь 50-иас дээш тооны ажиллагсадтай байна /Хүснэгт 2/.

¹ ААН-ийн үйл ажиллагаа, санхүүжилтийн талаар мэдээлэл өгөх бүрэн боломжтой удирдах албан тушаалтнууд.

² $n = \frac{z^2 s^2 N}{\Delta^2 N + z^2 s^2}$; n-хамгийн бага түүврийн хэмжээ, z- итгэх интервалд харгалзах критик утга (95%-ийн итгэх түвшинд 1.96-тай тэнцүү байна), s- стандарт хазайлт, N- эх олонлогийн хэмжээ Δ- үнэлгээний нарийвчлал.

³ ҮСХ, Статистикийн мэдээ, 2010 он 12 сар.

Хүснэгт 1.2 Бүртгэлтэй ААН-ийн тоо, ажиллагсдын тооны бүлгээр

Ажиллагсдын тооны бүлэг	ААН-ийн тоо	Нийт ААН-д эзлэх хувийн жин
1-9	34,827	85.1%
10-49	4,918	12.0%
50-аас дээш	1,176	2.9%
Нийт	40,921	100.0%

Эх үүсвэр: УСХ

Харин судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийг үйл ажиллагаа явуулж буй ажиллагсдын тооны бүлгээр ангилбал 70% нь 1-9 (Бичил), 26% нь 10-49 (Жижиг), 4% нь 50-199 (Дунд) ажиллагсадтай байна /Хүснэгт 3/.

Хүснэгт 1.3 Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн тоо

ЭЗ-ийн салбар, ажиллагсдын тоогоор

	Бичил (1-9)	Жижиг (10-49)	Дунд (50-199)	Нийт
Худалдаа	26%	6%	1%	32%
Үйлчилгээ	16%	5%	1%	22%
Зочид буудал, нийтийн хоол	8%	4%	0%	13%
Үйлдвэрлэл	15%	6%	1%	21%
Барилга	1%	3%	1%	5%
Тээвэр	1%	1%	0%	2%
ХАА	3%	1%	0%	5%
Нийт	70%	26%	4%	100%

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Үйл ажиллагаа эрхэлж буй чиглэлээр нь харвал 32% нь худалдааны салбарт, 22% нь үйлчилгээ, 21% нь үйлдвэрлэл, үлдсэн 25% нь бусад салбарт үйл ажиллагаагаа явуулж байна.

Харин бизнес регистрийн санд бүртгэлтэй ААН-үүдийн 48.3% нь худалдааны салбарт, 30.8% нь үйлчилгээний салбарт, 7.2% нь үйлдвэрлэлийн салбарт, үлдсэн 13.7% нь бусад салбарт үйл ажиллагаагаа явуулж байна /Хүснэгт 4/. Эндээс үйлдвэрлэлийн салбарт харьцангуй цөөн тооны ААН-үүд үйл ажиллагаа явуулдаг боловч, судалгаанд харьцангуй өндөр хувийн жинтэй оролцсон нь харагдаж байна.

Хүснэгт 1.4 Бүртгэлтэй ААН-ийн тоо

Аймаг, эдийн засгийн салбараар

	Худалдаа	Үйлчилгээ	Үйлдвэрлэл	Барилга	Зочид буудал, нийт хоол	Тээвэр	ХАА	Нийт
Улаанбаатар	78.3%	64.7%	50.8%	61.9%	74.0%	75.5%	22.0%	65.6%
Орхон	3.5%	3.3%	2.6%	6.6%	3.4%	0.9%	1.1%	3.2%
Сэлэнгэ	2.8%	3.2%	2.7%	2.6%	0.3%	2.3%	28.2%	3.8%
Дархан	2.0%	2.5%	2.8%	4.3%	3.5%	3.0%	3.8%	2.5%
Ховд	1.9%	4.3%	2.7%	3.3%	1.9%	2.0%	6.8%	2.6%
Хэнтий	1.2%	0.8%	2.0%	1.1%	0.9%	0.5%	1.3%	1.4%
Дорнод	1.2%	1.6%	2.3%	2.9%	1.6%	0.6%	1.6%	1.6%
Өмнөговь	1.1%	1.2%	2.3%	1.7%	0.6%	1.6%	1.2%	1.5%
Увс	1.0%	1.5%	2.0%	0.8%	1.6%	0.7%	4.0%	1.5%
Баян-Өлгий	0.9%	1.9%	2.7%	1.8%	2.1%	1.6%	3.2%	1.7%
Дорноговь	0.9%	0.6%	1.7%	2.3%	0.6%	0.9%	0.4%	1.1%
Өвөрхангай	0.8%	2.1%	3.0%	1.6%	0.7%	1.4%	2.7%	1.7%
Сүхбаатар	0.8%	0.3%	1.6%	1.8%	0.8%	0.8%	0.7%	1.0%
Дундговь	0.7%	0.9%	1.6%	1.0%	0.3%	1.0%	0.7%	1.0%
Архангай	0.6%	1.5%	2.4%	1.1%	1.0%	1.0%	1.9%	1.3%
Булган	0.5%	1.3%	2.0%	0.7%	0.5%	0.6%	5.4%	1.2%
Баянхонгор	0.4%	1.7%	3.2%	0.8%	1.4%	0.6%	1.0%	1.4%
Хөвсгөл	0.4%	1.9%	2.7%	0.9%	1.2%	1.8%	2.1%	1.4%
Төв	0.4%	1.1%	2.7%	1.1%	1.2%	1.6%	6.9%	1.5%
Говь-Алтай	0.3%	1.0%	2.3%	0.5%	0.9%	0.8%	2.0%	1.1%
Завхан	0.3%	2.5%	3.0%	0.8%	1.3%	0.6%	2.8%	1.4%
Говьсүмбэр	0.2%	0.2%	0.7%	0.5%	0.1%	0.3%	0.3%	0.4%
Нийт	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%

Эх үүсвэр: Үндэсний Статистикийн Хороо, 2010 он

Бизнес регистрийн санд бүртгэлтэй ААН-үүдийн үйл ажиллагааны чиглэлийг аймгуудаар ангилан харвал Улаанбаатар хот ихэнх салбаруудад жигд хөгжиж, тэргүүлж байгаа нь харагдаж байгаа бөгөөд харин ХАА-н салбарын хувьд Сэлэнгэ аймаг илүү олон ХАА-н салбарт ажиллаж байна. Улаанбаатараас гадна, худалдааны салбар Орхон аймагт, үйлчилгээний салбар Ховд аймагт, үйлдвэрлэлийн салбар Баянхонгор, Завхан ба Өвөрхангай аймгуудад түлхүү хөгжсөн гэж хэлж болхоор байна. Харин барилгын салбар Орхон болон Дархан-Уул аймгуудад, зочид буудал, нийтийн хоолны салбар Дархан-Уул аймгуудад, тээврийн салбар Дархан-Уул аймагт, ХАА салбар Сэлэнгэ аймагт түлхүү хөгжсөн байна.

2. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Аж ахуйн нэгжийн хамрагдсан байдал: Санал асуулгад нийт 2227 ЖДҮ эрхлэгчид хамрагдсан бөгөөд үүний 46.3% нь Улаанбаатар хотоос, 53.7% нь орон нутгаас оролцов.

Аж ахуйн нэгжийн өмчлөлийн хэлбэр: Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх хувийг худалдааны салбарт үйл ажиллагаа явуулж буй дотоодын хөрөнгө оруулалттай ХХК-иуд эзэлж байна.

Аж ахуйн нэгжүүдийн төрөл: Судалгаанд оролцогчдын ихэнх нь 1-5 жил үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд 1-9 хүртэлх тооны ажиллагсадтай, жилийн 1-10 хүртэлх сая төгрөгийн борлуулалтын орлоготой байна.

Түүхий эд, материалаа хаанаас авдаг эсэх: ЖДҮ эрхлэгчид ихэвчлэн Улаанбаатар хотоос түүхий эд, материалаа авч, үйл ажиллагаа эрхэлж буй аймагтаа бараа, үйлчилгээгээ борлуулдаг байна.

Зардлын төрөл: ЖДҮ эрхлэгчдийн үйл ажиллагааны нийт зардалд түүхий эдийн зардал хамгийн өндөр хувийг, харилцаа холбооны зардал хамгийн бага хувийг эзэлж байна.

Тайлан тэнцэл гаргадаг эсэх: Санал асуулгад оролцсон ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх хэсэг нь тайлан тэнцэл гаргадаг байна.



БҮЛГИЙН АГУУЛГА:

- ☐ Аж ахуйн нэгжийн хэлбэр
- ☐ Аж ахуйн нэгжийн өмчлөлийн хэлбэр
- ☐ Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны төрөл
- ☐ Бараа, үйлчилгээг хаана борлуулдаг эсэх
- ☐ Түүхий эд, материалаа хаанаас авдаг эсэх
- ☐ Үйл ажиллагаа эрхэлж буй хугацаа
- ☐ Ажиллагсдын тоо
- ☐ Борлуулалтын орлого
- ☐ Зардлын төрөл
- ☐ Тайлан тэнцэл гаргадаг эсэх

2. Ерөнхий мэдээлэл


Энэхүү бүлэгт санал асуулгад хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн талаарх ерөнхий мэдээллийг харуулав.

2.1. Аж ахуйн нэгжийн хэлбэр

Санал асуулгад оролцсон ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх буюу 65%-ийг Хязгаарлагдмал хариуцлагатай компани (ХХК)-иуд, 27% -ийг иргэд эзэлж байна. Хувьцаат компани (ХК), нөхөрлөл, хоршоо болон бусад хэлбэрийн ААН-үүд нийлээд нийт оролцогчдын 8%-ийг эзэлж байна.

Зураг 2.1 ААН-ийн хэлбэр

(ЖДҮ-ийн хариулсан хувиар)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

ААН-ийн хэлбэрийг үйл ажиллагаа явуулж буй эдийн засгийн салбараар ангилж үзвэл ХХК-иуд барилга, зочид буудал, нийтийн хоолны салбараас, иргэд ХАА, тээврийн салбараас хамгийн их оролцсон байна.

Зураг 2.2 ААН-ийн хэлбэр, салбараар

(ЖДҮ-ийн хариулсан хувиар)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Аймгуудаар авч үзвэл Төв, Хөвсгөл аймгуудад ХХК-ууд хамгийн их буюу 80%-аас дээш хувиар хамрагдсан бол Дорнод, Говьсүмбэр аймгуудад хамгийн бага буюу 25%-аас доош хувиар хамрагдсан байна. Говьсүмбэр, Дорнод, Архангай аймгуудад иргэд хамгийн их буюу 50%-иас дээш хувьтай байгаа бол Хөвсгөл, Дундговь аймгуудад хамгийн бага буюу 10%-иас доош байна.

Зураг 2.3 ААН-ийн хэлбэр, аймгуудаар

(ЖДҮ-ийн хариулсан хувиар)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

2.2. Аж ахуйн нэгжийн өмчлөлийн хэлбэр

Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн өмчлөлийн хэлбэрээр нь авч үзвэл дийлэнх хэсэг нь буюу 86% нь дотоодын хөрөнгө оруулалттай ААН-үүд байна. Гадаадын хөрөнгө оруулалттай болон холимог өмчлөлттэй ЖДҮ эрхлэгчид тус бүр 3%-ийг эзэлж байна.

Зураг 2.4 ААН-ийн өмчлөлийн хэлбэр

(ЖДҮ-ийн хариулсан хувиар)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Салбаруудаар авч үзвэл ХАА ба зочид буудал, нийтийн хоолны салбарт дотоодын хөрөнгө оруулалттай ЖДҮ эрхлэгчид хамгийн их хувьтай байгаа бол тээврийн ба барилгын салбарт холимог өмчлөлттэй ААН-үүд хамгийн их, үйлдвэрлэлийн салбарт гадаадын хөрөнгө оруулалттай ААН-үүд харьцангуй илүү хувьтай байна.

Зураг 2.5 ААН-ийн өмчлөлийн хэлбэр, салбараар

(ЖДҮ-ийн хариулсан хувиар)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Улаанбаатар хот болон аймгуудын хувьд гадаадын хөрөнгө оруулалттай ба холимог ААН-үүд тус бүр 6%-иас хэтрэхгүй байгаа бөгөөд гадаадын хөрөнгө

оруулалттай ААН-үүд зөвхөн Улаанбаатар хот ба Төв, Баян-Өлгий, Булган, Дорнод аймгуудаас оролцсон байна. Харин холимог өмчлөлтэй ААН-үүд Булган, Төв, Хэнтий аймгуудад харьцангуй их хувьтай оролцсон байна.

Зураг 2.6 ААН-ийн өмчлөлийн хэлбэр, аймгуудаар



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

2.3. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны төрөл

Санал асуулгад оролцогчдын 31.9% нь худалдааны, 21.8% нь үйлчилгээний, 21.3% нь үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулж байна. Харин хамгийн бага хувь нь тээврийн салбарт үйл ажиллагаа эрхэлж байна. Салбарууд дотроос жижиглэнгийн худалдаа, нийтийн хоол, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг ЖДҮ эрхлэгчид голчлон эрхэлдэг байна.


Зураг 2.7 ААН-ийн үйл ажиллагааны төрөл



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

ЖДҮ эрхлэгчдийн үйл ажиллагааны төрлийн хувийн жинг аймгуудаар ялгаж харвал худалдааны чиглэлээр Булган аймагт, үйлчилгээний чиглэлээр Говь-Алтай аймагт, үйлдвэрлэлийн чиглэлээр Өмнөговь аймагт, зочид буудал, нийтийн хоолны чиглэлээр Төв аймагт, барилга угсралтын чиглэлээр Хөвсгөл аймагт, ХАА-н чиглэлээр Дорнод аймагт, тээврийн чиглэлээр Ховд аймагт бусдаасаа илүү түлхүү хөгжсөн гэж хэлж болхоор байна.

Зураг 2.8 ААН-ийн үйл ажиллагааны төрөл, аймгуудаар



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

2.4. Бараа, үйлчилгээг хаана борлуулдаг эсэх

Санал асуулгад оролцсон ЖДҮ эрхлэгчид ихэвчлэн үйл ажиллагаа эрхэлж буй аймагтаа болон нийслэл хотод бараа, үйлчилгээгээ борлуулдаг байна.


Зураг 2.9 Бараа, үйлчилгээгээ хаана борлуулдаг эсэх



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Үйл ажиллагааны салбаруудаар харвал ХАА болон үйлдвэрлэлийн салбарынхан үйл ажиллагаа эрхэлж буй аймагтаа, зочид буудал зоогийн газрынхан нийслэл хотод бүтээгдэхүүнээ борлуулах хандлагатай байна. Харин тээврийн салбарт гадаадад гэсэн хариултыг бусад салбараас илүү хувиар өгсөн байна.

Зураг 2.10 Бараа, үйлчилгээгээ хаана борлуулдаг эсэх, салбараар




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

УБ хот болон Төв аймгийн ЖДҮ эрхлэгчдийн ихэнх нь нийслэл хотод бараа, үйлчилгээгээ борлуулдаг бол бусад аймгуудын хувьд дийлэнх нь буюу 73.3% - 98.0% нь үйл ажиллагаа эрхэлж буй аймагтаа борлуулдаг байна. Харин гадаадад бараа, үйлчилгээгээ экспортолдог ЖДҮ эрхлэгчид Баян-Өлгий, Ховд, Баянхонгор зэрэг аймгуудад илүү хувьтай байна.

Зураг 2.11 Бараа, үйлчилгээгээ хаана борлуулдаг эсэх, аймгуудаар

(ЖДҮ-ийн хариулсан хувиар, давхардсан тоогоор)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

2.5. Түүхий эд, материалаа хаанаас авдаг эсэх

Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн ихэнх нь буюу гуравны хоёр орчим нь нийслэл хотоос түүхий эд, материалаа авдаг байна.

Зураг 2.12 Түүхий эд, материалаа хаанаас авдаг эсэх

(ЖДҮ-ийн хариулсан хувиар, давхардсан тоогоор)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

ХАА, үйлдвэрлэл ба барилгын салбарын ЖДҮ эрхлэгчид ихэвчлэн нийслэл хотоос түүхий эд, материалаа авдаг бол зочид буудал, нийтийн хоол, тээвэр болон үйлчилгээний салбарынхан үйл ажиллагаа эрхэлж буй аймгаасаа голлон түүхий эд, материалаа авч байна. Худалдааны салбарын хувьд үйл ажиллагаа эрхэлж буй аймаг болон нийслэл хотоос гэсэн хариултууд ойролцоо хувьтай байна.

Зураг 2.13 Түүхий эд, материалаа хаанаас авдаг эсэх, салбараар

(ЖДҮ-ийн хариулсан хувиар, давхардсан тоогоор)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Аймгуудаар авч үзвэл Төв аймгийн ЖДҮ эрхлэгчид нийслэл хотоос, Дорнод аймгийнх үйл ажиллагаа эрхэлж буй аймгаасаа ихэвчлэн түүхий эд, материалаа авдаг байна. Харин гадаадаас импортолдог ЖДҮ эрхлэгчид Хэнтий, Дархан аймгуудад харьцангуй илүү хувьтай байна.

Зураг 2.14 Түүхий эд, материалаа хаанаас авдаг эсэх, аймгуудаар

(ЖДҮ-ийн хариулсан хувиар, давхардсан тоогоор)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

2.6. Үйл ажиллагаа эрхэлж буй хугацаа

ЖДҮ эрхлэгчдийг үйл ажиллагаа явуулж буй хугацаагаар нь авч үзвэл 35% нь 1-5 жил, 30% нь 5-10 жил, 24% нь 10-аас дээш жил, 10% нь 1 жил хүртэл үйл ажиллагаа эрхэлж байна.

Зураг 2.15 ААН-ийн үйл ажиллагаа эрхэлж буй хугацаа


(ЖДҮ-ийн хариулсан хувиар)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн


Үйл ажиллагаагаа эрхэлж буй хугацааны хувьд 1-5, 5-10 ба 10-аас дээш жил ажилласан ЖДҮ эрхлэгчид харьцангуй жигд оролцоотой байна. 10-аас дээш жил үйл ажиллагаа эрхэлж байгаа ЖДҮ эрхлэгч барилгын салбарт хамгийн их байгаа бол 5-10 жил нь худалдааны салбарт, 1-5 жил нь зочид буудал, нийтийн хоолны салбарт, 1 жил хүртэлх үйл ажиллагаа явуулж байгаа ЖДҮ эрхлэгчид тээврийн салбарт тус тус хамгийн их хувьтай байна.

Зураг 2.16 ААН-ийн үйл ажиллагаа эрхэлж буй хугацаа



Судалгаанд оролцсон ААН-үүдийг аймгуудаар харвал Говь-Алтай, Өмнөговь, Говьсүмбэр зэрэг аймгуудад 1-5 жил үйл ажиллагаа эрхэлж буй ЖДҮ эрхлэгчид хамгийн их бол Ховд, Сэлэнгэ, Хэнтий аймгуудад 5-10 жил, Сүхбаатар, Баянхонгор, Булган аймгуудад 10-аас дээш жил, Архангай аймагт 1 жил хүртэл үйл ажиллагаа явуулж байгаа ЖДҮ эрхлэгчид хамгийн их байна.


Зураг 2.17 ААН-ийн үйл ажиллагаа эрхэлж буй хугацаа, аймгуудаар



2.7. Ажиллагсдын тоо


Судалгаанд оролцсон ЖДҮ эрхлэгчдийн 70 орчим хувь нь 1-9 хүртэлх ажиллагсадтай байгаагаас харахад дийлэнх хэсэг нь бичил бизнес эрхэлдэг байна. Дөрөвний нэг хэсэг нь 10-49 хүртэлх ажиллагсадтай буюу жижиг үйлдвэр эрхлэгчид байна. Харин 50-аас дээш тооны ажиллагсадтай ЖДҮ эрхлэгчид харьцангуй цөөн буюу нийт оролцогчдын 5%-ийг эзэлж байна.

Зураг 2.18 ААН-ийн ажиллагсдын тоо




Ажиллагсдын тооны ангиллыг үйл ажиллагаа явуулж буй салбаруудаар харвал худалдааны салбарт 1-9 хүртэлх ажиллагсадтай бичил бизнес эрхлэгчид хамгийн их байгаа бол барилгын салбарын ЖДҮ эрхлэгчдийн ихэнх хувь нь 10-49 хүртэлх ажиллагсадтай байна.

Зураг 2.19 ААН-ийн ажиллагсдын тоо, салбараар



Аймгуудаар авч үзвэл Архангай аймагт хамгийн олон бичил бизнес эрхлэгчид, Хөвсгөл аймагт хамгийн олон жижиг үйлдвэрлэл эрхлэгчид /10-49 ажиллагсадтай/ байна. 100-199 хүртэлх ажиллагсадтай ЖДҮ эрхлэгчид Өмнөговь, Орхон, Дорноговь, Сэлэнгэ аймгуудад тус бүр 1, Улаанбаатар хотоос 10 ЖДҮ эрхлэгчид оролцжээ.

Зураг 2.20 ААН-ийн ажиллагсдын тоо, аймгуудаар




2.8. Борлуулалтын орлого

Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 34% нь жилд 10 хүртэлх сая төгрөгийн борлуулалтын орлоготой бөгөөд 27% нь 10-50 сая төгрөгийн орлоготой байдаг байна. Эндээс харахад судалгаанд оролцсон ЖДҮ эрхлэгчдийн ихэнх нь буюу 60 гаруй хувь нь 50 сая хүртэлх төгрөгний борлуулалтын орлоготой байна.

Зураг 2.21 Жилийн борлуулалтын орлого

(ЖДҮ-ийн хариулсан хувиар)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Салбаруудын хувьд хамгийн өндөр борлуулалтын орлоготой нь барилгын салбарын ЖДҮ эрхлэгчид буюу дийлэнх хувь нь жилд 100-500 сая төгрөгийн борлуулалтын орлоготой байна. Дараа нь тээврийн салбарт 50-аас дээш сая төгрөгийн борлуулалтын орлоготой ЖДҮ эрхлэгчид ихэнх хувийг эзэлж байна. Бусад салбаруудын хувьд ихэнх нь жилд 1-50 хүртэлх сая төгрөгийн борлуулалтын орлоготой байна.

Зураг 2.22 Жилийн борлуулалтын орлого

(ЖДҮ-ийн хариулсан хувиар)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Аймгуудаар ангилж үзвэл Хөвсгөл, Дундговь, Дархан-Уул аймгуудад 500-1.5 тэрбумын борлуулалтын орлоготой гэж бусад аймгуудаас илүү өндөр хувьтай хариулсан байхад Дорнод, Архангай, Өмнөговь аймгуудад хамгийн бага борлуулалтын орлоготой ЖДҮ эрхлэгчид байна.

Зураг 2.23 Жилийн борлуулалтын орлого, аймгуудаар

(ЖДҮ-ийн хариулсан хувиар)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

2.9. Зардлын төрөл

ЖДҮ эрхлэгчдийн үйл ажиллагаанд түүхий эдийн зардал хамгийн өндөр хувийг, харилцаа холбооны зардал хамгийн бага хувийг эзэлж байна.

Зураг 2.24 Үйл ажиллагааны орлогын хэдэн хувийг дараах зардлуудад зарцуулдаг эсэх

(ЖДҮ-ийн хариулсан хувиар)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Үйл ажиллагааны салбаруудаар ангилж үзвэл худалдааны салбарт түүхий эдийн зардал⁴ хамгийн их, цалингийн болон түрээсийн зардал үйлдвэрлэлийн салбарт, зээлийн хүүний зардал үйлдвэрлэлийн салбарт, хуримтлал ХАА салбарт тус тус хамгийн их хувьтай байна.

⁴ Худалдааны салбарын түүхий эдийн зардал эргэлтийн хөрөнгө, бараа, материалыг ойлгоно.

Зураг 2.25 Зардлын төрөл, салбараар

(ЖДҮ-ийн хариулсан хувиар)


	Худалдаа	Үйлчилгээ	Үйлдвэрлэл зооулал, нийтийн хоол	Барилга	Холбоо аж ахуй	Тээвэр
Түүхий эд	42.5	31.4	33.4	38.8	39.3	25.4
Цалин	15.8	24.2	22.0	18.6	23.2	17.6
Бусад	21.8	15.4	9.9	15.8	31.8	35.1
Хуримтлал	16.4	19.3	12.8	11.0	10.6	20.3
Ажлын байрны түрээс	13.1	15.2	13.1	10.7	7.5	7.6
Тоног төхөөрөмж, технолог	8.9	10.9	8.1	10.4	13.2	22.2
Зээлийн хүү	10.8	12.1	12.6	9.3	7.8	13.9
Тээвэр	11.9	10.0	7.1	8.3	10.1	20.8
Татвар	8.9	8.7	8.9	8.8	10.6	10.5
Эрчим хүч	6.1	7.4	6.6	6.4	6.2	9.6
Хураамж, шимтгэл, төлбөр	6.3	6.6	6.2	4.9	6.1	9.8
Дулаан, ус	5.5	6.9	6.2	4.8	3.9	7.3
Харилцаа холбоо	5.5	5.5	4.1	3.8	3.9	4.6

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Зардлуудаас хамгийн өндөр хувийг эзэлж байгаа түүхий эдийн зардлыг аймгуудаар Зураг 1.20-д харуулав. Улсын дундаж дүнгээр ЖДҮ эрхлэгчдийн түүхий эдийн зардал нийт үйл ажиллагааны орлогын 39.4%-тай тэнцэж байгаа бол Төв аймагт хамгийн бага буюу 28.6%, Дорноговь аймагт хамгийн их буюу 49.7%-тай тэнцүү байна.

Зураг 2.26 Түүхий эдийн зардлын үйл ажиллагааны орлогод эзлэх хувь, аймгуудаар

(ЖДҮ-ийн хариулсан хувиар)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

2.10. Тайлан тэнцэл гаргадаг эсэх

Санал асуулгад хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх хэсэг нь буюу 70% нь тайлан тэнцэл гаргадаг байна.

Зураг 2.27 Тайлан тэнцэл гаргадаг эсэх

(ЖДҮ-ийн хариулсан хувиар)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Салбаруудаар харвал барилгын салбарт тайлан тэнцэл гаргадаг ЖДҮ эрхлэгчид хамгийн өндөр хувьтай байгаа бол ХАА-н салбарт хамгийн бага хувьтай байна.

Зураг 2.28 Тайлан тэнцэл гаргадаг эсэх

(ЖДҮ-ийн хариулсан хувиар)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Аймгуудаар авч үзвэл Төв, Хөвсгөл аймгуудад тайлан, тэнцэл гаргадаг ЖДҮ эрхлэгчид хамгийн их, Говьсүмбэр, Булган аймгуудад хамгийн цөөн байна.

Зураг 2.29 Тайлан тэнцэл гаргадаг эсэх, аймгуудаар

(ЖДҮ-ийн хариулсан хувиар)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

3. Дэмжлэгүүд

Энэхүү бүлэгт манай улсад ЖДҮ эрхлэгчдийг ямар төрлийн байгууллагууд дэмжиж байна, тэдгээрээс ямар ямар дэмжлэгүүд үзүүлж байна, мөн цаашид нэн түрүүнд ямар төрлийн арга хэмжээнүүдийг авах шаардлагатай байгаа талаарх санал асуулгын үр дүнг танилцууллаа.

Дэмжиж буй байгууллагууд: Одоогийн байдлаар ЖДҮ эрхлэгчдийг хамгийн ихээр дэмжиж буй байгууллагууд нь арилжааны банкууд байна. Засгийн газар болон орон нутгийн захиргааны дэмжлэг багагүй хувийг эзэлж байна.

Үзүүлж буй дэмжлэгүүд: Дээрх байгууллагуудаас санхүүжилт олгох, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах ажлыг илүү ихээр явуулж байна. Эдийн засгийн салбаруудаар ангилж харвал ХАА, үйлдвэрлэлийн салбарт бусад салбаруудаас илүү дэмжлэг авдаг байна.

Цаашид авах арга хэмжээ: Цаашид нэн түрүүнд төрийн байгууллагын үйлчилгээг чирэгдэлгүй болгох шаардлагатай байна. Үүний дараа санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгох, үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, татварын таатай орчинг бүрдүүлэх, авилгалыг бууруулах шаардлагатай байна гэж үзжээ.



БҮЛГИЙН АГУУЛГА:

- Жижиг дунд үйлдвэрлэлийг хамгийн ихээр дэмждэг байгууллагууд
- ЖДҮ эрхлэгчдэд үзүүлж буй дэмжлэгүүд
- Бодлого, үйл ажиллагааны хүрээнд цаашид авбал зохих арга хэмжээнүүд

3.1. Жижиг дунд үйлдвэрлэлийг хамгийн ихээр дэмждэг байгууллагууд

Санал асуулгын дүнгээр ЖДҮ эрхлэгчдийг арилжааны банкууд, засгийн газар (ЗГ) болон орон нутгийн засаг захиргаа бусад байгууллагуудаас илүү ихээр дэмжиж байгаа нь харагдлаа. /Зураг 3.1/.

Зураг 3.1 ЖДҮ эрхлэгчдийг дэмжиж буй байгууллагууд

(давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Дэлхийн санхүү эдийн засгийн хямралаас хойш арилжааны банкуудын зээлийн өрийн үлдэгдэл тасралтгүй өсч⁵, 2011 оны 1-р улирлын эцсийн байдлаар арилжааны банкуудын нийт зээлийн өрийн үлдэгдэлд ЖДҮ эрхлэх зориулалтаар олгосон зээлийн хэмжээ 19%-ийг⁶ эзэлж байна. Энэ нь ЖДҮ эрхлэгчдийн 45% нь арилжааны банкууд дэмжиж байна гэж хариулсан судалгааны үр дүнтэй нийцтэй байгаа хэдий ч нөгөө талаараа судалгааны үр дүн нь ЖДҮ эрхлэгчид санхүүжилтээ арилжааны банкнаас өөр эх үүсвэрээс олох боломж хомс байдгаас шалтгаалсан байж болох юм.

Харин Засгийн газраас ЖДҮ-ийг хөгжүүлэх талаар мянганы хөгжлийн зорилт, тогтвортой хөгжлийн хөтөлбөр, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал болон эдийн засгийн өсөлтийг дэмжих, ядуурлыг бууруулах стратеги зэрэг бодлогын олон гол баримт бичгүүдэд тусган арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна. Улсын төсөвт 2006-2008 онуудад 3 тэрбум төгрөг, 2009-2010 онуудад ЖДҮ-ийг дэмжихээр 60.8⁷ тэрбум төгрөг баталсан байгаагаас харахад жил ирэх тусам ЖДҮ эрхлэгчдэд үзүүлэх дэмжлэгийг нэмэгдүүлж байна. Үүний үр дүнд судалгаанд оролцогчдоос давхардсан тоогоор 30 гаруй хувь нь ЗГ болон орон нутгийн захиргаа дэмждэг гэсэн хариуг өгсөн болов уу.

Шигтгээ 3.1. Олон улсын туршлага

БНСУ-ын эдийн засаг маш богино хугацаанд хөгжингүй орны түвшинд хүрсэн нь олон улсын судлаач, эдийн засагч нарын анхаарлыг татсан бөгөөд энэхүү эдийн засгийн үрсэнгүй хөгжлийн талаар нэлээд судалгаа хийгджээ. Дэлхийн II дайны дараах үеэс эхэлсэн эдийн засгийн өсөлтөд “Чаэбул” буюу тухайн орны том компаниуд гол үүрэг гүйцэтгэсэн гэж судлаачид үзэж байгаа боловч ЖДҮ-үүд багагүй хувь нэмэр үзүүлжээ.

Өнөөгийн байдлаар БНСУ-ын нийт аж ахуйн нэгжүүдийн 99.9 хувь нь ЖДҮ эрхлэгчид бөгөөд тэдгээрт эдийн засгийн идэвхтэй хүн амын 90 хувь нь хүн ажилладаг. ЖДҮ-үүд ДНБ-ий 50 гаруй хувь, нийт экспортын 35 гаруй хувийг бүрдүүлж байна. ЖДҮ-ийн дийлэнх нь бичил бизнес эрхлэгчид бөгөөд тэдгээр нь ихэвчлэн бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхэлдэг байна.

Өмнөд Солонгосын эдийн засаг нь 1960-аад оноос эхлэн хурдтай өсөж эхэлсэн бөгөөд судлаачид 4 үе шаттайгаар хөгжсөн гэж үздэг.

- Нэгдүгээр үе шат буюу 1960-1970 онуудад том компаниуд өргөжин хөгжиж экспорт хурдтай өсчээ. Энэ хугацаанд ЖДҮ-үүд харьцангуй зогсонги байдалтай байв. Засгийн газар гол анхаарлаа гадаад худалдаанд хандуулж түүнийг дэмжих бодлого хэрэгжүүлсний үр дүнд зарим томоохон компаниуд үйл ажиллагаагаа олон улсын хэмжээнд явуулдаг болов.
- Хоёрдугаар үе шат буюу 1970-1980 онуудад ЖДҮ-үүд сэргэн хөгжиж эхлэв. Засгийн газар хүнд болон химийн үйлдвэрлэлийг дэмжиж гадаадын өрсөлдөгч компаниудаас хамгаалах бодлого хэрэгжүүлснээр энэ чиглэлийн том үйлдвэрүүд хурдтай хөгжжээ. Энэ нь ЖДҮ хөгжих гол үндэс болов. Өөрөөр хэлбэл том үйлдвэрүүдийн үйл ажиллагаа өргөжин илүү олон төрлийн үйлдвэрлэлийн орцуудыг хэрэглэх болсон нь ЖДҮ-үүдэд тэдгээрийг хангах бизнесийн орчинг бий болгов. Ийнхүү ЖДҮ-үүд том компаниудын импортын бараа, бүтээгдэхүүнийг орлуулсан бүтээгдэхүүний нийлүүлэгч болж үйл ажиллагаагаа идэвхжүүлжээ.
- Гурав, дөрөвдүгээр үе шатанд үйлдвэрлэлийн салбарын бүтэц өөрчлөгдөж, технологийн шинэчлэл хийгджээ.

Манай орны хувьд Өмнөд Солонгосын жишгийг даган ЖДҮ-ийг хөгжүүлэх боломжтой. Уул уурхайн салбарт томоохон компаниуд бий болж байгаа өнөө үед Засгийн газар тэдгээрийн үйл ажиллагааг дэмжих бодлого хэрэгжүүлж байна. Монголын уул уурхайн компаниудын дунд нэлээд томд тооцогддог “Оюутолгой” компани ЖДҮ-ийг дэмжих зорилгоор нэг сая ам.доллартай тэнцэх хэмжээний зээлийг Өмнөговь аймагт бизнес эрхлэгч болон ЖДҮ эрхлэгчдэд хөнгөлттэй нөхцлөөр олгон тус компанид бүтээгдэхүүн, үйлчилгээ нийлүүлэх түнш болох боломж нээж өгчээ. Иймэрхүү арга хэмжээнүүд нь ЖДҮ-ийн үйл ажиллагааг идэвхжүүлэн цаашид ЖДҮ хөгжихэд түлхэц болно.


⁵ Монголбанк, Сарын мэдээ, 2011 оны 3 сарын байдлаар 3.7 их наяд төгрөг, жилийн 35%-ийн өсөлттэй байна.

⁶ Монголбанк, ЖДҮ-ийн зээлийн тайлан, 2011 оны 1-р улирал.

⁷ ЖДҮ-ийн газар.

Дэмжлэг үзүүлдэг байгууллагуудыг аймгуудаар ангилж үзвэл /Зураг 3.2/ давхардсан тоогоор Дундговь, Өвөрхангай, Баянхонгор гэсэн аймгуудад бусад аймгуудтай харьцуулахад илүү их дэмжлэг үзүүлдэг гэж хариулсан байхад Улаанбаатар хот, Төв болон Дорноговь аймгуудад эсрэгээрээ байлаа. Банкуудын дэмжлэгийг Увс, Завхан, Өмнөговь гэсэн аймгуудад бусдаасаа харьцангуй ихээр авдаг бол Улаанбаатар хот, Төв болон Дорнод аймгуудад харьцангуй бага байна. Харин ЗГ болон орон нутгийн захиргаанаас үзүүлж буй дэмжлэгүүд Говьсүмбэр, Дорнод, Дундговь аймгуудад бусад аймгуудаас илүү өндөр хувьтай байхад Улаанбаатар хот, Төв болон Дархан-Уул аймгуудад харьцангуй бага байна. Худалдаа, аж үйлдвэрийн тэнхимийн дэмжлэгийг Өвөрхангай, Баянхонгор аймгуудад бусдаасаа харьцангуй өндөр байдаг гэж хариулсан бол олон улсын байгууллагын дэмжлэг Сүхбаатар, Говь-Алтай аймгуудад харьцангуй өндөр байна гэжээ.


Зураг 3.2 ЖДҮ эрхлэгчдийг дэмжиж буй байгууллагууд (аймгуудаар)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Мөн эдийн засгийн гол салбаруудаар ангилж харвал ХАА-н салбарыг бусад салбараас илүү олон тооны байгууллагууд дэмждэг гэж хариулсан байна. Харин арилжааны банкны дэмжлэг салбаруудад харьцангуй жигд тархсан байхад ЗГ, орон нутгийн захиргааны дэмжлэг хөдөө аж ахуй (ХАА) –н салбар, барилгын салбар, үйлдвэрлэлийн салбарт бусад салбараас харьцангуй ихээр төвлөрдөг болох нь харагдаж байна /Зураг 3.3/.

Зураг 3.3 ЖДҮ эрхлэгчдийг дэмжиж буй байгууллагууд (салбарын ангиллаар)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

3.2. ЖДҮ эрхлэгчдэд үзүүлж буй дэмжлэгүүд

Санал асуулгын дүнгээр манай улсад ЖДҮ эрхлэгчдэд голчлон санхүүжилт олгох, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, сургалт, зөвлөгөө явуулах, татварыг хөнгөвчлөх (татвар, НӨАТ-аас чөлөөлсөн) замаар дэмжлэг үзүүлдэг нь харагдаж байна /Зураг 3.4/.

Зураг 3.4 ЖДҮ эрхлэгчдэд үзүүлж буй дэмжлэгүүд



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Банкуудаас 2011 оны 1-р улирлын эцсийн байдлаар ЖДҮ эрхлэх зориулалтаар 48 мянга гаруй зээлдэгчдийг санхүүжүүлж, зээлийн өрийн үлдэгдлийн дүн нь 690 тэрбум төгрөг болж 2010 оны эцсээс 65 тэрбум төгрөгөөр буюу 9 хувиар өссөн байна⁸. 2009-2010 онуудад Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зориулалтаар 60.8 тэрбум төгрөгийг улсын төсвөөс хувиарлаж, арилжааны банкуудаар сарын 0,8% ба 1%-ийн хүүтэй, 3 ба 5 хүртэл жилийн

⁸ Монголбанк, ЖДҮ-ийн зээлийн тайлан, 2011 оны 1-р улирал.


хугацаатай дамжуулан олгосон бөгөөд 2011 оноос зээлийн эргэн төлөлтөөр олгохоор төлөвлөж байна. Суманд үйлдвэрлэл хөгжүүлэх сан байгуулан ажиллахаар 24 тэрбум төгрөг 2011 оны улсын төсөвт тусгагдсан бөгөөд үйл ажиллагааг эхлүүлэх зохион байгуулалтын бэлтгэл ажлууд хийгдэж байна⁹.

Олон улсын байгууллагуудын хувьд Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу бизнес эрхлэгчдийг дэмжих зорилготой олон төрлийн хөнгөлөлттэй зээл, тусламжийг арилжааны банкуудаар дамжуулан ЖДҮ эрхлэгчдэд олгож байна.

ЖДҮ эрхлэгчдэд үзүүлсэн дэмжлэгүүдийг аймгуудаар ангилан харвал /Зураг 3.5/ Орхон, Дундговь, Завхан аймгуудад бусдаасаа их дэмжлэг авсан нь харагдаж байхад Улаанбаатар хот, Хэнтий болон Төв аймгуудад хамгийн бага хувьтай байна. Үүний дотроос санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгосон гэж Өмнөговь, Дундговь, Баянхонгор аймгуудад бусдаасаа өндөр хувьтай хариулсан бол Улаанбаатар хот, Төв болон Булган аймгуудад бага байна. Харин Өвөрхангай, Увс, Завхан аймгуудад үзэсгэлэн худалдаа зохион байгуулах ажил бусдаасаа илүү өндөр байдаг бол мөн л Улаанбаатар хот, Төв болон Булган аймгуудад харьцангуй бага, сургалт зөвлөгөөний хувьд Өвөрхангай, Ховд, Дорноговь аймгуудад бусдаасаа өндөр хувьтай хариулсан байхад Төв, Баян-Өлгий болон Хөвсгөл аймгуудад харьцангуй бага байна. Ховд, Дундговь, Архангай аймгуудад татвараас чөлөөлсөн гэж харьцангуй өндөр хувьтай хариулсан бол Сүхбаатар, Баянхонгор, Увс аймгуудад эсрэгээрээ байна. Орхон аймагт бусад дэмжлэгүүд бусад аймгуудаас нилээд өндөр түвшинд байна.

Зураг 3.5 ЖДҮ эрхлэгчдэд үзүүлж буй дэмжлэгүүд (аймгаар)

(давхардсан тоогоор)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Эдийн засгийн гол салбаруудаар ангилж харвал /Зураг 3.6/ ХАА болон үйлдвэрлэлийн салбарт бусад салбараас харьцангуй их дэмжлэг үзүүлдэг болох нь харагдаж байна. Үүн дотроос санхүүжилт олгох,

үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, сургалт зөвлөгөө өгөх зэрэг дэмжлэгүүд нь ХАА болон үйлдвэрлэлийн салбарт түлхүү явагдаж байгаа бол бусад дэмжлэгүүд нь салбаруудын хувьд төдийлэн ялгаа ажиглагдахгүй байна.

Зураг 3.6 ЖДҮ эрхлэгчдэд үзүүлж буй дэмжлэгүүд (салбараар)

(давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

3.3. Бодлого, үйл ажиллагааны хүрээнд цаашид авбал зохих арга хэмжээнүүд

Судалгааны дүнгээр ЖДҮ эрхлэгчид цаашид нэн түрүүнд төрийн байгууллагын үйлчилгээг чирэгдэлгүй болгож, сайжруулах шаардлагатай байна гэж хариулсан байна. Харин үүний дараа бизнесээ эрхлэх санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгох, үндэсний үйлдвэрлэлийг дэмжсэн бодлогыг явуулах, татварын таатай орчинг бүрдүүлэх, авилгалыг бууруулах шаардлагатай байна гэж үзжээ /Зураг 3.7/.

Зураг 3.7 Цаашид авах арга хэмжээнүүд

(давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

⁹ ЖДҮ-ийн газар.


Дэлхийн банкны засаглалын индексийн 2009 оны дүнгээр¹⁰ Монгол улс Засгийн газрын үр ашгийн¹¹ байдлаараа 23 хувьтай буюу нилээд чанар муутай байгаа нь төрийн байгууллагын үйлчилгээг чирэгдэлгүй болгох ёстой гэсэн санал асуулгын дүнг батлан харуулж байна.

Түүнээс гадна уг индексийн иргэдийн дуу хоолой ба хариуцлагатай байдал¹² гэсэн бүрэлдэхүүн хэсгээр Монгол улс 49 хувьтай буюу дундаж түвшинд байгаа бөгөөд санал асуулгын дүнгээр ЗГ-ийн бизнестэй холбоотой шийдвэрт иргэд, хувийн хэвшлийнхний санал, бодлыг тусгах ёстой гэж судалгаанд оролцогчдын гуравны нэг нь хариулсан байгаатай нийцтэй байна.

Мөн Херитаж сангаас¹³ дэлхий даяар явуулдаг эдийн засгийн эрх чөлөөний индексийн судалгааны 2010 оны дүнгээр Монгол улс авилгал, хээл хахуулийн байдлаар 100-аас 27 оноотойгоор маш доогуур бүлэгт хамрагдаж өмнөх жилийнхээс нэлээд хэдэн байраар ухарсан нь нийгэмд авилгал их хэмжээгээр нэмэгдсэнийг харуулж байгаа бөгөөд судалгаанд оролцогчдын 35% нь авилгалыг бууруулах хэрэгтэй гэж үзжээ.

Зураг 3.8 Цаашид авах арга хэмжээнүүд (аймгаар)

(давхардсан тоогоор)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Нэн түрүүнд авах шаардлагатай арга хэмжээнүүдийг аймгуудаар харьцуулж /Зураг 3.8/ харвал улсын дундаж дүнгээс төдийлэн ялгарахгүй байна. Харин

төрийн байгууллагын үйлчилгээг чирэгдэлгүй болгоё гэж Орхон, Баянхонгор, Хөвсгөл аймгууд бусдаасаа арай өндөр хувьтай хариулсан байна. Санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгох шаардлагатай гэж Увс, Баянхонгор, Өмнөговь аймгуудад, үндэсний үйлдвэрлэлийг дэмжжэ гэж Увс, Баянхонгор, Баян-Өлгий аймгуудад бага зэрэг өндөр хувьтай хариулжээ.

Зураг 3.9 Цаашид авах арга хэмжээнүүд (салбараар)

(давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Дээрх арга хэмжээнүүдийг эдийн засгийн салбаруудаар ангилан харахад төдийлэн ялгаа ажиглагдахгүй байна /Зураг 3.9/.

¹⁰ Дэлхийн засаглалын индикаторууд 2010, Дэлхийн банкны цахим хуудас.

¹¹ Төрийн байгууллагын нийгэмд үзүүлж буй үйлчилгээний чанар, түүний улс төрөөс хараат бус байдал, иргэдийн бодлого боловсруулалтанд итгэх итгэл зэргээс бүрдсэн индекс.

¹² Иргэдийн үг хэлэх эрх чөлөө, хэвлэлийн эрх чөлөө, эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, ЗГ-аа сонгоход оролох эрх чөлөө зэрэг үзүүлэлтүүдээс бүрдсэн индекс.

¹³ АНУ-ын судалгааны байгууллага.

4. ЖДҮ-ийн хөгжилд нөлөөлөгч хүчин зүйлс



Макро эдийн засгийн орчин: Түүвэр судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх нь ЖДҮ эрхлэх эдийн засгийн таатай орчин хангалттай бүрдээгүй гэж үзжээ.

Санал асуулгад оролцогчид инфляцийн түвшин нам дор, тогтвортой бөгөөд ханш тогтвортой байх нь тэдгээрийн бизнесд дэмжлэг үзүүлнэ гэжээ. Эдийн засаг 2010 онд 6.1%-иар өссөн боловч ЖДҮ эрхлэгчид энэхүү өсөлтийн үр шим хангалттай хүртэхгүй байна гэжээ.

Нийгмийн орчин: Судалгааны үр дүнгээр ядуурал болон ажилгүйдлийн түвшин ЖДҮ-ийн хөгжилд нийгмийн зүгээс учруулах хамгийн гол бэрхшээл болж байна.

Бизнесийн орчин: Судалгааны үр дүнгээр ЖДҮ эрхлэгчид ЗГ болон ОУБ-ын хөнгөлөлттэй зээлийн олдоц, төрийн байгууллагын үйлчилгээ, санхүүжилтийн буюу зээлийн хүүний хэмжээ, зам тээврийн хөгжил, хөрөнгийн зах зээлээс хөрөнгө босгох боломж зэрэг нь их хүндрэлтэй байдаг нь судалгааны үр дүнгээр харагдлаа.

Зардлын байдал: Судалгааны үр дүнгээр ЖДҮ эрхлэгч нарт зардлуудаас зээлийн хүү, шимтгэл хураамжийн төлбөр, тоног төхөөрөмжинд зарцуулах зардал болон түрээсийн зардал зэрэг үзүүлэлтүүд хамгийн их хүндрэл үзүүлдэг байна.

Дотоод орчин: Судалгааны үр дүнгээр ЖДҮ эрхлэгчдэд дотоод орчны зүгээс хүний нөөцийн удирдлага, тоног төхөөрөмжийн чанар бусад үзүүлэлттэй харьцуулахад хамгийн их хүндрэл учруулдаг бол түхий эдийн чанар бусад үзүүлэлттэй харьцуулахад харьцангуй бага хүндрэл учруулдаг байна.


БҮЛГИЙН АГУУЛГА:

- ☐ Макро эдийн засгийн орчин
- ☐ Нийгмийн орчин
- ☐ Бизнесийн орчин
- ☐ Зардлын байдал
- ☐ Дотоод орчин

4.1 Макро эдийн засгийн орчин

Судалгаанд хамрагдсан 2,227 ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх буюу 67% нь манай оронд бизнес эрхлэх эдийн засгийн таатай орчин хангалттай бус бүрдсэн гэж үзсэн бол 17% нь огт бүрдээгүй гэж үзжээ. Харин бизнес хийх боломж бүрдсэн гэж санал асуулгад оролцогчдын 9% нь хариулсан нь ЖДҮ эрхлэгчдийн 10 хүрэхгүй хувь нь үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна гэж хэлж болхоор байна /Зураг 4.1/.

Зураг 4.1 Бизнес эрхлэх эдийн засгийн таатай орчин бүрдсэн эсэх



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Түүнчлэн Дэлхийн Банкнаас жил болгон олон улсын хэмжээнд явуулдаг “Бизнес эрхлэх нь”¹⁴ 2010” судалгааны үр дүнгээр Монгол улс дэлхийн 183 орноос бизнес эрхлэх боломжоор 73-т жагсаж өмнөх оныхоос 10 байраар ухарсан нь **бизнес эрхлэх таатай орчин улам муудсаныг** харууллаа. Судалгаанд оролцогчдын дийлэнх хувь нь бизнес эрхлэх таатай нөхцөл манай оронд бүрдээгүй гэж хариулсан нь Дэлхийн Банкны дээрх судалгааны үр дүнтэй нийцтэй гарсан гэж үзэж байна.


Монголд бизнес эрхлэх боломж 2009 оноос 2010 онд 10 байраар ухрахад бизнесийн үйл ажиллагааг эхлүүлэх болон хаахад зарцуулах хугацаа, үйл ажиллагаа явуулах зардал өндөр зэрэг үзүүлэлтүүд голлон нөлөөлсөн бол зээл авах боломж, хөрөнгө бүртгүүлэх, гадаад оронтой худалдаа хийх, барилга барих зөвшөөрөл авах, хөрөнгө оруулагчдыг хамгаалах бодлого сул зэрэг нь бага зэрэг нөлөөлсөн байна.

Дэлхийн санхүү эдийн засгийн хямралаас шалтгаалан манай улсын эдийн засгийн өсөлт 2009 онд бууралттай гарсан ч 2010 оноос уул уурхайн салбарын өндөр өсөлт, төсвийн тэлэх бодлого болон хувийн хэвшлийн идэвхжлээс үүдэн эдийн засаг огцом өсч жилийн эцсээр **6%-ийн өсөлттэй** гарсан. Эдийн засаг хэдий ийнхүү өсч байгаа хэдий ч судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 30 гаруй хувь нь сөргөөр, 20 гаруй хувь нь огт нөлөөлөөгүй гэсэн хариултуудыг өгсөн байгаа нь **иргэдийн бодит амьдралд, тэр дундаа хувийн хэвшлийнхэнд**

¹⁴ Дэлхийн банкнаас 1996 оноос хойш, 183 оронд явуулж буй уг судалгаа нь бизнесийн үйл ажиллагаанд саад бэрхшээл болж байгаа болон дэмжиж буй зүйлүүдийг судлах зорилготой юм.


эдийн засгийн өсөлтийн үр шим хүртэхгүй байгааг харуулж байна /Зураг 4.2/.

Шигтгээ 4.1. Эдийн засгийн өсөлт



Эх үүсвэр: YCX

Сүүлийн 20 жилийн турш манай улсын эдийн засаг дунджаар 3.3 хувиар өсч, ялангуяа 2004-2008 оны хооронд 6.5 хувиар өссөнөөр нэг хүнд ноогдох ДНБ 2.7 дахин нэмэгдэж Дэлхийн банкны бага орлоготой орнуудын жагсаалтаас гарч дундаж орлоготой улсуудын тоонд оржээ. Гэсэн ч дэлхийн санхүү эдийн засгийн хямралын нөлөөгөөр 2009 оны эхний 3 улирлын турш огцом унаж байсан ч сүүлийн улиралд уналт харьцангуй тогтворжиж саарч эхэлсэн. Энэхүү уналт нь Зүүн Азийн орнууд дундаа томоохон уналтанд тооцогдох үзэгдэл юм.¹⁵ Энэхүү хямралаас шалтгаалан манай улсын зарим салбаруудад мэдэгдэхүйц уналтууд гарсан байна. Тухайлбал үйлдвэрлэлээс барилгын салбарт 49 хувь, үйлчилгээнээс худалдааны салбарт 27, санхүүгийн гүйлгээний салбарт 20 хувийн уналтууд бий болжээ.




Эх үүсвэр: YCX

2009 онд үйлдвэрлэл огцом буурч эдийн засаг унаад байсан үетэй харьцуулахад 2010 онд эдийн засаг огцом сэргэж 6 хувиар өслөө. ДНБ-ий тооцооноос харахад барилгын салбар 38 хувиар, худалдааны салбар 23 хувиар, тээврийн салбар 16 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Харин ХАА-н салбар сүүлийн жилүүдэд өсөлттэй байсан хэдий ч 2010 онд өмнөх онтой харьцуулахад ойролцоогоор 17 хувиар буурлаа. Үүнд зуднаас шалтгаалан нийт мал сүргийн 20 гаруй хувь нь хорогдсон, ХАА-н салбарын экспорт огцом буурсан зэрэг хүчин зүйлс нөлөөлсөн байна.

¹⁵ Дэлхий санхүү эдийн засгийн Монголын эдийн засагт үзүүлж буй нөлөө

Зураг 4.2 Эдийн засгийн өсөлт бизнест нь хэрхэн нөлөөлж байгаа эсэх



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Судалгаанд оролцогчдын тал нь буюу 51% нь инфляцийн түвшин тогтвортой бол сайн, 25% буюу дөрөвний нэг нь буурвал бизнест нь сайнаар нөлөөлнө гэсэн хариултуудыг өгсөн байна. Ерөнхийдөө бизнес эрхлэгчдийн хувьд үнийн ерөнхий түвшин тогтвортой, доогуур түвшинд байх нь тэдгээрийн бизнесд дэмжлэг үзүүлнэ гэж үздэг нь харагдлаа¹⁶ /Зураг 4.3/.


Зураг 4.3 Инфляцийн түвшин бизнест нь хэрхэн нөлөөлж байгаа эсэх



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Бизнес эрхлэгчдийн 53% нь ханшийн түвшин тогтвортой бол сайн гэж үзсэн бөгөөд, 20% нь ханш өсвөл буюу чангарвал бизнест нь сайнаар нөлөөлнө гэжээ. Харин дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын үеэр төгрөгийн ханшийн хэлбэлзэл ихэсч бизнес эрхлэгчдэд тодорхой бус байдлыг бий болгож байсан төдийгүй, төгрөгийн ханшийн огцом сулралт нь гадаадаас импортодлог ААН-үүдэд хүндээр туссан байх магадлалтай. Монгол улсад орох хөрөнгийн урсгал сүүлийн жилд улам эрчимжиж байгаагаас шалтгаалан төгрөгийн ам.доллартай харьцах ханш аажмаар чангарсаар 2011 оны 1-р улирлын байдлаар 1250 төгрөгт хүрч хямралын өмнөх үеийн түвшинд хүрсэн нь ханш тогтвортой бөгөөд чангарвал сайн гэсэн хариултуудтай нийцтэй байна.

Зураг 4.4 Төгрөгийн ханшийн хэлбэлзэл бизнест нь хэрхэн нөлөөлж байгаа эсэх




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

¹⁶ Өнгөрсөн 2010 онд нилээд өсч 2 оронтой тоонд хүрээд байсан инфляцийн түвшин 2011 оны эхнээс буурч 4 дүгээр сарын эцсийн байдлаар улсын хэмжээнд 5.5%-д хүрээд байна.


2011 оны 3-р сарын дундаж ханш өмнөх сартай харьцуулахад 2%-иар, 2010 оны 3-р сартай буюу өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13%-иар тус тус чангарсан бөгөөд судалгааны үр дүнгээс харвал ЖДҮ эрхлэгчдийн хувьд ханшийн чангаралт нь сайнаар нөлөөлсөн байх талтай байна.

Шигтгээ 4.2. Инфляци, ханшийн өөрчлөлт



Эх үүсвэр: УХСХ

Инфляци (Улаанбаатар) 2008 онд сүүлийн жилүүдэд байгаагүй өндөр түвшинд хүрч 30 гаруй хувьд хүрээд байсан бол дэлхийн санхүү эдийн засгийн хямралаас шалтгаалан эрэлт буурч, дэлхийн түүхий эдийн үнэ огцом буурснаас 2009 онд буурч хасах түвшинд хүрсэн. Энэхүү Хямралаас хойш инфляци өсч хоёр оронтой тоонд хүрээд байсан бол сүүлийн саруудад буурч нэг оронтой тоонд хадгалагдан, 2010 оны 4 сарын байдлаар 4.2 хувьтай гарсан байна. Энэ жилийн их хэмжээний төсвийн зардлын тэлэлт, өнгөрсөн оны 30 хувийн цалингийн өсөлт зэргээс шалтгаалан эрэлт хүчтэй нэмэгдсэнээс цаашид үнэ өсөх дарамт үргэлжлэх төлөвтэй байсан. Үүний зэрэгцээ Хятад болон дэлхий дахины хүнсний үнийн өсөлт, зээлийн дахин сэргэлт, уул уурхайн салбарын хурдтай хөгжил нь үнийн өсөлтийн дарамтыг улам нэмэгдүүлж байна. ОУВС-гийн судлаачид хэрвээ төсвийн зардал хумигдахгүй бол оны эцэст инфляци 20 хувь байхаар тооцоолж байна. Эрх баригчид инфляци ингэж хурдацтай өсөх нь нийгэм, эдийн засагт ялангуяа ядуучуудад маш хүндээр тусна гэдгийг онцолж байгаа ч Төв банк төсвийн тэлэлтийг тэнцвэржүүлэх мөнгөний бодлогод хязгаарлалт хийхийг анхааруулж байна.



Эх үүсвэр: Монголбанк

2008 оны сүүлээр эдийн засгийн хямралаас шалтгаалан төгрөгийн ханш огцом суларч, 2009 онд ханшийн хэлбэлзэл нэмэгдэж эхэлсэн. Харин 2010 оноос хямралын нөлөө харьцангуй сааран төгрөгийн ханшийн хэлбэлзэл багасч иржээ. Сүүлийн жил Монгол улсад орох хөрөнгийн урсгал улам эрчимжиж байгаагаас шалтгаалан ам.доллартай харьцах төгрөгийн ханш аажмаар чангарсаар хямралын өмнөх үеийн түвшинд дөхсөн байна. 2011 оны 4-р сарын дундаж ханш өмнөх сартай харьцуулахад 1 хувиар, 2010 оны мөн үетэй харьцуулахад 12 хувиар тус тус чангарчээ. Мөн гадаад валютын дотогшлох урсгал эрс нэмэгдсэнээс Монголбанкны гадаад валютын нөөц түүхэндээ байгаагүй өндөр түвшинд хүрээд байна.

4.2 Нийгмийн орчин

2010 оны эцсийн байдлаар Монгол улсын ДНБ-ий жилийн өсөлт 6.1%, нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 3,727.3 ам.доллар болж өмнөх оноос 7.9%- иар өссөн ч ядуурлын түвшин 39.2%, ажилгүйдлын түвшин 9.9%-д хүрсэн байна. Хүний хөгжлийн индекс 0.622 байгаа нь дэлхийн 169 орноос 100-рт жагсаж байгаа бол авилгалын индекс¹⁷ 2.7 байгаа нь 178 орноос 116-рт жагсаж байна.

Нэгдсэн дүн

ЖДҮ-ийн бизнес эрхлэхэд нийгмийн орчны зүгээс саад болж буй хүчин зүйлсийг **хүндрэлгүй** /0/-ээс **маш их хүндрэлтэй** /-4/ гэсэн чанарын 5 асуултаар асууж, нэгдсэн үнэлгээг тоон утга руу шилжүүлэн тооцлоо.

Түүвэр судалгааны үр дүнгээр ЖДҮ эрхлэгчдэд хамгийн их хүндрэл учруулж байгаа нийгмийн орчны үзүүлэлтээр ядуурал, ажилгүйдэл, хээл хахууль, гэмт хэрэг болон улс төрийн тогтворгүй байдал зэрэг үзүүлэлтүүд гарлаа /Зураг 4.5/.

Зураг 4.5 Нийгмийн орчин

/-4 = маш их хүндрэлтэй, -3 = их хүндрэлтэй, -2 = хүндрэлтэй, -1 = бага хүндрэлтэй, 0 = хүндрэлгүй/




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны дүнгээр 2010 оны ядуурлын түвшин (ядуурлын хамралтын хүрээ) 39.2% хүрч, 2007 оноос 9.9%-иар өссөн бөгөөд ядуурлын түвшин ийнхүү нэмэгдэж байгаа нь ЖДҮ-ийн хөгжилд сөргөөр нөлөөлж байна. Түүнчлэн Үндэсний Статистикийн хорооны мэдээгээр хүн амын хэрэглээний тэгш бус байдал өндөр хэвээр байгаа бөгөөд 2010 оны хэрэглээний дундаж хэмжээ нь ядуу хэсгийн 20%-ийнхаас 5.3 дахин өндөр байна.

ЖДҮ эрхлэхэд ажилгүйдэл нийгмийн зүгээс ядуурлын дараа орох гол бэрхшээл гэж дүгнэсэн байна. Үндэсний Статистикийн хорооны “Ажиллах хүчний судалгаа”-ны дүнгээр 2010 онд эдийн засгийн идэвхтэй хүн 1,147.1 мянга байгаагаас 1,033.7 мянга буюу 90.1%-нь ажиллагсад, 113.4 мянга буюу 9.9% нь ажилгүй иргэд байна.

Ядуурал болон ажилгүйдлийн түвшин бизнес эрхлэхэд гол бэрхшээл болж байна гэдэг нь нийгэмд хэрэглэгчдийн худалдан авах чадвар сул байгааг илтгэнэ. Хэрэглэгчдийн худалдан авах чадвар сул байгаагаас шалтгаалж ЖДҮ эрхлэгчдийн борлуулалт хангалттай түвшинд хийгдэхгүй бөгөөд урт хугацаанд эргэлтийн хөрөнгөөр дутагдах, хэрэв зээлтэй бол зээлийн эргэн төлөлтийн дарамтанд орох зэрэг санхүүгийн хүндрэлтэй тулгардаг байх талтай юм. Монгол улсын иргэдийн дундаж худалдан авах чадвар ОУВС-гийн 2010 оны мэдээгээр түүнд бүртгэлтэй 183 орноос 124-т, Дэлхийн банкны 2009 оны мэдээгээр 168 орноос 114-т жагсчээ.

Шигтгээ 4.3. Хүний хөгжлийн индекс ба ядуурлын индекс



Эх үүсвэр: НҮБ-ийн Хөгжлийн Хөтөлбөр, 2010

Хүний хөгжлийн индекс (ХХИ) нь хүний чадавхийн хөгжлийг харуулах бөгөөд эрүүл байх, боловсрол эзэмших, амьжиргааны зохистой нөхцөлд аж төрөх гэсэн 3 үндсэн хэмжигдэхүүнээр илэрхийлэгддэг. НҮБ-ийн Хөгжлийн Хөтөлбөр (UNDP)-ийн хийсэн судалгаагаар¹⁸ 2010 онд Монгол улсын ХХИ 0.622 байгаа нь өмнөх оноос 1%-иар, 2005 оноос 15.4%-иар өссөн байна. Олон улсын түвшинтэй харьцуулбал Монгол улс дундаж түвшний хүний хөгжилтэй орнуудын ангилалд багтах бөгөөд 169 орноос 100-рт жагсаж байна. ХХИ-ийн жилийн өсөлт бусад улсаас харьцангуй хурдацтай өсч, 2010 он гэхэд дэлхийн дундаж түвшинтэй бараг ижил түвшинд хүрсэн байна.

Төрийн болон төрийн бус байгууллагын тогтолцоонд эрх бүхий албан хаагчид хээл хахууль авах замаар лиценз, тусгай зөвшөөрөл болон бусад төрлийн холбогдох зөвшөөрлийг олгодог үзэгдэл нийгэмд тодорхой хэмжээгээр оршин байсаар байна.¹⁹ Нийгмийн уг сөрөг үзэгдлийг ЖДҮ эрхлэхэд саад болж буй гол бэрхшээлүүдийн нэг гэж дүгнэжээ.

Дээрэм тонуул, залилан болон бусад төрлийн гэмт хэрэг нийгэмд тодорхой хэмжээгээр оршин байгаа нь ЖДҮ эрхлэхэд саад учруулж буй бас нэгэн бэрхшээл

¹⁸ Human Development Report 2010

¹⁹ Авлигатай тэмцэх газар 2010 онд ирсэн нийт гомдол, мэдээллээс гэмт хэргийн шинжтэй 483 гомдол, мэдээллийг хуульд заасан үндэслэл журмын дагуу шалгаж шийдвэрлэсэн бөгөөд нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаанд хамаарах 90, салбарын яамдын үйл ажиллагаанд хамаарах 4, улсын бүртгэлийн ажилтанд хамаарах 7 санал гомдол тус тус иргэд, байгууллагаас ирүүлсэн байна.

¹⁷ Transparency international, Corruption perceptions index 2010

гэж үзжээ. Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 2010 онд 19.9 мянга болж, өмнөх оны дүнгээс 2.7%-иар буурсан байна. Нийт гэмт хэргийн тоонд өмчлөх эрх болон малын хулгайн гэмт хэргийн эзлэх хувь 2010 оны эцсийн байдлаар 45.5%-тай байна.

Шигтгээ 4.4. Ядуурлын индекс

Үзүүлэлтүүд	2000-2008 оны дунджаар
Ядуурлын индекс	0.065
Үндэсний ядуурлын шугам	36.1%
Ядуурлын түвшин дэх хүн амаас ажил эрхлэгчдийн тоо	15.8%
Ядууралд өртөх магадлалтай хүн ам	20.7%
1 өдөрт 1.25 ам.доллараас бага орлогтой хүн ам	2.2%
Боловсрол	6.8%
Эрүүл мэнд	19.0%
Амжиргааны доод түвшин	39.6%

Эх үүсвэр: НҮБ-ийн Хөгжлийн Хөтөлбөр, 2010

НҮБ-ийн Хөгжлийн Хөтөлбөр (UNDP) - ийн 2010 онд хийсэн судалгаагаар Монгол улсын хүн амын ядуурлын индекс 2000-2008 оны дунджаар 0.065 байгаа нь 169 улсаас 100-рт жагсаж байна. 2000-2008 оны дунджаар нийт хүн амын 36.1% нь ядуурлын шугамаас доогуур, 20.7% нь ядууралд өртөх магадлалтай хүн амын ангилалд орж байна. Ядуурлын шугамаас доогуур ангилалд байгаа хүн амын 15.8% нь ажил эрхэлдэг хүмүүс байгаа бөгөөд 2.2% нь амжиргааны доод түвшин (1 өдөрт 1.25 ам.доллар)-ээс доогуур түвшинд амьдарч байна.

Улс төрийн тогтворгүй байдлыг ЖДҮ эрхлэгчид бизнес эрхлэхэд их хүндрэл учруулдаг гэж дүгнэжээ. Орон нутагт ЖДҮ-ийн үйл ажиллагаа эрхлэгчидтэй судалгаа авч, ярилцлага хийж байх явцад цөөнгүй тооны бизнес эрхлэгчид 'ЖДҮ-д зориулсан хөнгөлөлттэй зээлийг эрх бүхий албан тушаалтнууд танил тал болон орон нутгын засаг захиргааны нэгжид ажиллагч албан тушаалтнууд намын харьяалал харах замаар зөвшөөрөл, эрх олгодог' гэсэн бэрхшээлийг дурьдаж байсан. Энэ нь улс төрийн тогтворгүй байдал санал асуулгад оролцогчдын дунд их хүндрэлтэй гэж үнэлэгдэх болсон нэг шалтгаан болсон байх талтай.

Түүхий эдийн чанар, ажилчдын ур чадвар, тоног төхөөрөмжийн чанар, хүний нөөцийн удирдлага болон мэдээллийн хүртээмж зэрэг үзүүлэлтийг бага хүндрэлтэй гэж үздэг нь судалгааны үр дүнгээр харагдлаа.


Аймаг, нийслэл

Нийгмийн орчны ерөнхий индексийг аймаг болон нийслэл хотын хэмжээнд авч үзвэл Ховд аймаг, Төв аймаг болон Улаанбаатар хотод ЖДҮ эрхлэгчид нийгмийн орчин бизнесийн үйл ажиллагаа явуулахад их хүндрэл учруулж байна гэж үзжээ. Харин Сүхбаатар, Өмнөговь, Дорнод болон Дорноговь аймагт ЖДҮ эрхлэгчид нийгмийн орчинг бусад аймагтай харьцуулахад харьцангуй бага хүндрэлтэй гэж үр дүн гарлаа /Зураг 4.6/.

Нийгмийн орчинг тодорхойлогч үзүүлэлтүүдийг аймаг, нийслэл хотын хэмжээнд задлан авч үзвэл **ядуурлын түвшин** их хүндрэл учруулж байна гэж Говь-Алтай аймаг, Улаанбаатар хот болон Булган аймагт ЖДҮ эрхлэгчид илүүтэй үзсэн байна. Түүнчлэн ядуурлын түвшин 2010 онд хөдөө орон нутагт 47.8%, сумын төвд 38.8%, аймгийн төвд 36.2% байгаа бол нийслэл хотод хамгийн бага буюу 29.8%-ийн үзүүлэлттэй байна. Хот суурин газруудад ядуурал харьцангуй доогуур түвшинд байна. Түүнчлэн хотын хүн амын дундаж хэрэглээ улсын дунджаас 10.5%-иар, хөдөөгийн хүн амын дундаж хэрэглээнээс 27%-иар дээгүүр байгаа нь хот болон хөдөөд орлогын тэгш бус хуваарилалт өндөр байгааг илтгэж байна /Хүснэгт 4.1/.

Зураг 4.6 Нийгмийн орчин

/-4 = маш их хүндрэлтэй, -3 = их хүндрэлтэй, -2 = хүндрэлтэй, -1 = бага хүндрэлтэй, 0 = хүндрэлгүй/, аймаг, нийслэл, улсын дундаж



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Хэнтий аймаг, Булган аймаг болон Улаанбаатар хотод ЖДҮ эрхлэгчид **ажилгүйдлийн түвшин** үйл ажиллагаа эрхлэхэд нь их хүндрэл учруулж байна гэж үзсэн бол Өмнөговь болон Дорнод аймгийн ЖДҮ эрхлэгчид харьцангуй бага хүндрэлтэй гэж дүгнэжээ. Улаанбаатар хотод 2010 оны байдлаар ажилгүйдлийн түвшин 8.7% байгаа бөгөөд улсын хэмжээнд уг үзүүлэлт 9.9%-тай байна.

Улаанбаатар хотод ЖДҮ эрхлэгчид бусад аймгуудтай харьцуулахад хээл хахууль бизнес эрхлэхэд их хүндрэл үзүүлж байна гэж үзсэн бол аймгуудаас Төв, Ховд болон Орхон аймагт үйл ажиллагаа эрхлэгчид бусад аймагтай харьцуулахад хээл хахууль их хүндрэл учруулдаг гэжээ. Харин Сүхбаатар, Өмнөговь болон Говьсүмбэр аймагт үйл ажиллагаа эрхлэгчид хээл хахууль бага хүндрэл үзүүлдэг гэж үзжээ.

Хүснэгт 4.1 Нийгмийн орчин

/-4 = маш их хүндрэлтэй, -3 = их хүндрэлтэй, -2 = хүндрэлтэй, -1 = бага хүндрэлтэй, 0 = хүндрэлгүй/, аймаг, нийслэл, улсын дундаж

Аймаг/үзүүлэлт	Ядуурал	Ажилгүйдэл	Хээль хахууль	Гэмт хэрэг	Улс төрийн байдал	Харилцагчийн ёс суртахуун	Хувийн хэвшил, иргэдийн оролцоо	Мэдээллийн хүртээмж
Улсын дүн	-2.62	-2.62	-2.50	-2.39	-2.26	-1.82	-1.69	-1.65
Говь-Алтай	-2.78	-2.74	-2.46	-2.20	-1.88	-1.82	-1.24	-1.47
Улаанбаатар	-2.77	-2.75	-2.72	-2.67	-2.46	-2.00	-1.91	-1.37
Булган	-2.76	-2.88	-2.53	-2.49	-2.41	-1.96	-1.63	-1.62
Төв	-2.76	-2.59	-2.67	-2.59	-2.47	-2.04	-2.04	-2.02
Завхан	-2.74	-2.60	-2.32	-2.14	-2.24	-1.86	-1.72	-1.56
Говьсүмбэр	-2.65	-2.49	-1.86	-2.41	-1.96	-1.41	-1.24	-1.31
Хэнтий	-2.65	-2.76	-2.37	-2.31	-2.18	-1.75	-1.55	-1.51
Увс	-2.63	-2.53	-2.39	-2.24	-2.25	-1.51	-1.53	-1.37
Дундговь	-2.60	-2.70	-2.38	-1.86	-2.08	-1.84	-1.18	-1.26
Орхон	-2.58	-2.65	-2.59	-2.31	-2.11	-1.79	-1.51	-1.60
Ховд	-2.55	-2.69	-2.61	-2.59	-2.53	-2.16	-1.94	-1.54
Дархан	-2.54	-2.53	-2.22	-2.21	-2.03	-1.73	-1.59	-1.40
Хөвсгөл	-2.50	-2.56	-2.24	-2.12	-2.04	-1.64	-1.60	-1.54
Баян-Өлгий	-2.48	-2.67	-2.31	-1.73	-2.12	-1.50	-1.23	-1.20
Сэлэнгэ	-2.47	-2.56	-2.56	-2.24	-2.29	-1.89	-1.74	-0.65
Баянхонгор	-2.40	-2.38	-1.88	-2.06	-1.74	-1.62	-1.24	-1.71
Архангай	-2.39	-2.43	-2.14	-2.16	-2.12	-1.61	-1.51	-2.02
Өвөрхангай	-2.28	-2.52	-2.34	-1.96	-2.04	-1.68	-1.58	-1.84
Дорноговь	-2.25	-2.22	-2.12	-1.75	-2.00	-1.35	-1.39	-1.78
Дорнод	-2.15	-1.98	-2.20	-2.04	-1.93	-1.24	-1.17	-2.24
Өмнөговь	-2.02	-1.80	-1.86	-1.82	-1.80	-1.34	-1.26	-1.38
Сүхбаатар	-1.94	-2.06	-1.65	-1.49	-1.41	-0.96	-1.24	-1.57

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн /хөндлөн: үзүүлэлтүүдийг маш муу хүндрэлгүйгээс маш их хүндрэлтэй; босоо: хүндрэлгүйгээс маш их хүндрэлтэй/

Эдийн засгийн салбарын ангилал

Худалдааны салбарт үйл ажиллагаа эрхлэгчид бусад салбартай харьцуулахад ядуурал болон ажилгүйдлийн түвшин бусад салбаруудтай харьцуулахад их хүндрэл учруулдаг гэж үзжээ. Харин үйлчилгээний салбарт үйл ажиллагаа эрхлэгчид бусад салбартай харьцуулахад хүндрэл багатай гэжээ.

Хээл хахууль, гэмт хэрэг болон улс төрийн тогтворгүй байдал үйл ажиллагаа явуулахад бага хүндрэл үзүүлдэг гэж үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа эрхлэгчид дүгнэсэн салбарт үйл ажиллагаа эрхлэгчдтэй хурьцуулахад харьцангуй бага хүндрэл учруулдаг гэж дүгнэсэн байна. /Хүснэгт 4.2/.

Хүснэгт 4.2 Нийгмийн орчин

/-4 = маш их хүндрэлтэй, -3 = их хүндрэлтэй, -2 = хүндрэлтэй, -1 = бага хүндрэлтэй, 0 = хүндрэлгүй/

Үзүүлэлтүүд	Худалдаа	Үйл/лэл	Үйл/гээ	Нийт дүн
Ядуурал	-2.79	-2.47	-2.60	-2.62
Ажилгүйдэл	-2.83	-2.43	-2.59	-2.62
Хээль хахууль	-2.71	-2.32	-2.46	-2.50
Гэмт хэрэг	-2.57	-2.19	-2.40	-2.39
Улс төрийн тогтворгүй байдал	-2.37	-2.14	-2.27	-2.26
Харилцагчийн ёс суртахуун	-1.92	-1.65	-1.89	-1.82
Иргэдийн оролцоо	-1.81	-1.58	-1.69	-1.69
Мэдээллийн хүртээмж	-1.78	-1.50	-1.66	-1.65
Хүний нөөцийн удирдлага	-1.57	-1.22	-1.27	-1.35
Тоног төхөөрөмжийн чанар	-1.41	-1.12	-1.19	-1.24
Ажилчдын ур чадвар	-1.28	-1.19	-1.22	-1.23
Түүхий эдийн чанар	-1.37	-1.00	-1.24	-1.20

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

4.3 Бизнесийн орчин

ЖДҮ эрхлэгчдийн бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлөгч хүчин зүйлсийг дараах үндсэн 4 бүлэгт (орчин) хуваан авч үзлээ:

- Хууль эрх зүй, зохицуулалтын орчин
- Санхүүжилтийн орчин
- Дэд бүтцийн очин
- Зах зээлийн орчин

Дээрх бүлэг нь нийт 27 хүчин зүйлсээс²⁰ бүрдэх бөгөөд бүлэг тус бүр нь өөрсдийн хүчин зүйлсийг агуулсан болно. Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдээс асуулга авах замаар үндсэн мэдээллийг цуглуулан авлаа. Хүчин зүйлсийг бүлгээр нь биш нийтэд үнэлгээний дарааллаар жагсааж харвал ЖДҮ эрхлэгчид хөнгөлөлттэй зээл буюу ЗГ болон ОУБ-аас олгож байгаа зээлийн олдцыг бусад үзүүлэлттэй харьцуулахад хамгийн муу байна гэж онцлон үзсэн байна /Хүснэгт 4.3/.

Тэдгээрийн дараа төрийн байгууллагын үйлчилгээ, санхүүжилтийн буюу зээлийн хүү, зам тээврийн хөгжил болон хөрөнгийн зах зээлээс хөрөнгө босгох боломж гэж үзсэн байна. Харин судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчид мэдээлэл холбооны хөгжлийг хамгийн боломжийн буюу эерэгээр дүгнэжээ. Түүнчлэн цахилгааны хангамж, банкны зээл олголт, технологийн дэвшил болон дулаан усан хангамжийг бусад хүчин зүйлстэй харьцуулахад харьцангуй бага хүндрэлтэй гэж үзсэн үр дүн гарлаа.

Хүснэгт 4.3 ЖДҮ эрхлэгчдийн бизнесийн орчин

/-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, 1= сайн 2=маш сайн/

№	Үзүүлэлтүүд	индекс
1	Олон улсын байгууллагын хөнгөлөлттэй зээлийн олдоц	-1.01
2	Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн олдоц	-0.97
3	Төрийн байгууллагын үйлчилгээ	-0.66
4	Санхүүжилтийн хүү	-0.65
5	Зам, тээврийн хөгжил	-0.58
6	Хөрөнгийн зах зээлээс санхүүжилт авах	-0.58
7	Санхүүжилтийн хугацаа	-0.54
8	Хууль, эрх зүйн орчин	-0.54
9	Татварын тогтолцоо	-0.50
10	Санхүүжилтийн хэмжээ	-0.48
11	Санхүүжилтийн барьцаа хөрөнгө	-0.47
12	Гадаад худалдаа хийх нөхцөл	-0.46
13	Газар эзэмших	-0.44
14	Шудрага өрсөлдөөн	-0.42
15	Хяналт, шалгалтын тогтолцоо	-0.42
16	Өөрийн хөрөнгийн хүрэлцээ	-0.41
17	Хэрэглэгчдийн худалдан авах чадвар	-0.39
18	Бусад банк санхүүгийн байгууллагын зээл	-0.39
19	Даатгалын үйлчилгээ	-0.39
20	Зээлийн батлан даалт	-0.38
21	Зах зээлийн багтаамж	-0.38
22	Зээл олгох үйл ажиллагаа	-0.33
23	Дулаан, усан хангамж	-0.31
24	Технологийн дэвшил	-0.26
25	Банкны зээл олголт	-0.20
26	Цахилгаан хангамж	-0.05
27	Мэдээлэл холбооны хөгжил	0.24

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

²⁰ 27 хүчин зүйлсийг маш муу, муу, боломжийн, сайн, маш сайн гэсэн үнэлгээнүүдээр үнэлүүлж, чанарын хариултыг тоон утга руу /-2оос 2/индексжүүлэн тооцлоо.

Шигтгээ 4.5. ЖДҮ-ийн хөгжлийн хандлага

Олон улсын хэмжээнд ЖДҮ-ийн хөгжлийн түвшинг голчлон ДНБ болон ажил эрхлэлтэнд оруулж буй хувь нэмрээр тодорхойлдог. Дэлхийн банкаас хийсэн судалгаанаас харахад ЖДҮ-ийн хөгжил бага орлоготой орнуудад бага, өндөр орлоготой орнуудад илүү сайн хөгжилтэй байдаг байна.



Эх үүсвэр: WB, 2008

Бага орлоготой орнуудад дунджаар ДНБ-ий 18%-ийг, ажил эрхлэлтийн түвшний 30%-ийг ЖДҮ бүрдүүлдэг бол дундаж орлоготой орнуудад ДНБ-ий 40%-ийг, ажил эрхлэлтийн түвшний 58%-ийг, өндөр орлоготой орнуудад ДНБ-ий 51%-ийг, ажил эрхлэлтийн түвшний 64%-ийг тус тус ЖДҮ бүрдүүлж байна.


Дараах хүснэгтэд зарим орнуудын ЖДҮ-ийн эдийн засагт оруулж буй хувь нэмрийг харуулав.

	Нийт ААН-ийн тоонд эзлэх хувь	ДНБ-ийн хэмжээн д эзлэх хувь	Ажил эрхлэлтийн түвшинд эзлэх хувь	Экспортын орлоготой эзлэх хувь
АНУ	98%		53%	
Япон	99%	52%	72%	13%
Энэтхэг	95%	40%	45%	35%
Тайвань	97%	81%	79%	48%
Сингапур	97%	32%	58%	16%
Өмнөд Солонгос	90%	33%	51%	40%
Малайз	92%	13%	17%	15%
Индонези	99%	36%	45%	11%
Австрали	-	23%	50%	-
Герман	-	43%	70%	-
Польш	-	49%	69%	-
Турк	-	27%	61%	-

Эх үүсвэр: MPRA, 2008

Олон Улсын Санхүүгийн Корпорациас хийсэн судалгаанаас харахад ЖДҮ эрхлэгчдийн бизнес эрхлэх боломж, нөхцөл муудах тусам, ЖДҮ эрхлэгчдийн ажиллагсдын тоо буурч байгааг харуулсан байна.

ЖДҮ эрхлэгчдийн тоо, 1000 хүн тутамд



Эх үүсвэр: IFC, 2008

Судалгааны үр дүнгээр ЖДҮ эрхлэгчид санхүүжилтийн орчны үзүүлэлт болох ЗГ, ОУБ-ын хөнгөлөлттэй зээлийн олдц, зээлийн хүүний

хэмжээг бусад үзүүлэлттэй харьцуулахад муу буюу бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд нь төдийлөн дэмжлэг үзүүлж чаддаггүй гэж үздэг нь харагдлаа. Харин банкны зээлийн олдцыг бага хүндрэлтэй байдаг гэсэн үр дүн гарлаа. Банкны зээлийн олдоц харьцангуй боломжийн байгаа боловч хөнгөлөлттэй зээлийн олдоц маш ховор байгаа нь зээлийн хүү, хугацаа, хэмжээ болон бусад банкны зээлийн нөхцөл ЖДҮ эрхлэхэд хангалттай дэмжлэг үзүүлж чадахгүй байгааг харуулж байна. Санал асуулгын үр дүнгээр зээлийн хүү, хугацаа, хэмжээ болон барьцаа хөрөнгийн үнэлгээ эрмбээрээ дээгүүр гарлаа /Хүснэгт 4.3/.

Эндээс харахад ЖДҮ эрхлэгчдэд банкнаас зээл авах боломж өндөр байдаг хэдий ч зээлийн хүү бизнес эрхлэх үйл ажиллагаанд дэмжлэг учруулж чаддаггүй байна.

Төрийн байгууллагын зүгээс бизнес эрхлэгчдэд үзүүлж буй үйлчилгээний хүнд суртал, захиргааны байгууллагаас гаргаж буй дүрэм журмын давхардал, хянан шалгалт зэрэг нь ЖДҮ эрхлэгчид төрийн байгууллагын үйлчилгээ сайн биш байна гэж дүгнэхэд хүргэсэн байх талтай. Монгол улсын Засгийн газраас “ЖДҮ-ийг дэмжих хөтөлбөр”-ийг 2005 онд Засгийн газрын 64 тоот тогтоолоор батлан хэрэгжүүлж байгаа бөгөөд уг хөтөлбөрийн хүрээнд ЖДҮ-ийн хөгжлийг дэмжих эрх зүйн таатай орчин бүрдүүлэх, Төрийн үйлчилгээг нээлттэй чирэгдэлгүй болгох, татвар санхүүгийн бодлогоор дэмжих, сургалт мэдээллээр хангах зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна. 2008 оны эцсийн байдлаар гарсан үнэлгээний тайланд дурьдсанаар зорилтууд 80%-иас дээш хэрэгжилттэй байна гэж үзжээ.

Монгол улс нь олон улс, улсын чанартай нийт 11,230 км авто зам байгаагаас дөнгөж 20 орчим хувь нь хатуу хучилттай зам байдаг бөгөөд 2010 оны эцсийн байдлаар Сэлэнгэ, Дархан-уул, Орхон, Булган, Хэнтий, Төв, Өвөрхангай, Говьсүмбэр аймгууд хатуу хучилттай замын нэгдсэн сүлжээнд холбогдоод байна. Харин үлдсэн 13 аймаг нь уг сүлжээнд холбогдоогүй байгаа нь судалгааны үр дүнд нөлөөлжээ.


Монголын Хөрөнгийн биржид 2010 оны эцсийн байдлаар 336 компани бүртгэлтэй байгаа бөгөөд энэ нь үйл ажиллагаа эрхэлж буй ААН-ийн дөнгөж 1% байна. Монголын Хөрөнгийн бирж нь хөгжлийн эхэн үедээ явж байгаа бөгөөд бусад орнуудтай харьцуулахад хөрөнгийн зах зээлийн тогтолцоо сул хөгжилтэй байна. Мөн ЖДҮ эрхлэгчдийн санхүүгийн талаарх мэдлэг хомс, судалгааны үр дүнгээр санал асуулгад хамрагдсан ААН-ийн 25% нь тайлан бүртгэлээ гаргадаггүй зэрэг нь хөрөнгийн зах зээлээс санхүүжилт авах боломж муу байдаг гэж үзэхэд нөлөөлсөн байна.

4.3.1. Бизнесийн орчны ерөнхий индекс

Нэгдсэн дүн

Бизнес эрхлэх ерөнхий орчны хүчин зүйлсийг хууль эрх зүйн зохицуулалт, дэд бүтэц, санхүүжилт болон зах зээл гэсэн хэсгүүдэд хувааж, санал асуулгыг явууллаа. Санал асуулгын дүнг нэгтгэж, бизнесийн орчны ерөнхий индексийг тооцоход Санхүүжилтийн орчин (**0.53**), Хууль эрх зүй, зохицуулалтын орчин (**0.50**), Зах зээлийн орчин (**0.37**), Дэд бүтцийн орчин (**0.18**) гэсэн үнэлгээтэй гарлаа. Энэхүү үнэлгээ нь манай орны ЖДҮ эрхлэгчдийн хувьд хөрөнгө санхүүгийн бэрхшээл бизнес эрхлэхэд нь гол хүндрэл болж байгааг илтгэх бол дэд бүтэц харьцангуй боломжийн буюу бусад ерөнхий индексгүй харьцуулахад хамгийн бага хүндрэл учруулж байгааг харуулж байна /Зураг 4.7/.

Зураг 4.7 ЖДҮ эрхлэгчдийн бизнесийн орчин



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Түүнчлэн Дэлхийн Банкнаас гаргадаг “Улсуудын төрх”²¹ илтгэлд тэмдэглэснээр Монгол улсад үйл ажиллагаа эрхэлж буй аливаа бизнесийн хамгийн гол хүндрэл нь хэмжээ болон төрлөөс үл хамаарч **санхүүжилт** байгааг тэмдэглэжээ. Түүнчлэн уг илтгэлд хэмжээгээрээ жижиг буюу бичил бизнес эрхлэгч нарт татварын түвшин, ЖДҮ эрхлэгчдийн бүртгэл, ажилчдын боловсролын түвшин зэрэг нь хүндрэл учруулдаг бол томоохон бизнес эрхлэгч нарт худалдааны зохицуулалт, хээл хахууль зэрэг тулгамдсан асуудал болж байгааг өгүүлжээ.


Аймаг, нийслэл

Бизнесийн орчны ерөнхий индексийг аймгуудаар нь авч үзвэл Говьсүмбэр (**-0.12**) аймгийн ЖДҮ эрхлэгчид бизнесийн үйл ажиллагаа эрхлэх орчинг хамгийн боломжийн гэж үзсэн бол Ховд (**-0.60**), Өмнөговь (**-0.54**) болон Говь-Алтай (**-0.51**) аймгуудын хувьд бусад аймгуудтай харьцуулахад муу байна гэж хариуллаа /Зураг 4.8/.

²¹ World bank “Country Profiles- Mongolia”

Зураг 4.8 ЖДҮ эрхлэгчдийн бизнесийн орчин

/Хувьчилсан тархалтаар/




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Ховд аймгийн хувьд бизнесийн гадаад орчны ерөнхий индексд хамгийн муу үнэлгээ **(-0.60)** өгсөн нь гадаад хүчин зүйлсээс шалтгаалан өөрсдийнхөө нөөц бололцоог бүрэн ашиглаж чадахгүй байгаатай холбоотой байж болох талтай. Ховд аймаг нь цемент шохой, шар шавар, төмс, тарвас зэрэг бүтээгдэхүүнээр зэргэлдээх бүс нутгуудаа хангаад зогсохгүй, улс даяар борлуулах нөөц бололцоотой боловч зам тээврийн хөгжил сул байгаагаас шалтгаалан бүтээгдэхүүнүүдийг худалдаалах зардал ихэсдэг байна.

Харин бизнесийн ерөнхий орчинг харьцангуй бага хүндрэлтэй **(-0.12)** гэж үнэлсэн Говьсүмбэр аймгийн хувьд зам тээврийн хөгжил сайн, нийслэл хотоос холгүй байдаг нь ерөнхий бизнесийн орчинг ийнхүү үнэлэхэд нөлөөлсөн байж болно.

Зураг 4.9 ЖДҮ эрхлэгчдийн бизнесийн орчин

/-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, 1= сайн 2=маш сайн/




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Эдийн засгийн салбарын ангилал

Бизнесийн ерөнхий индексийг үйл ажиллагаа эрхэлж буй эдийн засгийн салбарын ангиллаар авч үзвэл тээвэр **(-0.43)**, худалдааны **(-0.43)** салбарт үйл ажиллагаа эрхлэгчид бизнесийн гадаад орчинд хамгийн муу үнэлгээ өгсөн байна. Харин ХАА, үйлдвэрлэл болон нийтийн хоолны үйл ажиллагаа эрхлэгчид бизнесийн ерөнхий орчныг харьцангуй бага хүндрэлтэй гэжээ /Зураг 4.10/.

Зураг 4.10 ЖДҮ эрхлэгчдийн бизнесийн орчин

/-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, 1= сайн 2=маш сайн/



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

4.3.2. Санхүүжилтийн орчин

Монгол улсын хэмжээнд 2010 оны эцсийн байдлаар 36.0 мянган ААН үйл ажиллагаа явуулж байгаа боловч тэдгээрийн 12.0 орчим мянга буюу 30%-нь татвар тогтмол төлдөг байна. Ажилчдын тоо нь 1-ээс 9 хүртэлх буюу ЖДҮ эрхлэгчид нийт ААН-ын 80 гаруй хувийг бүрдүүлдэг бөгөөд татвар төлөгч ААН-ын тооноос харахад ЖДҮ эрхлэгчид санхүүгийн хүндрэлтэй тулгардаг нь харагдаж байна.

Нэгдсэн дүн

Түүвэр судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчид санхүүжилтийн орчны ерөнхий индексийг **(-0.53)** хамгийн муу гэсэн үнэлгээг өглөө. Өөрөөр хэлбэл санхүүжилт нь ЖДҮ эрхлэхэд хамгийн том хүндрэл болдог бөгөөд энэ нь олон улсын түвшинд хийгдсэн ЖДҮ-ийн талаарх судалгааны үр дүнгүүдтэй нийцтэй гарлаа. ЖДҮ эрхлэгчдийн дунд Улаанбаатар хот болон аймгуудад явуулсан түүвэр судалгааны үр дүнд хамгийн ихээр бэрхшээл болж байгаа үзүүлэлтээр ЗГ, ОУБ-ын хөнгөлөлттэй зээлийн олдоц, ХЗЗ-ийн санхүүжилт, хүүний түвшин, зээлийн хугацаа, зээлийн үндсэн хэмжээ болон барьцаа хөрөнгийн асуудал зэрэг үзүүлэлтүүд гарлаа /Зураг 4.11/.


ОУБ болон ЗГ-ын хөнгөлөлттэй зээлийн олдоц муу буюу хамгийн гол хүндрэл болж байна гэж үзжээ. Сүүлийн жилүүдэд ЗГ-аас ЖДҮ эрхлэгчдэд зориулан багагүй хэмжээний хөнгөлөлттэй зээл, хүүгийн хөнгөлөлт зэргийг үзүүлж байгаа хэдий ч судалгаанд оролцогчдын зүгээс хөнгөлөлттэй зээлд хамрагдах олон шат дамжлага болон орон нутгын удирдах албан тушаалтны танилд талд олгодог зэргээс үүдэн зээлд хамрагдах боломжгүй болдог талаар хэлж байлаа. Мөн Төрөөс тодорхой хэмжээний ЖДҮ-ийн хөгжлийг дэмжих зээлийг олгож байгаа боловч зээлийн эх үүсвэр хангалттай их биш, хамрах хүрээ бага байна.²² Энэ нь хөнгөлөлттэй зээлийн олдоц хамгийн муу гарахад нөлөөллөө. Нөгөө талаас зээл олгогч

²² Энэхүү шалтгааны улмаас судалгаанд хамрагдсан хөдөө орон нутгын ЖДҮ эрхлэгчдийн олонх нь хөнгөлөлттэй зээлд хамрагдаж чадахгүй байгаа бөгөөд хөнгөлөлттэй зээл зөвхөн танил талаар дамжин олгогддог гэсэн тайлбарыг судалгааны багийн гишүүдэд мэдэгдэж байлаа.

Шигтгээ 4.6. ЖДҮ-ийн хөгжилд учирч буй саад бэрхшээлүүд

Дэлхийн банкнаас хийсэн ЖДҮ-ийн хөгжилд тулгарч буй саад бэрхшээлийн талаархи судалгааны дүнгээс харахад өндөр орлоготой орнуудын хувьд хууль эрхзүй, татварын орчин хамгийн их саад бэрхшээл болдог бол дундаж орлоготой орнуудад авилгал, хууль эрхзүйн орчин, бага орлоготой орнуудад **санхүүжилт**, цахилгаан хангамж тус тус хамгийн их бэрхшээл болж байна.


ЖДҮ-ийн хөгжилд учирч буй саад бэрхшээлүүд, улс орнуудын орлогын түвшнээр



Эх үүсвэр: Дэлхийн банк, 2006-2009

Бага орлоготой орнуудын ЖДҮ-д тулгарч буй гол бэрхшээл болох санхүүжилтийг ААН-үүдийн хэмжээгээр ангилж, бусад орнуудтай харьцуулан дараах зурагт харуулав.

Санхүүжилтийн бэрхшээл, улс орнуудын орлогын түвшин ба ААН-үүдийн хэмжээгээр



Эх үүсвэр: Дэлхийн банк, 2006-2009


Тайлбар: Жижиг ААН-д 20-оос бага ажиллагсадтай, дунд хэмжээний ААН-д 20-99 хүртэлх ажиллагсадтай, том хэмжээний ААН-д 100 ба түүнээс дээш ажиллагсадтай ААН-үүдийг оруулав.

Бага орлоготой орнуудад жижиг ААН-үүдийн 43%-д, дунд ААН-үүдийн 38%-д, том ААН-үүдийн 33%-д нь бизнес эрхлэхэд санхүүжилт хамгийн их бэрхшээл болдог байна. Дундаж орлоготой орнуудын хувьд нийт ААН-үүдийн 23-32%-д нь, өндөр орлоготой орнуудад 11-17%-д нь санхүүжилт гол бэрхшээл болж байна.

Эндээс дүгнэхэд, санхүүжилтийн бэрхшээл нь хөгжиж буй орнуудад ихэвчлэн тулгардаг бөгөөд ялангуяа жижиг ААН-үүдэд хамгийн их бэрхшээл болдог байна.

ЖДҮ эрхлэгчдийн санхүүжилтийн гол эх үүсвэр нь арилжааны банкуудын зээл байдаг. ЖДҮ-д зориулж олгосон зээлийг улс орнуудын орлогын түвшнээр ангилан доор харуулав.

ЖДҮ-д зориулж олгосон зээл, улс орнуудын орлогын түвшнээр



Эх үүсвэр: Дэлхийн банк, Санхүүжилтийн үнэлгээ, 2010

Бага болон дундаж орлоготой орнуудад ЖДҮ-д зориулж олгосон зээл нийт зээлийн 15%-ийг, бизнесийн зээлийн 34%-ийг эзэлж байгаа бол өндөр орлоготой орнуудын хувьд нийт зээлийн 19%, бизнесийн зээлийн 62%-ийг ЖДҮ-ийн зээл эзэлж байна.

Эндээс харахад хөгжиж буй орнуудад хөгжингүй орнуудтай харьцуулахад ЖДҮ-ийн санхүүжилтийн эх үүсвэр харьцангуй бага байна.

Санхүүжилтийн бэрхшээлийг улс орнуудаар эрэмбэлж үзвэл бизнес эрхлэхэд санхүүжилт хамгийн их хүндрэлтэй байдаг ААН-үүдийн тоог нийт ААН-ийн тоонд харьцуулсан үзүүлэлтээр Монгол улс 103 орноос 8-рт жагсаж байна.

Санхүүжилтийн бэрхшээлийн үнэлгээ, улс орнуудын ранкаар



Эх үүсвэр: Encyclopedia of the Nations, 2009

байгууллагуудын үзэж байгаагаар ЖДҮ эрхлэгчид нь хөнгөлөлттэй зээлд хамрагдах зээлийн төслөө хангалттай сайн гүйцэтгэдэггүй нь зээл олгохгүй байх гол нөхцөл болдог байна.

ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүнгээр **зээлийн хүүний** индекс (-0.65) буюу бизнес эрхлэхэд нь хүндрэл учруулж байна гэж үзжээ. 2010 оны 4 дүгээр улирлын байдлаар ХААН банкны зээлийн жигнэсэн дундаж хүү жилийн 19.9%, ХХБ-ны жигнэсэн дундаж хүү 18.3%, ХАС банкны жигнэсэн

дундаж хүү 21.8%, Голомт банкны жигнэсэн дундаж хүү 18.5%-тай байна. Харин ЗГ-ын хөнгөлөлттэй зээлийн жилийн хүү дунджаар 12%-тай байгаа бөгөөд уг зээлийн олдоц хангалттай бус байдаг. Ерөнхийдөө ЖДҮ эрхлэгчид хүүний түвшнийг өндөр байгаа нь үйл ажиллагаа эрхлэхэд хүндрэл учруулж байна гэжээ.

Зураг 4.11 Санхүүжилтийн орчин

/-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, 1= сайн, 2=маш сайн/



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Санал асуулгын явцад, ЖДҮ үйлдвэрлэл эрхлэгчдээс гарсан дараах бэрхшээл нь **зээлийн хугацаа богино** байгаа явдал гэж үзжээ. Саяхныг хүртэл бизнесийн зээл 1-ээс 3 хүртэлх жилийн хугацаатай байж байгаад 5 хүртэлх жилийн хугацаатай олгогдож эхэлсэн байна. Арилжааны банкууд урт хугацааны эх үүсвэр татаж чаддаггүй нь зээлийн хугацаа богино байхад голлон нөлөөлдөг байна. Иймд банкууд урт хугацаатай зээл олгох нь тэдгээрийг хөрвөх чадварын эрсдэлд оруулж болзошгүй байгаа учир бизнес эрхлэгчдэд урт хугацааны санхүүжилт олгоход бэрхшээлтэй байна.

ЗГ-ын 1991 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн 13 тоот тогтоолоор улсын өмч хувьчлалын ажлыг эхлүүлэх, цаашид үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх зорилгоор Монголын хөрөнгийн биржийг үүсэн байгуулсан. Манай орны хувьд ХЗЗ-ийн систем хараахан хөгжиж амжаагүй, иргэдийн болон ААН-ийн хувьд үнэт цаас, хөрөнгийн зах зээлийн талаарх мэдлэг хомс байдаг нь санал асуулгын үр дүнд нөлөөлсөн байна.

Санал асуулгад оролцогчид төслөөс болон банкнаас олгогдсон **зээлийн үндсэн хэмжээ** бизнесийн үйл ажиллагааг явуулахад хангалттай хүрэлцээтэй байдаггүй гэж хариулжээ. 2010 оны 4 дүгээр улирлын байдлаар банкууд 45.5 мянган ЖДҮ эрхлэгч иргэдэд нийт 347.5 тэрбум төгрөгийн зээл, 2.5 мянган ЖДҮ эрхлэгч ААН-д нийт 277.6 тэрбум төгрөгийн зээлийг тус тус олгожээ. Эндээс ЖДҮ

эрхлэгч нэг иргэнд дунджаар 7.6 сая төгрөг, ААН-д 111.0 сая төгрөгийн зээлийг олгосон байна.


Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчид зээлийн барьцаа хөрөнгө, өөрийн хөрөнгийн хүрэлцээ, банк бус санхүүгийн байгууллагын зээлийн олдоц, зээлийн батлан даалт, зээл олгох үйл ажиллагаа болон банкны зээлийн олдоц зэрэг үзүүлэлтүүдийг харьцангуй боломжийн гэж дүгнэсэн байна.

Орон нутаг, нийслэл

Санхүүжилтийн орчны ерөнхий индексийг аймаг, нийслэл хотын хэмжээнд авч үзвэл Ховд, Дундговь аймаг болон Улаанбаатар хотоос санал асуулгад хамрагдсан ЖДҮ эрхлэгчид улсын дундажтай харьцуулахад өөрийн аймгийн санхүүжилтийн тогтолцоог муу байна гэсэн үнэлгээг харьцангуй өндөр өглөө. Харин Дархан-Уул, Говьсүмбэр болон Булган зэрэг аймгууд санхүүжилтийн орчинг харьцангуй боломжийн гэж дүгнэжээ /Зураг 4.12/.

Зураг 4.12 Санхүүжилтийн орчны ерөнхий индекс

/-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, 1= сайн, 2=маш сайн/



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Хүснэгт 4.4-өөс харахад Ховд аймагт ЖДҮ эрхлэгчид зээлийн хугацаа, зээлийн хүү зээлийн хэмжээ болон барьцаа хөрөнгийн хүрэлцээ нь санхүүжилтийн гол хүндрэл гэж үзсэн бол Дундговь аймгийн ЖДҮ эрхлэгчдийн хувьд ЗГ-ын хөнгөлөлттэй зээлийн олдоц, зээлийн хүү болон зээлийн хугацаа хангалтгүй байгаа нь бизнес эрхлэхэд гол хүндрэл болж байна гэж тус тус үзжээ.

Хүснэгт 4.4 Санхүүжилтийн орчин

/-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, 1= сайн, 2=маш сайн/ , аймаг болон нийслэл хот

Аймаг/үзүүлэлт	ОУБ-ын хөн/зээл олдоц	ЗГ-ын хөн/зээл олдоц	Зээлийн хүү	ХЗЗ санхүүжилт авах	Зээлийн хугацаа	Зээлийн хэмжээ	Барьцаа хөрөнгө	ӨХ-ийн хүрэлцээ	ББСБ зээл	Зээлийн батлан даалт	Зээл олгох Y/A	Банкны зээл
Улсын дүн	-1.01	-0.97	-0.65	-0.58	-0.54	-0.48	-0.47	-0.41	-0.39	-0.38	-0.33	-0.20
Дорнод	-1.22	-0.74	-0.65	-0.74	-0.52	-0.70	-0.46	-0.59	-0.26	-0.33	-0.24	-0.09
Өмнөговь	-1.18	-1.10	-0.38	-0.58	-0.56	-0.58	-0.68	-0.78	-0.54	-0.64	0.06	0.02
Сэлэнгэ	-1.17	-0.94	-0.72	-0.70	-0.43	-0.38	-0.43	-0.15	-0.39	-0.34	-0.06	0.09
Дорноговь	-1.16	-1.00	-0.55	-0.41	-0.45	-0.33	-0.41	-0.35	-0.33	-0.29	-0.12	0.16
Говь-Алтай	-1.14	-1.08	-0.68	-0.56	-0.56	-0.44	-0.36	-0.36	-0.40	-0.38	-0.12	0.06
Баян-Өлгий	-1.13	-0.83	-0.56	-0.63	-0.48	-0.46	-0.19	-0.23	-0.17	-0.15	-0.04	0.10
Орхон	-1.12	-1.04	-0.78	-0.62	-0.59	-0.40	-0.33	-0.43	-0.21	-0.27	-0.19	-0.02
Увс	-1.08	-1.02	-0.71	-0.49	-0.47	-0.45	-0.20	-0.33	-0.49	-0.27	-0.02	0.08
Сүхбаатар	-1.06	-1.02	-0.59	-0.39	-0.55	-0.29	-0.04	-0.45	-0.24	-0.12	0.00	0.31
Ховд	-1.06	-1.00	-0.94	-0.88	-1.00	-0.94	-0.76	-0.49	-0.80	-0.63	-0.67	-0.47
Хөвсгөл	-1.04	-1.08	-0.72	-0.58	-0.62	-0.56	-0.20	-0.24	-0.28	-0.08	-0.12	0.10
Хэнтий	-1.04	-1.06	-0.53	-0.53	-0.33	-0.37	-0.47	-0.43	-0.39	-0.31	-0.18	0.00
Улаанбаатар	-1.02	-1.01	-0.67	-0.61	-0.57	-0.51	-0.56	-0.43	-0.48	-0.49	-0.53	-0.49
Дундговь	-0.98	-1.10	-0.92	-0.60	-0.80	-0.62	-0.62	-0.50	-0.36	-0.50	-0.52	-0.10
Архангай	-0.94	-0.76	-0.51	-0.71	-0.45	-0.51	-0.41	-0.59	-0.27	-0.24	-0.16	0.18
Өвөрхангай	-0.94	-0.86	-0.68	-0.58	-0.58	-0.52	-0.58	-0.42	-0.40	-0.34	-0.14	0.02
Төв	-0.92	-0.94	-0.55	-0.57	-0.45	-0.35	-0.55	-0.39	-0.39	-0.41	-0.47	-0.25
Баянхонгор	-0.92	-0.96	-0.96	-0.42	-0.78	-0.70	-0.72	-0.48	-0.08	-0.12	-0.06	0.16
Завхан	-0.90	-0.90	-0.56	-0.52	-0.40	-0.44	-0.38	-0.36	-0.20	-0.30	-0.10	0.18
Дархан	-0.76	-0.83	-0.60	-0.35	-0.35	-0.16	-0.25	-0.24	-0.07	-0.08	0.04	0.23
Говьсүмбэр	-0.76	-0.45	-0.35	-0.20	-0.43	-0.45	-0.24	-0.39	-0.14	-0.24	-0.20	0.14
Булган	-0.69	-0.82	-0.33	-0.49	-0.18	-0.24	-0.31	-0.27	-0.27	-0.10	-0.04	-0.02

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн /хөндлөн: үзүүлэлтүүдийг маш муугаас маш сайн руу; босоо: маш муугаас маш сайн руу/

Дорнод, Өмнөговь, Сэлэнгэ, Дундговь болон Хөвсгөл аймгийн ЖДҮ эрхлэгчид хөнгөлөлттэй зээлийн олдоц хангалтгүй байгаа нь бизнесийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж чадахгүй байна гэж бусад аймагтай харьцуулахад илүү хариулжээ. Харин зээлийн хүү өндөр байгаа нь бизнес эрхлэхэд бэрхшээл учруулж байна гэж Баянхонгор, Ховд болон Дундговь аймгийн ЖДҮ үзэж байна.

Эдийн засгийн салбарын ангилал

Салбарын ангиллаар нь авч үзвэл худалдааны салбарт үйл ажиллагаа эрхлэгчид бусад салбартай харьцуулахад ЗГ болон ОУБ-ын хөнгөлөлттэй зээлийн олдоц муу байдаг гэж үзжээ. Энэ нь бага хүүтэй, төслийн хөнгөлөлттэй зээлүүд нь ихэвчлэн үйлдвэрлэл эрхлэгч нарт түлхүү олгогдогтой холбоотой байж болох талтай юм /Хүснэгт 4.5/.

Харин үйлдвэрлэл эрхлэгчдийг бусад салбарт үйл ажиллагаа явуулдаг ЖДҮ эрхлэгч нартай харьцуулахад зээлийн хүү өндөр, хугацаа хангалттай бус, барьцаа хөрөнгийн хүрэлцээ муу болон өөрийн хөрөнгийн хүрэлцээ дутагдалтай байдаг гэж үзсэн байна. Уг салбарт үйл ажиллагаа эрхэлж, тогтвортой үйл ажиллагаа явуулахад цаг хугацаа их зарцуулдаг зэрэг нь дээрх үр дүн гарахад нөлөөлжээ.

Үйлдвэрлэл эрхлэгчдэд бусад салбартай харьцуулахад бага хүүтэй, урт хугацаатай санхүүжилт илүү шаардлагатай байна.

Хүснэгт 4.5 Санхүүжилтийн орчин /ЭЗ-ийн салбарын ангиллаар/

/-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, 1= сайн, 2=маш сайн/

Үзүүлэлтүүд	Худалдаа	Үйл/зэл	Үйл/гээ	Нийт дүн
ОУБ-ын хөн/зээл олдоц	-1.07	-1.01	-0.97	-1.01
ЗГ-ын хөн/зээл олдоц	-1.05	-0.93	-0.94	-0.97
Зээлийн хүү	-0.63	-0.72	-0.62	-0.65
ХЗЗ санхүүжилт авах	-0.58	-0.61	-0.55	-0.58
Зээлийн хугацаа	-0.49	-0.58	-0.55	-0.54
Зээлийн хэмжээ	-0.43	-0.52	-0.49	-0.48
Барьцаа хөрөнгө	-0.45	-0.51	-0.47	-0.47
ӨХ-ийн хүрэлцээ	-0.36	-0.44	-0.42	-0.41
ББСБ зээл	-0.40	-0.36	-0.40	-0.39
Зээлийн батлан даалт	-0.33	-0.40	-0.40	-0.38
Зээл олгох Y/A	-0.29	-0.30	-0.38	-0.33
Банкны зээл	-0.19	-0.12	-0.29	-0.20

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

4.3.3. Хууль, эрх зүйн зохицуулалтын орчин

Олон жилийн туршид ЖДҮ-ийн хөгжлийг нэгдсэн цогц бодлогоор дэмжих, түүнийг хэрэгжүүлэх арга механизмыг тодорхойлсон эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлага зүй ёсоор тавигдаж ирсний үр дүнд 2007 онд “Жижиг дунд үйлдвэрийн тухай хууль”-ийг УИХ-аар баталсан. “ЖДҮ-ийн тухай хууль”-аар ЖДҮ-ийн тодорхойлолт, ЖДҮ-ийг дэмжих талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхой болгож өгснөөр ЖДҮ эрхлэгчдийн статус тодорхой болж, үндэсний үйлдвэрлэлийн өсөлт, хөгжилд ЖДҮ-ийн үзүүлэх хувь нэмэр, ач холбогдол,

хөгжлийн цаашдын стратеги, чиг хандлагыг тодорхойлох боломжийг бүрдүүлсэн. Мөн ЖДҮ-ийг хөгжүүлэх эрх зүйн таатай орчныг бүрдүүлэхэд Засгийн газраас анхааран ажилласны үр дүнд үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг санхүүгийн түрээс буюу “Лизинг”-ээр авах боломжийг бий болгож “Санхүүгийн түрээс /Лизинг/-ийн тухай хууль”-ийг батлуулж хэрэгжүүлж эхлээд байна. Дээрх хууль батлагдан гарснаар барьцаа хөрөнгийн боломж тааруу бизнес эрхлэгчдэд худалдан авч байгаа тоног төхөөрөмжөө барьцаалан зээл авч үйл ажиллагаагаа хэвийн явуулах боломж бүрдсэн байна. “Засгийн газрын тусгай сангийн тухай хууль”-д /2006 онд/ ЖДҮ-ийг дэмжих санг оруулан хуульчилж өгснөөр ЖДҮ шинээр бий болох, өргөжин хөгжих таатай нөхцлийг бүрдүүлсэн.

Нэгдсэн дүн

Түүвэр судалгааны үр дүнгээр хууль эрх зүй, зохицуулалтын орчны ерөнхий индексийг муу **(-0.50)** гэж дүгнэжээ. Хууль эрх зүй, зохицуулалтын орчныг дотор нь задлан авч үзвэл Төрийн байгууллагын үйлчилгээг бусад үзүүлэлттэй харьцуулахад хамгийн муу буюу хүндрэл учруулж буй гол үзүүлэлт гэж дүгнэжээ. Хууль эрх зүйн орчин, татварын тогтолцоо зэрэг үзүүлэлтүүд нь ЖДҮ эрхлэгчдийн хувьд дараах гол бэрхшээл нь болж байна. /Зураг 4.13/.

Зураг 4.13 Хууль эрх зүйн зохицуулалтын орчин

/-2=маш муу, -1= муу, 0=боломжгүйн, 1= сайн 2=маш сайн/



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Төрийн байгууллагын үйл ажиллагаа нь тууштай, ил тод байж чадахгүй байгаа бөгөөд шалгалтанд хамруулах ААН-ийг сонгохдоо тэдний үйл ажиллагааны эрсдэлийг үнэлэх, хяналтын хуудас ашиглах, бизнес эрхлэгчдэд дагаж мөрдөх дүрэм, журмыг сурталчлан таниулах зэрэг олон улсын дэвшилтэт туршлагуудыг нэвтрүүлээгүй, түүнчлэн байцаагчид нь шалгалт хийхдээ субъектив талаас нь нөхцөл байдлыг үнэлж, дүгнэдэг нь нэг талаас ЖДҮ эрхлэгчид төрийн байгууллагын үйлчилгээ хамгийн их бэрхшээл учуурлж байна гэж дүгнэхэд хүргэжээ. Түүнчлэн Германы техник хамтын ажиллагааны нийгэмлэг /ГТХАН/-ийн “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих” төслийн хүрээнд хийгдсэн судалгаагаар Төрийн байгууллагаас бизнес эрхлэгчдэд үзүүлж буй үйлчилгээний хүнд суртал болон Төрийн захиргааны байгууллагаас гаргаж буй дүрэм, журамтай ижил төстэй дүрэм журмыг Орон нутгаас давхардуулан гаргаж хяналт шалгалтын давхардал үүсгэж байгаа

нь ЖДҮ эрхлэгчдэд хүндрэл үүсгэж байна гэж үзсэн байна.

2007 онд “Жижиг дунд үйлдвэрийн тухай хууль”-ийг, 2009 онд “Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль”-ийг УИХ-аар батлуулж, мөрдөн ажиллаж байгаа боловч ЖДҮ эрхлэгч иргэн буюу хувиараа хөдөлмөр эрхэлж буй иргэн, өрх айлын талаарх төрийн бодлого тодорхой бус хэвээр байна. Энэ нь хууль эрх зүйн орчин хоёрдугаар муу үзүүлэлт болох үндсэн шалтгаан нь болсон гэж үзэж байна.

2011 оны 1 дүгээр улирлын байдлаар Монгол улсад 75,691 ААН бүртгэгдсэнээс 40,317 ААН үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тэдгээрийн дийлэнх буюу 98% хуулийн тодорхойлолтоор жижиг дунд үйлдвэрт хамаарах ААН-үүд байна. Түүнчлэн үйл ажиллагаа тогтмол явуулж буй ААН-ийн 33% буюу 12,000 орчим нь тогтмол татвар төлдөг байна. Үйл ажиллагаа тогтмол явуулж буй ААН-ийн дийлэнх хэсгийг ЖДҮ эрхлэгчид эзэлж байгаа хэдий ч татвар төлөгчдийн тооноос харахад ЖДҮ эрхлэгчдийн талаас илүү нь татвараа тогтмол төлдөггүй, санхүүгийн хүнд байдалтай байгаа нь харагдаж байна²³. Энэ нь татварын тогтолцоо гуравдагч гол хүндрэл болоход нөлөөлсөн гэж үзэж байна.


Орон нутаг, нийслэл

Хууль эрх зүй, зохицуулалтын орчны ерөнхий индексийг аймаг болон нийслэл хотын хэмжээнд авч үзвэл Төв аймаг, Улаанбаатар хот, Өмнөговь аймаг болон Дундговь аймгийн санал асуулгад хамрагдсан ЖДҮ эрхлэгчид улсын дундажтай харьцуулахад ЖДҮ-ийн хөгжлийг дэмжих эрх зүй, хяналт шалгалт болон татварын бодлогын таатай орчин хангалттай сайн биш байна гэж дүгнэжээ. Харин Говьсүмбэр, Баян-Өлгий, Сүхбаатар болон Өвөрхангай аймгуудад бусад аймгуудтай харьцуулахад хууль эрх зүйн тогтолцоо, төрийн үйлчилгээ нь харьцангуй боломжийн байгаа гэсэн үнэлгээг өглөө /Зураг 4.14/.

²³ ХХААХҮЯ-ны статистик мэдээгээр манай оронд хувиараа жижиг бизнес эрхлэгч нийт 60.0 мянга орчим иргэд байдаг бөгөөд тэдгээрийн олонх нь ХҮОАТ-ын 10%-ийг төлдөг гэжээ. Харин хуулийн дагуу ЖДҮ-д хамрагдах 31.0 мянга орчим ААН-үүд нь гол төлөв ААНОАТ-ыг 10%-иар, НӨОАТ-ыг 10%-иар тус тус төлж байна. Албан бус сектор буюу далд эдийн засагт үйл ажиллагаа явуулж байгаа хувиараа бизнес эрхлэгчдийн тоог хараахан бүртгэлд хамруулж чадаагүй байгаа нь татвар төлөгчдийг бүрэн хамруулах боломжийг хязгаарлаж байна.

Зураг 4.14 Хууль эрх зүйн зохицуулалтын орчин

/-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, 1= сайн 2=маш сайн/, аймаг, нийслэл хот



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Хууль эрх зүй, зохицуулалтын орчинг тодорхойлогч үзүүлэлтүүдийн хувьд задлан авч үзвэл Өмнөговь, Төв, Ховд аймаг болон Улаанбаатар хотын түүвэр судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчид бусад аймагтай харьцуулахад **хууль эрх зүйн орчныг** төдийлөн хангалттай сайн биш байна гэж үзсэн бол Говьсүмбэр, Дорнод болон Сүхбаатар аймгуудад харьцангуй боломжийн байгаа гэсэн үнэлгээг өглөө /Хүснэгт 4.6/.

Төв, Дундговь, Орхон аймаг болон нийслэл хотод **төрийн байгууллагын үйлчилгээ** хангалттай сайн биш гэж үзсэн бол Говьсүмбэр, Сүхбаатар аймагт ЖДҮ эрхлэгчид харьцангуй боломжийн байна гэж үзжээ.

Дундговь, Дорноговь, Сэлэнгэ болон Орхон аймагт бизнес эрхлэгчид **татварын тогтолцоо** сайн биш буюу хүндрэл учруулж байна гэж үзсэн нь байна. Харин Өвөрхангай, Баян-Өлгий, Ховд болон Сүхбаатар аймагт үйл ажиллагаа эрхлэгчид бусад аймагтай харьцуулахад татварын тогтолцоо боломжийн гэж дүгнэжээ.

Улаанбаатар хотод ЖДҮ-ийн үйл ажиллагаа эрхлэгчид төрийн байгууллагын үйлчилгээг бусад үзүүлэлттэй харьцуулахад хамгийн муу гэж дүгнэлээ. Харин гадаад худалдаа хийх нөхцлийг бусад үзүүлэлттэй харьцуулахад боломжийн байна гэж үзсэн байна.

Хүснэгт 4.6 Хууль эрх зүй, зохицуулалтын орчин

/-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, 1= сайн 2=маш сайн/, аймаг, нийслэл хот

Аймаг/үзүүлэлт	Төрийн байгууллагын үйлчилгээ	Хууль, эрх зүйн орчин	Татварын тогтолцоо	Гадаад худалдаа хийх нөхцөл	Газар эзэмших	Хяналт, шалгалтын тогтолцоо
Улсын дүн	-0.66	-0.54	-0.50	-0.46	-0.44	-0.42
Өмнөговь	-0.70	-0.72	-0.62	-0.52	-0.34	-0.56
Улаанбаатар	-0.75	-0.65	-0.56	-0.43	-0.60	-0.52
Төв	-0.80	-0.63	-0.47	-0.63	-0.59	-0.45
Ховд	-0.45	-0.57	-0.27	-0.33	-0.35	-0.35
Орхон	-0.74	-0.52	-0.64	-0.42	-0.36	-0.37
Хөвсгөл	-0.70	-0.52	-0.36	-0.50	-0.30	-0.30
Булган	-0.63	-0.51	-0.31	-0.69	-0.39	-0.16
Говь-Алтай	-0.68	-0.50	-0.52	-0.46	-0.52	-0.14
Сэлэнгэ	-0.64	-0.48	-0.62	-0.58	-0.24	-0.45
Хэнтий	-0.63	-0.47	-0.45	-0.41	-0.33	-0.29
Архангай	-0.61	-0.43	-0.39	-0.45	-0.27	-0.29
Увс	-0.47	-0.41	-0.45	-0.65	-0.08	-0.31
Дорноговь	-0.43	-0.41	-0.63	-0.22	-0.35	-0.18
Баянхонгор	-0.52	-0.40	-0.44	-0.48	-0.32	-0.36
Баян-Өлгий	-0.48	-0.38	-0.15	-0.15	-0.40	0.00
Дархан	-0.50	-0.38	-0.41	-0.46	-0.32	-0.28
Дундговь	-0.80	-0.38	-0.68	-0.50	-0.26	-0.64
Өвөрхангай	-0.64	-0.36	-0.14	-0.34	-0.30	-0.42
Завхан	-0.50	-0.32	-0.36	-0.56	-0.36	-0.36
Сүхбаатар	-0.37	-0.31	-0.27	-0.94	0.04	-0.22
Дорнод	-0.59	-0.28	-0.46	-0.48	-0.17	-0.46
Говьсүмбэр	-0.16	-0.22	-0.41	-0.33	-0.20	-0.08

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн/ хөндлөн: үзүүлэлтүүдийг маш муугаас маш сайн руу; босоо: маш муугаас маш сайн руу/

Эдийн засгийн салбарын ангилал

ЖДҮ-ийг дэмжих **төрийн байгууллагын үйлчилгээг** худалдаа, үйлдвэрлэл болон үйлчилгээний салбарт үйл ажиллагаа эрхлэгчид хангалттай сайн биш буюу дунджаар (-0.66) индексгүйгээр үнэллээ /Хүснэгт 4.7/.

Хууль эрх зүй, зохицуулалтын орчинг үйлдвэрлэл эрхлэгчид бусад салбарт үйл ажиллагаа эрхлэгчтэй харьцуулахад харьцангуй боломжийн гэж дүгнэсэн байна. Энэ нь ЖДҮ-ийг дэмжих төрийн бодлого нэмүү өртөг шингэсэн, бодит үйлдвэрлэл эрхэлдэг ЖДҮ-ийг илүүтэй чиглэдэгтэй холбоотой байж болох талтай. Худалдааны салбарт үйл ажиллагаа эрхлэгчид бусад салбаруудтай харьцуулахад татварын тогтолцоо сайн биш байна гэж илүү өндрөөр үнэлжээ.

Хүснэгт 4.7 Хууль эрх зүй, зохицуулалтын орчин

/-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, 1= сайн 2=маш сайн/, салбарын ангилал

Үзүүлэлтүүд	Худалдаа	Үйл/гэл	Үйл/гээ	Нийт дүн
Т/Б-ын үйлчилгээ	-0.69	-0.63	-0.67	-0.66
Хууль, эрх зүйн орчин	-0.61	-0.43	-0.57	-0.54
Татварын тогтолцоо	-0.54	-0.49	-0.47	-0.50
ГХ хийх нөхцөл	-0.49	-0.49	-0.40	-0.46
Газар эзэмших	-0.49	-0.39	-0.46	-0.44
Хяналтын тогтолцоо	-0.47	-0.39	-0.39	-0.42

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийг 2007 онд шинэчилсэн найруулгаар батлагдаж, 2 шатлалтай, 10 ба 25% байхаар зөвхөн хувь хэмжээний өөрчлөлтүүдийг оруулсан байна. Уг шатлалаар ААН-ийн 99.9%-нь орлогын албан татварын 10%-ийн ангилалд хамрагдсан бөгөөд хууль мөрдөгдөж эхэлснээр ААН-ийн төсөвт төлөх албан татварын хэмжээ буурах, бизнес эрхлэгчид хөрөнгө үйл ажиллагаагаа нэгтгэн томруулах боломжууд бүрдэж, цаашдын хөгжилд томоохон түлхэцийг өгсөн байна.

4.3.4. Зах зээлийн орчин

Түүвэр судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчид зах зээлийн орчныг бусад үзүүлэлттэй харьцуулахад **(-0.37)** буюу боломжийн гэж дүгнэлээ. Зах зээлийн орчныг илэрхийлэх хүчин зүйлсээс **шударга өрсөлдөөн (-0.42)** хамгийн муу үнэлгээтэй гарлаа. ЖДҮ эрхлэгчид зах зээлд шударга өрсөлдөөн хангалттай явагдахгүй байгаа нь бизнесийн үйл ажиллагаанд сөрөг нөлөөг үзүүлж байна гэж үзлээ. Төрийн зүгээс “Шударга өрсөлдөөний тухай хууль”-ийг УИХ-аас 1993 онд баталсан бөгөөд 2005 онд Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар /ШӨХТГ/ байгуулсан. 2010 оны 6 сард “Өрсөлдөөний тухай хууль”-ийг шинээр баталжээ. Уг хууль нь аж ахуй эрхлэгчдийн зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцлийг бүрдүүлэх, зах зээлд ноёлох болон өрсөлдөөнд харш аливаа үйл ажиллагаа явуулсан бизнест торгууль ноогдуулах замаар өрсөлдөөнийг дэмжих, өрсөлдөөнийг зохицуулах байгууллагын эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулах үүрэгтэй юм.


Нэгдсэн дүн

Түүвэр судалгааны үр дүнгээр зах зээлийн орчны ерөнхий индексийг **(-0.37)** буюу муугаас илүүтэйгээр боломжийн байна гэсэн дүгнэлтийг ЖДҮ эрхлэгчид өглөө. Зах зээлийн орчны ерөнхий индексийг тодорхойлогч үзүүлэлтүүдээр нь задлан авч үзвэл ЖДҮ эрхлэгчид зах зээлд шударга өрсөлдөөн²⁴ хангалттай сайн явагдахгүй байгаа нь зах зээлийн орчны гол хүндрэл болж байна гэж үзжээ. Түүнчлэн хэрэглэгчийн худалдан авах чадвар төдийлөн сайн

биш, даатгалын үйлчилгээ хангалттай сайн нэвтрээгүй гэж үзсэн нь судалгааны үр дүнгээс харагдлаа /Зураг 4.15/.

Зураг 4.15 Зах зээлийн орчин

/-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, 1= сайн, 2=маш сайн/




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Аймаг, нийслэл

Зах зээлийн орчны ерөнхий индексийг аймаг болон нийслэл хотын хэмжээнд авч үзвэл Ховд, Говь-Алтай, Завхан болон Дундговь аймгийн санал асуулгад хамрагдсан ЖДҮ эрхлэгчид бизнес эрхлэх зах зээлийн орчин хангалттай сайн бүрдээгүй гэж үзжээ. Харин Баян-Өлгий, Дархан аймгуудад бизнес эрхлэгчид бусад аймгуудтай харьцуулахад зах зээлийн орчин харьцангуй боломжийн байгаа гэсэн үнэлгээг өглөө /Зураг 4.16/.

Зураг 4.16 Зах зээлийн орчин

/-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, 1= сайн, 2=маш сайн/, аймаг, нийслэл хот



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Зах зээлийн орчинг тодорхойлогч үзүүлэлтүүдийн хувьд задлан авч үзвэл Ховд, Хэнтий болон Дорнод аймгийн түүвэр судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчид бусад аймагтай харьцуулахад **шударга бус өрсөлдөөн** өндөр байна гэж үзсэн бол Сүхбаатар

²⁴ ГТХА-ны “Жижиг дунд үйлдвэрлэл”-ийн талаар хийсэн төслийн судалгааны үр дүнгээр ЖДҮ эрхлэгчдэд хамгийн ихээр саад болж байгаа үзүүлэлтээр татвар, авилгал, зээлийн хүү өндөр болон бизнесийн шударга бус өрсөлдөөн гэсэн үзүүлэлтүүд гарсан байна.

Говьсүмбэр болон Өвөрхангай аймгуудад уг үзүүлэлт харьцангуй боломжийн байгаа гэсэн үнэлгээг өглөө /Хүснэгт 4.8/.

Говь-Алтайн, Дундговь болон Завхан аймагт үйл ажиллагаа эрхлэгчид хэрэглэгчдийн худалдан авах чадвар сайн биш гэсэн үнэлгээг өгсөн бол Баян-Өлгийн аймгийн ЖДҮ эрхлэгчид бараг боломжийн гэсэн үнэлгээг өглөө. Статистикийн хорооны 2010 оны дүнгээр Өвөрхангай, Дундговь, Архангай, Завхан, Төв аймгийн хүн амын 80 орчим хувь нь хөдөөд амьдардаг гэсэн нь дээрх үр дүн гарахад нөлөөлсөн байна.

Дундговь, Говьсүмбэр болон Ховд аймгийн ЖДҮ эрхлэгчид даатгалын үйлчилгээ үзүүлэх тогтолцоог бусад аймагтай харьцуулахад сайн биш гэж дүгнэсэн бол Булган, Хэнтий, Дундговь аймагт бизнес эрхлэгчид бусад аймагтай харьцуулахад харьцангуй боломжийн гэж үзлээ.

Говь-Алтай, Говьсүмбэр болон Ховд аймгийн ЖДҮ эрхлэгчид өөрийн аймагт бүтээгдэхүүний борлуулах зах зээлийн багтаамж сайн биш гэж үзжээ. Харин Увс, Хөвсгөл, Дархан-Уул болон Орхон аймагт үйл ажиллагаа эрхлэгчид бусад аймагтай харьцуулахад уг үзүүлэлтийг бараг боломжийн гэж дүгнэлээ.

Улаанбаатар хотод ЖДҮ-ийн үйл ажиллагаа эрхлэгчид шударга өрсөлдөөн зах зээлд явагдахгүй байна гэж үзсэн нь бусад үзүүлэлттэй харьцуулахад хамгийн муу гэж дүгнэгдлээ.

Хүснэгт 4.8 Зах зээлийн орчин

/-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, 1= сайн, 2=маш сайн/

	Шударга өрсөлдөөн	Худалдан авах чадвар	Даатгалын үйлчилгээ	Зах зээлийн багтаамж	Технологийн дэвшил
Улсын дүн	-0.42	-0.39	-0.39	-0.38	-0.26
Ховд	-0.61	-0.51	-0.98	-0.51	-0.49
Хэнтий	-0.59	-0.53	-0.22	-0.49	-0.59
Дорнод	-0.54	-0.52	-0.28	-0.33	-0.50
Хөвсгөл	-0.54	-0.44	-0.40	-0.20	-0.36
Төв	-0.47	-0.45	-0.51	-0.41	-0.27
Говь-Алтай	-0.46	-0.74	-0.42	-0.72	-0.48
Орхон	-0.46	-0.38	-0.55	-0.25	-0.15
Архангай	-0.45	-0.47	-0.49	-0.47	-0.27
Завхан	-0.44	-0.62	-0.50	-0.58	-0.46
Улаанбаатар	-0.44	-0.36	-0.37	-0.37	-0.20
Увс	-0.43	-0.31	-0.27	-0.18	-0.39
Дундговь	-0.42	-0.74	-0.24	-0.56	-0.64
Сэлэнгэ	-0.41	-0.33	-0.46	-0.37	-0.37
Баян-Өлгий	-0.37	-0.04	-0.31	-0.31	-0.13
Өмнөговь	-0.36	-0.20	-0.34	-0.38	-0.24
Дорноговь	-0.33	-0.25	-0.37	-0.33	-0.18
Булган	-0.33	-0.53	-0.20	-0.35	-0.27
Дархан	-0.27	-0.37	-0.27	-0.21	-0.08
Баянхонгор	-0.26	-0.46	-0.38	-0.48	-0.30
Өвөрхангай	-0.26	-0.42	-0.44	-0.36	-0.28
Говьсүмбэр	-0.22	-0.53	-0.43	-0.55	-0.31
Сүхбаатар	-0.22	-0.18	-0.35	-0.41	-0.37

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн /хөндлөн: үзүүлэлтүүдийг маш муугаас маш сайн руу; босоо: маш муугаас маш сайн руу/

Эдийн засгийн салбарын ангилал: Худалдааны салбарт үйл ажиллагаа эрхлэгчид бусад салбартай харьцуулахад шударга өрсөлдөөн зах зээлд хангалттай сайн явагдахгүй байна гэж гэж дүгнэжээ. Худалдааны салбарын шударга өрсөлдөөний индекс (-0.47) гарсан бол улсын дундаж үзүүлэлт (-0.42) байна /Хүснэгт 4.9/.

Хэрэглэгчдийн худалдан авах чадварыг үйлдвэрлэл болон үйлчилгээний салбарын ЖДҮ эрхлэгчид худалдааны салбарынхантай харьцуулахад боломжийн гэж үзжээ. Энэ нь нэг талаас хөдөө орон нутагт үйлдвэрлэл эрхлэгчид өөрийн орон нутгын онцлогт нийцүүлэн бүтээгдэхүүнээ үйлдвэрлэдэг нь байнгын худалдан авагчтай болж чадсан байдаг, нөгөө талаас үйлчилгээ эрхлэгчид нь зочид буудал, зоогийн газар, тээвэр, үсчин зэрэг хэрэглэгчдийн анхдагч хэрэгцээг хангах үйлчилгээ явуулдаг нь худалдан авах чадварыг салбарын хооронд ялгаатай үнэлэх үндэс нь болсон гэж үзэж байна.

Хүснэгт 4.9 Зах зээлийн орчин

/-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, 1= сайн, 2=маш сайн/, салбарын ангилал

Үзүүлэлтүүд	Худалдаа	Үйл/лэл	Үйл/гээ	Нийт дүн
Шударга өрсөлдөөн	-0.47	-0.40	-0.38	-0.42
Худалдан авах чадвар	-0.47	-0.34	-0.37	-0.39
Даатгалын үйлчилгээ	-0.43	-0.37	-0.37	-0.39
Зах зээлийн багтаамж	-0.44	-0.34	-0.36	-0.38
Технологийн дэвшил	-0.28	-0.27	-0.24	-0.26

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

4.3.5. Дэд бүтцийн байдал

Монгол улс нь олон улс, улсын чанартай нийт 11,230 км авто зам байгаагаас 20 орчим хувь нь хатуу хучилттай зам байдаг бөгөөд 2010 оны эцсийн байдлаар Сэлэнгэ, Дархан-уул, Орхон, Булган, Хэнтий, Төв, Өвөрхангай, Говьсүмбэр аймгууд хатуу хучилттэй замын нэгдсэн сүлжээнд холбогдоод байна.

Сүүлийн жилүүдэд үүрэн утасны хэрэглэгчдийн тоо мэдэгдэхүйц нэмэгдэж, давхардсан тоогоор 2010 онд 2.5 саяд хүрсэн нь өмнөх оныхоос 14.7 хувиар өсчээ. Түүнчлэн сансрын холбооны хэрэглэгчдийн тоо 2009 онд 674 байсан бол 2010 онд 773-д хүрсэн байна. Харин суурин утасны цэгийн тоо 2010 онд 143.2 мянга болж, 2009 оныхоос 0.3 мянгаар өслөө.


Нэгдсэн дүн

Түүвэр судалгааны үр дүнгээр ЖДҮ эрхлэгчид дэд бүтцийн байдлыг бусад бизнесийн орчны ерөнхий индексүүдтэй харьцуулахад хамгийн боломжийн (**-0.18**) гэсэн үнэлгээг өглөө. Дэд бүтцийн байдлын ерөнхий индексийг тодорхойлогч үзүүлэлтүүдээр нь задлан авч үзвэл Зам тээврийн хөгжил болон дулаан усан хангамжийн байдлыг бусад үзүүлэлттэй харьцуулахад сайн биш гэж дүгнэгдлээ. Харин мэдээлэл холбооны салбарыг сайн, цахилгаан

хангамжийг бараг хэвийн (боломжийн) гэж дүгнэсэн үр дүн гарлаа /Зураг 4.17/.

Зураг 4.17 Дэд бүтцийн байдал

/-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, 1= сайн, 2=маш сайн/




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Аймаг, нийслэл

Дэд бүтцийн байдлын ерөнхий индексийг аймаг болон нийслэл хотын хэмжээнд авч үзвэл Өмнөговь, Ховд, Завхан болон Говь-Алтай зэрэг төвөөс алслагдсан аймгуудын санал асуулгад хамрагдсан ЖДҮ эрхлэгчид дэд бүтцийн байдал сайн бүрдээгүй гэж үзлээ. Харин Говьсүмбэр, Дархан-Уул, Сүхбаатар болон Орхон зэрэг аймагт ЖДҮ эрхлэгчид дэд бүтцийн байдлыг сайн гэж үзсэн нь эдгээр аймгуудын дийлэнх²⁵ нь хатуу хучилттай замын нэгдсэн сүлжээнд холбогдсон, цахилгаан дулааны нэгдсэн сүлжээтэй зэрэг нь индекс эерэг гарахад нөлөөллөө /Зураг 4.18/.

Зураг 4.18 Дэд бүтцийн байдал

/-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, 1= сайн, 2=маш сайн/



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Дэд бүтцийн байдлыг тодорхойлогч үзүүлэлтүүдийг аймаг, нийслэл хотын хэмжээнд задлан авч үзвэл Говь-Алтай, Дундговь, Баян-Өлгий болон Өмнөговь

аймгуудад бизнес эрхлэгчид өөрийн аймгийн зам тээврийн хөгжлийг бусад аймагтай харьцуулахад сайн биш гэж дүгнэсэн нь эдгээр аймгууд хатуу хучилттай замын нэгдсэн сүлжээнд холбогдоогүй, төвөөс алслагдсан байдал зэрэг нь дээрх нөлөөлсөн байж болзошгүй юм. Харин Говьсүмбэр, Хэнтий, Булган болон Сэлэнгэ аймууд зам тээврийн хөгжлөө сайн гэж үнэлжээ. Говьсүмбэр аймгийн төв Чойр хот

Увс, Өмнөговь болон Говь-Алтай аймагт үйл ажиллагаа эрхлэгчид дулаан хангамжийн асуудал бусад аймагтай харьцуулахад сайн биш гэсэн үнэлгээг өгсөн бол Дархан аймаг сайн, Говьсүмбэр болон Дорнод аймгууд хэвийн гэж үнэллээ.

Өмнөговь аймагт үйл ажиллагаа эрхлэгчид цахилгаан хангамжийн асуудлыг бусад аймагтай харьцуулахад муу гэж дүгнэсэн бол бусад аймгууд харьцангуй хэвийн гэсэн үнэлгээг өглөө.

Улаанбаатар хотод ЖДҮ эрхлэгчид зам тээврийн хөгжил сайн биш гэж үнэлсэн нь замын түгжрэл, хатуу хучилттай замын бат бөх чанар зэргээс шалтгаалж уг үнэлгээг өгсөн байх талтай. Харин бусад үзүүлэлтийн хувьд нийслэл хотын бизнес эрхлэгчид харьцангуй боломжийн гэсэн үнэлгээг өглөө /Хүснэгт 4.10/.

Хүснэгт 4.10 Дэд бүтцийн байдал

/-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, 1= сайн, 2=маш сайн/

Аймаг/үзүүлэлт	Зам, тээврийн хөгжил	Дулаан, усан хангамж	Цахилгаан хангамж	Мэдээлэл холбооны хөгжил
Улсын дүн	-0.58	-0.31	-0.05	0.24
Говь-Алтай	-1.20	-0.84	-0.44	0.46
Дундговь	-1.18	-0.54	0.36	0.50
Баян-Өлгий	-1.06	-0.12	0.27	0.56
Өмнөговь	-1.04	-0.90	-1.10	0.22
Завхан	-1.00	-0.62	-0.74	0.14
Ховд	-0.94	-0.76	-0.53	-0.18
Увс	-0.90	-0.96	0.00	0.18
Хөвсгөл	-0.88	-0.70	0.10	0.30
Төв	-0.84	-0.55	-0.29	0.00
Баянхонгор	-0.84	-0.16	0.22	0.46
Дорнод	-0.80	0.00	0.28	0.41
Улаанбаатар	-0.68	-0.25	-0.10	0.15
Дорноговь	-0.51	-0.39	0.10	0.24
Орхон	-0.33	-0.01	0.14	0.43
Дархан	-0.25	0.15	0.25	0.32
Архангай	-0.24	-0.27	0.06	0.27
Сүхбаатар	-0.04	-0.51	0.22	0.76
Өвөрхангай	-0.02	-0.36	-0.08	0.44
Булган	-0.02	-0.33	0.02	0.25
Сэлэнгэ	0.01	-0.13	0.03	0.28
Хэнтий	0.04	-0.35	-0.04	0.08
Говьсүмбэр	0.65	0.00	0.67	0.57

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн /хөндлөн: үзүүлэлтүүдийг маш муугаас маш сайн руу; босоо: маш муугаас маш сайн руу/

²⁵ Сүхбаатар аймгаас бусад нь

Эдийн засгийн салбарын ангилал

Худалдааны салбарт үйл ажиллагаа эрхлэгчид бусад салбартай харьцуулахад зам тээврийн хөгжил сайн биш байна гэж дүгнэжээ. Уг салбарт үйл ажиллагаа эрхлэгчид бусад салбартай харьцуулахад зам тээврийн хөгжилд түшиглэж үйл ажиллагаа явуулдаг нь үнэлгээ муу гарахад нөлөөлсөн байж болзошгүй юм /Хүснэгт 4.11/.

Дулаан усан хангамж болон цахилгааны хангамжийг үйлдвэрлэл болон үйлчилгээний салбарын ЖДҮ эрхлэгчид худалдааны салбарынхантай харьцуулахад боломжийн гэж үзжээ. Мөн гурван салбарын хувьд мэдээлэл холбооны хөгжлийг боломжийн сайн гэсэн үнэлгээг өглөө.

Хүснэгт 4.11 Зах зээлийн орчин

/-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, 1= сайн, 2=маш сайн/, салбарын ангилал

Үзүүлэлтүүд	Худалдаа	Үйл/лэл	Үйл/гээ	Нийт дүн
Зам, тээврийн хөгжил	-0.61	-0.54	-0.60	-0.58
Дулаан, усан хангамж	-0.38	-0.27	-0.27	-0.31
Цахилгаан хангамж	-0.08	-0.01	-0.05	-0.05
Мэдээ/холбооны хөгжил	0.17	0.35	0.21	0.24

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

4.4 Зардлын байдал

ЖДҮ эрхлэгчдийн үйл ажиллагаа явуулахад гарах зардлын өнөөгийн нөхцөл байдлыг тогтоож, аль зардал ЖДҮ эрхлэхэд хүндрэл учруулж байгааг тандах зорилго тавьсан болно.

Нэгдсэн дүн

Судалгааны үр дүнгээр ЖДҮ эрхлэгч нарт зардлуудаас зээлийн хүү, шимтгэл хураамжийн төлбөр, тоног төхөөрөмжинд зарцуулах зардал болон түрээсийн зардал зэрэг үзүүлэлтүүд хамгийн их хүндрэл үзүүлдэг байна /Зураг 4.19/.

Харин харилцаа холбооны зардал, зар сурталчилгааны зардал болон үйл ажиллагааны зардал бизнесийн эрхлэхэд төдийлөн хүндрэл үзүүлдэггүй гэсэн үр дүн гарлаа.

Зураг 4.19 Зардлын байдал



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

ЖДҮ эрхлэгчдэд зээлийн хүүний зардлыг хамгийн их хүндрэл болж байна гэж үзсэн нь Бизнесийн орчны Санхүүжилтийн хэсгийн санхүүжилтийн хүү өндөр байна гэсэн үр дүнтэй нийцтэй гарлаа. Төрөөс зээлийн хүүг бууруулах зах зээлийн таатай орчинг бүрдүүлэх ажлыг Монголбанк, Монгол Улсын Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо хамтран шат дараатай арга хэмжээнүүдийг авч ажиллаж байгаа билээ.

Дэлхийн банкны “Бизнес эрхлэх нь 2010” тайланд бизнес эрхлэхэд тулгардаг бэрхшээлд тусгай зөвшөөрөл, лицензийг олж авах шат дамжлагын тоо, хугацаа болон зардал өндөр байгааг дурьдсан байдаг. Шимтгэл хураамжийн зардал зээлийн хүүний дараах хамгийн их хүндрэл учруулж байгаа үзүүлэлт болсон нь дээрх судалгааны үр дүнтэй нийцтэй гарлаа.


Хэдийгээр ЖДҮ эрхлэгч нарт тоног төхөөрөмжийн зардал голлох хүндрэлүүдийн тоонд орж байгаа боловч ЖДҮ-ийг хөгжүүлэх эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх ажлын хүрээнд Засгийн газраас “Санхүүгийн түрээс /Лизинг/-ийн тухай хууль”-ийг 2006 онд, “Жижиг, дунд үйлдвэрийн тоног

төхөөрмжийг гаалийн болон НӨАТ-аас чөлөөлөх тухай хууль”-ийг 2009 онд тус тус батлуулж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүний үр дүнд үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг санхүүгийн түрээс буюу “Лизинг”-ээр авах боломж бий болсон бөгөөд Тоног төхөөрөмжийн импортын татварыг 2012 оны эцэс хүртэл хөнгөлсөн нь цаашид тоног төхөөрөмжийн зардал буурах нөхцлийг бүрдүүлнэ гэж үзэж байна.

Аймаг, нийслэл

Зардлын байдлын ерөнхий индексийг аймаг болон нийслэл хотын хэмжээнд авч үзвэл Ховд, Говь-Алтай болон Төв аймагт ЖДҮ эрхлэгчид бусад аймагтай харьцуулахад зардлын байдал их хүндрэлтэй байна гэж үзлээ. Харин Говьсүмбэр, Сүхбаатар, Баянхонгор болон Өмнөговь аймагт ЖДҮ эрхлэгчид зардлын байдал харьцангуй бага хүндрэлтэй гэж дүгнэлээ /Зураг 4.20/.

Зураг 4.20 Зардлын байдал



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Зардлын байдлыг тодорхойлогч үзүүлэлтүүдийг аймаг, нийслэл хотын хэмжээнд задлан авч үзвэл Ховд, Говь-Алтай, Дундговь болон Завахан аймагт бизнес эрхлэгчид зээлийн хүүний зардлыг бусад аймагтай харьцуулахад хамгийн их хүндрэл үзүүлж байна гэж үзжээ. Харин Говьсүмбэр, Дорнод болон Сэлэнгэ аймагт ЖДҮ эрхлэгчид хүүний зардлыг харьцангуй боломжийн гэж дүгнэлээ.

Ховд, Дундговь болон Төв аймагт ЖДҮ эрхлэгчид шимтгэл, хураамжийн төлбөрийг бусад аймагтай харьцуулахад хамгийн их хүндрэл учруулж байна гэсэн бол Говьсүмбэр, Өмнөговь болон Дорнод аймагт үйл ажиллагаа эрхлэгчид бага хүндрэлтэй гэжээ.

Тоног төхөөрөмжийн зардлыг Ховд, Дорнод болон Хэнтий аймагт бизнес эрхлэгчид бусад аймагтай харьцуулахад их хүндрэл учруулж байна гэсэн бол Сүхбаатар, Өвөрхангай, Баянхонгор болон

Хүснэгт 4.12 Зардлын байдал

/-4 = маш их хүндрэлтэй, -3 = их хүндрэлтэй, -2 = хүндрэлтэй, -1 = бага хүндрэлтэй, 0 = хүндрэлгүй/, аймаг, нийслэл хот

Аймаг/үзүүлэлт	Зээлийн хүүний зардал	Шимтгэл, хураамжийн төлбөр	Тоног төхөөрөмжийн зардал	Түрээсийн зардал	Түүхий эдийн зардал	Зам, тээврийн зардал	Дулаан, усны зардал	Эрчим хүч, цахилгааны зардал	Ажиллах хүчний өртөг	Захираа, үйл ажиллагааны зардал	Зар сурталчилгааны зардал	Харилцаа холбооны зардал
Улсын дүн	-1.84	-1.74	-1.62	-1.60	-1.60	-1.58	-1.50	-1.49	-1.39	-1.32	-1.32	-1.08
Ховд	-2.63	-2.49	-2.20	-2.33	-2.14	-2.33	-2.12	-2.12	-2.41	-2.00	-2.29	-2.18
Говь-Алтай	-2.26	-1.86	-1.60	-1.62	-1.84	-2.14	-2.36	-2.26	-1.52	-1.12	-1.30	-0.98
Дундговь	-2.10	-2.06	-1.92	-1.46	-1.68	-1.64	-1.52	-1.76	-1.32	-0.96	-0.82	-0.60
Завхан	-2.02	-1.58	-1.66	-1.46	-1.70	-2.34	-1.34	-1.76	-1.28	-1.42	-1.06	-1.06
Баянхонгор	-1.98	-1.64	-1.28	-1.10	-1.48	-1.40	-1.02	-1.14	-1.14	-1.02	-0.86	-0.44
Баян-Өлгий	-1.96	-1.81	-1.56	-1.52	-1.75	-1.52	-1.13	-1.04	-1.17	-1.35	-0.92	-0.98
Төв	-1.94	-1.96	-1.71	-1.53	-1.78	-1.75	-1.76	-1.65	-1.59	-1.57	-1.65	-1.27
Увс	-1.90	-1.71	-1.80	-1.25	-1.59	-1.90	-1.35	-1.14	-1.37	-1.16	-0.96	-0.82
Улаанбаатар	-1.89	-1.78	-1.62	-1.74	-1.62	-1.62	-1.49	-1.48	-1.41	-1.42	-1.57	-1.25
Хөвсгөл	-1.88	-1.74	-1.40	-1.48	-1.40	-1.58	-1.32	-1.20	-1.28	-1.10	-0.76	-0.74
Өвөрхангай	-1.84	-1.74	-1.28	-1.50	-1.20	-1.12	-1.32	-1.36	-1.28	-1.06	-1.02	-0.82
Дорноговь	-1.80	-1.78	-1.51	-1.41	-1.59	-1.55	-1.73	-1.51	-1.08	-1.31	-0.98	-0.76
Хэнтий	-1.78	-1.71	-1.90	-1.63	-1.73	-1.37	-1.59	-1.67	-1.80	-1.43	-1.47	-1.08
Сүхбаатар	-1.76	-1.41	-1.04	-0.76	-1.18	-1.37	-1.82	-1.63	-1.10	-0.80	-0.43	-0.35
Орхон	-1.71	-1.67	-1.55	-1.63	-1.58	-1.40	-1.60	-1.62	-1.37	-1.20	-1.15	-0.94
Архангай	-1.71	-1.75	-1.73	-1.47	-1.65	-1.51	-1.65	-1.61	-1.41	-1.25	-1.12	-1.04
Дархан	-1.61	-1.75	-1.60	-1.77	-1.54	-1.40	-1.47	-1.51	-1.33	-1.28	-1.12	-1.01
Өмнөговь	-1.60	-1.38	-1.32	-1.32	-1.42	-1.50	-1.38	-1.54	-1.32	-0.84	-0.94	-0.74
Булган	-1.59	-1.71	-1.75	-1.80	-1.73	-1.59	-1.51	-1.39	-1.41	-1.45	-1.45	-1.22
Сэлэнгэ	-1.58	-1.55	-1.67	-1.39	-1.60	-1.23	-1.35	-1.38	-1.24	-1.30	-1.13	-0.97
Дорнод	-1.37	-1.48	-1.93	-1.35	-1.48	-1.48	-1.24	-1.39	-1.22	-1.52	-0.89	-0.80
Говьсүмбэр	-1.12	-1.24	-1.51	-1.10	-1.31	-1.04	-1.20	-0.80	-1.20	-0.86	-0.76	-0.47

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн /хөндлөн: үзүүлэлтүүдийг маш муугаас маш сайн руу; босоо: маш муугаас маш сайн руу/

Өмнөговь аймагт үйл ажиллагаа эрхлэгчид харьцангуй хүндрэл багатай гэж үзсэн байна.

Ховд, Булган болон Дархан-Уул аймагт ЖДҮ эрхлэгчид түрээсийн зардлыг бусад аймагтай харьцуулахад хамгийн их хүндрэл учруулж байна гэж үзсэн бол Сүхбаатар, Говьсүмбэр болон Баянхонгор аймагт үйл ажиллагаа эрхлэгчид бага хүндрэлтэй гэжээ.

Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхлэгчдийн хувьд хамгийн их хүндрэл учруулж буй зардал нь хүүний зардал, шимтгэл хураамжийн, түрээсийн зардал ордог байна. Харин зар сурталчилгааны зардал орон нутагт үйл ажиллагаа эрхлэгчтэй харьцуулахад харьцангуй хүндрэл үзүүлдэг гэж хариулжээ /Хүснэгт 4.12/.

Эдийн засгийн салбарын ангилал

Худалдааны салбарт үйл ажиллагаа эрхлэгчид бусад салбарт үйл ажиллагаа эрхлэгчидтэй харьцуулахад зээлийн хүүний зардал, шимтгэл хураамжийн төлбөр, тоног төхөөрөмжийн зардал, түрээсийн зардал, түүхийн эдийн зардал болон тээврийн зардлыг их хүндрэлтэй гэж үзжээ.

Харилцаа холбооны зардал, зар сурталчилгааны зардал болон үйл ажиллагааны зардлыг бусад

салбартай харьцуулахад бага хүндрэл үзүүлдэг гэж үйлдвэрлэлийн салбарынхан үзсэн байна.

Үйлчилгээний салбарт үйл ажиллагаа эрхлэгчдийн хувьд бусад салбартай адил зээлийн хүүний зардал, шимтгэл хураамжийн төлбөр их хүндрэл учруулдаг бол түрээсийн төлбөр нь тоног төхөөрөмжийн зардлаас илүү хүндрэлийг үзүүлдэг байна /Хүснэгт 4.13/.

Хүснэгт 4.13 Зардлын байдал

/-4 = маш их хүндрэлтэй, -3 = их хүндрэлтэй, -2 = хүндрэлтэй, -1 = бага хүндрэлтэй, 0 = хүндрэлгүй/

Үзүүлэлт	Худалдаа	Үйл/лэл	Үйл/гээ	Нийт дүн
Зээлийн хүүний зардал	-1.96	-1.77	-1.80	-1.84
Шимтгэл, хураамжийн төлбөр	-1.90	-1.65	-1.69	-1.74
Тоног төхөөрөмжийн зардал	-1.68	-1.58	-1.59	-1.62
Түрээсийн зардал	-1.66	-1.49	-1.65	-1.60
Түүхий эдийн зардал	-1.65	-1.59	-1.57	-1.60
Зам, тээврийн зардал	-1.78	-1.47	-1.51	-1.58
Дулаан, усны зардал	-1.61	-1.35	-1.53	-1.50
Эрчим хүч, цахилгааны зардал	-1.60	-1.40	-1.47	-1.49
Ажиллах хүчний өртөг	-1.47	-1.32	-1.38	-1.39
Үйл ажиллагааны зардал	-1.55	-1.16	-1.27	-1.32
Зар сурталчилгааны зардал	-1.49	-1.10	-1.36	-1.32
Харилцаа холбооны зардал	-1.26	-0.89	-1.08	-1.08

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

4.5 Дотоод орчин


ЖДҮ эрхлэгчдийн үйл ажиллагаа явуулахад дотоод орчны зүгээс нөлөөлөх хүчин зүйлсийг ажилчдын ур чадвар, хүний нөөцийн удирдлага, тоног төхөөрөмжийн чанар болон түүхий эдийн чанар зэрэг үзүүлэлтүүдээр төлөөлүүлэн авч судаллаа.

Нэгдсэн дүн

Судалгааны үр дүнгээр ЖДҮ эрхлэгчдэд дотоод орчны зүгээс хүний нөөцийн удирдлага, тоног төхөөрөмжийн чанар бусад үзүүлэлттэй харьцуулахад хамгийн их хүндрэл учруулдаг бол түүхий эдийн чанар бусад үзүүлэлттэй харьцуулахад харьцангуй бага хүндрэл учруулдаг байна /Зураг 4.21/.

Зураг 4.21 Дотоод орчин

/-4 = маш их хүндрэлтэй, -3 = их хүндрэлтэй, -2 = хүндрэлтэй, -1 = бага хүндрэлтэй, 0 = хүндрэлгүй/




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Аймаг, нийслэл

Дотоод орчны ерөнхий индексийг аймаг болон нийслэл хотын хэмжээнд авч үзвэл Ховд, Хэнтий болон Булган аймагт ЖДҮ эрхлэгчид бусад аймагтай харьцуулахад дотоод орчны байдал хамгийн их хүндрэлтэй байна. Харин Сүхбаатар, Өмнөговь болон Баянхонгор аймагт ЖДҮ эрхлэгчид дотоод орчинг харьцангуй бага хүндрэлтэй гэж дүгнэлээ /Зураг 4.22/.

Зураг 4.22 Дотоод орчин

/-4 = маш их хүндрэлтэй, -3 = их хүндрэлтэй, -2 = хүндрэлтэй, -1 = бага хүндрэлтэй, 0 = хүндрэлгүй/



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Дотоод орчныг тодорхойлогч үзүүлэлтүүдийг аймаг, нийслэл хотын хэмжээнд задлан авч үзвэл Ховд, Хэнтий, Говьсүмбэр болон Завхан аймагт бизнес эрхлэгчид хүний нөөцийн удирдлагыг бусад аймагтай харьцуулахад хамгийн их хүндрэл үзүүлж байна гэж үзжээ. Харин Хөвсгөл, Баянхонгор болон Архангай аймагт ЖДҮ эрхлэгчид дотоод орчныг харьцангуй боломжийн гэж дүгнэлээ.

Ховд, Хэнтий болон Булган аймагт ЖДҮ эрхлэгчид тоног төхөөрөмжийн чанарыг бусад аймагтай харьцуулахад хамгийн их хүндрэл үзүүлж байна гэсэн бол Баянхонгор, Сүхбаатар болон Өмнөговь аймагт үйл ажиллагаа эрхлэгчид бага хүндрэлтэй гэжээ.

Түүхий эдийн чанарыг Ховд, Хэнтий аймаг болон Улаанбаатар хотод бизнес эрхлэгчид бусад аймагтай харьцуулахад их хүндрэл учруулж байна гэсэн бол Сүхбаатар аймагт үйл ажиллагаа эрхлэгчид харьцангуй хүндрэл багатай гэж үзсэн байна /Хүснэгт 4.14/.

Хүснэгт 4.14 Дотоод орчин

/-4 = маш их хүндрэлтэй, -3 = их хүндрэлтэй, -2 = хүндрэлтэй, -1 = бага хүндрэлтэй, 0 = хүндрэлгүй/

Аймаг/үзүүлэлт	Хүний нөөцийн удирдлага	Тоног төхөөрөмжийн чанар	Ажилчдын чадвар	Түүхий эдийн чанар
Улсын дүн	-1.35	-1.24	-1.23	-1.20
Ховд	-2.20	-2.20	-2.18	-2.02
Хэнтий	-1.63	-1.88	-1.49	-1.37
Говьсүмбэр	-1.57	-1.39	-1.22	-0.98
Завхан	-1.54	-1.38	-1.30	-1.12
Булган	-1.53	-1.45	-1.27	-1.37
Дорноговь	-1.49	-1.06	-1.29	-0.92
Дархан	-1.46	-1.25	-1.40	-1.07
Өвөрхангай	-1.42	-1.12	-1.26	-1.02
Улаанбаатар	-1.38	-1.20	-1.13	-1.30
Баян-Өлгий	-1.33	-1.29	-1.02	-1.04
Төв	-1.29	-1.14	-1.27	-1.18
Сэлэнгэ	-1.28	-1.31	-1.30	-1.31
Говь-Алтай	-1.26	-1.10	-1.40	-1.24
Орхон	-1.21	-1.11	-1.25	-1.10
Дундговь	-1.20	-1.32	-1.62	-1.12
Дорнод	-1.15	-1.22	-1.37	-1.02
Архангай	-1.12	-1.12	-1.31	-1.08
Өмнөговь	-1.10	-1.04	-0.96	-0.94
Увс	-1.10	-1.41	-1.08	-0.92
Сүхбаатар	-1.04	-0.86	-1.16	-0.55
Баянхонгор	-1.02	-0.98	-1.24	-0.96
Хөвсгөл	-0.96	-1.22	-1.18	-1.18

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Эдийн засгийн салбарын ангилал

Худалдааны салбарт үйл ажиллагаа эрхлэгчид бусад салбарт үйл ажиллагаа эрхлэгчидтэй харьцуулахад хүний нөөцийн удирдлага, тоног төхөөрөмжийн чанар, ажилчдын ур чадвар болон түүхий эдийн чанарыг бусад салбаруудтай харьцуулахад харьцангуй их хүндрэлтэй гэжээ.

Харин үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа эрхлэгчид дотоод орчны хүчин зүйлсийг бусад салбартай харьцуулахад харьцангуй бага хүндрэл үзүүлдэг гэсэн үр дүн гарлаа.

Үйлчилгээний салбарт үйл ажиллагаа эрхлэгчдийн хувьд хүний нөөцийн удирдлага голлох бэрхшээл болж байгаа бол түүхий эдийн чанар дараах гол хүндрэл болж байгаа нь харагдлаа /Хүснэгт 4.15/.

Хүснэгт 4.15 Дотоод орчин

/-4 = маш их хүндрэлтэй, -3 = их хүндрэлтэй, -2 = хүндрэлтэй, -1 = бага хүндрэлтэй, 0 = хүндрэлгүй/

Үзүүлэлт	Худалдаа	Үйл/лэл	Үйл/гээ	Нийт дүн
Хүний нөөцийн удирдлага	-1.57	-1.22	-1.27	-1.35
Тоног төхөөрөмжийн чанар	-1.41	-1.12	-1.19	-1.24
Ажилчдын ур чадвар	-1.28	-1.19	-1.22	-1.23
Түүхий эдийн чанар	-1.37	-1.00	-1.24	-1.20

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

5. Санхүүжилт



Санхүүжилтийн анхны эх үүсвэр: ЖДҮ эрхлэгчдийн олонх нь гэр бүлийн хамтын хөрөнгөөр үйл ажиллагааны анхны хөрөнгө оруулалтаа хийж байсан бол 25% нь банкнаас зээл авч байжээ.

Санхүүжилтэнд хамрагдсан байдал: Түүвэр судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 60 орчим хувь нь урьд өмнө нь зээл болон бусад хэлбэрээр санхүүжилтэнд хамрагдаж байсан бол 40 гаруй хувь нь тодорхой шалтгаануудын улмаас санхүүжилт авч чадаагүй байна.

Санхүүжилт авч чадаагүй шалтгаан: Өнгөрсөн хугацаанд санхүүжилтэнд хамрагдаагүй ЖДҮ эрхлэгчдийн олонх нь өөрийн хөрөнгөөр санхүүждэг учир зээл авах хэрэгцээ өмнө нь тулгараагүй гэжээ.

Санхүүжилтийн эх үүсвэр: Өнгөрсөн хугацаанд үйл ажиллагаагаа эрхлэн явуулах болон бизнесээ өргөжүүлэх зорилгоор санхүүжилтэнд хамрагдсан 1,230 ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх нь банкны зээлд хамрагдсан байна.

Санхүүжилтийн зарцуулалт: ЖДҮ эрхлэгчид санхүүжилтээ эргэлтийн хөрөнгөд, бизнесийн үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд болон машин тоног төхөөрөмж худалдан авахдаа голлон зарцуулдаг байна.

Зээлээ эргэн төлөхөд үүсч буй хүндрэл: Зээлд хамрагдсан ЖДҮ-ийн зээлийн хүү өндөр, зээлийн хугацаа богино, зээлийн хэмжээ үйл ажиллагаа явуулахад хангалтгүй байдаг нь зээлээ эргэн төлөхөд хүндрэл учруулдаг гэж үзжээ.

Цаашид санхүүжилт авах хэрэгцээ: Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх хувь нь цаашид санхүүжилт авах хэрэгцээ байгаа гэж үзэж байна.

Шаардлагатай санхүүжилтийн хэмжээ, хүү, хугацаа: ЖДҮ эрхлэгчдийн талаас илүү хувьд нь 10-аас 50 сая төгрөгийн санхүүжилт шаардлагатай байгаа бөгөөд улсын хэмжээнд ЖДҮ эрхлэгчдийн хүсч буй хүүний дундаж хэмжээ нь 5.8% байна. Мөн ЖДҮ эрхлэгчдэд зориулсан зээлийн хугацааг 1-ээс дээш жилээр тогтоох нь тэдгээрийн бизнесд дэмжлэг үзүүлнэ гэжээ.

БҮЛГИЙН АГУУЛГА:

- ☐ Санхүүжилтийн анхны эх үүсвэр
- ☐ Санхүүжилтэнд хамрагдсан байдал
- ☐ Зээлээ эргэн төлөхөд тулгарч буй хүндрэл
- ☐ Зээлд хамрагдаж чадахгүй байгаа шалтгаан
- ☐ Санхүүжилтийн эх үүсвэр, зарцуулалт болон барьцаа хөрөнгийн шаардлага
- ☐ Санхүүжилтийн зарцуулалт
- ☐ Санхүүжилтээ эргэн төлөхөд тулгарч буй хүндрэл
- ☐ Санхүүжилт авах хэрэгцээ
- ☐ Хэрэгцээт санхүүжилтийн хүсч буй хүүний түвшин, зээлийн хэмжээ болон хугацаа

Төрөөс ЖДҮ-ийн талаар баримтлах бодлого, үндсэн чиглэлийг тогтоож, тэдгээрийн дэмжих талаар авах арга хэмжээний хүрээнд 2007 оны 7 дугаар сарын 27-ны өдөр “Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль”-ийг батлан гаргаж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Хуулийн 5 дугаар бүлгийн 15.1.4-т жижиг, дунд үйлдвэрийг санхүүгийн талаар дэмжих, тэдгээрийн өөрийн хөрөнгийн хангалттай байдлыг сайжруулах талаар тусгажээ.

ЖДҮ эрхлэгчдийг Төрийн зүгээс дэмжиж, холбогдох хууль эрх зүйн орчныг бүрдүүлсний үр дүнд ЖДҮ эрхлэгчид Төсөв-тусгай сан, Гадаад эх үүсвэр (ОУБ), Арилжааны банкны зээл зэрэг голлох 3 эх үүсвэрээс санхүүжиж байна.

Бүлэг 4-ийн 3-р хэсгийн Санхүүжилтийн орчны санал асуулгын дүнгээр ЖДҮ эрхлэгчдийн хувьд ОУБ болон ЗГ-ын хөнгөлөлттэй зээлийн олдоц муу байгаа нь санхүүжилт авахад хамгийн их хүндрэл үзүүлж байгаа бөгөөд санхүүжилтийн хүү, Хөрөнгийн зах зээлээс санхүүжилт авах боломж зэрэг нь дараах гол хүндрэлтэй үзүүлэлт болж байгаа нь харагдлаа.

2010 оны эцсийн байдлаар Бизнесийн регистрийн санд бүртгэлтэй, үйл ажиллагаа явуулж байгаа 40.9 мянган ААН байгаа бөгөөд, тэдгээрийн 30 орчим хувь нь тогтмол татвараа төлдөг нь ЖДҮ эрхлэгчдийн санхүүгийн байдал төдийлөн сайн биш байгааг илтгэж байна.


5.1. Санхүүгийн анхны эх үүсвэр

5.1.1. Нэгдсэн дүн

Түүвэр судалгаанд хамрагдсан нийт 2,227 ЖДҮ эрхлэгчдээс анх ямар төрлийн санхүүгийн эх үүсвэр ашиглан үйл ажиллагаа эхлүүлж байсныг нь тодруулан асуухад давхардсан тоогоор 60% нь гэр бүлийн хамтын хөрөнгөөр, 25% нь банкнаас зээл авах, 5% нь найз нөхдөөс зээлэх, 4% нь ЖДҮ-ийг дэмжих зориулалттай хөнгөлөлттэй зээлд хамрагдах замаар санхүүжиж байсан гэж хариуллаа /Зураг 5.1/.

Зураг 5.1 ЖДҮ эрхлэгчдийн санхүүгийн анхны эх үүсвэр

(ЖДҮ эрхлэгчдийн хариулсан нийт дүн, хувиар)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Дээрхээс харахад ЖДҮ эрхлэгчдийн талаас илүү хувь нь өөрийн хөрөнгөөр санхүүжиж байсан бол

үлдэх 40 орчим хувь нь бусад төрлийн санхүүгийн эх үүсвэрээс санхүүжилт авах замаар үйл ажиллагаагаа эхлүүлжээ.

5.1.2. Эдийн засгийн салбарын ангилал


Үйлдвэрлэл болон худалдааны салбарт үйл ажиллагаа эрхлэгчдийг үйлчилгээний салбарт үйл ажиллагаа эрхлэгчидтэй харьцуулахад санхүүгийн анхны эх үүсвэрээс банкнаас түлхүү (дунджаар 27%) авсан байна.

Үйлдвэрлэл эрхлэгчид бусад салбарт үйл ажиллагаа эрхлэгчидтэй харьцуулахад хөнгөлөлттэй зээлд хамрагдах замаар анхны хөрөнгө оруулалтаа түлхүү хийж байсан нь энэ төрлийн ЖДҮ-ийн үйл ажиллагаа эрхлэгчдийг түлхүү дэмждэгтэй холбоотой байж болох юм /Зураг 5.3/.

Үйлчилгээ болон худалдааны салбарт ЖДҮ эрхлэгчид үйлдвэрлэлийн салбартай харьцуулахад найз нөхдөөс зээл авч анхны хөрөнгө оруулалтаа хийж байсан хувь өндөр байгаа нь салбарын онцлогтой холбоотой байж болох талтай. Учир нь үйлчилгээ, худалдаа эрхлэхэд зарцуулах хугацаа үйлдвэрлэлийн салбартай харьцуулахад харьцангуй бага бөгөөд ихэвчлэн эргэлтийн хөрөнгөө санхүүжүүлдэгтэй холбоотой.

Зураг 5.2 ЖДҮ эрхлэгчдийн санхүүгийн анхны эх үүсвэр

(ЭЗ-н салбарын ангилал)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

ЖДҮ эрхлэгчдийн талаас илүү хувь нь гэр бүлийн хамтын хөнгөөр анхны хөрөнгө оруулалтаа хийж байсан бол 25% нь банкны зээлд хамрагдах замаар үйл ажиллагаагаа эхлүүлж байжээ. Эндээс дүгнэхэд ЖДҮ эрхлэхэд ихэвчлэн өөрийн хөрөнгөөр анхны хөрөнгө оруулалтаа хийдэг боловч банкны зээл голлох эх үүсвэрийг бүрдүүлдэг байна.

Бүлэг 4-ийн санхүүжилтийн хэсэгт санал асуулгад оролцсон ЖДҮ эрхлэгчид банкны зээлийн олдцыг бусад үзүүлэлттэй харьцуулахад боломжийн гэж дүгнэсэн нь манай орны ЖДҮ-ийн санхүүжилт авдаг хамгийн чухал санхүүгийн байгууллага нь арилжааны банк байдгийг баталж байна.

5.2. Өнгөрсөн хугацаанд санхүүжилтэнд хамрагдсан байдал

Улсын хэмжээнд нийт 2,226 ЖДҮ эрхлэгч судалгаанд хамрагдсанаас уг асуултанд 2,159 нь хариулж, 68 нь хариулаагүй байна. Судалгааны үр дүнгээр орон нутагт ЖДҮ эрхлэгчдийн 75% нь санхүүгийн үйлчилгээнд хамрагдаж байсан бол нийслэл хотын хувьд уг үзүүлэлт 40 орчим хувттай байна.

5.2.1. Нэгдсэн дүн

Санхүүжилт авсан байдал


Орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй ЖДҮ эрхлэгчдийн 840 буюу 75% нь урьд өмнө нь зээл авах болон бусад хэлбэрээр санхүүжилтэнд хамрагдаж байсан бол 287 буюу 25% нь тодорхой шалтгаануудын улмаас санхүүжилт авч байгаагүй байна. Харин Улаанбаатар хотын хэмжээнд ЖДҮ эрхлэгчдийн 390 буюу 38% нь зээл болон бусад хэлбэрийн санхүүжилтэнд хамрагдаж байсан бол 642 буюу 62% нь санхүүжилт авч байгаагүй гэж хариуллаа /Зураг 5.4/.

Түүвэр судалгааны үр дүнгээс харахад хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ЖДҮ эрхлэгчидэд санхүүжилт авах хэрэгцээ нийслэл хотын ЖДҮ эрхлэгчидтэй харьцуулахад харьцангуй өндөр байдаг нь ажиглагдлаа.

Өрхийн нийгэм, эдийн засгийн 2010 оны судалгааны дүнгээр хот, суурин газруудад ядуурал харьцангуй доогуур түвшинд байгаа бөгөөд ядуурлын түвшин хотод 39.2%, харин хөдөөд 47.8% байна. Хөдөө орон нутагт ядуурлын түвшин харьцангуй өндөр байгаа нь тэдэнд санхүүжилт авах хэрэгцээ өндөр байгааг илэрхийлж байна.

Зураг 5.3 ЖДҮ эрхлэгчдийн санхүүжилт авсан байдал

(ЖДҮ эрхлэгчдийн хариулсан нийт дүн, хувнар)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн


Санхүүжилт авдаг эх үүсвэр

Түүвэр судалгаанд хамрагдсан 2,227 ЖДҮ эрхлэгчдийн 1,230 буюу 57% нь өнгөрсөн хугацаанд үйл ажиллагаа эрхлэн явуулах болон бизнесээ өргөтгөх зорилгоор зээл болон бусад төрлийн санхүүжилтэд хамрагдаж байжээ. Давхардсан тоогоор тэдгээрийн 70% нь буюу дийлэнх хэсэг нь банкны зээл, 11% нь хөнгөлөлттэй зээл, 8% нь хамаатан болон найз нөхдөөс зээл авах замаар

санхүүжилт авч байжээ. Судалгааны үр дүнгээр ЖДҮ эрхлэгчид санхүүжилтээ голлон банкнаас авдаг нь харагдлаа /Зураг 5.4/.

Зураг 5.4 Санхүүжилтийн эх үүсвэрээ авсан байдал


(Асуулт 401-д ТИЙМ гэж хариулсан ЖДҮ эрхлэгчид, хувнар)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Бага болон тогтмол бус орлоготой, ядуу иргэдэд өөрсдийн аж ахуйг эрхлэх, хуримтлал үүсгэх, хэрэглээгээ тогтворжуулах зэрэг санхүүгийн бүхий л үйлчилгээ шаардагддаг. Тэд хэрэгцээт санхүүгийн үйлчилгээгээ төрөл бүрийн санхүүгийн харилцаан дээр тулгуурлан авдаг бөгөөд эдгээр нь гол төлөв ББСБ, Хадгаламж зээлийн хоршоо, ломбард болон хувь хүнээс өндөр өртгөөр зээлэх зэрэг албан бус харилцаа байдаг. Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 8% нь найз нөхдөөс, 4% нь ББСБ-аас, 3% нь борлуулагчаас зээлээр авах замаар санхүүгийн үйлчилгээ авч байжээ.

Шигтгээ 5.1. ЖДҮ эрхлэгчдэд олгосон зээл /тэрбум төгрөг/



Эх үүсвэр: Монголбанк,

Банкны салбарын хэмжээгээр 2010 оны эцсийн байдлаар зээлийн өрийн нийт үлдэгдэл 3.3 их наяд төгрөгт хүрлээ. Уг зээлийн 19.1%-ийг ЖДҮ эрхлэгч нийт 45.5 мянган иргэн, 2.5 мянган ААН-үүдэд олгосон байна. 2009 оны 3 дугаар улирлаас нийт зээлд эзлэх ЖДҮ эрхлэгчдийн зээлийн дүн 2010 оны 1 дүгээр улирлыг хүртэл 18.7%-иас 16.9% хүртэл буурсан нь эдийн засгийн хямралтай холбоотойгоор зээлийн багцын чанар муудаж, банкууд зээл олголтоо бууруулсантай холбоотой. Харин 2010 оны эхнээс эдийн засаг сэргэж эхэлсэн нь ЖДҮ эрхлэгч нарт олгох зээлийн хэмжээ тогтмол өсөхөд нөлөөлсөн. ББСБ болон ХЗХ-дын зээлийн нийт дүн 2010 оны эцсийн байдлаар 109.3 тэрбум төгрөгт хүрсэн нь банкны салбарын нийт зээлийн 3.3%, ЖДҮ эрхлэгчидэд олгосон банкны зээлийн 17.4%-ийг бүрдүүлээд байна.


Санхүүжилтийн зарцуулалт

ЖДҮ эрхлэгчид санхүүжилтийн 31%-ийг эргэлтийн хөрөнгө, 21%-ийг бизнесийн үйл ажиллагаа өргөжүүлэх, 18%-ийг машин тоног төхөөрөмж худалдан авах, 17%-ийг барилгаа өргөжүүлэх болон шинэ барилга худалдан авахад зарцуулдаг байна.

ЖДҮ эрхлэгчдийн талаас илүү хувь нь бизнесийн үйл ажиллагаагаа эрхлэх болон эргэлтийн хөрөнгөө санхүүжүүлэхэд зээл авдаг байна. Харин санхүүжилтийн багагүй хэсгийг (20 орчим хувь) тоног төхөөрөмж худалдан авахад зарцуулдаг нь судалгааны үр дүнгээр харагдлаа /Зураг 5.5/.

Зураг 5.5 Санхүүжилтийн зарцуулалт

(Санхүүжилтэнд хамрагдсан ЖДҮ эрхлэгчид, хувиар)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Барьцаа хөрөнгийн шаардлага

Санхүүжилтэнд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдээс зээлийн олгогчийн зүгээс ямар төрлийн барьцаа хөрөнгө шаардаж байсныг нь тодруулан асуухад дийлэнх буюу 65% нь үл хөдлөх хөрөнгө, 13% нь тээврийн хэрэгсэл гэсэн хариултыг өглөө /Зураг 5.6/.


Хөнгөлөлттэй зээлийн олдоч, санхүүжилтийн хүү, Хөрөнгийн зах зээлээс санхүүжилт авах боломж, санхүүжилтийн хугацаа болон санхүүжилтийн хэмжээ нь санхүүгийн орчны голлох хүндрэл болдог нь судалгааны үр дүнгээр харагдсан²⁶. Харин дээрх үзүүлэлтүүдийн дараах гол хүндрэл нь санхүүжилтийн барьцаа хөрөнгийн асуудал болж байна. Банкны зүгээс зээл олгохдоо бизнесийн төсөл, ирээдүйд орж ирэх мөнгөн урсгалаас илүүтэйгээр барьцаа хөрөнгийн шаардлагыг үндсэн шалгуур болгодог нь манай орны санхүүгийн зээл олгох харилцаа хангалттай сайн бүрдээгүй байгааг харуулж байна.

Төрийн бодлогоор ЖДҮ-ийг эрхлэгчдээ амжилттай дэмжиж байгаа Бүгд Найрамдах Хятад Ард улсын туршлагаар Бизнес инкубацийн биеэ даасан өндөр чадавхтай бүтцийг бий болгож зээлийн баталгаа олгох, их дээд сургуулиудын дэргэд Бизнес инкубатор төвийг ажиллуулах, жижиг бизнес эрхлэгчдийг дэмжих сургалтын баазыг байгуулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэн амжилттай ажиллаж байна. Иймд тэдний туршлагаар зээлийн

баталгаа олгох санхүүгийн үйлчилгээг нэвтрүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Зураг 5.6 Барьцаа хөрөнгийн шаардлага

(Зээлд хамрагдсан ЖДҮ эрхлэгчид, хувиар)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Санхүүжилт авч чадаагүй шалтгаан

Улсын хэмжээнд авч үзвэл түүвэр судалгаанд хамрагдсан 2,227 ЖДҮ эрхлэгчдийн 43% буюу 929 нь өнгөрсөн хугацаанд үйл ажиллагаагаа эрхлэн явуулах болон бизнесээ өргөжүүлэх зорилгоор санхүүжилт авч байгаагүй гэж хариуллаа. Тэдгээрээс ямар шалтгааны улмаас санхүүжилтэнд хамрагдаагүйг нь тодруулан асуухад 254 буюу 27 % нь зээл авах нөхцлийг хангасан боловч зээлийн үндсэн нөхцөл хатуу байсан, 91 буюу 10% нь зээл авах хэрэгцээ байгаа хэдий ч зээл авах үндсэн нөхцлийг хангаж чадаагүйн улмаас зээлд хамрагдаагүй гэж хариулжээ. Харин санхүүжилтэд хамрагдаж байгаагүй ЖДҮ эрхлэгчдийн 557 буюу 60% нь бизнесийн үйл ажиллагаагаараа /өөрийн эх үүсвэрээр/ санхүүждэг учир зээл авах хэрэгцээ тулгарч байгаагүй гэжээ /Зураг 5.7/.

Зураг 5.7 ЖДҮ эрхлэгчдийн санхүүжилт аваагүй шалтгаан

(Асуулт 401-д ҮГҮЙ гэж хариулсан ЖДҮ эрхлэгчид, хувиар)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

5.2.2. Эдийн засгийн салбарын ангилал

Санхүүжилт авсан байдал


Салбарын ангиллаар авч үзвэл өнгөрсөн хугацаанд үйлдвэрлэл эрхлэгчид 68%, худалдаа эрхлэгчид 60%, үйлчилгээ эрхлэгчид 48%-тай санхүүжилт авч байсан үр дүн гарлаа. Эндээс харахад үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа эрхлэгчдэд санхүүжилтийн хэрэгцээ бусад салбарын ЖДҮ эрхлэгчтэй

²⁶ Бүлэг 4-ийн 3 хэсэг, Санхүүжилтийн орчин.

харьцуулахад харьцангуй өндөр байна. Харин үйлчилгээний салбарт үйл ажиллагаа эрхлэгчид бусад салбартай харьцуулахад харьцангуй бага зээлд хамрагдсан үр дүн ажиглагдаж байна /Зураг 5.8/.

Зураг 5.8 ЖДҮ эрхлэгчдийн санхүүжилт авсан байдал

(ЭЗ-ийн салбарын ангилал)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Санхүүжилт авдаг эх үүсвэр


Үйлдвэрлэл, үйлчилгээ болон худалдааны салбарт үйл ажиллагаа эрхлэгчдийн банкнаас санхүүжилт авдаг хувь ойролцоо буюу дунджаар 70%-тай байгаа нь ЖДҮ эрхлэгчдийн санхүүгийн гол эх үүсвэр арилжааны банк байгааг харууллаа.

Харин үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа эрхлэгчдийн 16% хөнгөлттэй зээлд хамрагдсаныг бусад салбарт үйл ажиллагаа эрхлэгчидтэй харьцуулахад дунджаар 8 орчим нэгж хувиар өндөр байна. Төрөөс ЖДҮ эрхлэгчдийн үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа эрхлэгчдийг түлхүү дэмждэг нь судалгааны үр дүнгээр харагдаж байна.

Худалдааны салбарт үйл ажиллагаа эрхлэгчдийн борлуулагчаас зээл авдаг хувь бусад салбаруудтай харьцуулахад өндөр байна /Зураг 5.9/.

Зураг 5.9 Санхүүжилтийн эх үүсвэрээ авсан байдал

(Эдийн засгийн салбарын ангилал)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Санхүүжилтийн зарцуулалт

Үйл ажиллагаа эрхэлж буй эдийн засгийн салбараас үл хамааран санхүүжилтийн зарцуулалтын 30 орчим хувийг эргэлтийн хөрөнгөдөө түлхүү хэрэглэгдэг байна.


Үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа эрхлэгчид машин тоног төхөөрөмжинд санхүүжилтийн 24%-ийг зарцуулдаг нь бусад салбартай харьцуулахад өндөр үзүүлэлт болж байна. Түүнчлэн санхүүжилтийн 20 орчим хувийг бизнесээ өргөжүүлэхэд ашигладаг нь харагдлаа.

Үйлчилгээний салбарт үйл ажиллагаа эрхлэгчдийн хувьд санхүүжилтийн 23%-ийг бизнесээ өргөжүүлэх үйл ажиллагаанд, 18%-ийг тоног төхөөрөмжинд зарцуулдаг байна.

Харин худалдааны салбарт үйл ажиллагаа эрхлэгчид санхүүжилтийн 20%-ийг бизнесээ өргөжүүлэх, 11%-ийг барилгаа өргөтгөх үйл ажиллагаанд зарцуулдаг бөгөөд 10%-ийг тээвэрлэлт хийх машин худалдан авахад зарцуулдаг гэжээ /Зураг 5.10/.

Зураг 5.10 Санхүүжилтийн зарцуулалт

(Эдийн засгийн салбарын ангилал)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Санхүүжилт авч чадаагүй шалтгаан

Санхүүжилтэнд яагаад хамрагдаагүйг нь тодруулан асуухад бүх салбарт үйл ажиллагаа эрхлэгчид дунджаар дунджаар 60%-тай өөрийн эх үүсвэрээр санхүүждэг гэж харуулсан нь бусад шалтгаантай харьцуулахад харьцангуй өндөр үзүүлэлт юм.

Зураг 5.11 ЖДҮ эрхлэгчдийн санхүүжилт аваагүй шалтгаан

(ЭЗ-ийн салбарын ангилал)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Харин санхүүжилтэнд хамрагдаагүй дараах гол шалтгаан нь бүх салбарт үйл ажиллагаа эрхлэгчдийн хувьд зээлийн нөхцөл хатуу буюу дунджаар 30 орчим хувьтэй хариуллаа. Үүн дотроос үйлдвэрлэл эрхлэгчдийн хувьд зээлийн үндсэн нөхцөл хүнд

байгаагийн улмаас зээлд хамрагдах боломжгүй гэж хариулсан хувь үйлчилгээ болон худалдааны салбарынхантай харьцуулахад 10 орчим нэгж хувиар өндөр байна. Зээлийн нөхцөл хүнд гэж үзсэн шалтгаан нь үйлдвэрлэл эрхлэн явуулахад урт хугацаа шаардагддаг, зээлийн эргэн төлөлт тодорхой хугацааны дараа эхэлдэг, нэлээд хугацааны дараагаар үйлдвэрлэл ашигаа өгдөг, урт хугацаанд зах зээлийн тодорхойгүй байдлаас шалтгаалж бизнесийн эрсдэл өндөр байдаг, технологийн хоцрогдолд орох, ажиллах хүчний зардал тогтвортой бус байдаг болон бизнес төлөвлөгөө боловсруулах зэрэг нарийн тооцоо шаардсан олон хүчин зүйлс шаардагддагаас шалтгаалсан байдаг /Зураг 5.11/. Эдгээр шалтгааны улмаас үйлдвэрлэл эрхэлж буй ЖДҮ-ийнхэнд бусад салбаруудтай харьцуулахад зээлийн хэрэгцээ шаардлага өндөр байдаг боловч зээлийн үндсэн нөхцөл хатуу байдаг байх талтай юм.

5.2.3. Аймаг, нийслэл хот


Санхүүжилт авсан байдал

Түүвэр судалгааны үр дүнгээр Увс, Дархан-Уул, Сүхбаатар болон Сэлэнгэ²⁷ аймгуудад санхүүжилтэнд хамрагдсан хувь (85%-иас дээш) бусад аймгуудаас харьцангуй өндөр байна.

Харин Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй ЖДҮ эрхлэгчдийн хувьд уг үзүүлэлт 38%-тай буюу хамгийн бага дүнтэй байна. Нийслэл хоттой үнэлгээний хувьд ойролцоо буюу санхүүжилтэнд харьцангуй бага хувьтай хамрагдсан аймгуудад Ховд, Төв болон Өмнөговь аймгууд багтаж байна /Зураг 5.12/.

Зураг 5.12 ЖДҮ эрхлэгчдийн санхүүжилт авсан байдал

(Аймаг, нийслэл хот)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Санхүүжилт авдаг эх үүсвэр

Увс аймаг бусад аймагтай харьцуулахад ЖДҮ эрхлэгчдийн санхүүжилтэнд хамрагдсан байдал хамгийн өндөр байгаа бөгөөд тус аймгийн ЖДҮ

²⁷ Хөдөө орон нутагт олгогдсон нийт зээлийн хэмжээ 2011 оны 1-р улирлын байдлаар 805.8 тэрбум төгрөг байгаа бөгөөд Дархан-Уул, Орхон болон Сэлэнгэ аймгууд зээл олгосон нийт хэмжээ бусад аймгуудтай харьцуулахад хамгийн өндөр байна (дунджаар 70 тэрбум төгрөг).


эрхлэгчдийн дийлэнх буюу 86% нь банкнаас зээл авсан гэж хариулжээ /Зураг 5.13/.

Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхлэгчдийн 65% нь банкнаас зээл авч, 11% нь хувь хүнээс зээлж, 7% нь ББСБ-аас зээл авч санхүүгийн үйлчилгээ авсан гэж хариулжээ.

Түүвэр судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх хувь (60-аас 70%) эрхэлж буй газар зүйн байршлаасаа үл хамааран банкны зээлээр гол санхүүжилтээ хийдэг нь судалгааны үр дүнгээр харагдлаа.

Зураг 5.13 Санхүүжилтийн эх үүсвэрээ авсан байдал

(Аймаг, нийслэл хот)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Санхүүжилтийн зарцуулалт

Судалгааны үр дүнгээс харахад нийслэл хот, Сэлэнгэ, Өмнөговь, Увс болон Өвөрхангай аймгуудад ЖДҮ эрхлэгчид санхүүжилтийн 35 орчим хувийг эргэлтийн хөрөнгөд зарцуулдаг бол Дорнод, Хэнтий болон Дорноговь аймгуудад бизнесээ өргөжүүлэхэд санхүүжилтийн 30 орчим хувийг, харин Өвөрхангай аймагт машин тоног төхөөрөмжинд санхүүжилтийн 33%-ийг зарцуулдаг нь бусад аймгуудтай харьцуулахад харьцангуй өндөр үзүүлэлт юм /Зураг 5.14/.

Зураг 5.14 Санхүүжилтийн зарцуулалт

(Аймаг, нийслэл хот)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Санхүүжилт авч чадаагүй шалтгаан

Сүхбаатар, Дундговь, Төв аймаг болон Улаанбаатар хотод өөрийн эх үүсвэрээр санхүүждэг учир санхүүжилт авах хэрэгцээ байгаагүй гэж хариулсан хувь (60%-иас дээш) бусад аймгуудтай харьцуулахад харьцангуй өндөр байна. Харин Өмнөговь, Ховд, Булган болон Өвөрхангай аймгуудад зээл авах хэрэгцээ өнгөрсөн хугацаанд байсан хэдий ч зээлийн нөхцөл хүнд байгаагийн улмаас зээлд хамрагдаж чадаагүй гэж хариулсан ЖДҮ эрхлэгчдийн хувь (50%-иас дээш) бусад аймагтай харьцуулахад илүү дүн юм /Зураг 5.15/.

Зураг 5.15 ЖДҮ эрхлэгчдийн санхүүжилт аваагүй шалтгаан

(Аймаг, нийслэл хот)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

5.3. ЖДҮ-ийн санхүүжилттэй холбоотой үүсч буй хүндрэл

5.3.1. Нэгдсэн дүн

Зээлээ эргэн төлөхөд тулгарч буй хүндрэл

Зээлд хамрагдаж байсан болон зээлтэй байгаа ААН-үүдийн хувьд давхардсан тоогоор 35% нь зээлийн хүүний төлбөр өндөр, 27% нь зээлийн хугацаа богино, 15% нь зээлийн үндсэн хэмжээ бага байгаа нь бизнес эрхлэхэд хүндрэл учруулж байна гэж үзжээ. Харин 19% нь зээлээ эргэн төлөхөд ямар нэг хүндрэл учирдаггүй буюу зээлийн нөхцөл боломжийн гэж хариуллаа /Зураг 5.16/

Зураг 5.16 Зээл эргэн төлөхөд тулгарч буй бэрхшээл

(Зээлтэй ЖДҮ эрхлэгчид, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Зээлийн үндсэн нөхцөл хатуу

Өнгөрсөн хугацаанд зээл авах эрмэлзэлтэй байсан хэдий ч зээлийн нөхцөл хатуу байгаагийн улмаас зээл авч чадаагүй 452 (түүврийн 27%) ЖДҮ эрхлэгчдээс зээлийн нөхцөл ямар шалтгааны улмаас хүнд байгааг нь тодруулан асуухад 37% нь зээлийн хүү өндөр, 24% нь зээлийн хугацаа богино болон 19% нь барьцаа хөрөнгийн үнэлгээ бодитой бус байдаг учраас зээл аваагүй гэж хариуллаа /Зураг 5.17/.

Зураг 5.17 Зээлийн үндсэн нөхцөл хатуу


(Зээлийн нөхцөл хатуу гэж үзсэн ЖДҮ эрхлэгчид, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Зээлд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 35% нь зээлийн хүүний өртөг өндөр, зээлийн үндсэн нөхцөл хатуу гэж үзсэний улмаас зээлд хамрагдаагүй бизнес эрхлэгчдийн 37% нь зээлийн хүү өндөр байгаагаас зээл авах боломжгүй байна гэж үзсэн нь зээлийн хүү ЖДҮ эрхлэгчдийн багагагүй хэсэгт дарамт учруулдаг гэж дүгнэж болохоор байна.

Шигтгээ 5.2. Банкны зээлийн хүү



Эх үүсвэр: Монголбанк,

Зээлийн хүү 2007 оны эхнээс 2009 оныг хүртэл буурч байсан боловч эдийн засагт хямрал нүүрлэсэнтэй холбоотойгоор 2009 оны 1-р улирлаас 3-р улирал хүртэл огцом өссөн. Монголбанкны зүгээс зээлийн хүүг бууруулах эдийн засгийн таатай орчинг бүрдүүлэх арга хэмжээнүүдийг авч байгаа болон эдийн засаг сэргэж байгаагаар холбоотойгоор зээлийн хүү хурдацтай буурч зээлийн жигнэсэн дундаж хүү улсын хэмжээнд 17.9% хүрлээ.

Орон нутагт олгогдож буй зээлийн хүү улсын дундаж хүүнээс дунджаар 4%-иар илүү байгаа нь нэг талаас хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхлэгчдийн бизнес эрхлэх зардал өндөр, нөгөө талаас хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлдэг банкны салбарууд эх үүсвэр зардал өндөр байдаг нь орон нутаг, улсын дундаж хүүний зөрүү өндөр байхад нөлөөлдөг байна..

Зээл авах нөхцөлийг хангаагүй

Өнгөрсөн хугацаанд зээл авах хүсэлтээ зээл олгогчдод гаргасан хэдий ч зээлийн шаардлагыг хангаж чадаагүйн улмаас санхүүжилтэнд хамрагдаагүй 91 ЖДҮ эрхлэгчид байна. Тэдгээрээс ямар шалтгааны улмаас зээл авч чадаагүйг нь тодруулахад давхардсан тоогоор 28% нь барьцаа хөрөнгийн хүрэлцээ муу, 23% нь тогтмол орлогогүй болон тогтмол орлогоо батлах баримтгүй, 15% нь эрхэлж буй бизнесийн эрсдэл өндөр байгаагийн улмаас зээл авч чадаагүй гэж хариуллаа /Зураг 5.18/.

Түүвэр судалгааны үр дүнгээс харахад зээлд хамрагдаж чадахгүй байгаа ЖДҮ эрхлэгчдийн хамгийн том хүндрэл нь барьцаа хөрөнгийн бэрхшээл байна. Санхүүжилтийн зайлшгүй хэрэгцээ байгаа хэдий ч барьцаа хөрөнгөгүй, бизнесийн эрсдэл өндөр, тогтмол орлогогүй буюу орлогоо батлах баримтгүйн улмаас зээлд хамрагдаж чадахгүй байгаа эмзэг бүлгийн ЖДҮ эрхлэгчдийн тогтвортой үйл ажиллагааг дэмжих, цаашлаад тэдгээрийн амьжиргааг дээшлүүлэх зорилгоор зээлийн батлан даалтын байгууллага буюу барьцаа хөрөнгийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээг нэвтрүүлэх нь чухал байна.

Зураг 5.18 Зээлд хамрагдаж чадаагүй шалтгаан

(Зээлийн авах нөхцлийг хангаагүй ЖДҮ эрхлэгчид, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

5.3.2. Эдийн засгийн салбарын ангиллаар

Зээлээ эргэн төлөхөд тулгарч буй хүндрэл

Эдийн засгийн салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаагаас үл хамааран бүхий л ЖДҮ эрхлэгч нарт зээлээ эргэн төлөхөд зээлийн хүүний төлбөр өндөр (*дунджаар 35%*), зээлийн хугацаа богино (*дунджаар 27%*) байдаг нь зээлээ эргэн төлөхөд тулгардаг нийтлэг хүндрэл болж байна.


Худалдааны салбарт үйл ажиллагаа эрхлэгчид бусад салбаруудтай харьцуулахад зээлээ эргэн төлөхөд хүндрэл тулгарахгүй байна гэж хамгийн өндөр буюу 23%-тай хариуллаа. Энэ нь худалдааны салбарын бараа бүтээгдэхүүний эргэлт хурдан, хэрэглэгчид олон байдагтай холбоотой байж болох юм.

Үйлчилгээний салбарт үйл ажиллагаа эрхлэгчдийн хувьд зээлийн хугацаа богино байгаа нь зээлээ эргэн төлөхөд хүндрэл үзүүлж байна гэж бусад салбартай харьцуулахад ялимгүй өндөр үр дүн гарлаа.

Үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа эрхлэгчдийн хувьд бусад салбаруудтай харьцуулахад зээлийн хүүний дарамт харьцангуй бага байна гэж үзсэн бол зээлийн үндсэн хэмжээ бага байгаа нь үйл ажиллагаа явуулахад хүндрэл болдог нь бусад салбаруудтай харьцуулахад өндөр байна. Үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа эрхлэгчдийн хувьд бусад салбартай харьцуулахад тоног төхөөрөмж, барилга болон эргэлтийн хөрөнгө зэрэг санхүүжилтийн хэрэгцээ тулгардаг нь уг үр дүн гарахад нөлөөлсөн байх талтай юм /Зураг 5.19/.

Зураг 5.19 Зээл эргэн төлөхөд тулгарч буй бэрхшээл

(Эдийн засгийн салбарын ангилал)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Зээлийн үндсэн нөхцөл хатуу


Бүхий л салбарт үйл ажиллагаа эрхлэгчдийн хувьд зээлийн хүү өндөр, зээлийн хугацаа богино, барьцаа хөрөнгийн үнэлгээ бодитой бус байгаа нь зээлийн үндсэн нөхцөл хатуу гэж үзэхэд хүргэж, улмаар зээл авахгүй байх шийдвэрт тэдгээрийг хүргэж байна.

Худалдааны салбарт үйл ажиллагаа эрхлэгчдийн хувьд зээлийн хугацаа богино, барьцаа хөрөнгийн үнэлгээ бодит бус болон зээл олгох үйл ажиллагаа чирэгдэлтэй байдаг зэрэг хүндрэлүүдийг бараг ижил түвшинд хариулсан байна.

Үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа эрхлэгчид үйлчилгээ болон худалдааны салбарынхантай харьцуулахад зээлийн хүү өндөр байгаа нь зээлд хамрагдаж чадахгүй байгаагийн гол шалтгаан гэж үзжээ. Түүнчлэн зээлийн хүүний дараах гол хүндрэл нь зээлийн хугацаа богино, барьцаа хөрөнгийн үнэлгээ бодитой бус гэж хариуллаа /Зураг 5.20/.

Зураг 5.20 Зээлийн үндсэн нөхцөл хатуу

(Эдийн засгийн салбарын ангилал, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Зээл авах нөхцлийг хангаагүй


Үйлчилгээ эрхлэгчид барьцаа хөрөнгөгүйн улмаас зээлд хамрагдаж чадаагүй гэж бусад салбартай харьцуулахад хамгийн өндөр буюу 32%-тай хариуллаа.

Үйлдвэрлэл эрхлэгчдийн хувьд тогтмол орлогогүй бөгөөд орлогоо батлах баримтгүйн улмаас зээлд

хамрагдаж чадахгүй байгаа хүндрэл нь бусад салбартай харьцуулахад өндөр байна. Бусад хүндрэлүүдийн хувьд салбарын ангиллаас үл хамааран улсын дундаж үзүүлэлтэй ижил хандлага ажиглагдлаа /Зураг 5.21/.

Зураг 5.21 Зээлд хамрагдаж чадаагүйн шалтгаан

(Эдийн засгийн салбарын ангилал, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

5.3.3. Аймаг, нийслэл хот

Зээлээ эргэн төлөхөд тулгарч буй хүндрэл


Зээлээ эргэн төлөхөд ямар нэг хүндрэл тулгараагүй гэж Сүхбаатар, Сэлэнгэ, Өмнөговь, Завхан болон Дархан-уул аймгийн ЖДҮ эрхлэгчид 24-ээс 29%-тай буюу хамгийн өндөр хувьтай хариуллаа.

Харин зээлийн хүүний төлбөр өндөр байгаа бизнес эрхлэхэд дэмжлэг үзүүлэхгүй байна гэж Увс, Орхон болон Дархан-Уул аймгийн ЖДҮ эрхлэгчид илүүтэй хариулжээ.

Зээлийн хугацаа хэт богино байгаа нь зээлийн дарамтыг үүсгэж байна гэж Дундговь, Өвөрхангай болон Төв аймагт үйл ажиллагаа эрхлэгч ААН-үүд 33-аас 38%-тай хариуллаа /Зураг 5.22/.

Зураг 5.22 Зээлээ төлөхөд тулгарч буй бэрхшээл

(Аймаг, нийслэл хот)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

5.4. Цаашид санхүүжилт авах хэрэгцээ, зээлийн үндсэн нөхцөл

5.4.1. Нэгдсэн дүн


Цаашид санхүүжилт авах хэрэгцээ

Түүвэр судалгаанд хамрагдсан 2,227 ААН, иргэдийн 1,516 буюу 68% нь үйл ажиллагаа эрхлэхэд нь цаашид санхүүжилтийн зайлшгүй хэрэгцээ байна гэж үзлээ. Харин 619 буюу 28% нь санхүүжилт авах шаардлагагүй гэж үзсэн бол 92 буюу 4% нь мэдэхгүй гэж хариуллаа /Зураг 5.23/.

Эндээс дүгнэхэд ЖДҮ эрхлэгчдийн 70 орчим хувь нь санхүүгийн бэрхшээлтэй тулгарч байдаг бөгөөд тэдгээрт тодорхой хэмжээний санхүүгийн хэрэгцээ үүсч байна.

Зураг 5.23 Санхүүжилт авах хэрэгцээ

(Улсын хэмжээнд, хувиар)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн


Санхүүжилт авах төлөвлөж буй эх үүсвэр

Цаашид санхүүжилтийн хэрэгцээ зайлшгүй байгаа гэж үзсэн 1,516 ЖДҮ эрхлэгчдийн 44% нь банкнаас зээл авах замаар санхүүжих хүсэлтэй байгаа бол 38% нь хөнгөлөлттэй зээлд хамрагдах эрмэлзэлтэй байна. Харин борлуулагчаас зээлээр бараа бүтээгдэхүүн авах, гэр бүл найз нөхдөөс зээлэх, зах зээлд хувьцаа гаргах замаар санхүүжих төлөвлөгөөтэй ЖДҮ эрхлэгчид харьцангуй цөөн буюу дунджаар 3%-тай байна.

Судалгааны үр дүнгээр ЖДҮ эрхлэгчид санхүүжилтийн эх үүсвэрээ банкнаас авах хандлага хадгалагдаж байгаа нь манай орны санхүүгийн системд банк хамгийн том санхүүгийн зуучлагчийн үүрэг гүйцэтгэж холбоотой юм. Түүнчлэн ЖДҮ эрхлэгчид хөнгөлөлттэй зээлд хамрагдах хүсэл өндөр байгаа нь уг судалгаагаар харагдлаа /Зураг 5.24/.

Зураг 5.24 Санхүүжилтээ хаанаас авах байдал

(Санхүүжилт авахаар төлөвлөж буй ЖДҮ эрхлэгчид, хувиар)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн


Санхүүжилтийн зарцуулалт төлөвлөлт

ЖДҮ эрхлэгчид хэрэгцээтэй байгаа гэж үзсэн санхүүжилтийн эх үүсвэрийн 31%-ийг эргэлтийн хөрөнгө, 12%-ийг бизнесийн үйл ажиллагаа өргөжүүлэх, 18%-ийг машин тоног төхөөрөмж худалдан авах, 23%-ийг барилгаа өргөжүүлэх болон шинэ барилга худалдан авах, 7%-ийг ажилчдаа сургахад зарцуулах төлөвлөгөөтэй байна.

Энэхүү зарцуулалтын хувь ЖДҮ эрхлэгчдийн өнгөрсөн хугацааны санхүүжилтийн зарцуулалттай бараг ижил байна. Өөрөөр хэлбэл ЖДҮ эрхлэгчдэд эргэлтийн хөрөнгөө санхүүжүүлэх, тоног төхөөрөмж худалдан авахад санхүүжилтийн эх үүсвэр хамгийн хэрэгцээтэй байдаг байна /Зураг 5.25/.

Зураг 5.25 Санхүүжилтийн зарцуулалт

(Санхүүжилт авахаар төлөвлөж буй ЖДҮ эрхлэгчид, хувиар)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Шаардлагатай санхүүжилтийн хэмжээ


Түүвэр судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 34% нь 10-аас 50 хүртэлх сая төгрөгийн санхүүжилт бизнесийн үйл ажиллагаа явуулахад нь шаардлагатай байгаа бол 15% нь 5-аас 10 хүртэлх, 19% нь 50-иас 100 хүртэлх сая төгрөгийн санхүүжилт хэрэгцээтэй байна. Нэг ЖДҮ эрхлэгчид хэрэгцээтэй байгаа санхүүжилтийн дундаж хэмжээ нь ойролцоогоор 73.0 сая төгрөг байна.

Шаардлагатай санхүүжилтийн хэмжээг ЖДҮ эрхлэгч иргэн болон ААН-ийн хувьд авч үзэхэд иргэдийн 51%-д нь 1-ээс 10 хүртэлх сая төгрөгийн санхүүжилт хэрэгцээтэй байгаа бол 30%-д нь 10-аас 50 сая төгрөгийн санхүүжилт шаардлагатай байна. Харин ААН-ийн 32%-д нь 10-аас 50 хүртэлх сая төгрөгийн, 46%-д нь 50-н сая төгрөгөөс дээш санхүүжилт шаардлагатай байна. Дээрхээс харахад ЖДҮ эрхлэгч

иргэдийн хүсч буй санхүүжилтийн дундаж хэмжээ нь 36.0 орчим сая төгрөг, ААН-ийн хувьд уг үзүүлэлт 100.0 орчим сая төгрөг байгаа юм /Зураг 5.26/.

Зураг 5.26 Санхүүжилтийн хэмжээ

(Шаардлагатай санхүүжилтийн хэмжээ, хувнар)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Шаардлагатай санхүүжилтийн хугацаа

Ирээдүйд санхүүжилт шаардлагатай байгаа ЖДҮ эрхлэгчдийн тэн хагас орчим нь буюу 45% нь 5-аас дээш жилийн санхүүгийн эх үүсвэр хэрэгцээтэй байна гэж үзжээ. Харин санхүүжилт шаардлагатай байгаа ЖДҮ эрхлэгчдийн 30% нь 3-аас 5 жил хүртэлх, 19% нь 1-ээс 3 хүртэлх жилийн хугацаатай санхүүжилтийн эх үүсвэр шаардлагатай байна гэсэн үр дүн гарлаа /Зураг 5.27/.

Зураг 5.27 Санхүүжилтийн хугацаа

(Шаардлагатай санхүүжилтийн хугацаа, хувнар)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Шаардлагатай санхүүжилтийн хүү

Түүвэр судалгааны үр дүнгээр цаашид санхүүжилт авах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн ЖДҮ эрхлэгчдийн хүсч буй хүүний дундаж хэмжээ 5.8% байна. Уг хүсч буй хүүний хэмжээ нь Төсөв, тусгай сангийн эх үүсвэрээр олгогдож байгаа хөнгөлөлттэй зээлийн хүүнээс ойролцоогоор 2 дахин бага байна.

Судалгааны үр дүнгээр санхүүжилтэнд хамрагдах хүсэлтэй ЖДҮ-ийн 30 орчим хувь нь цаашид хүүгүй зээлд хамрагдах хүсэлтэй байгаагаа илэрхийлсээ байна. Энэ нь хөнгөлөлттэй зээлийн санхүүгийн эх үүсвэр хангалттай хүрэлцээгүй байгаагийн өнөөдрийн нөхцөлд боломжгүй хүсэлт билээ.


Харин зээлийн хүү 10-аас 15%-тай байх нь тэдгээрийн бизнес хийх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ гэж 15% нь үзлээ. Зээлийн хүү 5-аас 10%-тай

байх нь зээл авахад тохиромжтой хэмжээ гэж судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 31% нь хариуллаа.

Эндээс дүгнэхэд санхүүжилтийн бодит хэрэгцээ байгаа ЖДҮ эрхлэгчдийн тал хувь нь хөнгөлөлттэй зээлийн хүүг 5-аас 15% байх нь тохиромжтой гэж үзсэн нь байна. Үйлдвэрлэл эрхлэгчдийг үйл ажиллагааны онцлогоос нь хамааруулж ЖДҮ эрхлэгчдэд олгох хөнгөлөлттэй зээлийн хүүг 5-аас 15%-ийн хооронд тогтоох боломжтой юм. Өөрөөр хэлбэл үйлдвэрлэл эрхлэгч нарын хөнгөлөлттэй зээлийн хүүг 5%-аас 10%, үйлчилгээ болон худалдааны салбарт үйл ажиллагаа эрхлэгчдийн хөнгөлөлттэй зээлийн хүүг 10-аас 15%-иар тогтоох боломжтой нь судалгааны үр дүнгээс харагдлаа.

Зураг 5.28 Санхүүжилтийн хүү

(Шаардлагатай санхүүжилтийн хүү, хувнар)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

5.5. Дүгнэлт

Түүвэр судалгааны үр дүнгээс харахад хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ЖДҮ эрхлэгчдэд санхүүжилт авах хэрэгцээ нийслэл хотын ЖДҮ эрхлэгчидтэй харьцуулахад харьцангуй өндөр байна. Энэ нь хөдөө орон нутагт хоттой харьцуулахад ядуурал, ажилгүйдлийн түвшин харьцангуй өндөр байгаатай холбоотой юм.

Түүвэр судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн талаас илүү хувь эрхэлж буй газар зүйн байршил, үйл ажиллагааны салбарын ангиллаас үл хамааран банкны зээл авах замаар санхүүжилтийн хэрэгцээгээ хангадаг байна. Уг санхүүжилтийн талаас илүү хувийг бизнесийн үйл ажиллагаа болон эргэлтийн хөрөнгөө санхүүжүүлэхэд зарцуулдаг нь ажиглагдлаа.

Хөнгөлөлттэй зээлийн олдоц, санхүүжилтийн хүү, Хөрөнгийг зах зээлээс санхүүжилт авах боломж, санхүүжилтийн хугацаа болон санхүүжилтийн хэмжээ нь санхүүгийн орчны голлох хүндрэл болдог нь судалгааны үр дүнгээр харагдсан²⁸.

Зээлд хамрагдаж байсан болон зээлтэй байгаа ААН-үүдийн хувьд зээлийн хүүний төлбөр өндөр, зээлийн хугацаа богино, зээлийн үндсэн хэмжээ бага байгаа нь бизнес эрхлэхэд хүндрэл учруулж байна. Харин зээлээ эргэн төлөхөд ямар нэг хүндрэл учирдаггүй буюу зээлийн нөхцөл боломжийн гэж зээлтэй байгаа ЖДҮ эрхлэгчдийн 20 орчим хувь нь хариуллаа. 2008 оны эцсийн байдлаар ЖДҮ эрхлэгчдийн 35 орчим хувь нь тогтмол татвар төлдөг гэсэн үр дүн гарсан байдаг. Эндээс харахад ЖДҮ-ийн 30 орчим хувийх нь үйл ажиллагаа тогтворжиж, тогтвортой орлого олдог байх магадлалтай байна.

Өнгөрсөн хугацаанд зээл авах эрмэлзэлтэй байсан хэдий ч зээлийн нөхцөл хүнд байгаагийн улмаас зээл авч чадаагүй ЖДҮ (27%) эрхлэгчдээс зээлийн нөхцөл ямар шалтгааны улмаас хүнд байгааг нь тодруулан асуухад зээлийн хүү өндөр, зээлийн хугацаа богино болон барьцаа хөрөнгийн үнэлгээ бодитой бус байдаг учраас зээл аваагүй гэж хариуллаа.

Зээл авах хүсэлтээ зээл олгогчдод гаргасан хэдий ч зээлийн шаардлагыг хангаж чадаагүйн улмаас санхүүжилтэнд хамрагдаж чадаагүй багагүй тооны ЖДҮ эрхлэгчид байна. Тэдгээрээс ямар шалтгааны улмаас зээл авч чадаагүйг нь тодруулахад барьцаа хөрөнгийн хүрэлцээ муу, тогтмол орлогогүй болон тогтмол орлогоо батлах баримтгүй, эрхэлж буй бизнесийн эрсдэл өндөр байгаагийн улмаас зээл авч чадаагүй гэж хариуллаа.

Түүвэр судалгааны үр дүнгээс харахад зээлд хамрагдаж чадахгүй байгаа ЖДҮ эрхлэгчдийн хамгийн том хүндрэл нь барьцаа хөрөнгийн бэрхшээл байна. Санхүүжилтийн зайлшгүй хэрэгцээ

байгаа хэдий ч барьцаа хөрөнгөгүй, бизнесийн эрсдэл өндөр, тогтмол орлогогүй буюу орлогоо батлах баримтгүйн улмаас зээлд хамрагдаж чадахгүй байгаа эмзэг бүлгийн ЖДҮ эрхлэгчдийн тогтвортой үйл ажиллагааг дэмжих, цаашлаад тэдгээрийн амьжиргааг дээшлүүлэх зорилгоор зээлийн батлан даалтын байгууллага буюу барьцаа хөрөнгийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээг нэвтрүүлэх нь чухал байна.

Түүвэр судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх буюу 70% нь үйл ажиллагаа эрхлэхэд нь цаашид санхүүжилтийн зайлшгүй хэрэгцээ байгаа гэж үзсэн бол 30 орчим хувь нь санхүүжилт авах шаардлагагүй гэжээ. Эндээс дүгнэхэд ЖДҮ эрхлэгчдийн 70 орчим хувь нь санхүүгийн бэрхшээлтэй тулгарч байдаг бөгөөд тэдгээрт тодорхой хэмжээний санхүүгийн хэрэгцээ үүсч байна.

Цаашид санхүүжилтийн хэрэгцээ байгаа ЖДҮ эрхлэгч иргэдийн 51%-д нь 1-ээс 10 хүртэлх сая төгрөгийн санхүүжилт хэрэгцээтэй байгаа бол ААН-ийн 32%-д нь 10-аас 50 хүртэлх сая төгрөгийн, 46%-д нь 50-н сая төгрөгөөс дээш санхүүжилт шаардлагатай байна.

ЖДҮ эрхлэгчдийн хүсч буй хүүний дундаж хэмжээ 5.8% байгаа нь хөнгөлөлттэй зээлийн хүүнээс 2 дахин бага үзүүлэлт юм. Санхүүжилтийн хэрэгцээ тулгарсан ЖДҮ эрхлэгчдийн тал хувь нь хөнгөлөлттэй зээлийн хүүг 5-аас 15% байх нь тохиромжтой гэж үзсэн байна. Эдгээр ЖДҮ эрхлэгчдийг үйл ажиллагаа эрхэлж буй салбарын онцлогоос хамааруулж хүүг тогтоох нь зүйтэй юм. Жишээ нь үйлдвэрлэл эрхлэгч нарын хөнгөлөлттэй зээлийн хүүг 5%-аас 10%, үйлчилгээ болон худалдааны салбарт үйл ажиллагаа эрхлэгчдийн хөнгөлөлттэй зээлийн хүүг 10-аас 15%-иар тогтоох боломжтой юм.

²⁸ Бүлэг 4-ийн 3 хэсэг, Санхүүжилтийн орчин.

Монголбанк МЕК ХХК-тай хамтран 2011 оны 3 дугаар сарын 9-ний өдрөөс 4 дүгээр сарын 10-ны өдөр хүртэлх хугацаанд ЖДҮ эрхлэгчдийн дунд “Монгол улс дахь ЖДҮ-ийн хөгжлийн өнөөгийн байдал, түүний санхүүжилт”-ийн талаар санал асуулга явуулж үр дүнг нэгтгэн танилцууллаа.

Энэхүү судалгаанд нийслэл хотын бүх дүүргүүд болон 21 аймаг хамрагдсан бөгөөд нийт 2,227 ЖДҮ эрхлэгч аж ахуйн нэгж (ХК, ХХК, нөхөрлөл, хоршоо), иргэд оролцов. Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн ихэнх нь худалдааны салбарт үйл ажиллагаа явуулдаг, дотоодын хөрөнгө оруулалттай, 1-9 хүртэлх ажилчидтай, 1-10 жил үйл ажиллагаа эрхэлж буй, жилийн 50 хүртэлх сая төгрөгийн борлуулалтын орлоготой бөгөөд дийлэнх нь түүхий эдээ нийслэл хотоос авч, бараа үйлчилгээгээ нийслэл хот болон үйл ажиллагаагаа эрхэлж буй аймагтай борлуулж, нийт зардлын дийлэнх нь түүхий эд, цалингийн зардалд зарцуулагддаг ААН, иргэд байв.

ЖДҮ-ийн хөгжилд Засгийн газар, Олон улсын байгууллагууд, Санхүүгийн байгууллагууд болон Төрийн бус байгууллагуудын оролцоо, дэмжлэг чухал үүрэг гүйцэтгэдэг. Санал асуулгад оролцсон ЖДҮ эрхлэгчдийн зүгээс тэднийг хамгийн ихээр дэмжиж буй байгууллагуудаар:

- Арилжааны банкууд,
- Засгийн газар,
- Орон нутгийн засаг захиргаа тодорсон байна.

Эдгээр байгууллагуудаас голчлон санхүүжилт олгох, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, сургалт, зөвлөгөө явуулах, татварыг хөнгөвчлөх (татвар, НӨАТ-аас чөлөөлсөн) замаар дэмжлэг үзүүлдэг байна. Эдийн засгийн салбаруудаар ангилж харвал ХАА, үйлдвэрлэлийн салбарт бусад салбаруудаас илүү ихээр дэмжлэг авдаг байна. ЖДҮ эрхлэгчдийн зүгээс цаашид нэн түрүүнд:

- Төрийн байгууллагын үйлчилгээг чирэгдэлгүй болгох,
- Санхүүжилтийн хөнгөлөлттэй, хангалттай эх үүсвэрийг бүрдүүлэх,
- Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих,
- Татварын таатай орчинг бий болгох,
- Авилгалыг бууруулах зэрэг арга хэмжээнүүдийг бодлогын түвшинд авч хэрэгжүүлэх шаардлагатай байна гэж үзжээ.

Бизнес эрхлэхэд (ЖДҮ эрхлэхэд) макроэдийн засгийн байдал, нийгмийн өөрчлөлт, хууль эрх зүйн орчин, дэд бүтцийн хөгжил, санхүүжилтийн эх үүсвэр, зах зээлийн байдал, зардал болон бизнес эрхлэгчдийн өөрсдийн ур чадвар зэрэг олон хүчин зүйлс нөлөөлдөг.

Түүвэр судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх нь ЖДҮ эрхлэх эдийн засгийн таатай орчин хангалттай бүрдээгүй гэж үзсэн нь манай улсад бизнес эрхлэх орчин, боломж муу байгааг харуулж байна. Аравны нэг орчим хувь нь бизнес эрхлэн явуулах эдийн засгийн боломж бүрдсэн гэж үзсэн нь ЖДҮ эрхлэгч иргэд, ААН-ийн маш бага хэсгийн үйл ажиллагаа харьцангуй хэвийн тогтвортой ажиллаж байгаа гэж дүгнэж болохоор байна. Эдийн засгийн өсөлтийн үр шим ЖДҮ эрхлэгчдийн 30 хувьд нь л хүртээмжтэй байгаагаас үзэхэд нийгэмд бүрэлдэж буй баялаг түүний хуваарилалтын тогтолцоо тэгш бус байгааг гэрчилж байна. Түүнчлэн санал асуулгад оролцогчид инфляцийн түвшин доогуур тогтвортой, төгрөгийн ханш бага зэргийн чангаралттай хэлбэлзэл багатай байх нь тэдгээрийн бизнест эерэг нөлөө үзүүлнэ гэжээ.

Нийгмийн зүгээс ЖДҮ-ийн хөгжилд ядуурал болон ажилгүйдэл хамгийн гол бэрхшээл болж байна. Ядуурал, ажилгүйдлийн түвшин өндөр байгаа нь нэг талаас хэрэглэгчдийн худалдан авах чадвар сул байгааг харуулах бөгөөд үүнээс шалтгаалж ЖДҮ эрхлэгчдийн борлуулалт хангалттай түвшинд хийгдэхгүйд хүрч, урт хугацаанд эргэлтийн хөрөнгөөр дутагдах, хэрэв зээлтэй бол зээлийн эргэн төлөлтийн дарамтанд орох зэрэг санхүүгийн хүндрэлүүдтэй тулгарах магадлалтай. Нөгөө талаас ядуурал, ажилгүйдэл нийгэмд өндөр байгаагаас ЖДҮ эрхлэгчдийн тодорхой хэсэг нь санхүүжилт авах барьцаа хөрөнгө, баталгаа байхгүй байгааг нотолж байна. Хээл хахууль, гэмт хэрэг болон улс төрийн тогтворгүй байдал нь ЖДҮ-ийн хөгжилд багагүй саад болж байгаа нь санал асуулгын дүнгээс харагдлаа.

Монгол улсад ЖДҮ эрхлэхэд хамгийн их саад бэрхшээл учруулж байгаа хүчин зүйл нь хөгжиж буй улсуудын нэгэн адил санхүүжилтийн орчин буюу:

- Хөнгөлттэй зээлийн олдоц хомс,
- Зээлийн үндсэн нөхцөл хатуу (хүү өндөр, хэмжээ бага, хугацаа богино),
- Хөрөнгийн зах зээлийн хөгжил сул,
- Барьцаа хөрөнгө, баталгаа байхгүй зэрэг болж байна.

Олон улсын байгууллагууд, Засгийн газраас дамжуулан олгож буй хөнгөлттэй зээлийн хэмжээ нь ЖДҮ-ийг бүрэн санхүүжүүлэх хэмжээнд хүрч чадахгүй (бүрэн санхүүжүүлэх боломж ч байхгүй биз дээ) байгаагийн зэрэгцээ ЖДҮ эрхлэгчдийн хүсээд байгаа бага хүүтэй, дунд болон урт хугацаатай, бизнес эрхлэхэд хангалттай хэмжээтэй санхүүжилтийн эх үүсвэрийг өнөөгийн байдлаар манай банк, санхүүгийн байгууллагууд олгох боломжоор тааруухан байна. Хөрөнгийн зах зээлийн хөгжил сул (ялангуяа орон нутагт огт хөгжөөгүй) байгаагаас шалтгаалж бизнес эрхлэгчид өөрсдийн

хөрөнгө, техник, технологи дээр тулгуурлан мөнгө босгох боломжоор хязгаарлагдмал байгаагийн зэрэгцээ ажилгүйдэл, ядуурал их байгаа учир санхүүжилт авах барьцаа хөрөнгө, баталгааны асуудал хүндрэлтэй хэвээр байна.

Хууль, эрх зүй, зохицуулалтын орчин нь ЖДҮ-ийн хөгжилд хамгийн чухал хүчин зүйлсийн нэг бөгөөд манай улсад олон жилийн турш ЖДҮ-ийн хөгжлийг нэгдсэн цогц бодлогоор дэмжих, эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлага тавигдаж ирсний үр дүнд 2007 онд “ЖДҮ-ийн тухай хууль”-ийг УИХ-аар анх батлан гаргаж, Засгийн газрын зүгээс бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэхээр анхааран ажиллаж байгаа билээ. Гэсэн хэдий ч санал асуулгын дүнгээр манай улсын хууль эрх зүйн ерөнхий орчныг “муу” гэж дүгнэсэн байна. Ялангуяа төрийн байгууллагын үйлчилгээ “хамгийн муу” бөгөөд тууштай ил тод байдаггүй, хяналт шалгалтын дарамт хэт их байдаг нь харагдлаа. Үүнээс гадна хууль, эрх зүй татварын тогтолцоо мөн “муу” гэсэн үнэлгээг авсан нь татвар төлөгчдөд очих татварын дарамт төдий чинээ өндөр бөгөөд энэ хэрээр татвараас зайлсхийх үзэгдэл их гарч болзошгүй нь судалгааны дүнгээр харагдлаа.

Зах зээлийн зүгээс бизнес эрхлэгчдэд учруулж буй хамгийн хүндрэлтэй асуудал нь шударга бус өрсөлдөөн болж байна. Эндээс зах зээлд шударга бусаар оролцож, өрсөлдөөнд харш үйл ажиллагаа явуулдаг ААН, иргэд нийгэмд байсаар байгаа бөгөөд нөгөө талаар өрсөлдөөнийг хянан зохицуулах үүрэг бүхий байгууллагын ажлын үр дүнг харуулж байгаа юм. Үүнээс гадна зах зээлийн багтаамж бага, мөн даатгалын тогтолцоо сул байгааг судалгаанд оролцогчид онцолж байна.

Бизнес эрхлэхэд чухал хүчин зүйлсийн нэг нь дэд бүтцийн асуудал байдаг. Судалгааны дүнгээр манай улсын дэд бүтцийн байдлыг бага зэрэг муу гэсэн ч бусад бизнесийн орчны хүчин зүйлстэй харьцуулахад хамгийн боломжийн гэж үзжээ. Дэд бүтцийн орчин дотроо тээврийн хөгжлийг хамгийн муу байна гэж үзсэн бөгөөд дулаан, усан хангамжийн асуудал үүний дараа орж байна. Харин цахилгаан хангамж болон мэдээлэл холбооны хөгжил харьцангуй сайн үнэлгээг авчээ. Тоо баримтаас харвал үүрэн холбоо, интернет хэрэглэгчдийн тоо сүүлийн жилүүдэд мэдэгдэхүйц нэмэгдэж, бүх аймгуудад тэдгээрийн сүлжээ нэвтэрсэн нь мэдээлэл холбооны хөгжил харьцангуй сайн үнэлгээ авах гол шалтгаан нь болж байна.

Бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд ямар зардал, хэрхэн хүндрэл учруулж буйг олж тогтоох нь цаашдын бодлого боловсруулалтанд ихээхэн ач холбогдолтой билээ. Судалгааны үр дүнгээр ЖДҮ эрхлэгч нарт зардлуудаас зээлийн хүү, шимтгэл хураамжийн төлбөр, тоног төхөөрөмжинд зарцуулах зардал болон түрээсийн зардал зэрэг үзүүлэлтүүд

хамгийн их хүндрэл учруулдаг нь харагдаж байна. Ялангуяа зээлийн хүүний зардал хамгийн их хүндрэлтэй байгаа нь цаашдын санхүүжилтийг олгох болон тэдгээрийн бизнесийн үйл ажиллагаанд ихээхэн сөрөг үр дагавар үзүүлж байна. Мөн шимтгэл хураамжийн төлбөр хүндрэлтэй гэж үзсэн нь тусгай зөвшөөрөл, лицензийг авах шат дамжлага зарцуулах хугацааны хувьд хэт их байдгийг батлан харууллаа. Хэдийгээр ЖДҮ эрхлэх зориулалт бүхий тоног төхөөрөмжийг импортын татвараас чөлөөлсөн хэдий ч судалгааны дүнгээр тоног, төхөөрөмжийн зардал нь хүндрэлтэй хэвээр байгаа нь бизнес эрхлэгчдийн санхүүгийн чадавхи муудсаар байгааг илтгэж байна.

Судалгааны дүнгээр ЖДҮ эрхлэгчдийн ихэнхи нь санхүүжилтийн анхны эх үүсвэрээ гэр бүлийн хөрөнгөөр босгодог бөгөөд 4-ний нэг нь банкнаас зээл авч анхны санхүүжилтээ авсан байна. Судалгаанд оролцогчдын талаас илүү нь урьд нь зээл болон бусад хэлбэрээр санхүүжилт авсан бол үлдэж буй бизнес эрхлэгчдийн ихэнх нь зээлийн хэрэгцээ байгаагүй бөгөөд зарим нь зээлийн нөхцөл хангаагүй, хангасан боловч банкны зээлийн нөхцлийг хэт хатуу байна гэж үзсэний улмаас санхүүжилт аваагүй байна. Урьд нь санхүүжилтэнд хамрагдсан бизнес эрхлэгчдийн дийлэнх нь банкны зээлээр санхүүжсэн байхад үлдсэн нь хөнгөлөлттэй зээл, гэр бүлийн хөрөнгөөр санхүүжсэн байна. Судалгаанд оролцогчид авсан санхүүжилтээ эргэлтийн хөрөнгөө санхүүжүүлэх, үйл ажиллагаагаа өргөжүүлэх, машин тоног төхөөрөмж худалдан авах зэрэгт ихэвчлэн зарцуулдаг байна. Харин зээлээ эргэн төлөхөд хүү хэт өндөр, хугацаа богино, хэмжээ бага гэсэн хүндрэлүүд тулгарч байна. Мөн судалгаанд оролцогчдын ихэнх нь цаашид санхүүжилтийн хэрэгцээ байгаа бөгөөд 10-50 сая төгрөгийн хэмжээтэй, дунджаар жилийн 5.8 хувийн хүүтэй, нэгээс дээш жилийн хугацаатай зээл тохиромжтой гэж үзжээ.

Судалгааны үр дүнг нэгтгэж дүгнэхэд ЖДҮ-ийг банкны салбар болон Засгийн газрын зүгээс санхүүжилт олгох, сурталчлах зэргээр багагүй дэмжлэг үзүүлдэг хэдий ч хөгжлийн түвшин нь ерөнхийдөө доогуур хэвээр байна. ЖДҮ эрхлэгчдийн зүгээс манай улсад бизнес хийх таатай орчин бүрдээгүй гэж үзэж байгаагийн зэрэгцээ нийгэмд ядуурал, ажилгүйдэл, хээл хахууль, гэмт хэрэг, улс төрийн тогтворгүй байдал нүүрлэж байгаа нь тус салбарын хөгжилд сөрөг нөлөө үзүүлж байна гэжээ. Мөн хөнгөлөлттэй санхүүжилтийн эх үүсвэр хомс, төрийн байгууллын үйлчилгээ муу, зээлийн нөхцөл хатуу, зам тээврийн хөгжил тааруу байгаа нь сэтгэл зовоосон асуудлууд болж байна. ЖДҮ эрхлэгчдийн зүгээс Төрийн байгууллагууд дахь хүнд суртал, дарамт шахалт, авилгалыг арилгаж, хөнгөлөлттэй санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэн, импортыг орлох үндэсний үйлдвэрлэлийг дэмжиж өгвөл ЖДҮ хөгжинө гэж үзэж байна.

Улаанбаатар хот


1. Ерөнхий мэдээлэл

Улаанбаатар хотод 2011 оны 1 дүгээр улирлын байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа 26144²⁹ ААН-ээс санамсаргүй түүврийн аргаар 1032 жижиг дунд бизнес эрхлэгчийг судалгаанд хамрууллаа. Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 77% нь ХХК, 20% нь иргэд, 1% нь нөхөрлөл, 1% нь хоршоо байсан бөгөөд тэдгээрийн 91% нь дотоодын хөрөнгө оруулалттайгаар үйл ажиллагаагаа явуулдаг байна.

Улаанбаатар хотод судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 45% нь үйлчилгээ, 33% нь худалдаа, 22% нь худалдаа эрхэлдэг гэжээ. Аймгуудын судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчидтэй харьцуулбал үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгчдийн хувийн жин 9 нэгж хувиар бага, үйлчилгээнийх 8 нэгж хувиар их, худалдааных ойролцоо хувьтай сонгогдсон байна.

Зураг 1 ЖДҮ эрхлэгчдийн үйл ажиллагааны чиглэл

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Улаанбаатар хотоос судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 40% нь 1-5 жил, 28% нь 5-10 жил, 19% нь 10-аас дээш жил, 13% нь 1 жил хүртэл үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд тэдгээрийн 68% нь 10 хүртэл, 27% нь 10-49, 3% нь 50-99, 1% нь 100-149, 1% нь 150-199 ажиллагсадтай ЖДҮ-үүд байна.

Улаанбаатар хотын хувьд түүвэр судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн давхардсан тоогоор 78% нь үйл ажиллагаа эрхэлж буй хотоосоо, 30% нь гадаадаас түүхий эд, материалаа бэлтгэдэг бөгөөд эцсийн бүтээгдэхүүнээ 81% нь өөрийн хотдоо, 20-оод % нь улсын хэмжээнд борлуулдаг гэж хариулжээ. Улсын хэмжээнд бүтээгдэхүүнээ борлуулдаг гэсэн хариултын хувийн жин аймгуудын дунджаас 13 нэгж хувиар илүү байв.

Хүснэгт 1 Түүхий эд материалын бэлтгэл, бараа бүтээгдэхүүний борлуулалт

(Бусад аймаг болон УБ хоттой харьцуулсан дүн, давхардсан тоогоор, хувь)


Байршил	Түүхий эд бэлтгэл		Борлуулалт	
	Улаанбаатар	Аймгууд	Улаанбаатар	Аймгууд
Нийслэл хот		55		9
У/а эрхэлж буй аймаг	78	45	81	82
Бусад аймаг	6	8	4	13
Гадаад улс	30	27	5	3
Улсын хэмжээнд			19	6

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Улаанбаатар хотын судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 39% нь 1-10 сая, 26% нь 10-50 сая төгрөгийн жилийн борлуулалтын орлоготой гэжээ. Бусад аймгуудын дундаж үзүүлэлттэй харьцуулахад 1-10 сая төгрөгийн жилийн борлуулалтын орлоготой гэсэн хариултын хувийн жин 9 нэгж хувиар их, 10-50 сая төгрөг гэсэн хариултынх ойролцоо үзүүлэлттэй байна.

Зураг 2 ЖДҮ эрхлэгчдийн жилийн борлуулалтын орлого

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Түүвэр судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 77% нь тайлан тэнцэл гаргадаг гэсэн хариулт өгсөн нь аймгуудын дунджаас 12 нэгж хувиар их үзүүлэлттэй байна.

2. ЖДҮ-ийг дэмжих бодлогын арга хэмжээ

ЖДҮ эрхлэгчдийн бизнесийг хамгийн их дэмждэг байгууллагыг нэрлэнэ үү гэсэн асуултанд Улаанбаатар хотын санал асуулганд оролцсон ЖДҮ эрхлэгчдийн 42% нь мэдэхгүй гэсэн хариултыг өгсөн нь бусад аймгуудын хариултаас ялгаатай байлаа. Харин мэдэхгүй гэснээс өөрөөр хариулсан ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх (судалгаанд хамрагдагсдын 25%) арилжааны банкыг хамгийн их ЖДҮ-үүдийг дэмждэг гэжээ. Үүний дараагаар Засгийн газар (10%), төрийн бус байгууллагууд (7%), олон улсын байгууллагууд (7%), худалдаа аж үйлдвэрийн тэнхим (7%), үйлдвэр эрхлэгчдийн холбоо (6%), зөвлөгөө өгдөг, байгууллага, төвүүд (4%)-ийг нэрлэжээ.

²⁹ Бизнес регистрийн санд бүртгэлтэй

Зураг 3 ЖДҮ эрхлэгчдийг хамгийн ихээр дэмждэг байгууллага

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

ЖДҮ эрхлэгчдэд ямар нэг дэмжлэг үзүүлдэггүй гэж судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 38% хариулсан нь бусад аймгуудын хариултаас ялгаатай байв. Харин дэмжлэг үзүүлдэг байгууллагуудаас санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгосон (27%), сургалт зөвлөгөө зохион байгуулсан (10%), үзэсгэлэн худалдаа зохион байгуулсан байгуулсан (9%), эрх зүйн таатай орчинг бүрдүүлсэн (6%), ЖДҮ-ийн тоног төхөөрөмжийг НӨАТ-аас чөлөөлсөн (5%) гэж хариулсан байна. Дэмжлэгүүдийг дурдсан байдал нь аймгуудын хандлагатай төстэй өөрөөр хэлбэл санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлсэн, үзэсгэлэн худалдаа зохион байгуулсан, сургалт зөвлөгөө явуулсан гэсэн хариулт илүү сонгогдсон байна.

Зураг 4 ЖДҮ-д ямар дэмжлэг үзүүлсэн

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

ЖДҮ-ийг хөгжүүлэхэд төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох, татварын таатай орчинг бүрдүүлэх, авлигыг бууруулах, үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, хөнгөлөлттэй

санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгох, хүртээмжийг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээг нэн түрүүнд авах шаардлагатай гэж үзжээ.

Зураг 5 Цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

3. Макро эдийн засгийн орчин

Улаанбаатар хотоос санал асуулгад оролцсон ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх эдийн засгийн таатай орчин хангалттай бус гэж бусад аймгуудын нэг адил үзжээ. Мөн огт бүрдээгүй гэсэн хариултын хувийн жин аймгуудынхаас нэлээд их байлаа.

Хүснэгт 2 ЖДҮ хөгжих эдийн засгийн таатай орчин бүрдсэн эсэх

(Бусад аймаг болон УБ хоттой харьцуулсан дүн, давхардсан тоогоор, хувь)

ЖДҮ хөгжих орчин	Улаанбаатар	Аймгуудын дундаж
Бүрдсэн	8	10
Хангалттай бус	61	71
Огт бүрдээгүй	23	12
Мэдэхгүй	9	6

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Улаанбаатар хотоос судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 43% нь эдийн засгийн өсөлт өөрсдийн бизнест сөргөөр, 18% нь эергээр, 21% нь нөлөөлөөгүй гэж хариулсан бөгөөд аймгуудын хариултаас ялгаатай хариулт байлаа. Аймгуудын хувьд эерэгээр нөлөөлж байна гэсэн хариулт хамгийн их хувьтай байв.

Хүснэгт 3 ЖДҮ хөгжилд эдийн засгийн өсөлтийн үзүүлж буй нөлөө

(Бусад аймаг болон УБ хоттой харьцуулсан дүн, давхардсан тоогоор, хувь)

Эдийн засгийн өсөлт танай бизнест	Улаанбаатар	Аймгуудын дундаж
Эергээр	18	24
Сөргөөр	43	22
Нөлөөлөөгүй	21	19
Мэдэхгүй	18	16

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Санал асуулгад оролцогчдын 40 гаруй % нь инфляци болон төгрөгийн ханш тогтвортой байвал эрхэлж буй бизнест нь сайн гэж үзсэн байна. Мөн 30% нь инфляцийн түвшин буурвал сайн, 23% нь төгрөгийн ханш өсвөл сайн гэж хариулсан байна.

4. Бизнесийн орчин

Улаанбаатар хотын судалгаанд оролцсон ЖДҮ эрхлэгчид бизнесийн орчинд бусад аймгуудтай ижил ерөнхийдөө сөрөг үнэлгээг өгсний зэрэгцээ зах зээлийн орчин болон өөрсдийн дотоод байдалдаа өгсөн үнэлгээнээс бусад үнэлгээ илүү муу үзүүлэлттэй байв. Зах зээлийн орчин, дотоод орчны үнэлгээ аймгуудын дундажтай ойролцоо байлаа.

Санал асуулгад оролцогчид санхүүжилтийн орчинг муу боломжийн гэсэн үнэлгээний хооронд дүгнэв. ОУ-ын байгууллагын болон ЗГ-ын хөнгөлөлттэй зээлийг бусад аймгуудын адил муу гэж үнэлсэн нь санхүүжилтийн орчноос хамгийн муу үнэлгээ байлаа. Бусад үзүүлэлтүүдийн ихэнхэд нь муу боломжийн үнэлгээний дунджаар үнэлсэн ба үзүүлэлт бүрээрээ аймгуудын дундаж үнэлгээнээс доогуур үнэлгээтэй байв. Ялангуяа банкны зээл, зээл олгох явцын үнэлгээ аймгуудынхаас илүү муу байлаа.

Хүснэгт 4 Санхүүжилтийн орчин

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Санхүүжилтийн орчин	Улаан-баатар	Аймгуудын дундаж
ОУ-ын байгууллагын хөнгөлөлттэй зээлийн олдоц	-1.02	-1.01
Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн олдоц	-1.01	-0.93
Санхүүжилтийн хүү	-0.67	-0.63
Хөрөнгийн зах зээлээс санхүүжилт авах	-0.61	-0.55
Санхүүжилтийн хугацаа	-0.57	-0.52
Санхүүжилтийн барьцаа хөрөнгө	-0.56	-0.41
Зээл олгох үйл ажиллагаа	-0.53	-0.16
Санхүүжилтийн хэмжээ	-0.51	-0.47
Зээлийн батлан даалт	-0.49	-0.29
Банкны зээл	-0.49	0.04
Банк бус санхүүгийн байгууллагын зээл	-0.48	-0.32
Өөрийн хөрөнгийн хүрэлцээ	-0.43	-0.40

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Хууль, эрх зүйн зохицуулалтын орчинд Улаанбаатарчууд муу боломжийн үнэлгээний хооронд муу тал руу нь илүү дүгнэжээ. Гадаад худалдаа хийх нөхцөлд муу боломжийн үнэлгээнээс боломжийн үнэлгээг арай түлхүү өгсөн бөгөөд аймгуудын дунджаас бага зэрэг сайн байсан бол бусад үзүүлэлтүүдэд муу үнэлгээ түлхүү өгсний дээр үзүүлэлт бүрээрээ аймгуудын дундаж үнэлгээнээс муу үзүүлэлттэй байлаа.

Хүснэгт 5 Хууль эрх зүйн орчин

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Хууль, эрх зүйн зохицуулалтын орчин	Улаан-баатар	Аймгуудын дундаж
Төрийн байгууллагын үйлчилгээ	-0.75	-0.57
Хууль, эрх зүйн орчин	-0.65	-0.44
Газар эзэмших	-0.60	-0.31
Татварын тогтолцоо	-0.56	-0.43
Хяналт, шалгалтын тогтолцоо	-0.52	-0.32
Гадаад худалдаа хийх нөхцөл	-0.43	-0.48

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Зах зээлийн орчинг нийслэлийнхэн бусад аймгуудын адил боломжийн муу үнэлгээний хооронд боломжийн тал руу нь дүгнэжээ. Технологийн дэвшилд өгсөн үнэлгээ энэ бүлгээс хамгийн сайн үнэлгээтэй байсан бөгөөд боломжийн үнэлгээтэй илүү ойрхон байв. Бусад үзүүлэлтүүдийн үнэлгээ хоорондоо ойролцоо байсан бөгөөд аймгуудын үнэлгээнээс төдийлөн их зөрүүгүй бага зэрэг ялгаатай байв. Тухайлбал шударга өрсөлдөөнд өгсөн үнэлгээ бага зэрэг доогуур үнэлгээтэй байсан бол бусад үзүүлэлтүүдийнх бага зэрэг дээгүүр үнэлгээтэй байлаа.

Хүснэгт 6 Зах зээлийн орчин

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Зах зээлийн орчин	Улаан-баатар	Аймгуудын дундаж
Шударга өрсөлдөөн	-0.44	-0.40
Зах зээлийн багтаамж	-0.37	-0.40
Даатгалын үйлчилгээ	-0.37	-0.40
Хэрэглэгчдийн худалдан авах чадвар	-0.36	-0.43
Технологийн дэвшил	-0.20	-0.34

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Дэд бүтцэд өгсөн үнэлгээ бусад бүлгүүдээс хамгийн сайн үнэлгээтэй байсан бөгөөд Улаанбаатарчууд ерөнхийдөө боломжийн гэж дүгнэсэн байна. Ялангуяа мэдээлэл холбооны хөгжилд хамгийн сайн үнэлгээг өгчээ. Харин зам, тээврийн хөгжилд өгсөн үнэлгээний муу үнэлгээ нь боломжийн үнэлгээнээсээ арай их байсан бөгөөд аймгуудын дундаж үнэлгээнээс доогуур үзүүлэлттэй байлаа. Дулаан, ус, цахилгаан хангамжийн үнэлгээний боломжийн үнэлгээ муу үнэлгээнээсээ илүү байсан ба аймгуудын дундаж үнэлгээнээс дулаан хангамжийн үнэлгээ дээгүүр, цахилгаан хангамжийнх арай муу үзүүлэлт байв.

Хүснэгт 7 Дэд бүтэц

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Дэд бүтцийн байдал	Улаан-баатар	Аймгуудын дундаж
Зам, тээврийн хөгжил	-0.68	-0.54
Дулаан, усан хангамж	-0.25	-0.40
Цахилгаан хангамж	-0.10	-0.02
Мэдээлэл холбооны хөгжил	0.15	0.32

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

5. Дотоод орчин

ЖДҮ эрхлэгчид өөрсдийн дотоод орчиндоо бага хүндрэлтэй, хүндрэлтэй гэсэн үнэлгээг өгсөн бөгөөд бага хүндрэлтэй гэсэн үнэлгээ нь түлхүү өгөгджээ. Улаанбаатарчуудын хувьд хамгийн хүндрэлтэй нь хүний нөөцийн удирдлага, түүхий эдийн чанар байсан бөгөөд аймгуудынхаас ажилчдын чадварыг арай бага хүндрэлтэй гэж үзсэнээрээ ялгаатай байв.

Хүснэгт 8 Дотоод орчин

(Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4)

Дотоод орчин	Улаанбаатар	Аймгуудын дундаж
Хүний нөөцийн удирдлага	-1.38	-1.21
Түүхий эдийн чанар	-1.30	-1.10
Тоног төхөөрөмжийн чанар	-1.20	-1.11
Ажилчдын чадвар	-1.13	-1.25

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

6. Зардлын байдал

Зардлуудад бага хүндрэлтэй, хүндрэлтэй гэсэн үнэлгээг түлхүү өгчээ. Хамгийн хүндрэлтэй зардлуудад зээлийн хүүний, шимтгэл хураамжийн, түрээсийн, зам тээврийн, тоног төхөөрөмжийн, түүхий эдийн, зар сурталчилгааны зардлуудыг оруулсан нь ерөнхийдөө аймгуудын хандлагатай төстэй байв. Зар сурталчилгаа, харилцаа холбоо, түрээс, захиргаа, үйл ажиллагааны зардал Улаанбаатарчуудын хувьд аймгуудынхаас илүү хүндрэлтэй гэж дүгнэгдсэн байна.

Хүснэгт 9 Зардлын байдал

(Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4)

Зардлын байдал	Улаанбаатар	Аймгуудын дундаж
Зээлийн хүүний зардал	-1.89	-1.82
Шимтгэл, хураамжийн төлбөр	-1.78	-1.71
Түрээсийн зардал	-1.74	-1.47
Зам, тээврийн зардал	-1.62	-1.58
Тоног төхөөрөмжийн зардал	-1.62	-1.62
Түүхий эдийн зардал	-1.62	-1.59
Зар сурталчилгааны зардал	-1.57	-1.10
Дулаан, усны зардал	-1.49	-1.51
Эрчим хүч, цахилгааны зардал	-1.48	-1.50
Захиргаа, үйл ажиллагааны зардал	-1.42	-1.24
Ажиллах хүчний өртөг	-1.41	-1.37
Харилцаа холбооны зардал	-1.25	-0.92

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

7. Нийгмийн орчин

Улаанбаатарчууд хамгийн их сөрөг үнэлгээг нийгмийн орчинд өгсөн бөгөөд үүнээс ядуурал, ажилгүйдэл, хээл хахууль, гэмт хэрэг, улс төрийн байдалд их хүндрэлтэй, хүндрэлтэй, харилцагчийн ёс суртахуунд хүндрэлтэй, хувийн хэвшлийн оролцоо, мэдээллийн хүртээмжинд хүндрэлтэй, бага хүндрэлтэй гэсэн хариултыг түлхүү өгчээ.

Ерөнхийдөө аймгуудын дундаж үнэлгээтэй хандлага нь төстэй байгаа ч илүү муу үнэлгээтэй байна.

Хүснэгт 10 Нийгмийн орчин

(Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4)

Нийгмийн орчин	Улаанбаатар	Аймгуудын дундаж
Ядуурал	-2.77	-2.48
Ажилгүйдэл	-2.75	-2.49
Хээл хахууль	-2.72	-2.27
Гэмт хэрэг	-2.67	-2.13
Улс төрийн байдал	-2.46	-2.08
Харилцагчийн ёс суртахуун	-2.00	-1.65
Хувийн хэвшил, иргэдийн оролцоо	-1.91	-1.48
Мэдээллийн хүртээмж	-1.78	-1.53


Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

8. Санхүүжилт

Үйл ажиллагаагаа эхлүүлэхдээ нийслэл хотоос судалгаанд оролцсон ЖДҮ эрхлэгчдийн 60% нь өөрийн хөрөнгөөр, 23% нь гэр бүлийн хамтын хөрөнгөөр, 17% нь банкны зээлээр, 10% нь найз нөхдийн хамтын хөрөнгөөр, 4% нь хөнгөлөлттэй зээлд хамрагдах замаар санхүүжсэн гэжээ. Аймгуудын дунджаас банкны зээл гэсэн хариултын хувийн жин нэлээд бага, өөрийн хөрөнгөөр гэсэн хариултынх их байв.

Зураг 6 Анхдагч санхүүжилт

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Үйл ажиллагаагаа өргөжүүлэх, шинээр бизнес эрхлэхдээ Улаанбаатар хотоос судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 62% нь санхүүжилт авч байгаагүй гэж хариулсан нь аймгуудын хариултаас ялгаатай байв. Аймгуудын хувьд дийлэнх нь ямар нэг байдлаар санхүүжилт авч байсан гэж хариулжээ. Харин Улаанбаатарчуудын ердөө 38% санхүүжилт авч байсан гэж хариулсан бөгөөд тэдгээрийн дийлэнх (74%) аймгуудтай адил банкнаас зээл авсан байна. Зээлээ эргэн төлөхөд зээлийн хүүний төлбөр өндөр, зээлийн хугацаа богино байсан нь хамгийн их бэрхшээл учруулсан гэжээ.

Зураг 7 Зээлийн эргэн төлөлтийн бэрхшээл

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Цаашид үйл ажиллагаагаа явуулахад (59%) нь санхүүжилт авах хэрэгцээтэй гэжээ. Тэдгээрийн 29% нь 10-50 сая, 18% нь 50-100 сая, 16% нь 100-500 сая, 15% нь 5-10 сая, 10% нь 1-5 сая, 7% нь 500 саяас дээш төгрөгийн санхүүжилт шаардлагатай гэжээ. 10-50 сая гэж хариулсан хариултын хувийн жин нь бусад аймгуудын дунджаас бага, харин 500 саяас дээш гэсэн хариулт их байв.

Зураг 8 Шаардлагатай санхүүжилт

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Дүгнэлт

- Судалгаанд хамрагдсан Улаанбаатар хотын 1032 ЖДҮ эрхлэгчид олон жилийн туршлагатай, цөөн тооны ажиллагсадтай бөгөөд үйлчилгээ, худалдааны чиглэлээр түлхүү үйл ажиллагаа эрхэлдэг.
- Түүхий эд материалаа өөрийн хотоосоо голчлон бэлтгэн, хотдоо борлуулалтаа хийдэг гэжээ. Мөн улсын хэмжээнд борлуулалт хийдэг гэсэн хариулт (19%) аймгуудын дунджаас илүү байв. ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх 1-10 сая, 10-50 сая төгрөгийн орлого олдог гэжээ.
- Улаанбаатар хотын санал асуулганд оролцсон ЖДҮ эрхлэгчдийн 42% нь ЖДҮ эрхлэгчдийг дэмждэг байгууллагыг мэдэхгүй гэж хариулсан нь бусад аймгуудын хариултаас ялгаатай байлаа. Харин мэдэхгүй гэснээс өөрөөр хариулсан хариултын хандлага аймгуудынхтай адил байсан бөгөөд арилжааны банк хамгийн их хамгийн их ЖДҮ эрхлэгчдийг дэмждэг гэжээ. Мөн Засгийн газар,

ТББайгууллага, худалдаа аж үйлдвэрийн танхим, ОУ-ын байгууллага, үйлдвэр эрхлэгчдийн холбоо зэргийг дэмждэг гэж багагүй хувь хариулжээ. Эдгээр байгууллагуудаас санхүүгийн эх үүсвэрийг бий болгосон, сургалт зөвлөгөө явуулсан, үзэсгэлэн худалдаа зохион байгуулсан байна.

- Төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох, татварын таатай орчинг бүрдүүлэх, авлигыг бууруулах, үндэсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хөнгөлөлттэй санхүүгийн эх үүсвэр бий болгох, хүртээмжийг нэмэгдүүлэх, хууль эрх зүйн орчныг сайжруулах, зөвшөөрөл лицензийн тоог багасгах арга хэмжээг нэн түрүүнд авах шаардлагатай гэж үзжээ.

- ЖДҮ хөгжих эдийн засгийн таатай орчин хангалттай бус, огт бүрдээгүй гэж дийлэнх нь бусад аймгуудын судалгаанд оролцогчидтой адил дүгнэсэн байна.

- Бизнесийн орчинд өгсөн үнэлгээ бусад аймгуудтай ижил ерөнхийдөө сөрөг үнэлгээтэй байсны зэрэгцээ ихэнх үнэлгээ аймгуудын дундаж үнэлгээнээс илүү муу үзүүлэлттэй байв. Зах зээлийн орчин, дотоод орчны үнэлгээ аймгуудын дундажтай ойролцоо байлаа. Хамгийн их сөрөг буюу хүндрэлтэй гэсэн үнэлгээ өгсөн хэсэгт нийгмийн орчин үүнээс ядуурал, ажилгүйдэл, хээл хахууль, гэмт хэрэг, улс төрийн байдал, Зардлын хэсэг үүнээс зээлийн хүүний, шимтгэл хураамжийн, түрээсийн, зам тээврийн, тоног төхөөрөмжийн, түүхий эдийн, зар сурталчилгааны зардлууд орж байна. Харин мэдээлэл, холбооны хөгжил, цахилгаан хангамж гэсэн үзүүлэлтүүд боломжийн гэсэн үнэлгээг авчээ.

- Өөрийн хөрөнгөөр дийлэнх нь үйл ажиллагаагаа эхлүүлсэн бөгөөд үйл ажиллагаагаа өргөжүүлэх, шинээр бизнес эрхлэхэд ямар нэг санхүүжилт авч байгаагүй гэж хариулсан нь аймгуудын хариултаас ялгаатай байв. Аймгуудын хувьд дийлэнх нь ямар нэг санхүүжилт авч байсан гэжээ. Харин санхүүжилт авч байсан Улаанбаатар хотын ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх аймгуудтай адил банкнаас зээл авсан байна.

- Зээлээ эргэн төлөхөд зээлийн хүүний төлбөр өндөр, зээлийн хугацаа богино байсан нь хамгийн их бэрхшээл учруулдаг гэжээ.

- Цаашид үйл ажиллагаагаа явуулахад санхүүжилт шаардлагатай гэж дийлэнх нь хариулсан ба 10-50 сая, 50-100 сая, 100-500 сая төгрөг шаардлагатай гэжээ.

Архангай аймаг


1. Ерөнхий мэдээлэл

Архангай аймагт 2011 оны 1 дүгээр улирлын байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа 540³⁰ ААН-ээс санамсаргүй түүврийн аргаар 51 жижиг дунд бизнес эрхлэгчийг судалгаанд хамрууллаа. Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 51% нь иргэд, 39% нь ХХК, 6% нь нөхөрлөл байсан бөгөөд тэдгээрийн 55% нь дотоодын хөрөнгө оруулалттайгаар үйл ажиллагаагаа явуулдаг байна /45% нь уг асуултанд хариулаагүй/.

Архангай аймагт судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 45% нь үйлдвэрлэл, 35% нь үйлчилгээ 20% нь худалдаа эрхэлдэг гэжээ. Бусад аймгуудын дундаж үзүүлэлтээс үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ЖДҮ эрхлэгчдийн эзлэх хувь 6 нэгж хувь, үйлдвэрлэл 5 нэгж хувиар тус тус илүү харин худалдааны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгчид бусад аймгуудын дунджаас 11 нэгж хувиар бага сонгогдсон байна.

Зураг 1 ЖДҮ эрхлэгчдийн үйл ажиллагааны чиглэл

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийг үйл ажиллагаа эрхэлж буй хугацаагаар нь авч үзвэл 31% нь 5-10 жил, 29% нь 1-5 жил, 24% нь 10-аас дээш жил, 16% нь 1 хүртэл жил үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд тэдгээрийн 78% нь 10 хүртэл, 20% нь 10-49, 2% нь 50-99 ажиллагсадтай ЖДҮ-үүд байна.

Архангай аймгийн хувьд түүвэр судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн давхардсан тоогоор 55% нь нийслэл хотоос, 44% нь үйл ажиллагаа эрхэлж буй аймгаас түүхий эд, материалаа бэлтгэдэг гэж хариуллаа. Энэ нь бусад аймгуудын дундаж үзүүлэлттэй ойролцоо үр дүнтэй байна. Харин тэдгээр ЖДҮ эрхлэгчдийн 86% нь эцсийн бүтээгдэхүүнээ өөрийн аймагт нийлүүлдэг гэж хариулсан нь бусад аймгийн дунджаас 4 нэгж хувиар

илүү үзүүлэлттэй байна. Мөн улсын хэмжээ болон нийслэл хотод эцсийн бүтээгдэхүүнээ борлуулдаг гэж хариулсан ААН-ийн хувь 10%-тай байгаа нь бусад аймгийн дунджаас даруй 12 нэгж хувиар бага үзүүлэлт юм.

Хүснэгт 1 Түүхий эд материалын бэлтгэл, бараа бүтээгдэхүүний борлуулалт

(Бусад аймаг болон УБ хоттой харьцуулсан дүн, давхардсан тоогоор, хувь)


Байршил	Түүхий эд бэлтгэл			Борлуулалт		
	Архангай	Аймгууд	УБ	Архангай	Аймгууд	УБ
Нийслэл хот	55	55	73	4	9	76
У/а эрхэлж буй аймаг	41	45	5	86	82	5
Бусад аймаг	12	8	6	6	13	4
Гадаад улс	14	27	30	2	3	5
Улсын хэмжээнд				6	6	19

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Архангай аймгийн судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн талаас илүү нь буюу 51% нь 1-10 сая, 26% нь 10-50 сая төгрөгийн жилийн борлуулалтын орлоготой гэж хариуллаа. Үүнийг бусад аймгуудын дундаж болон нийслэл хотын үзүүлэлттэй харьцуулахад 1-10 сая төгрөгийн жилийн борлуулалтын орлоготой гэсэн хариултын хувь дунджаар 16 нэгж хувиар илүү, 10-50 сая төгрөг гэсэн хариултын хувь дунджаар 2 нэгж хувиар бага үзүүлэлттэй байна.

Зураг 2 ЖДҮ эрхлэгчдийн жилийн борлуулалтын орлого

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Түүнчлэн түүвэр судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 47% нь тайлан тэнцэл гаргадаг гэсэн хариулт өгсөн нь аймгуудын дунджаас 18 нэгж хувь, Улаанбаатар хотынхоос 30 нэгж хувиар тус тус бага үзүүлэлттэй байна.


2. ЖДҮ-ийг дэмжих бодлогын арга хэмжээ

Архангай аймгаас санал асуулгад оролцсон ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх нь ЖДҮ-ийг хамгийн ихээр **арилжааны банк** дэмждэг гэж хариулжээ. Мөн Засгийн газар, орон нутгийн засаг захиргаа гэсэн хариултыг бусад хариултаас илүү сонгосон байна. Уг үр дүнг аймгуудын дундаж үзүүлэлттэй харьцуулахад хариултуудын хандлага ерөнхийдөө ижил байлаа.

³⁰ Бизнес регистрийн санд бүртгэлтэй

Зураг 3 ЖДҮ эрхлэгчдийг хамгийн ихээр дэмждэг байгууллага

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Архангай аймгийн ЖДҮ эрхлэгчид дээрх байгууллагууд санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгосон, үзэсгэлэн худалдаа зохион байгуулсан, сургалт зөвлөгөө явуулах байдлаар дэмжлэг үзүүлсэн гэж үзжээ. Бусад аймгуудтай харьцуулахад хандлага ерөнхийдөө ижил байв.

Зураг 4 ЖДҮ-д ямар дэмжлэг үзүүлсэн

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Архангай аймгийн ЖДҮ эрхлэгчид цаашид төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох, үндэсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хөнгөлөлттэй санхүүгийн эх үүсвэр бий болгох, хүртээмжийг нэмэгдүүлэх, бизнестэй холбоотой шийдвэрт хувийн хэвшил, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, зөвшөөрөл лицензийн тоог багасгах зэрэг арга хэмжээнүүдийг нэн түрүүн авах нь зүйтэй гэж үзжээ. Энэхүү үр дүнг аймгууд болон Улаанбаатар хотын нэгдсэн дүнтэй харьцуулбал төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох гэсэн хариултын хувийн жин илүү, хөнгөлөлттэй санхүүгийн эх үүсвэр бий болгох, хүртээмжийг нэмэгдүүлэх гэсэн хариултынх аймгуудын дунджаас бага байв.

Зураг 5 Цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

3. Макро эдийн засгийн орчин

Архангай аймгийн судалгаанд оролцогчдын дийлэнх буюу 80% нь манай улсад ЖДҮ хөгжих эдийн засгийн таатай орчин хангалттай бус байна гэж үзжээ. Энэ нь аймгуудын дунджаас 9 нэгж хувь, Улаанбаатар хотын хувиас 19 нэгж хувиар илүү үзүүлэлттэй байна.

Хүснэгт 2 ЖДҮ хөгжих эдийн засгийн таатай орчин бүрдсэн эсэх

(Бусад аймаг болон УБ хоттой харьцуулсан дүн, давхардсан тоогоор, хувь)

ЖДҮ хөгжих орчин	Архангай	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Бүрдсэн	8	10	8
Хангалттай бус	80	71	61
Огт бүрдээгүй	8	12	23
Мэдэхгүй	2	6	9

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Түүнчлэн Архангай аймагт үйл ажиллагаа эрхлэгч ЖДҮ эрхлэгчдийн 27% нь эдийн засгийн өсөлт тэдгээрийн бизнест эерэгээр нөлөөлж байгаа гэж үзсэн бол 24% нь сөргөөр нөлөөлж байна гэж хариулжээ. Аймгуудын дундажтай харьцуулахад ЭЗ-ийн өсөлт өөрсдийн бизнест эерэгээр нөлөөлсөн гэсэн хариулт 11 нэгж хувиар бага байлаа.

Хүснэгт 3 ЖДҮ хөгжилд эдийн засгийн өсөлтийн үзүүлж буй нөлөө

(Бусад аймаг болон УБ хоттой харьцуулсан дүн, давхардсан тоогоор, хувь)

Эдийн засгийн өсөлт танай бизнест	Архангай	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Эергээр	27	24	18
Сөргөөр	20	22	43
Нөлөөлөөгүй	24	19	21
Мэдэхгүй	18	16	18

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Инфляцийн түвшин болон төгрөгийн бусад валюттай харьцах ханш өөрсдийн бизнест хэрхэн нөлөөлдөг талаар асуусан асуултанд тус аймгийн судалгаанд оролцогчдын 25-30% нь мэдэхгүй эсвэл хариулаагүй байгаа нь энэ асуултын хариулт бусад аймгуудаас ялгаатай байхад нөлөөлжээ. Инфляци, төгрөгийн ханш тогтвортой байх нь өөрсдийн бизнест сайн гэсэн хариултыг 37-43%, инфляцийн түвшин буурвал сайн гэсэн хариултыг 25% нь өгчээ.

4. Бизнесийн орчин

Архангай аймгийн судалгаанд оролцсон ЖДҮ эрхлэгчид дэд бүтцийн байдалд дунджаар **боломжийн**, хууль эрх зүй, санхүүжилт, зах зээлийн орчинд муу болон боломжийн гэсэн үнэлгээний хооронд, дотоод орчин, зардлын байдалд бага хүндрэлтэй болон хүндрэлтэй гэсэн хариултын дундуур, нийгмийн орчинд хүндрэлтэй гэсэн хариултуудыг тус тус өгсөн байна.

Архангай аймгийнхны санхүүжилтийн орчинд өгсөн үнэлгээ бусад аймгууд, Улаанбаатар хоттой харьцуулахад бага зэрэг дээгүүр байлаа. Тус аймгийнхны хамгийн бэрхшээлтэй нь ОУ-ын байгууллагын хөнгөлөлттэй зээлийн олдоц, Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн олдоц, Хөрөнгийн зах зээлээс санхүүжилт авах гэж үзсэн байна. Энэ хэсгээс хамгийн эерэг буюу боломжийн үнэлгээг банкны зээлд өгчээ.

Хүснэгт 4 Санхүүжилтийн орчин

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Санхүүжилтийн орчин	Архангай	Аймгуудын дундаж	Улаанбаатар
ОУ-ын байгууллагын хөнгөлөлттэй зээлийн олдоц	-0.94	-1.01	-1.02
Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн олдоц	-0.76	-0.93	-1.01
Хөрөнгийн зах зээлээс санхүүжилт авах	-0.71	-0.55	-0.61
Өөрийн хөрөнгийн хүрэлцээ	-0.59	-0.40	-0.43
Санхүүжилтийн хүү	-0.51	-0.63	-0.67
Санхүүжилтийн хэмжээ	-0.51	-0.47	-0.51
Санхүүжилтийн хугацаа	-0.45	-0.52	-0.57
Санхүүжилтийн барьцаа хөрөнгө	-0.41	-0.41	-0.56
Банк бус санхүүгийн байгууллагын зээл	-0.27	-0.32	-0.48
Зээлийн батлан даалт	-0.24	-0.29	-0.49
Зээл олгох үйл ажиллагаа	-0.16	-0.16	-0.53
Банкны зээл	0.18	0.04	-0.49

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Хууль, эрх зүй, зохицуулалтын орчин ерөнхийдөө боломжийн үнэлгээг түлхүү өгчээ. Харин төрийн байгууллагын үйлчилгээ бага зэрэг муу тал руугаа үнэлэгдсэн байгаа нь аймгуудын дундажтай ойролцоо, Улаанбаатарынхаас бага зэрэг дээгүүр үнэлгээтэй байв.

Хүснэгт 5 Хууль эрх зүйн орчин

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Хууль, эрх зүйн зохицуулалтын орчин	Архангай	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Төрийн байгууллагын үйлчилгээ	-0.61	-0.57	-0.75
Гадаад худалдаа хийх нөхцөл	-0.45	-0.48	-0.43
Хууль, эрх зүйн орчин	-0.43	-0.44	-0.65
Татварын тогтолцоо	-0.39	-0.43	-0.56
Хяналт, шалгалтын тогтолцоо	-0.29	-0.32	-0.52
Газар эзэмших	-0.27	-0.31	-0.60

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Зах зээлийн орчинд бусад аймаг, Улаанбаатартай ижил боломжийн үнэлгээг түлхүү өгчээ. Гэхдээ ихэнх үзүүлэлтүүд аймгуудын дундаж, Улаанбаатартай харьцуулахад бага зэрэг доогуур үнэлгээтэй байв. Технологийн дэвшилд хамгийн сайн үнэлгээг өгсөн нь аймгуудын дунджаас бага зэрэг дээгүүр, Улаанбаатарынхаас бага зэрэг доогуур үнэлгээтэй байлаа.

Хүснэгт 6 Зах зээлийн орчин

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Зах зээлийн орчин	Архангай	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Даатгалын үйлчилгээ	-0.49	-0.40	-0.37
Хэрэглэгчдийн худалдан авах чадвар	-0.47	-0.43	-0.36
Зах зээлийн багтаамж	-0.47	-0.40	-0.37
Шударга өрсөлдөөн	-0.45	-0.40	-0.44
Технологийн дэвшил	-0.27	-0.34	-0.20

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Архангай аймгийнхны дэд бүтцийн байдалд боломжийн гэсэн үнэлгээг түлхүү өгсөн ба хамгийн өндөр үнэлгээг мэдээлэл холбооны хөгжил, хамгийн доогуур үнэлгээг дулаан усан хангамжинд өгчээ. Бусад аймаг, Улаанбаатар хотынхноос үзүүлэлт бүрээрээ дээгүүр үнэлгээтэй байна.

Хүснэгт 7 Дэд бүтэц

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Дэд бүтцийн байдал	Архангай	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Дулаан, усан хангамж	-0.27	-0.40	-0.25
Зам, тээврийн хөгжил	-0.24	-0.54	-0.68
Цахилгаан хангамж	0.06	-0.02	-0.10
Мэдээлэл холбооны хөгжил	0.27	0.32	0.15

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

5. Дотоод орчин

Архангай аймгийн ЖДҮ эрхлэгчид өөрсдийн дотоод орчиндоо ерөнхийдөө бага хүндрэлтэй гэсэн үнэлгээг өгчээ. Эдгээрээс ажилчдын чадвар арай илүү хүндрэлтэй үнэлгээг авчээ. Үзүүлэлт бүрийн үнэлгээ аймаг, нийслэлийн дундажтай ерөнхийдөө ойролцоо үнэлгээтэй байв.

Хүснэгт 8 Дотоод орчин

(Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4)

Дотоод орчин	Архангай	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Ажилчдын чадвар	-1.31	-1.31	-1.13
Хүний нөөцийн удирдлага	-1.12	-1.33	-1.38
Тоног төхөөрөмжийн чанар	-1.12	-1.28	-1.20
Түүхий эдийн чанар	-1.08	-1.12	-1.30

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

6. Зардлын байдал

Зардлуудад бага хүндрэлтэй, хүндрэлтэй гэсэн үнэлгээг түлхүү өгчээ. Хамгийн хүндрэлтэй зардлуудад шимтгэл хураамжийн, тоног төхөөрөмжийн, зээлийн хүүний, түүхий эдийн, дулаан, усны, эрчим хүч, цахилгааны зардлуудыг оруулсан нь бусад аймгууд, Улаанбаатар хотынхны хандлагатай ерөнхийдөө төстэй байна.

Хүснэгт 9 Зардлын байдал

(Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4)

Зардлын байдал	Архангай	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Шимтгэл, хураамжийн төлбөр	-1.75	-1.71	-1.78
Тоног төхөөрөмжийн зардал	-1.73	-1.62	-1.62
Зээлийн хүүний зардал	-1.71	-1.82	-1.89
Түүхий эдийн зардал	-1.65	-1.59	-1.62
Дулаан, усны зардал	-1.65	-1.51	-1.49
Эрчим хүч, цахилгааны зардал	-1.61	-1.50	-1.48
Зам, тээврийн зардал	-1.51	-1.58	-1.62
Түрээсийн зардал	-1.47	-1.47	-1.74
Ажиллах хүчний өртөг	-1.41	-1.37	-1.41
Захиргаа, үйл ажиллагааны зардал	-1.25	-1.24	-1.42
Зар сурталчилгааны зардал	-1.12	-1.10	-1.57
Харилцаа холбооны зардал	-1.04	-0.92	-1.25

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

7. Нийгмийн орчин

Тус аймгынхны хамгийн ихээр сөрөг үнэлгээ өгсөн хэсэгт нийгмийн орчин орж байгаа ба үүнээс ажилгүйдэл, ядуурал, гэмт хэрэг, хээл хахууль, улс төрийн байдалд хүндрэлтэй, их хүндрэлтэй, харилцагчийн ёс суртахуун, хувийн хэвшлийн оролцоо, мэдээллийн хүртээмжинд хүндрэлтэй, бага хүндрэлтэй гэсэн хариултыг түлхүү өгчээ. Ерөнхийдөө бусад аймгууд, Улаанбаатартай хариултууд төстэй байлаа.

Хүснэгт 10 Нийгмийн орчин

(Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4)

Нийгмийн орчин	Архангай	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Ажилгүйдэл	-2.43	-2.49	-2.75
Ядуурал	-2.39	-2.48	-2.77
Гэмт хэрэг	-2.16	-2.13	-2.67
Хээл хахууль	-2.14	-2.27	-2.72
Улс төрийн байдал	-2.12	-2.08	-2.46
Харилцагчийн ёс суртахуун	-1.61	-1.65	-2.00
Хувийн хэвшил, иргэдийн оролцоо	-1.51	-1.48	-1.91
Мэдээллийн хүртээмж	-1.47	-1.53	-1.78

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

8. Санхүүжилт

Судалгаанд оролцогчдын дийлэнх банкны зээл, өөрийн хөрөнгөөр санхүүжигдэн үйл ажиллагаагаа эхлүүлж байжээ. Мөн судалгаанд оролцогчдын 25% нь гэр бүлийн хамтын хөрөнгөөр, 18% хөнгөлөлттэй зээлээр үйл ажиллагаа эхлүүлсэн байна. Банкны зээлээр санхүүжигдсэн гэсэн хариулт Улаанбаатар, аймгуудын дунджаас илүү, өөрийн хөрөнгөөр гэсэн хариулт бага зэрэг бага, гэр бүлийн хамтын хөрөнгөөр гэсэн хариулт аймаг нийслэлтэй ойролцоо, хөнгөлөлттэй зээлээр гэсэн хариулт илүү хувийн жинтэй байлаа.

Зураг 6 Анхдагч санхүүжилт

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Үйл ажиллагаагаа өргөжүүлэх, шинээр бизнес эрхлэхэд судалгаанд хамрагдагсдын дийлэнх бусад аймгуудтай адил (Улаанбаатарчуудын хувьд дийлэнх нь зээл аваагүй гэж хариулсан) санхүүжилт авч байсан гэж хариулсан бөгөөд тэдгээрийн 80-аад % нь банкны зээл авсан гэжээ. Зээлээ эргэн төлөхөд зээлийн хугацаа богино, хүүний төлбөр өндөр байгаа нь хамгийн их хүндрэл учруулсан гэж хариулжээ. Зээлийн хугацаа богино гэсэн хариулт нийслэлийн хариултаас илүү, аймгуудын дундажтай ойролцоо, зээлийн хүүний төлбөр өндөр гэсэн хариулт аймгуудынхаас бага, нийслэлийнхээс илүү байв.

Зураг 7 Зээлийн эргэн төлөлтийн бэрхшээл

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Цаашид үйл ажиллагаагаа явуулахад бусад аймгуудтай ижил судалгаанд хамрагдагсдын дийлэнх (80%) нь санхүүжилт авах хэрэгцээтэй гэжээ. Тэдгээрийн 57% нь 10-50 сая, 17% нь 50-100 сая, 14% нь 5-10 сая төгрөгийн санхүүжилт шаардлагатай гэжээ. 10-50 сая гэж хариулсан хариултын хувийн жин нь бусад аймгуудын дунджаас нэлээд их, 100-500 сая гэсэн хариулт аймаг, нийслэлийн хариултаас бага, бусад хариулт нийслэл, аймгуудын дундажтай ойролцоо байв.



Дүгнэлт

- Судалгаанд хамрагдсан Архангай аймгийн 51 ЖДҮ эрхлэгчид олон жилийн туршлагатай, цөөн тооны ажиллагсадтай бөгөөд үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр түлхүү үйл ажиллагаа эрхэлдэг.
- Түүхий эд материалаа нийслэл, өөрийн аймгаасаа голчлон бэлтгэн, аймагтаа борлуулалтаа хийдэг гэжээ. ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх 1-10 сая, 10-50 сая төгрөгийн орлого олдог гэжээ.
- Бусад аймаг, нийслэл хотын судалгааны дүнтэй адил арилжааны банкныг хамгийн их ЖДҮ эрхлэгчдийг дэмждэг гэжээ. Мөн Засгийн газар, орон нутгийн засаг захиргаа дэмждэг гэж багагүй хувь хариулжээ. Дэмжлэг үзүүлэгч байгууллагуудаас санхүүгийн эх үүсвэрийг бий болгосон, үзэсгэлэн худалдаа зохион байгуулсан, сургалт зөвлөгөө явуулсан байна.
- Төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох, үндэсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хөнгөлөлттэй санхүүгийн эх үүсвэр бий болгох, хүртээмжийг нэмэгдүүлэх, бизнестэй холбоотой шийдвэрт хувийн хэвшил, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, зөвшөөрөл лицензийн тоог багасгах арга хэмжээг нэн түрүүнд авах шаардлагатай гэж үзжээ.
- ЖДҮ хөгжих эдийн засгийн таатай орчин хангалттай бус байна гэж дийлэнх нь бусад аймаг, нийслэлчүүдтэй адил дүгнэсэн байна.
- Бизнесийн орчинд өгсөн үнэлгээ аймгуудын дундажтай үзүүлэлт бүрээрээ ойролцоо байлаа.

Хамгийн их сөрөг буюу хүндрэлтэй гэсэн үнэлгээ өгсөн хэсэгт нийгмийн орчин үүнээс ажилгүйдэл, ядуурал, гэмт хэрэг, хээл хахууль, улс төрийн байдал, Зардлын хэсэг үүнээс шимтгэл хураамжийн, тоног төхөөрөмжийн, зээлийн хүүний, түүхий эдийн, дулаан, усны, эрчим хүч, цахилгааны зардлууд орж байна. Харин мэдээлэл, холбооны хөгжил, банкны зээл, цахилгаан хангамж гэсэн үзүүлэлтүүд боломжийн гэсэн үнэлгээг авчээ.

- Банкны зээл, өөрийн хөрөнгөөр дийлэнх нь үйл ажиллагаагаа эхлүүлсэн бөгөөд үйл ажиллагаагаа өргөжүүлэх, шинээр бизнес эрхлэхэд банкны зээл авсан байна.
- Зээлээ эргэн төлөхөд зээлийн хугацаа богино, хүүний төлбөр өндөр байсан нь хамгийн их бэрхшээл учруулдаг гэжээ.
- Цаашид үйл ажиллагаагаа явуулахад санхүүжилт шаардлагатай гэж дийлэнх нь хариулсан ба 10-50 сая төгрөг шаардлагатай гэсэн хариултын хувийн жин бусад аймаг, Улаанбаатарынхаас их байв.

Баянхонгор аймаг

1. Ерөнхий мэдээлэл

Баянхонгор аймагт 2011 оны 1 дүгээр улирлын байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа 524³¹ ААН-ээс санамсаргүй түүврийн аргаар 50 жижиг дунд бизнес эрхлэгчийг судалгаанд хамрууллаа. Баянхонгор аймгийн жижиг дунд үйлдвэр эрхлэгчдээс санал асуулга авсны 14% нь хоршоод, 24% нь иргэд, 62% нь ХХК байсан бөгөөд дийлэнх нь дотоодын хөрөнгө оруулалттай үйл ажиллагаагаа явуулдаг байна. Үйл ажиллагааны чиглэлээр нь авч үзвэл худалдааны чиглэлээр аж ахуйн нэгжүүдийн 1/3 эрхэлдэг бөгөөд энэ нь аймгуудын дундаж болон нийслэл хотынхтой ойролцоо үзүүлэлт юм. Харин үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж буй ЖДҮ эрхлэгчдийн хувь нь бусад аймгуудтай харьцуулахад нэлээд их, нийслэл хотынхтой ойролцоо байв. Үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй ЖДҮ эрхлэгчдийн хувь аймгийн дунджаас 13.7 нэгж хувиар бага гарсан бөгөөд Улаанбаатар хотын судалгааны үзүүлэлтээс ялимгүй бага байлаа.

Зураг 1 ЖДҮ эрхлэгчдийн үйл ажиллагааны чиглэл

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Түүхий эд материалаа бусад аймгуудын адил дийлэнх нь өөрийн аймаг, нийслэл хотоос бэлтгэн, бараа үйлчилгээгээ ерөнхийд нь өөрийн аймагтаа борлуулдаг гэжээ. Түүхий эд материалаа гадаадаас авдаг аж ахуйн нэгжүүд нь аймгуудын дунджаас харьцангуй илүү байна.

Хүснэгт 1 Түүхий эд материалын бэлтгэл, бараа бүтээгдэхүүний борлуулалт

(Бусад аймаг болон УБ хоттой харьцуулсан дүн, давхардсан тоогоор, хувь)


Байршил	Түүхий эд бэлтгэл			Борлуулалт		
	Баянхонгор	Аймгууд	УБ	Баянхонгор	Аймгууд	УБ
Нийслэл хот	76	55	73	8	9	76
Ү/а эрхэлж буй аймаг	50	45	5	98	82	5
Бусад аймаг	6	8	6	12	13	4
Гадаад улс	36	27	30	6	3	5
Улсын хэмжээнд				6	19	

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн 22% нь үйл ажиллагаагаа 1-5 жил, 34% нь 5-10 жил, 38% нь 10-аас дээш жил эрхэлж байгаа бөгөөд 60% нь 1-9 ажиллагсадтай, 32% нь 10-49 ажиллагсадтай байна. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн 30% нь 10-50 сая төгрөг, 30% нь 1-10 сая төгрөг, 12% нь 50-100 сая төгрөгийн орлоготой гэж хариулсан бөгөөд орлогын тархалт нь аймгуудын дундажтай ойролцоо байв.

Зураг 2 ЖДҮ эрхлэгчдийн жилийн борлуулалтын орлого

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Түүнчлэн түүвэр судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 72% нь тайлан тэнцэл гаргадаг гэсэн хариулт өгсөн нь аймгуудын дунджаас 7 нэгж хувь их, Улаанбаатар хотынхоос 5 нэгж хувиар бага үзүүлэлттэй байна.


2. ЖДҮ-ийг дэмжих бодлогын арга хэмжээ

Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх буюу 62% нь арилжааны банк ЖДҮ-ийг хамгийн их дэмждэг гэж хариулжээ. Үүний дараагаар Худалдаа аж үйлдвэрийн тэнхим, Засгийн газар гэж үзсэн байна. Харин бага дэмжлэг үзүүлдэг байгууллагуудын тоонд төрийн бус байгууллагууд, Үйлдвэр эрхлэгчдийн холбоо, бусад санхүүгийн байгууллагууд, зөвлөгөө өгөх байгууллага, төвууд орсон байна.

³¹ Бизнес регистрийн санд бүртгэлтэй

Зураг 3 ЖДҮ эрхлэгчдийг хамгийн ихээр дэмждэг байгууллага

(Санал асуулгад оролцогчдын эзтх хувь, давхардсан тоогоор)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Баянхонгор аймгийн ЖДҮ эрхлэгчид дээрх байгууллагууд санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгосон, үзэсгэлэн худалдаа зохион байгуулсан, сургалт зөвлөгөө явуулах байдлаар дэмжлэг үзүүлсэн гэж үзжээ. Бусад аймгуудтай харьцуулахад хандлага ерөнхийдөө ижил байв.

Зураг 4 ЖДҮ-д ямар дэмжлэг үзүүлсэн

(Санал асуулгад оролцогчдын эзтх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

ЖДҮ эрхлэгчдийн үзэж буйгаар юуны өмнө санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, үндэсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох, татварын таатай орчин бүрдүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг нэн түрүүнд авах шаардлагатай гэж үзсэн байна. Харин бусад аймгуудтай харьцуулахад цаашид авах арга хэмжээнүүдээс авилгалыг бууруулах, зөвшөөрөл, лицензийн тоог багасгах, хууль, эрх зүйн орчинг сайжруулахыг ЖДҮ эрхлэгчид илүү түлхүү хариулжээ.

Зураг 5 Цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ

(Санал асуулгад оролцогчдын эзтх хувь, давхардсан тоогоор)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

3. Макро эдийн засгийн орчин

Санал асуулганд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 88% нь эдийн засгийн таатай орчин огт бүрдээгүй, хангалттай бус бүрдсэн гэж хариулсан байна. Эдийн засгийн таатай орчин бүрдсэн гэж үзэж буй аж ахуйн нэгжүүдийн хувь нь аймгуудын дундаж болон нийслэл хотынхоос бага байв. Эдийн засгийн өсөлт ЖДҮ эрхлэгчдийн бизнест эерэгээр нөлөөлсөн гэж 52%, 30% нь нөлөөлөөгүй, 8% нь мэдэхгүй гэж хариулжээ. Инфляцийн түвшин, төгрөгийн ханш тогтвортой байх нь өөрсдийн бизнест сайн гэж ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх нь бусад аймгуудын адил үзжээ.

Зураг 6 ЖДҮ хөгжих эдийн засгийн таатай орчин бүрдсэн эсэх

(Бусад аймаг болон УБ хоттой харьцуулсан дүн, давхардсан тоогоор, хувь)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

4. Бизнесийн орчин

Баянхонгор аймгийн ЖДҮ эрхлэгчид бизнесийн орчинг бусад аймгуудтай адил ерөнхийд нь сөрөг үнэлгээг өгч дүгнэсэн байна.

Хүснэгт 2 Хууль эрх зүйн орчин

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Хууль, эрх зүй, зохицуулалтын орчин	Баянхонгор	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Төрийн байгууллагын үйлчилгээ	-0.52	-0.58	-0.75
Гадаад худалдаа хийх нөхцөл	-0.48	-0.48	-0.43
Татварын тогтолцоо	-0.44	-0.44	-0.56
Хууль, эрх зүйн орчин	-0.40	-0.45	-0.65
Хяналт, шалгалтын тогтолцоо	-0.36	-0.33	-0.52
Газар эзэмших	-0.32	-0.32	-0.60

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

ЖДҮ эрхлэгчид хууль, эрх зүй, зохицуулалтын орчныг нийслэл хот болон аймгуудын дундажтай ойролцоо үнэлгээг өгсөн байна. Баянхонгор аймгийнхан бусад аймгуудын адил төрийн байгууллагын үйлчилгээнд хамгийн муу үнэлгээг өгсөн бол хяналт, шалгалтын тогтолцоонд боломжийн гэсэн хариуг түлхүү өгчээ.

Хүснэгт 3 Дэд бүтэц

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Дэд бүтцийн байдал	Баянхонгор	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Зам, тээврийн хөгжил	-0.84	-0.55	-0.68
Дулаан, усан хангамж	-0.16	-0.39	-0.25
Цахилгаан хангамж	0.22	-0.03	-0.10
Мэдээлэл холбооны хөгжил	0.46	0.31	0.15

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Зам тээврийн хөгжил, дулаан, усан хангамжинд боломжийн, муу гэсэн үнэлгээг өгсөн нь аймгуудын дундажтай ижил байв. Харин мэдээлэл холбооны хөгжил, цахилгаан хангамжинд боломжийн, сайн гэсэн үнэлгээг түлхүү өгсөн ба эдгээр нь Улаанбаатар хот, аймгуудын дунджаас дээгүүр үнэлгээг авчээ.

Хүснэгт 4 Санхүүжилтийн орчин

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Санхүүжилтийн орчин	Баянхонгор	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Застгийн газрын хөнгөлөлттэй зээлийн олдоц	-0.96	-0.93	-1.01
Санхүүжилтийн хүү	-0.96	-0.63	-0.67
Олон улсын байгууллагын хөнгөлөлттэй зээлийн олдоц	-0.92	-1.01	-1.02
Санхүүжилтийн хугацаа	-0.78	-0.53	-0.57
Санхүүжилтийн барьцаа хөрөнгө	-0.72	-0.42	-0.56
Санхүүжилтийн хэмжээ	-0.70	-0.47	-0.51
Өөрийн хөрөнгийн хүрэлцээ	-0.48	-0.40	-0.43
Хөрөнгийн зах зээлээс санхүүжилт авах	-0.42	-0.55	-0.61
Зээлийн батлан даалт	-0.12	-0.30	-0.49
Банк бус санхүүгийн байгууллагын зээл	-0.08	-0.33	-0.48
Зээл олгох үйл ажиллагаа	-0.06	-0.18	-0.53
Банкны зээл	0.16	0.02	-0.49

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Санхүүжилтийн орчинг Баянхонгор аймгийнхан ОУ-ын байгууллага болон ЗГ-ын хөнгөлөлттэй зээлийн олдоц муу, санхүүжилтийн хүү өндөр, хугацаа нь богино гэж бусад аймгууд болон нийслэлийнхний нэг адил үзжээ. Ялангуяа санхүүжилтийн хүү өндөр

гэсэн үнэлгээ нь бусад аймаг болон нийслэл хотынхоос нэлээд сөрөг гарчээ. Харин банк болон банк бус санхүүгийн байгууллагын зээл, зээл олгох үйл ажиллагаанд ерөнхийд нь харьцангуй сайн үнэлгээг өгсөн байна.

Хүснэгт 5 Зах зээлийн орчин

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Зах зээлийн орчин	Баянхонгор	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Зах зээлийн багтаамж	-0.48	-0.40	-0.37
Хэрэглэгчдийн худалдан авах чадвар	-0.46	-0.43	-0.36
Даатгалын үйлчилгээ	-0.38	-0.40	-0.37
Технологийн дэвшил	-0.30	-0.33	-0.20
Шударга өрсөлдөөн	-0.26	-0.40	-0.44

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Зах зээлийн орчинд зах зээлийн багтаамжийг хамгийн сөргөөр үнэлсэн байна. Үүний дараагаар хэрэглэгчдийн худалдан авах чадварыг аймгуудын дундажтай ойролцоогоор хариулжээ. Шударга өрсөлдөөнийг аймгуудын дундаж болон нийслэл хотынхоос харьцангуй эерэгээр үнэлсэн байна.

5. Дотоод орчин

Баянхонгор аймгийн ЖДҮ эрхлэгчид өөрсдийн дотоод орчиндоо ерөнхийдөө бага хүндрэлтэй гэсэн үнэлгээг түлхүү өгсөн бөгөөд ажилчдын чанар эдгээрээс арай илүү хүндрэлтэй гэгджээ. Дотоод орчны бүх үзүүлэлтийн үнэлгээ нь бусад аймгуудынхаас харьцангуй эерэг байв.

Хүснэгт 6 Дотоод орчин

(Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4)

Дотоод орчин	Баянхонгор	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Ажилчдын чадвар	-1.24	-1.31	-1.13
Хүний нөөцийн удирдлага	-1.02	-1.33	-1.38
Тоног төхөөрөмжийн чанар	-0.98	-1.27	-1.20
Түүхий эдийн чанар	-0.96	-1.13	-1.30

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

6. Зардлын байдал

Баянхонгор аймгийнхан хамгийн хүндрэлтэй зардлуудад зээлийн хүү, шимтгэл, хураамж, түүхий эдийн зардлуудыг оруулсан байна. Аймгуудын дундажтай харьцуулахад Баянхонгор аймгийн ЖДҮ эрхлэгчдийн хувьд зээлийн хүүний зардал илүүтэйгээр хүндрэл учруулж байгаа бөгөөд бусад зардлууд нь арай бага хүндрэлтэй байна.

Хүснэгт 7 Зардлын байдал

(Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4)

Зардлын байдал	Баянхонгор	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Зээлийн хүүний зардал	-1.98	-1.82	-1.89
Шимтгэл, хураамжийн төлбөр	-1.64	-1.72	-1.78
Түүхий эдийн зардал	-1.48	-1.59	-1.62
Зам, тээврийн зардал	-1.40	-1.58	-1.62
Тоног төхөөрөмжийн зардал	-1.28	-1.62	-1.62
Ажиллах хүчний өртөг	-1.14	-1.38	-1.41
Эрчим хүч, цахилгааны зардал	-1.14	-1.50	-1.48
Түрээсийн зардал	-1.10	-1.48	-1.74
Дулаан, усны зардал	-1.02	-1.51	-1.49
Захиргаа, үйл ажиллагааны зардал	-1.02	-1.25	-1.42
Зар сурталчилгааны зардал	-0.86	-1.12	-1.57
Харилцаа холбооны зардал	-0.44	-0.93	-1.25

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

7. Нийгмийн орчин

Тус аймгынхны хамгийн ихээр сөрөг үнэлгээ өгсөн хэсэгт нийгмийн орчин орж байгаа ба үүнээс ажилгүйдэл, ядуурал, гэмт хэрэг, хээл хахууль, улс төрийн байдалд хүндрэлтэй, их хүндрэлтэй, харилцагчийн ёс суртахуун, хувийн хэвшлийн оролцоо, мэдээллийн хүртээмжинд хүндрэлтэй, бага хүндрэлтэй гэсэн хариултыг түлхүү өгчээ. Ерөнхийдөө бусад аймгууд, Улаанбаатартай хариултууд төстэй байлаа.

Хүснэгт 8 Нийгмийн орчин

(Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4)

Нийгмийн орчин	Баянхонгор	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Ядуурал	-2.40	-2.50	-2.77
Ажилгүйдэл	-2.38	-2.50	-2.75
Гэмт хэрэг	-2.06	-2.15	-2.67
Хээл хахууль	-1.88	-2.29	-2.72
Улс төрийн байдал	-1.74	-2.09	-2.46
Мэдээллийн хүртээмж	-1.62	-1.54	-1.78
Харилцагчийн ёс суртахуун	-1.62	-1.67	-2.00
Хувийн хэвшил, иргэдийн оролцоо	-1.24	-1.50	-1.91


Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

8. Санхүүжилт

ЖДҮ эрхлэгчид голдуу өөрийн хөрөнгө, гэр бүлийн хамтын хөрөнгө болон банкны зээлээр үйл ажиллагаагаа эхлүүлжээ. Гэр бүлийн хамтын хөрөнгөөр үйл ажиллагаагаа эхлүүлсэн аж ахуйн нэгжүүдийн хувь нь бусад аймгуудаас нэлээд их байв.

Зураг 7 Анхдагч санхүүжилт

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

ЖДҮ эрхлэгчдийн 76% нь үйл ажиллагаагаа өргөжүүлэх буюу шинээр бизнес эрхлэхэд зээл авсан бөгөөд дийлэнх нь банкны зээл болон хөнгөлөлттэй зээлд хамрагдсан байна. Зээлийн эргэн төлөлт дээр хүндрэлгүй гэж хариулсан аж ахуйн нэгжүүдийн хувь бага байв. Дийлэнх нь ямарваа нэгэн хүндрэлтэй гэж хариулсан бөгөөд 58% нь зээлийн хүүний төлбөр өндөр, 44% нь зээлийн хугацаа богино, 34% нь зээлийн хэмжээ бага гэж үзжээ. Зээлийг эргэн төлөхөд хүүний төлбөр өндөр гэсэн хариултын хувь аймгуудын дунджаас нэлээд их байв.

Зураг 8 Зээлийн эргэн төлөлтийн бэрхшээл

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Цаашид санал асуулганд оролцогчдын 80% нь үйл ажиллагаа явуулахад санхүүжилт авах хэрэгцээтэй гэсэн бөгөөд тэдгээрийн 32.5% нь 10-50 сая төгрөг, 30% нь 100-500 сая төгрөг, 22.5% нь 50-100 сая төгрөгийн санхүүжилт шаардлагатай гэж үзжээ.

Зураг 9 Шаардлагатай санхүүжилт

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Дүгнэлт

- Үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж буй ЖДҮ эрхлэгчдийн хувь аймгуудын дунджаас нэлээд их, харин үйлдвэрлэлийн чиглэрээр эсрэгээр бага байв. Түүхий эд материалаа нийслэл хот, өөрийн аймгаасаа бэлтгэн, голчлон аймагтаа борлуулалтаа хийдэг.
- ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх 1-10 сая, 10-50 сая төгрөгийн орлоготой.
- Бусад аймагуудын судалгааны дүнтэй адил арилжааны банкныг хамгийн их ЖДҮ эрхлэгчдийг дэмждэг гэж хариулсан байна. Үүний дараагаар Худалдаа аж үйлдвэрийн тэнхим, Засгийн газар гэж үзсэн байна. Эдгээр байгууллагуудаас санхүүгийн эх үүсвэрийг бий болгосон, үзэсгэлэн худалдаа зохион байгуулсан, сургалт зөвлөгөө явуулсан байна.
- Санхүүгийн эх үүсвэр бий болгох, төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох, үндэсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хөнгөлөлттэй хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээг нэн түрүүнд авах шаардлагатай гэж үзжээ.
- ЖДҮ хөгжих эдийн засгийн таатай орчин хангалттай бус байна гэж дийлэнх нь бусад аймаг, нийслэлчүүдтэй адил дүгнэсэн байна.
- Бизнесийн орчноос Баянхонгор аймгийнхны хамгийн их сөрөг буюу хүндрэлтэй гэсэн үнэлгээ өгсөн хэсэгт нийгмийн орчин байв. Зардлын хэсэгт зээлийн хүүний, шимтгэл, хураамжийн, түүхий эдийн зардлууд хамгийн хүндрэлтэй гэж хариулжээ. Харин мэдээлэл, холбооны хөгжил, банкны зээл, цахилгаан хангамж гэсэн үзүүлэлтүүд боломжийн гэсэн үнэлгээг авчээ.
- ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх нь банкны зээл, гэр бүлийн хамтын хөрөнгө, өөрийн хөрөнгөөр үйл ажиллагаагаа эхлүүлсэн ба үйл ажиллагаагаа өргөжүүлэхдээ банкны зээл авчээ.
- Зээлээ эргэн төлөхөд зээлийн хугацаа богино, хүүний төлбөр өндөр байсан нь хамгийн их бэрхшээл учруулдаг гэжээ.

- Цаашид үйл ажиллагаагаа явуулахад санхүүжилт шаардлагатай гэж дийлэнх нь хариулсан байна.

Баян-Өлгий аймаг


1. Ерөнхий мэдээлэл

Баян-Өлгий аймагт 2011 оны 1 дүгээр улирлын байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа 750³² ААН-ээс санамсаргүй түүврийн аргаар 52 жижиг дунд бизнес эрхлэгчийг судалгаанд хамрууллаа. Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 63% нь ХХК, 19% нь иргэд, 6% нь ХК, 4% нь хоршоо байсан бөгөөд тэдгээрийн 87% нь дотоодын хөрөнгө оруулалттайгаар үйл ажиллагаагаа явуулдаг байна.

Баян-Өлгий аймагт судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 50% нь үйлдвэрлэл, 27% нь үйлчилгээ, 23% нь худалдаа эрхэлдэг гэжээ. Дээрх үзүүлэлтүүдийг аймгуудын дундаж үзүүлэлттэй харьцуулбал, үйлдвэрлэл 10 нэгж хувиар илүү, үйлчилгээ болон худалдаа харгалзан 2, 8 нэгж хувиар бага сонгогдсон байна.

Зураг 1 ЖДҮ эрхлэгчдийн үйл ажиллагааны чиглэл

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийг үйл ажиллагаа эрхэлж буй хугацаагаар нь авч үзвэл 33% нь 1-5 жил, 29% нь 5-10 жил, 31% нь 10-аас дээш жил, 6% нь 1 хүртэл жил үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд тэдгээрийн 60% нь 10 хүртэл, 25% нь 10-49, 12% нь 50-99, 2% нь 155-199 ажиллагсадтай ЖДҮ-үүд байна.

Баян-Өлгий аймгийн хувьд түүвэр судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн давхардсан тоогоор 46% нь нийслэл хотоос, 33% нь үйл ажиллагаа эрхэлж буй аймгаас түүхий эд, материалаа бэлтгэдэг гэж хариуллаа. Тус үзүүлэлтийг аймгуудын дундаж үзүүлэлттэй харьцуулбал, нийслэл хотоос бэлтгэдэг гэсэн хариулт 9.2 нэгж хувь, үйл ажиллагаа эрхэлж буй аймгаас гэсэн хариулт 12.0 нэгж хувиар бага байна. Харин тэдгээр ЖДҮ эрхлэгчдийн 83% нь эцсийн бүтээгдэхүүнээ өөрийн аймагт борлуулдаг гэж хариулсан нь бусад аймгийн дундажтай ойролцоо үзүүлэлттэй байна. Мөн улсын хэмжээ

болон нийслэл хотод эцсийн бүтээгдэхүүнээ борлуулдаг гэж хариулсан ААН-ийн хувь 6%-тай байгаа нь бусад аймгийн дунджаас даруй 9 нэгж хувиар бага үзүүлэлт юм.

Хүснэгт 1 Түүхий эд материалын бэлтгэл, бараа бүтээгдэхүүний борлуулалт

(Бусад аймаг болон УБ хоттой харьцуулсан дүн, давхардсан тоогоор, хувь)

Байршил	Түүхий эд бэлтгэл			Борлуулалт		
	Баян-Өлгий	Аймгууд	УБ	Баян-Өлгий	Аймгууд	УБ
Нийслэл хот	46	55	73	4	9	76
У/а эрхэлж буй аймаг	33	45	5	83	82	5
Бусад аймаг	15	8	6	15	13	4
Гадаад улс	37	27	30	10	3	5
Улсын хэмжээнд				2	6	19

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Баян-Өлгий аймгийн судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 29% нь 1-10 сая, 27% нь 10-50 сая төгрөгийн жилийн борлуулалтын орлоготой гэж хариулсан нь аймгуудын дундаж үзүүлэлттэй ойролцоо, 1-10 сая гэсэн хариулт Улаанбаатарынхаас бага үзүүлэлт байлаа.

Зураг 2 ЖДҮ эрхлэгчдийн жилийн борлуулалтын орлого

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Түүвэр судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 77% нь тайлан тэнцэл гаргадаг гэсэн хариулт өгсөн нь аймгуудын дунджаас 12 нэгж хувиар илүү байгаа бол Улаанбаатар хотынхтой ижил байв.


2. ЖДҮ-ийг дэмжих бодлогын арга хэмжээ

ЖДҮ эрхлэгчдийг арилжааны банкууд (62%), засгийн газар (29%), орон нутгийн засаг захиргаа (25%) хамгийн ихээр дэмждэг гэж хариулжээ. Уг үзүүлэлтийн үр дүнг аймгуудын дундаж үзүүлэлттэй харьцуулахад ерөнхий хандлага нь ойролцоо байна.

32 Бизнес регистрийн санд бүртгэлтэй

Зураг 3 ЖДҮ эрхлэгчдийг хамгийн ихээр дэмждэг байгууллага

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Баян-Өлгий аймгийн ЖДҮ эрхлэгчид дээрх байгууллагууд санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгосон гэж дийлэнх нь хариулжээ. Мөн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлсэн, үзэсгэлэн худалдаа зохион байгуулсан, тоног төхөөрөмжийг НӨАТ-аас чөлөөлсөн, сургалт зөвлөгөө явуулсан зэрэг хариултыг бусад хариултаас илүү сонгожээ.

Зураг 4 ЖДҮ-д ямар дэмжлэг үзүүлсэн

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

ЖДҮ-ийг хөгжүүлэхэд үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгох, төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох, татварын таатай орчинг бий болгох, хувийн хэвшил, олон нийтийн оролцоог бизнесийн шийдвэр гаргалтанд нэмэгдүүлэх, авлигыг бууруулах зэрэг арга хэмжээг нэн түрүүнд авах шаардлагатай гэж үзжээ. Аймгууд болон Улаанбаатар хотын нэгдсэн дүнтэй харьцуулахад үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгох гэсэн хариултууд Улаанбаатар хотынхоос илүү, аймгуудын дундаж үзүүлэлтээс бага байв.

Зураг 5 Цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

3. Макро эдийн засгийн орчин

Эдийн засгийн таатай орчин бүрдсэн эсэх талаар асуухад санал асуулгад оролцогчдын 62% нь хангалттай бус, 17% нь огт бүрдээгүй, 8% нь бүрдсэн гэж үзжээ.

Хүснэгт 2 ЖДҮ хөгжих эдийн засгийн таатай орчин бүрдсэн эсэх

(Бусад аймаг болон УБ хоттой харьцуулсан дүн, давхардсан тоогоор, хувь)

ЖДҮ хөгжих орчин	Баян-Өлгий	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Бүрдсэн	8	10	8
Хангалттай бус	62	71	61
Огт бүрдээгүй	17	12	23
Мэдэхгүй	8	6	9

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Харин эдийн засгийн өсөлт ЖДҮ эрхлэгчдийн бизнест хэрхэн нөлөөлж байгаа эсэхийг асуухад 31% нь нөлөөлөөгүй, 21% нь эерэгээр, 27% нь сөргөөр нөлөөлсөн, 13.5% нь мэдэхгүй гэж хариулжээ. Аймгуудын дундажтай харьцуулахад ЭЗ-ийн өсөлт өөрсдийн бизнест эерэгээр нөлөөлсөн гэсэн хариулт 17 нэгж хувиар бага байлаа.

Хүснэгт 3 ЖДҮ хөгжилд эдийн засгийн өсөлтийн үзүүлж буй нөлөө

(Бусад аймаг болон УБ хоттой харьцуулсан дүн, давхардсан тоогоор, хувь)

Эдийн засгийн өсөлт танай бизнест	Баян-Өлгий	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Эергээр	21	38	18
Сөргөөр	27	22	43
Нөлөөлөөгүй	31	19	21
Мэдэхгүй	13	16	18

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Санал асуулгад оролцогчдын дийлэнх хувь нь инфляци болон төгрөгийн ханш тогтвортой байвал эрхэлж буй бизнест нь сайн гэж үзсэн байна.

4. Бизнесийн орчин

Баян-Өлгий аймгийн судалгаанд оролцсон ЖДҮ эрхлэгчдийн бизнесийн орчин бусад аймгуудтай адил ерөнхийдөө сөрөг үнэлгээг өгчээ.

Санхүүжилтийн хувьд боломжийн, муу гэсэн үнэлгээнүүдийг түлхүү өгсөн бөгөөд үзүүлэлт бүрийн үнэлгээ ерөнхийдөө аймгуудын үнэлгээнээс бага зэрэг сайн байлаа. ОУ-ын байгууллагын болон ЗГ-ын хөнгөлөлттэй зээлийн олдоц муу гэж бусад аймгуудын адил үзжээ. Хөрөнгийн зах зээлээс санхүүжилт авах, санхүүжилтийн хүү, хугацаа, хэмжээг боломжийн муу гэсэн үнэлгээний дунджаар үнэлсэн бол бусад үзүүлэлтүүдэд боломжийн үнэлгээг түлхүү өгчээ. Ялангуяа банкны зээл, зээл олгох явцыг боломжийн гэж дүгнэжээ.

Хүснэгт 4 Санхүүжилтийн орчин

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Санхүүжилтийн орчин	Баян-Өлгий	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Олон улсын байгууллагын хөнгөлөлттэй зээлийн о	-1.13	-1.01	-1.02
Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн олдоц	-0.83	-0.93	-1.01
Хөрөнгийн зах зээлээс санхүүжилт авах	-0.63	-0.55	-0.61
Санхүүжилт хүү	-0.56	-0.63	-0.67
санхүүжилтийн хугацаа	-0.48	-0.53	-0.57
санхүүжилтийн хэмжээ	-0.46	-0.47	-0.51
Өөрийн хөрөнгийн хүрэлцээ	-0.23	-0.40	-0.43
санхүүжилтийн барьцаа хөрөнгө	-0.19	-0.42	-0.56
Банк санхүүгийн байгууллагын зээл	-0.17	-0.33	-0.48
Зээлийн батлан даалт	-0.15	-0.30	-0.49
Зээл олгох үйл ажиллагаа	-0.04	-0.18	-0.53
Банкны зээл	0.10	0.02	-0.49

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Баян-Өлгий аймгийн ЖДҮ эрхлэгчид хууль, эрх зүйн зохицуулалтын орчинд ерөнхийдөө боломжийн гэсэн үнэлгээг өгсөн бөгөөд бусад аймгууд, Улаанбаатар хотынхны үнэлгээнээс сайн үзүүлэлттэй байлаа. Төрийн байгууллагын үйлчилгээ, газар эзэмших, хууль эрх зүйн орчинд арай илүү муу үнэлгээг өгсөн бол хяналт шалгалтын тогтолцоо, татварын тогтолцоо, гадаад худалдаа хийх нөхцлийг боломжийн гэж үзсэн байна.

Хүснэгт 5 Хууль эрх зүйн орчин

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Хууль, эрх зүйн зохицуулалтын орчин	Баян-Өлгий	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Төрийн байгууллагын үйлчилгээ	-0.48	-0.58	-0.75
Газар эзэмших	-0.40	-0.32	-0.60
Хууль, эрх зүйн орчин	-0.38	-0.45	-0.65
Гадаад худалдаа хийх нөхцөл	-0.15	-0.48	-0.43
Татварын тогтолцоо	-0.15	-0.44	-0.56
Хяналт, шалгалтын тогтолцоо	0.00	-0.33	-0.52

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Баян-Өлгий аймгийн ЖДҮ эрхлэгчид зах зээлийн орчинг ерөнхийд нь боломжийн гэж дүгнэжээ. Шударга өрсөлдөөн, даатгалын үйлчилгээ, зах зээлийн багтаамжинд өгсөн үнэлгээ арай илүү муу

үнэлгээтэй байсан бол технологийн дэвшил, хэрэглэгчийн худалдан авах чадварт боломжийн үнэлгээг өгчээ. Бусад аймгууд, нийслэлийн үнэлтээтэй харьцуулбал үзүүлэлт бүрийн үнэлгээ сайн үнэлгээтэй байлаа.

Хүснэгт 6 Зах зээлийн орчин

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Зах зээлийн орчин	Баян-Өлгий	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Шударга өрсөлдөөн	-0.37	-0.40	-0.44
Даатгалын үйлчилгээ	-0.31	-0.40	-0.37
Зах зээлийн багтаамж	-0.31	-0.40	-0.37
Технологийн дэвшил	-0.13	-0.33	-0.20
Хэрэглэгчдийн худалдан авах чадвар	-0.04	-0.43	-0.36

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Дэд бүтцийн талаар асуухад зам, тээврийн хөгжил, дулаан, ус хангамжийн асуудалд муу гэж үнэлгээ өгсөн нь Улаанбаатар, аймгуудын дундажтай харьцуулбал муу үзүүлэлт байв. Бусад үзүүлэлтийн хувьд боломжийн сайн гэсэн үнэлгээтэй байгаа нь аймаг, нийслэлийн үзүүлэлтээс сайн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 7 Дэд бүтэц

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Дэд бүтцийн байдал	Баян-Өлгий	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Зам, тээврийн хөгжил	-1.06	-0.55	-0.68
Дулаан, усан хангамж	-0.12	-0.39	-0.25
Цахилгаан хангамж	0.27	-0.03	-0.10
Мэдрэл халбооны хөгжил	0.56	0.31	0.15

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

5. Дотоод орчин

Баян-Өлгий аймгийнхан өөрсдийн дотоод орчноо бусад аймаг, нийслэлчүүдийн адил бага хүндрэлтэй гэж үзжээ. Хамгийн их хүндрэлтэйд нь хүний нөөцийн удирдлага, тоног төхөөрөмжийн чанарыг оруулсан нь аймаг, нийслэлийн үнэлгээтэй ойролцоо байна. Харин түүхий эдийн чанар, ажилчдын чадварыг арай бага хүндрэлтэй гэж дүгнэсэн нь аймгуудын дундаж, нийслэлийнхээс дээгүүр үнэлгээтэй байв.

Хүснэгт 8 Дотоод орчин

(Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4)

Дотоод орчин	Баян-Өлгий	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Хүний нөөцийн удирдлага	-1.33	-1.33	-1.38
Тоног төхөөрөмжийн чанар	-1.29	-1.27	-1.20
Түүхий эдийн чанар	-1.04	-1.13	-1.30
Ажилчдын чадвар	-1.02	-1.31	-1.13

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

6. Зардлын байдал

Баян-Өлгий аймгийн судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчид зардлуудад бага хүндрэлтэй, хүндрэлтэй

гэсэн үнэлгээг түлхүү өгчээ. Хамгийн хүндрэлтэй зардлуудад зээлийн хүүний, шимтгэл хураамжийн төлбөр, түүхий эдийн, тоног төхөөрөмжийн, түрээсийн, зам тээврийн зардлуудыг оруулсан нь бусад аймгууд, Улаанбаатар хотынхны хандлагатай ерөнхийдөө төстэй байна. Бусад зардлуудыг бага хүндрэлтэй гэж үзэж байгаа бөгөөд дулаан, усны, эрчим хүч, цахилгааны зардалд өгсөн үнэлгээ нийслэл, аймгийн дундаж үнэлгээнээс дээгүүр үзүүлэлттэй байна.

Хүснэгт 9 Зардлын байдал

(Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4)

Зардлын байдал	Баян-Өлгий	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Зээлийн хүүний зардал	-1.96	-1.82	-1.89
Шимтгэл, хураамжийн төлбөр	-1.81	-1.72	-1.78
Түүхий эдийн зардал	-1.75	-1.59	-1.62
Тоног төхөөрөмжийн зардал	-1.56	-1.62	-1.62
Түрээсийн зардал	-1.52	-1.48	-1.74
Зам, тээврийн зардал	-1.52	-1.58	-1.62
Захираа, үйл ажиллагааны зардал	-1.35	-1.25	-1.42
Ажиллах хүчний өртөг	-1.17	-1.38	-1.41
Дулаан, усны зардал	-1.13	-1.51	-1.49
Эрчим хүч, цахилгааны зардал	-1.04	-1.50	-1.48
Харилцаа холбооны зардал	-0.98	-0.93	-1.25
Зар сурталчилгааны зардал	-0.92	-1.12	-1.57

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

7. Нийгмийн орчин

Тус аймгынхны хамгийн ихээр сөрөг үнэлгээ өгсөн хэсэгт нийгмийн орчин орж байгаа ба үүнээс ажилгүйдэл, ядууралд их хүндрэлтэй гэсэн хариултыг түлхүү өгсөн нь аймгуудын дундажтай ойролцоо, Улаанбаатарынхнаас бага зэрэг сайн үзүүлэлттэй байна. Мөн хээл хахууль, улс төрийн байдалд хүндрэлтэй гэсэн үнэлгээг өгсөн нь бусад аймгуудтай адил, Улаанбаатарынхнаас бага зэрэг сайн үзүүлэлттэй байна. Гэмт хэрэг, харилцагчийн ёс суртахуун, мэдээллийн хүртээмж, хувийн хэвшлийн оролцоонд өгсөн үнэлгээ Улаанбаатар, аймгуудын дундаж үнэлгээнээс сайн байгаа ба бага хүндрэлтэй, хүндрэлтэй гэсэн үнэлгээний хооронд, ихэнх нь бага хүндрэлтэй гэсэн үнэлгээ түлхүү өгөгджээ.

Хүснэгт 10 Нийгмийн орчин

(Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4)

Нийгмийн орчин	Баян-Өлгий	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Ажилгүйдэл	-2.67	-2.50	-2.75
Ядуурал	-2.48	-2.50	-2.77
Хээл хахууль	-2.31	-2.29	-2.72
Улс төрийн байдал	-2.12	-2.09	-2.46
Гэмт хэрэг	-1.73	-2.15	-2.67
Харилцагчийн ёс суртахуун	-1.50	-1.67	-2.00
Мэдээллийн хүртээмж	-1.37	-1.54	-1.78
Хувийн хэвшил, иргэдийн оролцоо	-1.23	-1.50	-1.91

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн


8. Санхүүжилт

Үйл ажиллагаагаа эхлүүлэхдээ анх ямар эх үүсвэрээр санхүүжсэнийг асуухад 54% нь өөрийн хөрөнгөөр,

37% нь банкны зээлээр, 27% нь гэр, бүл найз нөхдийн хөрөнгөөр, 10% нь хөнгөлөлттэй зээлд хамрагдах замаар санхүүжижсэн байна.

Зураг 6 Анхдагч санхүүжилт

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Өнгөрсөн хугацаанд үйл ажиллагаагаа өрөгжүүлэх, шинээр бизнес эрхлэхдээ 54% нь зээлд хамрагдаж байсан ба тэдгээрийн дийлэнх (67%) банкнаас зээл авсан байна. Зээлээ эргэн төлөхөд ямар хүндрэл учирч байна вэ гэсэн асуултанд 29% нь зээлийн хүүний төлбөр илүү, 29% зээлийн хугацаа богино, 17% нь зээлийн хэмжээ бага гэсэн бол 13% нь хүндрэл тулгараагүй гэж хариулсан байна.

Зураг 7 Зээлийн эргэн төлөлтийн бэрхшээл

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Цаашид үйл ажиллагаагаа явуулахад бусад аймгуудтай ижил судалгаанд хамрагдагсдын дийлэнх (80%) нь санхүүжилт авах хэрэгцээтэй гэжээ. Тэдгээрийн 21% нь 10-50 сая, 19% нь 5-10 сая, 17% нь 50-100 сая, 14% нь 100-500 сая төгрөгийн санхүүжилт шаардлагатай гэжээ. 5-10 сая гэж хариулсан хариултын хувийн жин нь бусад аймгуудын дунджаас нэлээд их, 50-100 сая, 100-500 сая гэсэн хариултын хувийн жин бага зэрэг их байсан бол 10-50 сая гэсэн хариулт аймгуудын дунджаас бага байлаа.

Зураг 8 Шаардлагатай санхүүжилт

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Дүгнэлт

- Судалгаанд хамрагдсан Баян-Өлгий аймгийн 52 ЖДҮ эрхлэгчид олон жилийн туршлагатай, цөөн тооны ажиллагсадтай бөгөөд үйлдвэрлэлийн чиглэлээр түлхүү үйл ажиллагаа эрхэлдэг гэжээ.
- Түүхий эд материалаа нийслэл, өөрийн аймгаасаа голчлон бэлтгэн, аймагтаа борлуулалтаа хийдэг гэжээ. ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх 1-10 сая, 10-50 сая төгрөгийн орлого олдог гэжээ.
- Бусад аймаг, нийслэл хотын судалгааны дүнтэй адил арилжааны банкиг хамгийн их ЖДҮ эрхлэгчдийг дэмждэг гэжээ. Мөн Засгийн газар, орон нутгийн засаг захиргаа дэмждэг гэж багагүй хувь хариулжээ. Дэмжлэг үзүүлэгч байгууллагуудаас санхүүгийн эх үүсвэрийг бий болгосон, үзэсгэлэн худалдаа зохион байгуулсан, сургалт зөвлөгөө явуулсан байна.
- Үндэсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хөнгөлөлттэй санхүүгийн эх үүсвэр бий болгох, хүртээмжийг нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох, бизнестэй холбоотой шийдвэрт хувийн хэвшил, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, татварын таатай орчинг бүрдүүлэх, авлигыг бууруулах арга хэмжээг нэн түрүүнд авах шаардлагатай гэж үзжээ.
- ЖДҮ хөгжих эдийн засгийн таатай орчин хангалттай бус байна гэж дийлэнх нь бусад аймаг, нийслэлчүүдтэй адил дүгнэсэн байна.
- Бизнесийн орчинд өгсөн үнэлгээ ерөнхийдөө сөрөг үнэлгээг өгсөн ч аймгуудын дундажтай үзүүлэлт бүрээрээ дээгүүр буюу сайн үнэлгээтэй байлаа. Хамгийн их сөрөг буюу хүндрэлтэй гэсэн үнэлгээ өгсөн хэсэгт нийгмийн орчин үүнээс ажилгүйдэл, ядуурал, хээл хахууль, Зардлын хэсэг үүнээс зээлийн хүүний, шимтгэл хураамжийн, түүхий эдийн зардлууд орж байна. Харин мэдээлэл, холбооны хөгжил сайн боломжийн, цахилгаан хангамж, банкны зээл, хяналт шалгалтын тогтолцоо гэсэн үзүүлэлтүүд боломжийн гэсэн үнэлгээг авчээ.
- Өөрийн хөрөнгөөр талаас дээш хувь нь үйл ажиллагаагаа эхлүүлсэн гэжээ. Мөн банкны зээл, гэр

бүлийн хамтын хөрөнгөөр багагүй хувь нь бизнесээ эхлүүлжээ.

- Үйл ажиллагаагаа өргөжүүлэх, шинээр бизнес эрхлэхэд мөн талаас дээш хувь нь банкны зээл авсан байна.
- Зээлээ эргэн төлөхөд зээлийн үндсэн хэмжээ багаас үйл ажиллагаагаа хүссэн хэмжээнд явуулж чадаагүй, зээлийн хүүний төлбөр өндөр, хугацаа богино байсан нь хамгийн их бэрхшээл учруулдаг гэжээ.
- Цаашид үйл ажиллагаагаа явуулахад санхүүжилт шаардлагатай гэж дийлэнх нь хариулсан ба 10-50 сая, 5-10 сая, 50-100 сая төгрөг шаардлагатай гэсэн хариулт давамгайлж байв.

Зураг 4 ЖДҮ-д ямар дэмжлэг үзүүлсэн

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

ЖДҮ эрхлэгчдийн үзэж буйгаар юуны өмнө төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох, санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хууль эрх зүйн орчинг сайжруулах, үндэсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, авилгалыг бууруулах зэрэг арга хэмжээнүүдийг нэн түрүүнд авах шаардлагатай гэж үзжээ.

Зураг 5 Цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн


3. Макро эдийн засгийн орчин

Санал асуулганд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 73% нь ЖДҮ хөгжих эдийн засгийн таатай орчин бүрдээгүй, хангалттай бус бүрдсэн, 20% нь мэдэхгүй гэж хариулсан байна. ЖДҮ хөгжих эдийн засгийн таатай орчин бүрдсэн гэж хариулсан аж ахуйн нэгжүүдийн хувь нь бусад аймгуудтай харьцуулахад хамгийн бага байв. Эдийн засгийн өсөлт ЖДҮ эрхлэгчдийн бизнест эерэгээр нөлөөлсөн гэж 29%,

сөргөөр нөлөөлсөн гэж 17%, нөлөөлөөгүй гэж 26%, мэдэхгүй гэж 16% хариулжээ. Инфляцийн түвшин, төгрөгийн ханш тогтвортой байх нь өөрсдийн бизнест сайнаар нөлөөлнө гэж ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх бусад аймгуудын адил үзжээ. Харин төгрөгийн ханш чангарвал сайн гэж хариулсан аж ахуйн нэгжүүдийн хувь бусад аймгуудаас харьцангуй их байв.

Зураг 6 ЖДҮ хөгжих эдийн засгийн таатай орчин бүрдсэн эсэх

(Бусад аймаг болон УБ хоттой харьцуулсан дүн, давхардсан тоогоор, хувь)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

4. Бизнесийн орчин

Булган аймгийн ЖДҮ эрхлэгчид бизнесийн орчинг бусад аймгуудтай адил ерөнхийд нь сөрөг үнэлгээг өгч дүгнэсэн байна.

Хүснэгт 2 Хууль эрх зүйн орчин

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Хууль, эрх зүй, зохицуулалтын орчин	Булган	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Гадаад худалдаа хийх нөхцөл	-0.69	-0.48	-0.43
Төрийн байгууллагын үйлчилгээ	-0.63	-0.58	-0.75
Хууль, эрх зүйн орчин	-0.51	-0.45	-0.65
Газар эзэмших	-0.39	-0.32	-0.60
Татварын тогтолцоо	-0.31	-0.44	-0.56
Хяналт, шалгалтын тогтолцоо	-0.16	-0.33	-0.52

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Хууль, эрх зүй, зохицуулалтын орчинд гадаад худалдаа хийх нөхцөл нь аймгуудын дундаж, Улаанбаатар хотынхоос илүү сөрөг үнэлгээтэй байв. Харин татвар, хяналт, шалгалтын тогтолцоог нийслэл хот, бусад аймгуудаас харьцангуй боломжийн гэж үзжээ.

Хүснэгт 3 Дэд бүтэц

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Дэд бүтцийн байдал	Булган	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Дулаан, усан хангамж	-0.33	-0.39	-0.25
Зам, тээврийн хөгжил	-0.02	-0.55	-0.68
Цахилгаан хангамж	0.02	-0.03	-0.10
Мэдээлэл холбооны хөгжил	0.25	0.31	0.15

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Дулаан, усан хангамжинд боломжийн, муу гэсэн үнэлгээг өгсөн нь аймгуудын дунджаас бага зэрэг эерэг, Улаанбаатарынхнаас бага зэрэг сөрөг байв. Зам, тээврийн хөгжилд Булган аймгийн ЖДҮ эрхлэгчид аймгуудын дундажтай харьцуулахад харьцангуй сайн үнэлгээ өгч ерөнхийд нь боломжийн гэж дүгнэжээ. Харин мэдээлэл холбооны хөгжил, цахилгаан хангамжинд боломжийн, сайн гэсэн үнэлгээг түлхүү өгсөн ба эдгээр нь Улаанбаатар хотын үзүүлэлтээс дээгүүр үнэлгээг авчээ. Мэдээлэл холбооны хөгжлийн хувьд аймгуудын дунджаас доогуур үнэлгээтэй байв.

Хүснэгт 4 Санхүүжилтийн орчин

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Санхүүжилтийн орчин	Булган	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн олдоц	-0.82	-0.93	-1.01
Олон улсын байгууллагын хөнгөлөлттэй зээлийн олдоц	-0.69	-1.01	-1.02
Хөрөнгийн зах зээлээс санхүүжилт авах	-0.49	-0.55	-0.61
Санхүүжилтийн хүү	-0.33	-0.63	-0.67
Санхүүжилтийн барьцаа хөрөнгө	-0.31	-0.42	-0.56
Өөрийн хөрөнгийн хүрэлцээ	-0.27	-0.40	-0.43
Банк бус санхүүгийн байгууллагын зээл	-0.27	-0.33	-0.48
Санхүүжилтийн хэмжээ	-0.24	-0.47	-0.51
Санхүүжилтийн хугацаа	-0.18	-0.53	-0.57
Зээлийн батлан даалт	-0.10	-0.30	-0.49
Зээл олгох үйл ажиллагаа	-0.04	-0.18	-0.53
Банкны зээл	-0.02	0.02	-0.49

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Санхүүжилтийн хувьд Булган аймгийнхан ОУ-ын байгууллага болон ЗГ-ын хөнгөлөлттэй зээлийн олдоц муу гэж бусад аймгууд болон нийслэлийхний нэг адил үзжээ. Санхүүжилтийн хугацаа, хэмжээ зэрэг бусад асуултанд боломжийн, муу гэсэн хариултыг түлхүү өгсөн бөгөөд аймгуудын дундаж, Улаанбаатар хотынхны өгсөн үнэлгээнээс боломжийн гэсэн үнэлгээ нь арай их байв.

Хүснэгт 5 Зах зээлийн орчин

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Зах зээлийн орчин	Булган	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Хэрэглэгчдийн худалдан авах чадвар	-0.53	-0.43	-0.36
Зах зээлийн багтаамж	-0.35	-0.40	-0.37
Шударга өрсөлдөөн	-0.33	-0.40	-0.44
Технологийн дэвшил	-0.27	-0.33	-0.20
Даатгалын үйлчилгээ	-0.20	-0.40	-0.37

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Зах зээлийн орчны хувьд хэрэглэгчдийн худалдан авах чадвар нь аймгуудын дундаж болон нийслэл хотынхоос харьцангуй муу үнэлгээтэй байв. Харин бусад үзүүлэлтүүдэд Булган аймгийнхан арай илүү эерэгээр хариулжээ.

5. Дотоод орчин

Булган аймгийн ЖДҮ эрхлэгчид өөрсдийн дотоод орчиндоо ерөнхийд нь хүндрэлтэй гэсэн үнэлгээг

өгсөн бөгөөд хүний нөөцийн удирдлага, тоног төхөөрөмжийн чанар эдгээрээс арай илүү хүндрэлтэй гэж хариулжээ.

Хүснэгт 6 Дотоод орчин

(Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4)

Дотоод орчин	Булган	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Хүний нөөцийн удирдлага	-1.53	-1.38	-1.33
Тоног төхөөрөмжийн чанар	-1.45	-1.20	-1.27
Түүхий эдийн чанар	-1.37	-1.30	-1.13
Ажилчдын чадвар	-1.27	-1.13	-1.31

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

6. Зардлын байдал

Зардлуудад ерөнхийд нь хүндрэлтэй, бага хүндрэлтэй гэсэн үнэлгээг өгчээ. Хамгийн хүндрэлтэй зардлуудад түрээсийн зардал, түүхий эд, тоног төхөөрөмжийн зардлуудыг дурьдсан бөгөөд эдгээр нь бусад аймаг, Улаанбаатар хотынхоос илүү хүндрэлтэй гэсэн үнэлгээ өгчээ. Харин зээлийн хүүний зардал аймгуудын дундаж болон нийслэл хотынхоос бага хүндрэлтэй гэж ЖДҮ эрхлэгчд хариулсан байна.

Хүснэгт 7 Зардлын байдал

(Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4)

Зардлын байдал	Булган	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Түрээсийн зардал	-1.80	-1.48	-1.74
Тоног төхөөрөмжийн зардал	-1.75	-1.62	-1.62
Түүхий эдийн зардал	-1.73	-1.59	-1.62
Шимтгэл, хураамжийн төлбөр	-1.71	-1.72	-1.78
Зам, тээврийн зардал	-1.59	-1.58	-1.62
Зээлийн хүүний зардал	-1.59	-1.82	-1.89
Дулаан, усны зардал	-1.51	-1.51	-1.49
Захиргаа, үйл ажиллагааны зардал	-1.45	-1.25	-1.42
Зар сурталчилгааны зардал	-1.45	-1.12	-1.57
Ажиллах хүчний өртөг	-1.41	-1.38	-1.41
Эрчим хүч, цахилгааны зардал	-1.39	-1.50	-1.48
Харилцаа холбооны зардал	-1.22	-0.93	-1.25

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

7. Нийгмийн орчин

Булган аймгынхны хамгийн ихээр сөрөг үнэлгээ өгсөн хэсэгт нийгмийн орчин орж байгаа ба үүнээс ажилгүйдэл, ядуурал, хээл хахууль, гэмт хэрэг илүү хүндрэлтэй гэсэн үнэлгээг өгсөн нь бусад аймгууд, Улаанбаатар хотынхтой адил байна.

Хүснэгт 8 Нийгмийн орчин

(Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4)

Нийгмийн орчин	Булган	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Ажилгүйдэл	-2.88	-2.50	-2.75
Ядуурал	-2.76	-2.50	-2.77
Хээл хахууль	-2.53	-2.29	-2.72
Гэмт хэрэг	-2.49	-2.15	-2.67
Улс төрийн байдал	-2.41	-2.09	-2.46
Мэдээллийн хүртээмж	-2.02	-1.54	-1.78
Харилцагчийн ёс суртахуун	-1.96	-1.67	-2.00
Хувийн хэвшил, иргэдийн оролцоо	-1.63	-1.50	-1.91

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

8. Санхүүжилт

ЖДҮ эрхлэгчид голдуу банкны зээл болон өөрийн хөрөнгөөр үйл ажиллагаагаа эхлүүлжээ. Тухайлбал, нийт судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн 51% нь банкнаас зээл авсан бол 57% нь өөрийн хөрөнгөө ашигласан байна. Банкны зээл болон өөрийн хөрөнгөөр санхүүжигдсэн гэсэн хариулт аймгуудын дунджаас бага зэрэг илүү, харин гэр бүлийн хамтын хөрөнгөөр гэсэн хариулт нь ойролцоо байв.

Зураг 7 Анхдагч санхүүжилт

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

ЖДҮ эрхлэгчдийн 67% нь үйл ажиллагаагаа өргөжүүлэх буюу шинээр бизнес эрхлэхэд зээл авсан бөгөөд дийлэнх нь банкны зээл болон хөнгөлөлттэй зээлд хамрагдсан байна. Зээлээ эргэн төлөхөд 25% нь зээлийн хугацаа богино, 22% нь зээлийн хүүний төлбөр өндөр, 20% нь зээлийн үндсэн хэмжээ бага гэж үзжээ. Зээлийг эргэн төлөхөд хүндрэлгүй гэсэн хариултын хувь аймгуудын дунджаас их байсан бол зээлийн хүүний төлбөр өдөр гэж хариулсан ЖДҮ эрхлэгчдийн хувь аймгуудын дунджаас бага байв.

Зураг 8 Зээлийн эргэн төлөлтийн бэрхшээл

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Цаашид санал асуулганд оролцогчдын 80% нь зээл авах бодолтой байгаа бөгөөд 29% нь 10-50 сая төгрөг, 22% нь 1-5 сая төгрөг, 22% нь 50-100 сая төгрөг, 17% нь 5-10 сая төгрөгийн зээл авах шаардлагатай гэж үзжээ.

Зураг 9 Шаардлагатай санхүүжилт

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Дүгнэлт

- Булган аймгийн ЖДҮ эрхлэгчд худалдааны чиглэлээр түлхүү үйл ажиллагаагаа явуулдаг. Түүхий эд материалаа нийслэл хот, өөрийн аймгаасаа бэлтгэн, голчлон аймагтаа борлуулалтаа хийдэг.
- ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх 1-10 сая, 10-50 сая төгрөгийн орлоготой. Арилжааны банкныг хамгийн их ЖДҮ эрхлэгчдийг дэмждэг гэж хариулсан байна. Үүний дараагаар орон нутгийн засаг захиргаа, Засгийн газар гэж үзсэн байна.
- Дэмжлэг үзүүлэгч байгууллагууд санхүүгийн эх үүсвэрийг бий болгосон, сургалт зөвлөгөө явуулсан, эрх зүйн орчинг сайжруулсан гэж үзжээ.
- Төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох, санхүүгийн эх үүсвэр бий болгох, хууль эрх зүйн орчинг сайжруулах, үндэсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх арга хэмжээг нэн түрүүнд авах шаардлагатай гэж хариулсан байна.
- ЖДҮ хөгжих эдийн засгийн таатай орчин хангалттай бус байна гэж дийлэнх нь бусад аймаг, нийслэлчүүдтэй адил дүгнэсэн.

- Бизнесийн орчинд Булган аймгийнхны хамгийн их сөрөг буюу хүндрэлтэй гэсэн үнэлгээ өгсөн хэсэг нь нийгмийн орчин байв. Зардлын хэсэгт түрээсийн, тоног төхөөрөмжийн, түүхий эдийн зардлууд хамгийн хүндрэлтэй гэж хариулжээ. Зээлийн хүүний зардлыг бусад аймгуудтай харьцуулахад харьцангуй хүндрэл багатай байв.
- Мэдээлэл, холбооны хөгжил, банкны зээл, цахилгаан хангамж гэсэн үзүүлэлтүүд боломжийн гэсэн үнэлгээг авчээ.
- ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх нь банкны зээл болон өөрийн хөрөнгөөр үйл ажиллагаагаа эхлүүлсэн бөгөөд үйл ажиллагаагаа өргөжүүлэх, шинээр бизнес эрхлэхэд банкны зээл авсан байна. Зээлээ эргэн төлөхөд зээлийн хугацаа богино, хүүний төлбөр өндөр, зээлийн үндсэн хэмжээ бага байсан нь хамгийн их бэрхшээл учруулдаг гэжээ. Цаашид үйл ажиллагаагаа явуулахад 24% нь 10-50 сая төгрөг, 18% нь 1-5 сая төгрөг, 18% нь 50-100 сая төгрөгийн санхүүжилт шаардлагатай гэж хариулсан байна.


Говь-Алтай аймаг

1. Ерөнхий мэдээлэл

Говь-Алтай аймагт 2011 оны 1 дүгээр улирлын байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа 442³⁴ ААН-ээс санамсаргүй түүврийн аргаар 50 жижиг дунд бизнес эрхлэгчийг судалгаанд хамрууллаа. Говь-Алтай аймгийн ЖДҮ эрхлэгчдээс 78% нь ХХК, 14% нь иргэд байсан бөгөөд дийлэнх нь дотоодын хөрөнгө оруулалттай үйл ажиллагаагаа явуулдаг байна. Бусад аймгуудтай харьцуулахад ХХК хэлбэртэй аж ахуйн нэгжүүдийн хувь нь харьцангуй их байгаа бөгөөд харин эсрэгээр ЖДҮ эрхэлдэг иргэдийн хувь нь бага байна. Тус аймагт судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 34% нь худалдаа, 50% нь үйлчилгээ, 16% нь үйлдвэрлэл эрхэлдэг гэжээ. Үйлчилгээ чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн хувь нь бусад аймгуудын дунджаас 21 нэгж хувиар илүү байсан бол үйлдвэрийн чиглэлийнх нь 24 нэгж хувиар бага байв.

Зураг 1 ЖДҮ эрхлэгчдийн үйл ажиллагааны чиглэл

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

ЖДҮ эрхлэгчдийн 92% нь бараа, үйлчилгээгээ тухайн аймагтаа борлуулдаг бөгөөд 60.0% нь түүхий эд, материалаа нийслэл хот, 46.0% нь тухайн аймгаасаа авдаг гэж хариулжээ. Харин гадаадаас түүхий эд, материалаа оруулж ирдэг аж ахуйн нэгжүүдийн % нь орон нутгийн дунджаас харьцангуй бага байв.

Хүснэгт 1 Түүхий эд материалын бэлтгэл, бараа бүтээгдэхүүний борлуулалт

(Бусад аймаг болон УБ хоттой харьцуулсан дүн, давхардсан тоогоор, хувь)


Байршил	Түүхий эд бэлтгэл			Борлуулалт		
	Говь-Алтай	Аймгууд	УБ	Говь-Алтай	Аймгууд	УБ
Нийслэл хот	60	55	73	2	9	76
У/а эрхэлж буй аймаг	46	45	5	92	82	5
Бусад аймаг	6	8	6	4	13	4
Гадаад улс	14	27	30	2	3	5
Улсын хэмжээнд				2	6	19

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн 44% нь үйл ажиллагаагаа 1-5 жил, 28% нь 5-10 жил, 22% нь 10-аас дээш жил эрхэлж байгаа бөгөөд 66% нь 1-9, 24% нь 10-49, 6% нь 50-99, 2% нь 150-199 ажиллагсадтай байна.

Зураг 2 ЖДҮ эрхлэгчдийн жилийн борлуулалтын орлого

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн


Түүнчлэн түүвэр судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 78% нь тайлан тэнцэл гаргадаг гэж хариулсан нь аймгуудын дунджаас 13 нэгж хувиар илүү үзүүлэлттэй байна.

2. ЖДҮ-ийг дэмжих бодлогын арга хэмжээ

ЖДҮ-ийг хамгийн их дэмждэг нь арилжааны банкууд, Засгийн газар болон олон улсын байгууллагууд гэж хариулсан байна. Харин бага дэмжлэг үзүүлдэг байгууллагуудын тоонд Үйлдвэр эрхлэгчдийн холбоо, бусад санхүүгийн байгууллага, Худалдаа, аж үйлдвэрийн тэнхим зэрэг байгууллагууд орсон байна.

Зураг 3 ЖДҮ эрхлэгчдийг хамгийн ихээр дэмждэг байгууллага

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

ЖДҮ эрхлэгчдэд ямар дэмжлэг үзүүлсэн гэсэн асуултанд дийлэнх нь санхүүгийн эх үүсвэр бий болгосон гэсэн бөгөөд энэхүү дэмжлэгийг голдуу банкууд үзүүлсэн байна. Харин бусад дэмжлэгт нь сургалт, зөвлөгөө, эрх зүйн орчинг сайжруулсан, үзэсгэлэн, худалдаа зохион байгуулсан гэсэн хариултыг харьцангуй түлхүү өгчээ. Мэдэхгүй болон ямарваа нэгэн дэмжлэг үзүүлдэггүй гэсэн хариултыг санал асуулганд оролцогчдын 22% нь өгсөн байна.

³⁴ Бизнес регистрийн санд бүртгэлтэй

Зураг 4 ЖДҮ-д ямар дэмжлэг үзүүлсэн

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

ЖДҮ эрхлэгчдийн үзэж буйгаар юуны өмнө татварын таатай орчинг бүрдүүлэх, төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох, санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, дэд бүтцийг сайжруулах зэрэг арга хэмжээнүүдийг нэн түрүүнд авах шаардлагатай гэж үзсэн байна. Бусад аймгуудтай харьцуулахад цаашид авах арга хэмжээнүүдээс татварын таатай орчинг бүрдүүлэх болон дэд бүтцийг сайжруулах дээр ЖДҮ эрхлэгчид илүү анхаарал хандуулсан байна.

Зураг 5 Цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн


3. Макро эдийн засгийн орчин

Санал асуулганд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 84% нь ЖДҮ хөгжих эдийн засгийн таатай орчин огт бүрдээгүй, хангалттай бус бүрдсэн гэж хариулсан байна. Эдийн засгийн өсөлт ЖДҮ эрхлэгчдийн бизнест эерэгээр нөлөөлсөн гэж 42%, сөргөөр нөлөөлсөн гэж 24%, нөлөөлөөгүй гэж 18%, мэдэхгүй гэж 24.5% хариулжээ. Инфляцийн түвшин, төгрөгийн ханш тогтвортой байх нь өөрсдийн бизнест сайн гэж ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх бусад аймгуудын адил үзжээ. Харин төгрөгийн ханш

чангарвал сайн гэж хариулсан аж ахуйн нэгжүүдийн хувь бусад аймгуудынхаас харьцангуй их байв.

Зураг 6 ЖДҮ хөгжих эдийн засгийн таатай орчин бүрдсэн эсэх

(Бусад аймаг болон УБ хоттой харьцуулсан дүн, давхардсан тоогоор, хувь)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

4. Бизнесийн орчин

Говь-Алтай аймгийн ЖДҮ эрхлэгчид бизнесийн орчинг бусад аймгуудтай адил ерөнхийд нь сөргөөр дүгнэсэн байна.

Хүснэгт 2 Хууль эрх зүйн орчин

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Хууль, эрх зүй, зохицуулалтын орчин	Говь-Алтай	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Төрийн байгууллагын үйлчилгээ	-0.68	-0.58	-0.75
Татварын тогтолцоо	-0.52	-0.44	-0.56
Газар эзэмших	-0.52	-0.32	-0.60
Хууль, эрх зүйн орчин	-0.50	-0.45	-0.65
Гадаад худалдаа хийх нөхцөл	-0.46	-0.48	-0.43
Хяналт, шалгалтын тогтолцоо	-0.14	-0.33	-0.52

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

ЖДҮ эрхлэгчид хууль, эрх зүй, зохицуулалтын орчинг дүгнэхдээ төрийн байгууллагын үйлчилгээнд муу үнэлгээг түлхүү өгсөн байна. Харин хяналт, шалгалтын тогтолцоог нийслэл хот, бусад аймгуудаас илүүтэйгээр боломжийн гэж хариулжээ. Бусад үзүүлэлтүүд нь ерөнхийд нь аймгуудын дундажтай ойролцоо байв.

Хүснэгт 3 Дэд бүтэц

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Дэд бүтцийн байдал	Говь-Алтай	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Зам, тээврийн хөгжил	-1.20	-0.55	-0.68
Дулаан, усан хангамж	-0.84	-0.39	-0.25
Цахилгаан хангамж	-0.44	-0.03	-0.10
Мэдээлэл холбооны хөгжил	0.46	0.31	0.15

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Зам, тээврийн хөгжил, дулаан, усан хангамж, цахилгаан хангамжинд аймгуудын дундаж болон Улаанбаатар хотынхоос нэлээд сөргөөр үнэлжээ. Мэдээлэл холбооны хөгжлийн хувьд бусад

аймгуудтай адил боломжийн ба сайн үнэлгээ түлхүү өгсөн бөгөөд аймгуудын дунджаас дээгүүр үнэлгээтэй байв.

Хүснэгт 4 Санхүүжилтийн орчин

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Санхүүжилтийн орчин	Говь-Алтай	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Олон улсын байгууллагын хөнгөлөлттэй зээлийн олдоц	-1.14	-1.01	-1.02
Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн олдоц	-1.08	-0.93	-1.01
Санхүүжилтийн хүү	-0.68	-0.63	-0.67
Хөрөнгийн зах зээлээс санхүүжилт авах	-0.56	-0.55	-0.61
Санхүүжилтийн хугацаа	-0.56	-0.53	-0.57
Санхүүжилтийн хэмжээ	-0.44	-0.47	-0.51
Банк бус санхүүгийн байгууллагын зээл	-0.40	-0.33	-0.48
Зээлийн батлан даалт	-0.38	-0.30	-0.49
Өөрийн хөрөнгийн хүрэлцээ	-0.36	-0.40	-0.43
Санхүүжилтийн барьцаа хөрөнгө	-0.36	-0.42	-0.56
Зээл олгох үйл ажиллагаа	-0.12	-0.18	-0.53
Банкны зээл	0.06	0.02	-0.49

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Санхүүжилтийн хувьд Говь-Алтай аймгийнхан ОУ-ын байгууллага болон ЗГ-ын хөнгөлөлттэй зээлийн олдоц муу, санхүүжилтийн хүү өндөр гэж бусад аймгууд болон нийслэлийхний нэг адил үзжээ. Банкны зээлийг ерөнхийд нь боломжийн гэж дүгнэсэн бөгөөд санхүүжилтийн хүү, хугацаа, хэмжээ зэрэг бусад асуултанд боломжийн, муу гэсэн хариултыг түлхүү өгсөн байна.

Хүснэгт 5 Зах зээлийн орчин

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Зах зээлийн орчин	Говь-Алтай	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Хэрэглэгчдийн худалдан авах чадвар	-0.74	-0.43	-0.36
Зах зээлийн багтаамж	-0.72	-0.40	-0.37
Технологийн дэвшил	-0.48	-0.33	-0.20
Шударга өрсөлдөөн	-0.46	-0.40	-0.44
Даатгалын үйлчилгээ	-0.42	-0.40	-0.37

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Зах зээлийн орчинд муу, боломжийн гэсэн үнэлгээг түлхүү өгсөн ба бусад аймгууд, Улаанбаатар хотынхтой харьцуулбал хэрэглэгчийн худалдан авах чадвар, зах зээлийн багтаамж, технологийн дэвшилээр илүү муу үнэлгээтэй байна.

5. Дотоод орчин

ЖДҮ эрхлэгчид өөрсдийн дотоод орчиндоо ерөнхийдөө бага хүндрэлтэй, хүндрэлтэй гэсэн үнэлгээг өгчээ. Эдгээрээс ажилчдын чадвар арай илүү хүндрэлтэй үнэлгээг авсан нь аймаг, нийслэлийн дунджаас илүү хүндрэлтэй үнэлгээтэй байв.

Хүснэгт 6 Дотоод орчин

(Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4)

Дотоод орчин	Говь-Алтай	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Ажилчдын чадвар	-1.40	-1.31	-1.13
Хүний нөөцийн удирдлага	-1.26	-1.33	-1.38
Түүхий эдийн чанар	-1.24	-1.13	-1.30
Тоног төхөөрөмжийн чанар	-1.10	-1.27	-1.20

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

6. Зардлын байдал

Говь-Алтай аймгийн ЖДҮ эрхлэгчид дулаан, усны зардал, эрчим хүч, цахилгааны зардал, зам, тээврийн зардлыг хүндрэлтэй ба их хүндрэлтэй гэж хариулсан бөгөөд эдгээр үзүүлэлтүүдийг нийслэл хот болон аймгуудын дундажтай харьцуулахад илүү сөргөөр дүгнэсэн байна. Тоног төхөөрөмжийн зардал, захиргаа, үйл ажиллагааны зардалд өгсөн үнэлгээ аймаг нийслэлийн дунджаас доогуур байв.

Хүснэгт 7 Зардлын байдал

(Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4)

Зардлын байдал	Говь-Алтай	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Дулаан, усны зардал	-2.36	-1.51	-1.49
Эрчим хүч, цахилгааны зардал	-2.26	-1.50	-1.48
Зээлийн хүүний зардал	-2.26	-1.82	-1.89
Зам, тээврийн зардал	-2.14	-1.58	-1.62
Шийтгэл, хураамжийн төлбөр	-1.86	-1.72	-1.78
Түүхий эдийн зардал	-1.84	-1.59	-1.62
Түрээсийн зардал	-1.62	-1.48	-1.74
Тоног төхөөрөмжийн зардал	-1.60	-1.62	-1.62
Ажиллах хүчний өртөг	-1.52	-1.38	-1.41
Зар сурталчилгааны зардал	-1.30	-1.12	-1.57
Захиргаа, үйл ажиллагааны зардал	-1.12	-1.25	-1.42
Хариуцаа холбооны зардал	-0.98	-0.93	-1.25

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

7. Нийгмийн орчин

Говь-Алтай аймгийнхны хамгийн ихээр сөрөг үнэлгээ өгсөн хэсэгт нийгмийн орчин орж байгаа ба үүнээс ажилгүйдэл, ядуурал, хээл хахуульд их хүндрэлтэй, хүндрэлтэй гэсэн хариултыг түлхүү өгчээ.

Хүснэгт 8 Нийгмийн орчин

(Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4)

Нийгмийн орчин	Говь-Алтай	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Ядуурал	-2.78	-2.50	-2.77
Ажилгүйдэл	-2.74	-2.50	-2.75
Хээл хахууль	-2.46	-2.29	-2.72
Гэмт хэрэг	-2.20	-2.15	-2.67
Улс төрийн байдал	-1.88	-2.09	-2.46
Хариуцагчийн ёс суртахуун	-1.82	-1.67	-2.00
Мэдээллийн хүртээмж	-1.56	-1.54	-1.78
Хувийн хэвшил, иргэдийн оролцоо	-1.24	-1.50	-1.91

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

8. Санхүүжилт

ЖДҮ эрхлэгчид голдуу өөрийн хөрөнгө, гэр бүлийн хамтын хөрөнгө болон банкны зээлээр үйл

ажиллагаагаа эхлүүлжээ. Гэр бүлийн хамтын хөрөнгөөр санхүүжигдсэн гэсэн хариулт Улаанбаатар, аймгуудын дунджаас нэлээд илүү байв.

Зураг 7 Анхдагч санхүүжилт

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

ЖДҮ эрхлэгчдийн 59% нь үйл ажиллагаагаа өргөжүүлэх буюу шинээр бизнес эрхлэхэд зээл авсан байна. Зээлийн эргэн төлөлт дээр 12% нь хүндрэлгүй гэж хариулсан бол 36% нь зээлийн хүүний төлбөр өндөр, 26% нь зээлийн хугацаа богино, 18% нь зээлийн хэмжээ бага гэж хариулжээ. Зээлийн эргэн төлөлтийн хандлага нь үндсэндээ бусад аймгуудын дундажтай ижил байна.

Зураг 8 Зээлийн эргэн төлөлтийн бэрхшээл

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Цаашид санал асуулганд оролцогчдын 68% нь үйл ажиллагаа явуулахад санхүүжилт авах хэрэгцээтэй гэсэн бөгөөд тэдгээрийн 47% нь 10-50 сая төгрөг, 18% нь 50-100 сая төгрөг, 18% нь 100-500 сая төгрөгийн санхүүжилт шаардлагатай гэж үзжээ.

Зураг 9 Шаардлагатай санхүүжилт

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Дүгнэлт

- Говь-Алтай аймгийн ЖДҮ эрхлэгчд үйлдвэрлэл, худалдааны чиглэлээр түлхүү үйл ажиллагаа эрхэлдэг.
- Түүхий эд материалаа нийслэл хот, өөрийн аймгаасаа бэлтгэн, голчлон аймагтаа борлуулалтаа хийдэг.
- ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх 1-10 сая, 10-50 сая төгрөгийн орлого олдог гэжээ.
- Арилжааны банкныг хамгийн их ЖДҮ эрхлэгчдийг дэмждэг гэж бусад аймгуудтай адил хариулсан байна. Үүний дараагаар Засгийн газар, олон улсын байгууллагууд гэж хариулав.
- Дэмжлэг үзүүлэгч байгууллагууд санхүүгийн эх үүсвэрийг бий болгосон, үзэсгэлэн худалдаа зохион байгуулсан, инкубатор төвүүдийг байгуулсан гэжээ.
- Татварын таатай орчинг бүрдүүлэх, төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох, санхүүгийн эх үүсвэр бий болгох арга хэмжээг нэн түрүүнд авах шаардлагатай гэж хариулсан байна.
- ЖДҮ хөгжих эдийн засгийн таатай орчин хангалттай бус байна гэж дийлэнх нь бусад аймаг, нийслэлчүүдтэй адил дүгнэсэн.
- Бизнесийн орчинд Говь-Алтай аймгийнхны хамгийн их сөрөг буюу хүндрэлтэй гэсэн үнэлгээ өгсөн хэсэг нь нийгмийн орчин байв.
- Зардлын хэсэгт дулаан, усны, эрчим хүч, цахилгааны, зээлийн хүүний зардлууд хамгийн хүндрэлтэй гэж хариулжээ.
- Мэдээлэл, холбооны хөгжил, банкны зээл, цахилгаан хангамж гэсэн үзүүлэлтүүд бусад аймгуудынхтай адил боломжийн гэсэн үнэлгээг авчээ.
- ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх нь банкны зээл болон өөрийн хөрөнгөөр үйл ажиллагаагаа эхлүүлсэн бөгөөд үйл ажиллагаагаа өргөжүүлэх, шинээр бизнес эрхлэхэд банкны зээл авсан байна.
- Зээлээ эргэн төлөхөд зээлийн хугацаа богино, хүүний төлбөр өндөр, зээлийн үндсэн хэмжээ бага байсан нь хамгийн их бэрхшээл учруулдаг гэжээ.
- Цаашид үйл ажиллагаагаа явуулахад 32% нь 10-50 сая төгрөг, 12% нь 50-100 сая төгрөг, 12% нь 100-

500 сая төгрөгийн санхүүжилт шаардлагатай гэж хариулсан байна.


Говьсүмбэр аймаг

1. Ерөнхий мэдээлэл

Говьсүмбэр аймагт 2011 оны 1 дүгээр улирлын байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа 151³⁵ ААН-ээс санамсаргүй түүврийн аргаар 49 жижиг дунд бизнес эрхлэгчийг судалгаанд хамрууллаа. Говьсүмбэр аймгийн ЖДҮ эрхлэгчдээс санал асуулга авсны 67% нь иргэд, 22% нь ХХК байсан бөгөөд дийлэнх нь дотоодын хөрөнгө оруулалттай үйл ажиллагаагаа явуулдаг байна. Бусад аймгуудтай харьцуулахад ЖДҮ эрхэлдэг иргэдийн хувь нь хамгийн их байв. Тус аймагт судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 20% нь худалдаа, 47% нь үйлчилгээ, 33% нь үйлдвэрлэл эрхэлдэг гэжээ. Үйлчилгээ чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн хувь нь аймгуудын дунджаас 18 нэгж хувиар илүү байсан бол үйлдвэрийн чиглэлийнх нь 7 нэгж хувиар бага байв.

Зураг 1 ЖДҮ эрхлэгчдийн үйл ажиллагааны чиглэл

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Түүхий эд материалаа бусад аймгуудын адил дийлэнх нь өөрийн аймаг, нийслэл хотоос бэлтгэн, бараа үйлчилгээгээ мөн өөрийн аймаг болон Улаанбаатар хотод борлуулдаг гэжээ.

Хүснэгт 1 Түүхий эд материалын бэлтгэл, бараа бүтээгдэхүүний борлуулалт

(Бусад аймаг болон УБ хоттой харьцуулсан дүн, давхардсан тоогоор, хувь)


Байршил	Түүхий эд бэлтгэл			Борлуулалт		
	Говьсүмбэр	Аймгууд	УБ	Говьсүмбэр	Аймгууд	УБ
Нийслэл хот	53	55	73	12	9	76
У/а эрхэлж буй аймаг	45	45	5	84	82	5
Бусад аймаг	8	8	6	10	13	4
Гадаад улс	14	27	30	2	3	5
Улсын хэмжээнд				4	6	19
Нийт	120	136	115	112	113	109

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн 42.9% нь үйл ажиллагаагаа 1-5 жил, 20.4% нь 5-10 жил, 22.4% нь 10-аас дээш жил эрхэлж байгаа бөгөөд 78% нь 1-9, 20% нь 10-49 ажиллагсадтай байна.

Зураг 2 ЖДҮ эрхлэгчдийн жилийн борлуулалтын орлого

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн


Түүнчлэн түүвэр судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 43% нь тайлан тэнцэл гаргадаг гэж хариулсан нь аймгуудын дунджаас 22 нэгж хувиар бага үзүүлэлттэй байна.

2. ЖДҮ-ийг дэмжих бодлогын арга хэмжээ

Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх орон нутгийн засаг захиргаа ЖДҮ-ийг хамгийн их дэмждэг гэж хариулжээ. Үүний дараагаар арилжааны банк, Засгийн газар гэж үзсэн байна. Харин бага дэмжлэг үзүүлдэг байгууллагуудын тоонд Үйлдвэр эрхлэгчдийн холбоо, бусад санхүүгийн байгууллага, олон улсын байгууллагууд орсон байна. Бусад аймгуудтай харьцуулахад Засгийн газар, орон нутгийн захиргаа ЖДҮ-ийг дэмждэг гэсэн хариулт илүү байв. Ялангуяа санал асуулганд оролцогчдын 57% нь орон нутгийн засаг захиргааг дэмждэг гэж хариулсан нь улсын хэмжээнд хамгийн их байв.

Зураг 3 ЖДҮ эрхлэгчдийг хамгийн ихээр дэмждэг байгууллага

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

ЖДҮ эрхлэгчдэд ямар дэмжлэг үзүүлсэн гэсэн асуултанд бусад аймгуудтай адил дийлэнх нь санхүүгийн эх үүсвэр бий болгосон, үзэсгэлэн худалдаа зохион байгуулсан, сургалт, зөвлөгөө зохион байгуулсан гэж хариулжээ. Эрх зүйн орчинг сайжруулсан гэж үзэж буй аж ахуйн нэгжүүдийн хувь нь бусад бүх аймгуудынхаас мэдэгдэхүйц илүү байв.

35 Бизнес регистрийн санд бүртгэлтэй

Зураг 4 ЖДҮ-д ямар дэмжлэг үзүүлсэн

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

ЖДҮ эрхлэгчдийн үзэж буйгаар юуны өмнө төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох, санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, татварын таатай орчин бүрдүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг нэн түрүүнд авах шаардлагатай гэж үзсэн байна. Харин бусад аймгуудтай харьцуулахад цаашид авах арга хэмжээнүүдээс дэд бүтцийг сайжруулахыг ЖДҮ эрхлэгчид төдийлөн чухал гэж үзээгүй.

Зураг 5 Цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн


3. Макро эдийн засгийн орчин

Санал асуулганд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 69% нь ЖДҮ хөгжих эдийн засгийн таатай орчин бүрдээгүй гэж хариулсан байна. ЖДҮ хөгжих эдийн засгийн таатай орчин бүрдсэн гэж хариулсан аж ахуйн нэгжүүдийн хувь нь бусад аймгуудын дунджаас харьцангуй илүү байв. Эдийн засгийн өсөлт ЖДҮ эрхлэгчдийн бизнест эерэгээр нөлөөлсөн гэж 31%, 18% нь нөлөөлөөгүй, 25% мэдэхгүй гэж хариулжээ. Инфляцийн түвшин, төгрөгийн ханш

тогтвортой байх нь өөрсдийн бизнест сайн гэж ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх бусад аймгуудын адил үзжээ.

Зураг 6 ЖДҮ хөгжих эдийн засгийн таатай орчин бүрдсэн эсэх

(Бусад аймаг болон УБ хоттой харьцуулсан дүн, давхардсан тоогоор, хувь)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

4. Бизнесийн орчин

Говьсүмбэр аймгийн ЖДҮ эрхлэгчид бизнесийн орчинг бусад аймгуудтай адил ерөнхийдөө сөргөөр үнэлжээ.

Хүснэгт 2 Хууль эрх зүйн орчин

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Хууль, эрх зүй, зохицуулалтын орчин	Говьсүмбэр	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Татварын тогтолцоо	-0.41	-0.44	-0.56
Гадаад худалдаа хийх нөхцөл	-0.33	-0.48	-0.43
Хууль, эрх зүйн орчин	-0.22	-0.45	-0.65
Газар эзэмших	-0.20	-0.32	-0.60
Төрийн байгууллагын үйлчилгээ	-0.16	-0.58	-0.75
Хяналт, шалгалтын тогтолцоо	-0.08	-0.33	-0.52

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

ЖДҮ эрхлэгчид хууль, эрх зүй, зохицуулалтын орчныг дүгнэхдээ нийслэл хот болон аймгуудын дунджаас харьцангуй сайн үнэлгээг өгсөн байна. Говьсүмбэр аймгийнхан татварын тогтолцоонд муу үнэлгээг илүүтэйгээр өгсөн бол төрийн байгууллагын үйлчилгээ болон хяналт, шалгалтын тогтолцоог үндсэндээ боломжийн гэж дүгнэжээ.

Хүснэгт 3 Дэд бүтэц

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Дэд бүтцийн байдал	Говьсүмбэр	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Дулаан, усан хангамж	0.00	-0.39	-0.25
Мэдээлэл холбооны хөгжил	0.57	0.31	0.15
Зам, тээврийн хөгжил	0.65	-0.55	-0.68
Цахилгаан хангамж	0.67	-0.03	-0.10

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Дэд бүтцийн байдлыг судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчид боломжийн, сайн гэж үзсэн байна. Ялангуяа зам, тээврийн хөгжил, цахилгаан хангамж дээр бусад аймаг, Улаанбаатар хотоос нэлээд сайн үнэлгээг өгчээ. Мөн мэдээлэл холбооны хөгжилд сайн гэсэн хариуг түлхүү өгсөн бөгөөд энэ нь

аймгуудын дундаж, нийслэл хотын хандлагатай ижил байв.

Хүснэгт 4 Санхүүжилтийн орчин

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Санхүүжилтийн орчин	Говьсүмбэр	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Олон улсын байгууллагын хөнгөлөлттэй зээлийн олдоц	-0.76	-1.01	-1.02
Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн олдоц	-0.45	-0.93	-1.01
Санхүүжилтийн хэмжээ	-0.45	-0.47	-0.51
Санхүүжилтийн хугацаа	-0.43	-0.53	-0.57
Өөрийн хөрөнгийн хүрэлцээ	-0.39	-0.40	-0.43
Санхүүжилтийн хүү	-0.35	-0.63	-0.67
Зээлийн батлан даалт	-0.24	-0.30	-0.49
Санхүүжилтийн барьцаа хөрөнгө	-0.24	-0.42	-0.56
Хөрөнгийн зах зээлээс санхүүжилт авах	-0.20	-0.55	-0.61
Зээл олгох үйл ажиллагаа	-0.20	-0.18	-0.53
Банк бус санхүүгийн байгууллагын зээл	-0.14	-0.33	-0.48
Банкны зээл	0.14	0.02	-0.49

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Санхүүжилтийн орчинг Говьсүмбэр аймгийнхан ОУ-ын байгууллага болон ЗГ-ын хөнгөлөлттэй зээлийн олдоц муу, санхүүжилтийн хэмжээ бага хугацаа нь богино гэж бусад аймгууд болон нийслэлийхний нэг адил үзжээ. Харин банк болон банк бус санхүүгийн байгууллагын зээлд ерөнхийд нь харьцангуй сайн үнэлгээ өгсөн байна.

Хүснэгт 5 Зах зээлийн орчин

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Зах зээлийн орчин	Говьсүмбэр	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Зах зээлийн багтаамж	-0.55	-0.40	-0.37
Хэрэглэгчдийн худалдан авах чадвар	-0.53	-0.43	-0.36
Даатгалын үйлчилгээ	-0.43	-0.40	-0.37
Технологийн дэвшил	-0.31	-0.33	-0.20
Шударга өрсөлдөөн	-0.22	-0.40	-0.44

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Зах зээлийн орчинд хэрэглэгчдийн худалдан авах чадвар, зах зээлийн багтаамж дээр аймгуудын дунджаас илүү сөргөөр үнэлсэн байна. Шударга өрсөлдөөнийг зах зээлийн орчноос хамгийн боломжийн гэж үзжээ.

5. Дотоод орчин

ЖДҮ эрхлэгчид өөрсдийн дотоод орчиндоо ерөнхийдөө бага хүндрэлтэй, хүндрэлтэй гэсэн үнэлгээг өгсөн бөгөөд хүний нөөцийн удирдлага, тоног төхөөрөмжийн чанар эдгээрээс арай илүү хүндрэлтэй гэгджээ. Ийнхүү хандлага нь бусад аймгуудынхтай ижил байв.

Хүснэгт 6 Дотоод орчин

(Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4)

Дотоод орчин	Говьсүмбэр	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Ядуурал	-2.65	-2.50	-2.77
Ажилгүйдэл	-2.49	-2.50	-2.75
Гэмт хэрэг	-2.41	-2.15	-2.67
Улс төрийн байдал	-1.96	-2.09	-2.46
Хээл хахууль	-1.86	-2.29	-2.72
Хариуцагчийн ёс суртахуун	-1.41	-1.67	-2.00
Мэдээллийн хүртээмж	-1.31	-1.54	-1.78
Хувийн хэвшил, иргэдийн оролцоо	-1.24	-1.50	-1.91

Дотоод орчин	Говьсүмбэр	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Хүний нөөцийн удирдлага	-1.57	-1.33	-1.38
Тоног төхөөрөмжийн чанар	-1.39	-1.27	-1.20
Ажилчдын чадвар	-1.22	-1.31	-1.13
Түүхий эдийн чанар	-0.98	-1.13	-1.30

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

6. Зардлын байдал

Говьсүмбэр аймгийнхан хамгийн хүндрэлтэй зардлуудад тоног төхөөрөмж, түүхийн эдийн зардлуудыг оруулсан байна. Харин бусад аймгуудаас онцлох зүйлд зээлийн хүүний зардал, түрээсийн зардлыг төдийлөн хүндрэл ихтэй гэж хариулсангүй. Хүндрэл багатай зардлуудад бусад аймгуудын хандлагатай адил зар сурталчилгаа болон харилцаа холбооны зардал орсон байна.

Хүснэгт 7 Зардлын байдал

(Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4)

Зардлын байдал	Говьсүмбэр	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Тоног төхөөрөмжийн зардал	-1.51	-1.62	-1.62
Түүхий эдийн зардал	-1.31	-1.59	-1.62
Шимтгэл, хураамжийн төлбөр	-1.24	-1.72	-1.78
Ажиллах хүчний өртөг	-1.20	-1.38	-1.41
Дулаан, усны зардал	-1.20	-1.51	-1.49
Зээлийн хүүний зардал	-1.12	-1.82	-1.89
Түрээсийн зардал	-1.10	-1.48	-1.74
Зам, тээврийн зардал	-1.04	-1.58	-1.62
Захиргаа, үйл ажиллагааны зардал	-0.86	-1.25	-1.42
Эрчим хүч, цахилгааны зардал	-0.80	-1.50	-1.48
Зар сурталчилгааны зардал	-0.76	-1.12	-1.57
Хариуцаа холбооны зардал	-0.47	-0.93	-1.25

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

7. Нийгмийн орчин

Говьсүмбэр аймгийнхны хамгийн ихээр сөрөг үнэлгээ өгсөн хэсэгт нийгмийн орчин орж байгаа ба үүнээс ажилгүйдэл, ядуурал, хээл хахуульд их хүндрэлтэй, хүндрэлтэй гэсэн хариултыг түлхүү өгчээ.

Хүснэгт 8 Нийгмийн орчин

(Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4)

Нийгмийн орчин	Говьсүмбэр	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Ядуурал	-2.65	-2.50	-2.77
Ажилгүйдэл	-2.49	-2.50	-2.75
Гэмт хэрэг	-2.41	-2.15	-2.67
Улс төрийн байдал	-1.96	-2.09	-2.46
Хээл хахууль	-1.86	-2.29	-2.72
Хариуцагчийн ёс суртахуун	-1.41	-1.67	-2.00
Мэдээллийн хүртээмж	-1.31	-1.54	-1.78
Хувийн хэвшил, иргэдийн оролцоо	-1.24	-1.50	-1.91


Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

8. Санхүүжилт

ЖДҮ эрхлэгчид голдуу өөрийн хөрөнгө, гэр бүлийн хамтын хөрөнгө болон банкны зээлээр үйл ажиллагаагаа эхлүүлжээ.

Зураг 7 Анхдагч санхүүжилт

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

ЖДҮ эрхлэгчдийн 73% нь үйл ажиллагаагаа өргөжүүлэх буюу шинээр бизнес эрхлэхэд зээл авсан бөгөөд дийлэнх нь банкны зээл болон хөнгөлөлттэй зээлд хамрагдсан байна. Зээлийн эргэн төлөлт дээр 27% нь хүндрэлгүй гэж хариулсан бол 35% нь зээлийн хүүний төлбөр өндөр, 27% нь зээлийн хугацаа богино, 22% нь зээлийн хэмжээ бага гэж хариулжээ. Зээлийн хугацаа богино гэсэн хариулт нийслэлийн хариултаас илүү, аймгуудын дундажтай ойролцоо, зээлийн хүүний төлбөр өндөр гэсэн хариулт аймгуудынхаас бага, нийслэлийнхээс илүү байв.

Зураг 8 Зээлийн эргэн төлөлтийн бэрхшээл

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Цаашид санал асуулганд оролцогчдын 88% нь үйл ажиллагаа явуулахад санхүүжилт авах хэрэгцээтэй гэсэн бөгөөд тэдгээрийн 40% нь 10-50 сая төгрөг, 30% нь 5-10 сая төгрөг, 14% нь 50-100 сая төгрөгийн санхүүжилт шаардлагатай гэж үзжээ. 100 сая төгрөгөөс дээш санхүүжилт хэрэгцээтэй гэж хариулсан аж ахуй нэгжүүдийн хувь нийслэл хот болон аймгуудаас нэлээд бага, харин эсрэгээр 5-10 сая төгрөгний санхүүжилт хэрэгцээтэй гэсэн хариултын хувь нэлээд их байв.

Зураг 9 Шаардлагатай санхүүжилт

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Дүгнэлт

- Говьсүмбэр аймгийн ЖДҮ эрхлэгчд үйлчилгээ, үйлдвэрлэлийн чиглэлээр түлхүү үйл ажиллагаа эрхэлдэг. Түүхий эд материалаа нийслэл хот, өөрийн аймгаасаа бэлтгэн, голчлон аймагтаа борлуулалтаа хийдэг.
- ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх 1-10 сая, 10-50 сая төгрөгийн орлого олдог гэжээ.
- Орон нутгийн захиргааг хамгийн их ЖДҮ эрхлэгчдийг дэмждэг гэж хариулсан нь бусад аймгуудаас онцлогтой байв. Үүний дараагаар арилжааны банк, Засгийн газар гэж хариулсан байна. Эдгээр байгууллагууд санхүүгийн эх үүсвэрийг бий болгосон, үзэсгэлэн худалдаа зохион байгуулсан, инкубатор төвүүдийг байгуулсан гэжээ.
- Санхүүгийн эх үүсвэр бий болгох, төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох, үндэсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх арга хэмжээг нэн түрүүнд авах шаардлагатай гэж хариулсан байна.
- ЖДҮ хөгжих эдийн засгийн таатай орчин хангалттай бус байна гэж дийлэнх нь бусад аймаг, нийслэлчүүдтэй адил дүгнэсэн.
- Бизнесийн орчинд Говьсүмбэр аймгийнхны хамгийн их сөрөг буюу хүндрэлтэй гэсэн үнэлгээ өгсөн хэсэг нь нийгмийн орчин байв.
- Зардлын хэсэгт тоног төхөөрөмжийн, түүхий эдийн зардлууд хамгийн хүндрэлтэй гэж хариулжээ.
- Мэдээлэл, холбооны хөгжил, банкны зээл, цахилгаан хангамж гэсэн үзүүлэлтүүдийг бусад аймгуудтай адил боломжийн гэж дүгнэжээ.
- ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх нь банкны зээл болон өөрийн хөрөнгөөр үйл ажиллагаагаа эхлүүлсэн бөгөөд үйл ажиллагаагаа өргөжүүлэх, шинээр бизнес эрхлэхэд банкны зээл авсан байна.
- Зээлээ эргэн төлөхөд зээлийн хугацаа богино, хүүний төлбөр өндөр, зээлийн үндсэн хэмжээ бага байсан нь хамгийн их бэрхшээл учруулдаг гэжээ.
- Цаашид үйл ажиллагаагаа явуулахад 35% нь 10-50 сая төгрөг, 27% нь 1-10 сая төгрөгийн санхүүжилт шаардлагатай гэж хариулсан байна.


Дархан-Уул аймаг

1. Ерөнхий мэдээлэл

Дархан-Уул аймагт 2011 оны 1 дүгээр улирлын байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа 959³⁶ ААН-ээс санамсаргүй түүврийн аргаар 92 жижиг дунд бизнес эрхлэгчийг судалгаанд хамрууллаа. Дархан-Уул аймгийн жижиг дунд үйлдвэр эрхлэгчдээс санал асуулга авсны 38% нь иргэд, 54% нь ХХК байсан бөгөөд дийлэнх нь дотоодын хөрөнгө оруулалттай үйл ажиллагаагаа явуулдаг байна. Тус аймагт судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 32% нь худалдаа, 18% нь үйлчилгээ, 50% нь үйлдвэрлэл эрхэлдэг гэжээ. Бусад аймгуудтай харьцуулахад үйлдвэрлэлийг түлхүү эрхэлдэг бөгөөд харин бусад чиглэлээрээ доогуур хариултыг өгчээ.

Зураг 1 ЖДҮ эрхлэгчдийн үйл ажиллагааны чиглэл

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Түүхий эд материалаа бусад аймгуудын адил дийлэнх нь өөрийн аймаг, нийслэл хотоос бэлтгэн, бараа үйлчилгээгээ мөн өөрийн аймаг болон Улаанбаатар хотод борлуулдаг гэжээ. Түүхий эд материалаа гадаадаас авдаг аж ахуйн нэгжүүд нь аймгуудын дунджаас харьцангуй илүү байна.

Хүснэгт 1 Түүхий эд материалын бэлтгэл, бараа бүтээгдэхүүний борлуулалт

(Бусад аймаг болон УБ хөтгөй харьцуулсан дүн, давхардсан тоогоор, хувь)

Байршил	Түүхий эд бэлтгэл			Борлуулалт		
	Дархан-Уул	Аймгууд	УБ	Дархан-Уул	Аймгууд	УБ
Нийслэл хот	47	55	73	14	9	76
У/а эрхэлж буй аймаг	51	45	5	74	82	5
Бусад аймаг	10	8	6	27	13	4
Гадаад улс	37	27	30	3	3	5
Улсын хэмжээнд				11	6	19


Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн 29% нь үйл ажиллагаагаа 1-5 жил, 39% нь 5-10 жил, 27% нь 10-аас дээш жил эрхэлж байгаа бөгөөд 74% нь 1-9 ажиллагсадтай, 21% нь 10-49 ажиллагсадтай гэжээ. ЖДҮ эрхлэгчдийн 42% нь 10-50 сая төгрөг, 15% нь 50-100 сая төгрөг, 11% нь 1-10 сая төгрөгийн орлоготой гэж хариулсан бөгөөд аймгуудын дундажтай харьцуулахад 1-10 сая төгрөг хүртэлх орлоготой гэсэн хариулт нь бага, харин 10-50 сая төгрөгийн орлоготой гэсэн нь нэлээд их байв.

³⁶ Бизнес регистрийн санд бүртгэлтэй

Зураг 2 ЖДҮ эрхлэгчдийн жилийн борлуулалтын орлого

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн


ЖДҮ эрхлэгчдийн 59% нь тайлан тэнцэл гаргадаг гэсэн хариулт өгсөн нь аймгуудын дунджаас 6 нэгж хувиар бага байна.

2. ЖДҮ-ийг дэмжих бодлогын арга хэмжээ

Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх буюу 78% нь арилжааны банк ЖДҮ-ийг хамгийн их дэмждэг гэж хариулжээ. Үүний дараагаар Худалдаа аж үйлдвэрийн тэнхим, орон нутгийн засаг захиргаа гэж үзсэн байна. Харин бага дэмжлэг үзүүлдэг байгууллагуудын тоонд төрийн бус байгууллагууд, зөвлөгөө өгөх байгууллага, төвүүд, бусад санхүүгийн байгууллагууд орсон байна. Судалгааны дүнгээр Засгийн газар болон орон нутгийн захиргаа ЖДҮ-д харьцангуй бага дэмжлэг үзүүлсэн гэж санал асуулганд орлцогчид үзэж байна.

Зураг 3 ЖДҮ эрхлэгчдийг хамгийн ихээр дэмждэг байгууллага

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

ЖДҮ эрхлэгчдэд ямар дэмжлэг үзүүлсэн гэсэн асуултанд бусад аймгуудтай адил дийлэнх нь санхүүгийн эх үүсвэр бий болгосон, үзэсгэлэн худалдаа зохион байгуулсан, сургалт, зөвлөгөө зохион байгуулсан гэж хариулжээ.

Зураг 4 ЖДҮ-д ямар дэмжлэг үзүүлсэн

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

ЖДҮ эрхлэгчдийн үзэж буйгаар юуны өмнө үндэсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох, санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, татварын таатай орчин бүрдүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг нэн түрүүнд авах шаардлагатай гэж үзсэн байна. Харин бусад аймгуудтай харьцуулахад цаашид авах арга хэмжээнүүдээс дэд бүтцийг сайжруулахыг ЖДҮ эрхлэгчид төдийлөн чухал гэж үзээгүй.

Зураг 5 Цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

3. Макро эдийн засгийн орчин

Санал асуулганд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 78% нь ЖДҮ хөгжих эдийн засгийн таатай орчин огт бүрдээгүй, хангалттай бус бүрдсэн гэж хариулсан байна. Эдийн засгийн өсөлт ЖДҮ эрхлэгчдийн бизнест эерэгээр нөлөөлсөн гэж 41%, 20% нь нөлөөлөөгүй, 13% мэдэхгүй гэж хариулжээ. Инфляцийн түвшин, төгрөгийн ханш тогтвортой байх нь өөрсдийн бизнест сайн гэж ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх бусад аймгуудын адил үзжээ. Харин төгрөгийн ханш чангарвал сайн гэж хариулсан аж ахуйн нэгжүүдийн хувь бусад аймгуудаас харьцангуй их байв.

Зураг 6 ЖДҮ хөгжих эдийн засгийн таатай орчин бүрдсэн эсэх

(Бусад аймаг болон УБ хоттой харьцуулсан дүн, давхардсан тоогоор, хувь)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

4. Бизнесийн орчин

Дархан-Уул аймгийн ЖДҮ эрхлэгчид бизнесийн орчинг бусад аймгуудтай адил ерөнхийд нь сөрөг үнэлгээ өгч дүгнэсэн байна.

Хүснэгт 2 Хууль эрх зүйн орчин

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Хууль, эрх зүй, зохицуулалтын орчин	Дархан-Уул	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Төрийн байгууллагын үйлчилгээ	-0.50	-0.58	-0.75
Гадаад худалдаа хийх нөхцөл	-0.46	-0.48	-0.43
Татварын тогтолцоо	-0.41	-0.44	-0.56
Хууль, эрх зүйн орчин	-0.38	-0.45	-0.65
Газар эзэмших	-0.32	-0.32	-0.60
Хяналт, шалгалтын тогтолцоо	-0.28	-0.33	-0.52

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

ЖДҮ эрхлэгчид хууль, эрх зүй, зохицуулалтын орчныг нийслэл хот болон аймгуудын дундажтай ойролцоо үнэлгээг өгсөн байна. Дархан-Уул аймгийнхан бусад аймгуудын адил төрийн байгууллагын үйлчилгээнд хамгийн муу үнэлгээг өгсөн бол хяналт, шалгалтын тогтолцоог үндсэндээ боломжийн гэж үзжээ.

Хүснэгт 3 Дэд бүтэц

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Дэд бүтцийн байдал	Дархан-Уул	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Зам, тээврийн хөгжил	-0.25	-0.55	-0.68
Дулаан, усан хангамж	0.15	-0.39	-0.25
Цахилгаан хангамж	0.25	-0.03	-0.10
Мэдээлэл холбооны хөгжил	0.32	0.31	0.15

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Дэд бүтцийн байдлыг судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчид үндсэндээ боломжийн, сайн гэж үзсэн байна. Дархан-Уул аймгийнхан зөвхөн зам, тээврийн хөгжил дээр харьцангуй муу үнэлгээ өгсөн бөгөөд үзүүлэлт тус бүрээр нь авч үзвэл аймгуудын дундаж болон нийслэл хотынхоос илүү сайн үнэлгээ өгчээ.

Хүснэгт 4 Санхүүжилтийн орчин

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Санхүүжилтийн орчин	Дархан-Уул	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Застгийн газрын хөнгөлөлттэй зээлийн олдоц	-0.83	-0.93	-1.01
Олон улсын байгууллагын хөнгөлөлттэй зээлийн олдоц	-0.76	-1.01	-1.02
Санхүүжилтийн хүү	-0.60	-0.63	-0.67
Хөрөнгийн зах зээлээс санхүүжилт авах	-0.35	-0.55	-0.61
Санхүүжилтийн хугацаа	-0.35	-0.53	-0.57
Санхүүжилтийн барьцаа хөрөнгө	-0.25	-0.42	-0.56
Өөрийн хөрөнгийн хүрэлцээ	-0.24	-0.40	-0.43
Санхүүжилтийн хэмжээ	-0.16	-0.47	-0.51
Зээлийн батлан даалт	-0.08	-0.30	-0.49
Банк бус санхүүгийн байгууллагын зээл	-0.07	-0.33	-0.48
Зээл олгох үйл ажиллагаа	0.04	-0.18	-0.53
Банкны зээл	0.23	0.02	-0.49

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Санхүүжилтийн орчинг Дархан-Уул аймгийнхан ОУ-ын байгууллага болон ЗГ-ын хөнгөлөлттэй зээлийн олдоц муу, санхүүжилтийн хэмжээ бага хугацаа нь богино гэж бусад аймгууд болон нийслэлийхний нэг адил үзжээ. Харин банк болон банк бус санхүүгийн байгууллагын зээл, зээл олгох үйл ажиллагаанд ерөнхийд нь харьцангуй сайн үнэлгээ өгсөн байна.

Хүснэгт 5 Зах зээлийн орчин

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Зах зээлийн орчин	Дархан-Уул	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Хэрэглэгчдийн худалдан авах чадвар	-0.37	-0.43	-0.36
Шударга өрсөлдөөн	-0.27	-0.40	-0.44
Даатгалын үйлчилгээ	-0.27	-0.40	-0.37
Зах зээлийн багтаамж	-0.21	-0.40	-0.37
Технологийн дэвшил	-0.08	-0.33	-0.20

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Зах зээлийн орчинд хэрэглэгчдийн худалдан авах чадварыг аймгуудын дундажтай ойролцоо үнэлгээг өгч, харин бусад үзүүлэлтийг харьцангуй эерэгээр дүгнэсэн байна. Ялангуяа технологийн дэвшлийг аймгуудын дундаж болон нийслэл хотынхоос илүүтэйгээр эерэг үнэлгээг өгчээ.

5. Дотоод орчин

ЖДҮ эрхлэгчид өөрсдийн дотоод орчиндоо ерөнхийдөө бага хүндрэлтэй, хүндрэлтэй гэсэн үнэлгээг өгсөн бөгөөд хүний нөөцийн удирдлага, ажилчдын чанар эдгээрээс арай илүү хүндрэлтэй гэгджээ. Ийнхүү хандлага нь бусад аймгуудынхтай ижил байв.

Хүснэгт 6 Дотоод орчин

(Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4)

Дотоод орчин	Дархан-Уул	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Хүний нөөцийн удирдлага	-1.46	-1.33	-1.38
Ажилчдын чадвар	-1.40	-1.31	-1.13
Тонг төхөөрөмжийн чанар	-1.25	-1.27	-1.20
Түүхий эдийн чанар	-1.07	-1.13	-1.30

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

6. Зардлын байдал

Дархан-Уул аймгийнхан хамгийн хүндрэлтэй зардлуудад түрээс болон шимтгэл, хураамжийн зардлуудыг оруулсан байна. Харин аймгуудын дундажтай харьцуулахад зээлийн хүүний зардлыг арай бага хүндрэлтэй гэж хариулжээ. Хүндрэл багатай зардлуудад бусад аймгуудын хандлагатай адил зар сурталчилгаа болон харилцаа холбооны зардал гэж үзсэн байна.

Хүснэгт 7 Зардлын байдал

(Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4)

Зардлын байдал	Дархан-Уул	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Түрээсийн зардал	-1.77	-1.48	-1.74
Шимтгэл, хураамжийн төлбөр	-1.75	-1.72	-1.78
Зээлийн хүүний зардал	-1.61	-1.82	-1.89
Тонг төхөөрөмжийн зардал	-1.60	-1.62	-1.62
Түүхий эдийн зардал	-1.54	-1.59	-1.62
Эрчим хүч, цахилгааны зардал	-1.51	-1.50	-1.48
Дулаан, усны зардал	-1.47	-1.51	-1.49
Зам, тээврийн зардал	-1.40	-1.58	-1.62
Ажиллах хүчний өртөг	-1.33	-1.38	-1.41
Захиргаа, үйл ажиллагааны зардал	-1.28	-1.25	-1.42
Зар сурталчилгааны зардал	-1.12	-1.12	-1.57
Харилцаа холбооны зардал	-1.01	-0.93	-1.25

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

7. Нийгмийн орчин

Дархан-Уул аймгийнхны хамгийн ихээр сөрөг үнэлгээ өгсөн хэсэгт нийгмийн орчин орж байгаа ба үүнээс ажилгүйдэл, ядуурал, хээл хахуульд их хүндрэлтэй, хүндрэлтэй гэсэн хариултыг түлхүү өгчээ.

Хүснэгт 8 Нийгмийн орчин

(Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4)

Нийгмийн орчин	Дархан-Уул	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Ядуурал	-2.54	-2.50	-2.77
Ажилгүйдэл	-2.53	-2.50	-2.75
Хээл хахууль	-2.22	-2.29	-2.72
Гэмт хэрэг	-2.21	-2.15	-2.67
Улс төрийн байдал	-2.03	-2.09	-2.46
Харилцагчийн ёс суртахуун	-1.73	-1.67	-2.00
Хувийн хэвшил, иргэдийн оролцоо	-1.59	-1.50	-1.91
Мэдээллийн хүртээмж	-1.51	-1.54	-1.78

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

8. Санхүүжилт

ЖДҮ эрхлэгчид голдуу өөрийн хөрөнгө, гэр бүлийн хамтын хөрөнгө болон банкны зээлээр үйл ажиллагаагаа эхлүүлжээ.

Зураг 7 Анхдагч санхүүжилт

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)




Дархан-Уул аймгийн ЖДҮ эрхлэгчдийн 84% нь үйл ажиллагаагаа өргөжүүлэх буюу шинээр бизнес эрхлэхэд зээл авсан бөгөөд дийлэнх нь банкны зээл болон хөнгөлөлттэй зээлд хамрагдсан байна. Зээлийн эргэн төлөлт дээр 30% нь хүндрэлгүй гэж хариулсан бол 50% нь зээлийн хүүний төлбөр өндөр, 28% нь зээлийн хугацаа богино, 16% нь зээлийн хэмжээ бага гэж хариулжээ. Зээлийг эргэн төлөхөд хүүний төлбөр өндөр гэсэн хариултын хувь аймгуудын дунджаас нэлээд их байв. Харин зээлийн хугацаа богино болон зээлийн үндсэн хэмжээ бага гэсэн хариултын хувь аймгуудын дундажтай ойролцоо гарсан байна.

(Санал асвулгал оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Цаашид санал асуулганд оролцогчдын 86% нь үйл ажиллагаа явуулахад санхүүжилт авах хэрэгцээтэй гэсэн бөгөөд тэдгээрийн 36% нь 10-50 сая төгрөг, 26% нь 50-100 сая төгрөг, 21% нь 100-500 сая төгрөгийн санхүүжилт шаардлагатай гэж үзжээ.

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Дүгнэлт

- Дархан-Уул аймгийн ЖДҮ эрхлэгчд бусад аймгуудтай харьцуулахад түлхүү үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг байна.
- Түүхий эд материалаа нийслэл хот, өөрийн аймгаасаа бэлтгэн, голчлон аймагтаа борлуулалтаа хийдэг. Гадаадаас түхий эд материалаа бэлтгэн авдаг аж ахуйн нэгжүүдийн хувь харьцангуй их байв.
- ЖДҮ эрхлэгчдийн 42% нь 10-50 сая төгрөгийн орлоготой гэж хариулсан нь аймгуудын дунджаас 15 нэгж хувиар их байв.
- Арилжааны банкныг хамгийн их ЖДҮ эрхлэгчдийг дэмждэг гэж бусад аймгуудтай адил хариулсан байна. Үүний дараагаар Худалдаа аж үйлдвэрийн тэнхим, орон нутгийн засаг захиргаа гэж үзсэн байна.
- Дэмжлэг үзүүлэгч байгууллагууд санхүүгийн эх үүсвэрийг бий болгосон, сургалт зөвлөгөө явуулсан, үзэсгэлэн худалдаа зохион байгуулсан гэжээ.
- Төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох, санхүүгийн эх үүсвэр бий болгох, хууль эрх зүйн орчинг сайжруулах, үндэсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх арга хэмжээг нэн түрүүнд авах шаардлагатай гэж хариулсан байна.
- ЖДҮ хөгжих эдийн засгийн таатай орчин хангалттай бус байна гэж дийлэнх нь бусад аймаг, нийслэлчүүдтэй адил дүгнэсэн.
- Бизнесийн орчинд Дархан-Уул аймгийнхны хамгийн их сөрөг буюу хүндрэлтэй гэсэн үнэлгээ өгсөн хэсэг нь нийгмийн орчин байв.
- Зардлын хэсэгт түрээсийн, шимтгэл, хураамжийн, зээлийн хүүний зардлууд хамгийн хүндрэлтэй гэж хариулжээ.
- Мэдээлэл, холбооны хөгжил, банкны зээл, цахилгаан хангамж гэсэн үзүүлэлтүүд бусад аймгуудынхтай адил боломжийн гэсэн үнэлгээг авчээ.
- ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх нь банкны зээл болон өөрийн хөрөнгөөр үйл ажиллагаагаа эхлүүлсэн бөгөөд үйл ажиллагаагаа өргөжүүлэх, шинээр бизнес эрхлэхэд банкны зээл авсан байна.
- Зээлээ эргэн төлөхөд зээлийн хугацаа богино, хүүний төлбөр өндөр, зээлийн үндсэн хэмжээ бага байсан нь хамгийн их бэрхшээл учруулдаг гэжээ.
- Цаашид үйл ажиллагаагаа явуулахад 29% нь 10-50 сая төгрөг, 22% нь 50-100 сая төгрөгийн санхүүжилт шаардлагатай гэж хариулсан байна.

Дорнод аймаг

1. Ерөнхий мэдээлэл

Дорнод аймаг 123.5 мянган хавтгай дөрвөлжин км нутаг дэвсгэртэй, хойд талаараа ОХУ-ын Чита муж, зүүн болон өмнө талаараа БНХАУ-ын ӨМӨЗО-ын Хөлөнбуйр, Хянган аймгуудтай, баруун урд, баруун талаараа Сүхбаатар, Хэнтий аймагтай тус тус хиллэдэг.

Дорнод аймаг халх, буриад, барга, үзэмчин зэрэг ястнаас бүрдэх 75.5 мянган хүн амтай, 75 хувийг хүүхэд, залуучууд эзэлдэг. Тус аймгийн төв Чойбалсан хот улсын нийслэл Улаанбаатараас 656 км алслагдсан.

Дорнод аймагт дэд бүтэц сайн хөгжсөн. “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ХК, Нүүрсний “Адуунчулуун” ХК, махны үйлдвэрлэл худалдааны “Дорнод” ХК, Нефть хангамжийн газар, Нийтийн аж ахуй үйлчилгээний газар, Зүүн бүсийн оношлогоо, эмчилгээний төв зэрэг бүсийн хэмжээний томоохон үйлдвэр, аж ахуйн нэгж, газруудтай.

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ХК нь Чойбалсан хот, 10 сумын төв, уул уурхайн 3 компани болон, Сүхбаатар аймгийг цахилгаан эрчим хүчээр найдвартай хангаж байна.

Адуунчулууны нүүрсний уурхай нь 600.0 мянган тонн нүүрс гаргах хүчин чадалтай. Гэвч зах зээлийн эрэлт хэрэгцээнээс хамаарч хүчин чадлынхаа 40 орчим хувийг ашиглаж байна. Дорнод гурил ХК нь жилдээ 9000 тн гурил, 5000 тонн малын тэжээл үйлдвэрлэх хүчин чадалтай, Баянтүмэн, Халхгол суманд газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж, 2200 гаруй га-д үр тариа тариа, жилдээ 5000 гаруй тн ургац хураан авч байгаа бөгөөд 600 га-д усалгаатай тариалан эрхэлж үйлдвэрийн түүхий эдээ өөрийн газар тариалангаас хангах зорилготой ажиллаж байна.


Дорнод аймагт 2011 оны 1 дүгээр улирлын байдлаар үйл ажиллагаа явуулж буй 512³⁷ ААН-ээс санамсаргүй түүврээр судалгаанд хамрууллаа. Судалгаанд 27 хувиараа аж ахуй эрхлэгч, 11 ХХК, 1 ХК, 3 бусад буюу нийт 46 аж ахуйн нэгж санал асуулгад оролцлоо. Тэдгээр аж ахуйн нэгжүүдийн 72% нь дотоодын хөрөнгө оруулалттай гэсэн хариултыг өгчээ.

Санал асуулгад оролцсон ЖДҮ эрхлэгчдийн үйл ажиллагааны чиглэл нь бусад орон нутгаас эрс ялгаатай байна. Орос, Хятад улстай хиллэдэг, чөлөөт зах зээлээс өмнө үйлдвэрлэл, боловсруулах чиглэлийн үйлдвэрүүд баригдсан байсан, тэдгээрийг

сүүлийн жилүүдэд сэргээж, ашиглалтанд оруулж чадсан зэрэг нь бусад аймгуудаас ялгаатай байх үндэслэл юм.

Зураг 1 ЖДҮ эрхлэгчдийн үйл ажиллагааны чиглэл

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Дорнод аймагт үйл ажиллагаа явуулдаг ЖДҮ эрхлэгчид бараа, үйлчилгээгээ хаана борлуулдаг гэсэн асуултанд 89.1% нь аймагтаа, 4.3% нь бусад аймгуудад, 2.2% нь гадаадад, 4.3% нь улсын хэмжээнд борлуулдаг гэж хариулжээ.

Зураг 2 Түүхий эд материалын борлуулалт

(Бусад аймаг болон УБ хоттой харьцуулсан дүн, давхардсан тоогоор, хувь)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн


Тус аймагт үйл ажиллагаа явуулж байгаа ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх нь (78.3%) 1-9 ажилтантай жилийн 1-10 сая (54.3%) төгрөгийн борлуулалтын орлоготой, үйлдвэрлэсэн бараа, үйлчилгээгээ өөрийн аймагтаа (89.1%) борлуулдаг байна.

Дорнод аймгийн бизнесийн үйл ажиллагаа нь бусад аймаг, хотуудтай харьцуулахад харьцангуй хараат бус байна. Бараа үйлчилгээний түүхий эд, материалын дийлэнх буюу 67.4% нь аймаг дотоодоос эх үүсвэртэй байгаа бусад аймгуудаас хол давсан үзүүлэлт юм.

³⁷ Бизнес регистрийн санд бүртгэлтэй

Зураг 3 ЖДҮ эрхлэгчдийн түүхий эдийн таталт

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Тус аймагт санал асуулгад оролцсон ЖДҮ эрхлэгчдийн 45.7% нь тайлан тэнцэл гаргадаг байна.

2. ЖДҮ-ийг дэмжих бодлогын арга хэмжээ

Банк, Засгийн газар, Орон нутгийн засаг захиргаа зэрэг байгууллагуудыг ЖДҮ эрхлэгчдийг дэмжигч хэмээн Дорнод аймгийн дийлэнх нь нэрлэжээ. Харин бусад байгууллагуудыг нэрлэсэн байдал нь орон нутгийн дунджаас тус бүр бага байна. Энэхүү асуулгад ажиглагсан содон зүйл бол Дорнод аймагт Засгийн газар, орон нутгийн засаг захиргааны дэмжлэгийг бусад аймгуудаас тус бүр 10 гаруй хувиар түлхүү нэрлэсэн явдал юм.

Зураг 4 ЖДҮ эрхлэгчдийг хамгийн ихээр дэмждэг байгууллага

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Дээрх ЖДҮ-ийг дэмждэг байгууллагуудын туслалцааны дийлэнх нь эх үүсвэрийг бий болгосон гэж хариулжээ. Тус хариулт нь хотынхоос 43 нэгж, орон нутгийн дунджаас 12 нэгж хувиар илүү байна. Эндээс, Дорнод аймгаас санал асуулгад оролцсон ЖДҮ-ийн 70 орчим% нь их бага тодорхой

хэмжээгээр санхүүжилтэнд хамрагдсан гэх дүгнэлтийг гаргаж болохоор байна. Оролцогчдын зөвхөн 2% нь дэмжлэг үзүүлдэггүй гэж хариулсан нь орон нутгийн дунджаас 9 нэгж хувь, Улаанбаатараас 36 нэгж хувиар бага үзүүлэлт юм.

Зураг 5 ЖДҮ-д ямар дэмжлэг үзүүлсэн

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Цаашид үндэсний үйлдвэрлэл дэмжих, эх үүсвэр бий болгох, төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох, татварын таатай орчинг бүрдүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг нэн түрүүн авбал зохистой гэж Дорнод аймгийнхан хариулжээ. Үндэсний үйлдвэрлэл дэмжих, эх үүсвэрийг бий болгох хариултууд тус бүр 54 хувийн санал авсан байна. Энэ хариулт болон өмнөх ЖДҮ-д үзүүлсэн дэмжлэгийн талаар хариулсан байдлаас Дорнодын ЖДҮ-ийн 25 орчим % нь зах зээл тодорхой байр суурийг олсон, цаашид өөрийг авч явж боломжтой гэх таамаглалыг дэвшүүлж болохоор байна.

Зураг 6 Цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн


3. Макро эдийн засгийн орчин

ЖДҮ-ийн хөгжүүлэх эдийн засгийн орчинг сайжруулах шаардлагатай гэдэг нь ЖДҮ эрхлэгчид нийтлэгээр түгсэн ойлголт. Тэр дундаа Дорнодод

бусдаас илүү түгжээ. Хангалттай бус, огт бүрэлдээгүй гэсэн хариултуудын нийлбэр 90 орчим хувь байгаа нь Улаанбаатар ба ОН-ын дунджийн аль алинаас нь олон хувиар давсан хариулт байв.

Зураг 7 ЖДҮ хөгжих эдийн засгийн таатай орчин бүрдсэн эсэх

(Бусад аймаг болон УБ хоттой харьцуулсан дүн, хувь)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Эдийн засгийн өсөлтийн ЖДҮ-т үзүүлэх нөлөөг байхгүй гэх хандлага Дорнод аймагт зонхилж байгаа бол тус хариултаас бага хувьтайгаар эерэгээр, сөргөөр гэх хариултыг ижил түвшинд өгчээ. Бусад аймгуудад эдийн засгийн өсөлтийг сайшаах хандлага байсан бол Дорнодынхон нөлөөлөл бага гэж үзнээр бусдаас онцлог юм.

Зураг 8 ЖДҮ хөгжилд эдийн засгийн өсөлтийн үзүүлж буй нөлөө

(Бусад аймаг болон УБ хоттой харьцуулсан дүн, хувь)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Инфляци, валютын ханш зэрэг эдийн засгийн үндсэн хүчин зүйлс тогтвортой байх нь эрхэлж буй бизнест сайн гэж үзсэн байна.

4. Бизнесийн орчин

Хууль эрх, зүйн зохицуулалтын орчинд хамааралтай хүчин зүйлсүүд ерөнхийдөө боломжийн ба муу гэсэн үнэлгээний дунд хэлбэлзэж байна. Дорнод аймагт газар эзэмших нөхцөл бололцоо боломжийн түвшинд

үнэлэгдэж байгаа бол төрийн байгууллагын үйлчилгээ бусдаас муу гэсэн үнэлгээг авчээ.

Хүснэгт 1 Хууль эрх зүйн орчин

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Хууль, эрх зүйн зохицуулалтын орчин	Дорнод	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Хууль, эрх зүйн орчин	-0.30	-0.60	-0.40
Татварын тогтолцоо	-0.50	-0.60	-0.40
Гадаад худалдаа хийх нөхцөл	-0.50	-0.40	-0.50
Төрийн байгууллагын үйлчилгээ	-0.60	-0.80	-0.60
Хяналт, шалгалтын тогтолцоо	-0.50	-0.50	-0.30
Газар эзэмших	-0.20	-0.60	-0.30

Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Цахилгаан, ус, дулааны станц Дорнод аймагт байдаг учраас зам тээврээс бусад бүх дэд бүтцийн ангилалууд боломжийн гэсэн үнэлгээг авчээ. Энэ нөхцөл байдлаас үндэслэгдэж Дорнод аймаг нь Улаанбаатар ба бусад ОН-аас ялгаатай хариултыг өгсөн байна.

Хүснэгт 2 Дэд бүтэц

Дэд бүтцийн байдал	Дорнод	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Зам, тээврийн хөгжил	-0.81	0.54	0.68
Цахилгаан хангамж	0.00	-0.02	-0.10
Мэдээлэл холбооны хөгжил	0.41	0.32	0.15

Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2, жигнэж гаргасан

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Банк, ББСБ-аас зээл авах, тэдгээрийн зээл олгох үйл ажиллагааг боломжийн хэмээн Дорнодынхон дүгнэжээ. Харин тэдгээрийн санал болгодог зээлийн хугацаа, барьцаа, хүү, хэмжээг муу гэж үнэлсэн байна. Тус хандлага нь Улаанбаатар ба ОН-д түгээмэл, адилаар үзэгдэл юм. Бусад санхүүгийн эх үүсвэр олгогчид болох ЗГ, ХЗЗ, ОУБ нарыг муу гэсэн үнэлгээтэйгээр санхүүжилт олгодог гэжээ.

Хүснэгт 3 Санхүүжилтийн орчин

Санхүүжилтийн орчин	Дорнод	Аймгуудын дундаж	Улаанбаатар
ХЗЗ-ээс санхүүжилт авах	-0.74	-0.61	-0.55
Санхүүжилтийн хэмжээ	-0.70	-0.51	-0.47
Санхүүжилтийн хүү	-0.65	-0.67	-0.63
Санхүүжилтийн хугацаа	-0.52	-0.57	-0.52
Санхүүжилтийн барьцаа хөрөнгө	-0.46	-0.56	-0.41
Өөрийн хөрөнгийн хүрэлцээ	-0.59	-0.43	-0.40
ОУБ-ын хөнгөлттэй зээлийн олдлоц	-1.22	-1.02	-1.01
Зээлийн батлан даалт	-0.33	-0.49	-0.29
Зээл олгох үйл ажиллагаа	-0.24	-0.53	-0.16
ЗГ-ын хөнгөлттэй зээлийн олдлоц	-0.74	-1.01	-0.93
ББСБ-ын зээл	-0.26	-0.48	-0.32
Банкны зээл	-0.09	-0.49	0.04

Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Зах зээлийн орчны талаар Дорнод аймгийнхан бусдаас харилцан ялгаатай үнэлгээг өгчээ. Зах зээлийн багтаамж, даатгалын үйлчилгээг боломжийн түвшинд байна гэж хариулсан бол худалдан авах чадвар, технологийн дэвшил, шударга өрсөлдөөнийг муу түвшинд байна гэж дүгнэжээ.

Хүснэгт 4 Зах зээлийн орчин

Зах зээлийн орчин	Дорнод	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Шударга өрсөлдөөн	-0.54	-0.44	-0.40
Худалдан авах чадвар	-0.52	-0.36	-0.43
Технологийн дэвшил	-0.50	-0.20	-0.34
Зах зээлийн багтаамж	-0.33	-0.37	-0.40
Лаатаалын үйлчилгээ	-0.28	-0.37	-0.40

Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2, жигнэж гаргасан

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

5. Дотоод орчин

Дотоод орчны талаар дорвитой арга хэмжээ авах болсон хэмээн Дорнод аймгийнхан үзэж байна. Тэдгээрээс ажилчдын ур чадвар, хүний нөөцийн удирдлагыг илүү онцолсон байна. Зөвхөн Дорнод биш улс орон даяар энэ талаар нэгэн сэтгэгдэлтэй байна.

Хүснэгт 5 Дотоод орчин

Дотоод орчин	Дорнод	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Ажилчдын чадвар	-1.37	-1.13	-1.31
Тоног төхөөрөмжийн чанар	-1.22	-1.20	-1.28
Хүний нөөцийн удирдлага	-1.15	-1.38	-1.33
Түүхий эдийн чанар	-1.02	-1.30	-1.12

Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

6. Зардлын байдал

Дорнод аймгийнхан тоног төхөөрөмжийн зардлыг их хүндрэлтэй зардлаар нэрлэсэн байна. Түүний араас захиргаа, үйл ажиллагаа, түүхий эд, шимтгэл хураамж, зам тээвэр зэрэг зардлуудыг оруулсан байна. Харин хүндрэл багатай зардлуудад харилцаа, холбооны ба сурталчилгаа зэргийг нэрлэсэн байна. Энэ үзүүлэлт нь Улаанбаатар хотод их хүндрэлтэй ангилалд ордог.

Хүснэгт 6 Зардлын байдал

Зардлын байдал	Дорнод	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Тоног төхөөрөмжийн зардал	-1.93	-1.62	-1.62
Захиргаа, үйл ажиллагааны зардал	-1.52	-1.42	-1.24
Түүхий эдийн зардал	-1.48	-1.62	-1.59
Зам, тээврийн зардал	-1.48	-1.62	-1.58
Шимтгэл, хураамжийн төлбөр	-1.48	-1.78	-1.71
Эрчим хүч, захилааны зардал	-1.39	-1.48	-1.50
Зээлийн хүүний зардал	-1.37	-1.89	-1.82
Түрээсийн зардал	-1.35	-1.74	-1.47
Дулаан, усны зардал	-1.24	-1.49	-1.51
Ажиллах хүчний өртөг	-1.22	-1.41	-1.37
Зар сурталчилгааны зардал	-0.89	-1.57	-1.10
Харилцаа холбооны зардал	-0.80	-1.25	-0.92

Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

7. Нийгмийн орчин

Нийгмийн орчин нь бусад бүлгүүдээс хамгийн муу үнэлгээтэйгээр дүгнэгдсэн. Харилцагчийн ёс суртахуун, хувийн хэвшлийн оролцоо, мэдээллийн хүртээмж талаарх асуултууд их хүндрэлтэй гэсэн хариултыг авсан бол бусад нь маш их хүндрэлтэй

гэсэн үнэлгээг авчээ. Дорнодоос гадна Улаанбаатар, бусад аймгууд ч нийгмийн орчинд муу үнэлгээг өгчээ.

Хүснэгт 7 Нийгмийн орчин

Нийгмийн орчин	Дорнод	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Хээл хахууль	-2.20	-2.72	-2.27
Ядуурал	-2.15	-2.77	-2.48
Гэмт хэрэг	-2.04	-2.67	-2.13
Ажилгүйдэл	-1.98	-2.75	-2.49
Улс төрийн байдал	-1.93	-2.46	-2.08
Мэдээллийн хүртээмж	-1.26	-1.78	-1.53
Харилцагчийн ёс суртахуун	-1.24	-2.00	-1.65
Хувийн хэвшил, иргэдийн оролцоо	-1.17	-1.91	-1.48

Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4


Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

8. Санхүүжилт

Дорнод аймгийн дийлэнх ЖДҮ эрхлэгчид банкны зээл ба өөрийн хөрөнгөөр гараагаа эхэлсэн гэж хариулжээ.

Зураг 9 Анхдагч санхүүжилт

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Зээлийн өргөжилт хийх төлөвлөгөөтэй байгаа ЖДҮ эрхлэгчид 54.3%-тай байна. Өөрөөр хэлбэл Дорнод аймагт ЖДҮ эрхлэгчдэд зах зээлийн орон зай байгааг ийнхүү харуулж байна.

Зураг 10 Дахин санхүүжилт


(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Харин өргөжих санхүүгийн эх үүсвэрийг банкны зээлээс бий болгоно гэж санал асуулгад оролцогчдын 34.8% хариулжээ. Харин зээл авахад хамгийн хүндрэлтэй байдаг асуудлыг зээлийн хугацаа, хүү хоёрыг нэрлэсэн байна.

ЖДҮ-ийг үүсгэн байгуулахад, эсвэл өргөжүүлэхэд 5-10 сая төгрөгийн санхүүжилт хэрэгтэй байдаг гэсэн хариултыг 19.5% өгсөн бол 10-50 сая төгрөг хэмээн 15.2% хариулжээ.



Дүгнэлт

- Судалгаанд хамрагдсан Дорнод аймгийн 46 ЖДҮ эрхлэгчид олон жилийн туршлагатай, цөөн тооны ажиллагсадтай бөгөөд үйлдвэрлэлийн чиглэлээр түлхүү үйл ажиллагаа эрхэлдэг.
- Түүхий эд материалаа өөрийн аймгаасаа голчлон бэлтгэдэг гэснээрээ бусад аймгуудаас ялгарч байв. Ихэнх борлуулалтаа аймагтаа хийдэг гэжээ.
- Борлуулалтын жилийн орлогоороо бусад аймгууд, Улаанбаатар хотын дунджаас өндөр байгаа бөгөөд дийлэнх нь тайлан тэнцэл гаргадаг гэжээ.
- Бусад аймгууд, нийслэл хотын судалгааны дүнтэй адил арилжааны банкиг хамгийн их ЖДҮ эрхлэгчдийг дэмждэг гэжээ. Мөн Засгийн газар, орон нутгийн засаг захиргааг дэмждэг гэж нэлээд хувь үзжээ. Эдгээр байгууллагаас санхүүгийн эх үүсвэрийг бий болгосон, үзэсгэлэн худалдаа зохион байгуулсан гэжээ.
- Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, эх үүсвэр бий болгох, төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох, татварын таатай орчинг бүрдүүлэх арга хэмжээг нэн түрүүнд авах шаардлагатай гэж үзжээ.
- Бусад аймаг, нийслэлчүүдийн адил дийлэнх нь ЖДҮ хөгжих эдийн засгийн таатай орчин хангалттай бус байна гэж дүгнэсэн байна. Мөн инфляци, ханш тогтвортой байх нь бизнест нь сайн гэжээ.

- Бизнесийн орчинд ерөнхийдөө сөрөг үнэлгээг өгсөн ч бусад аймгуудын үнэлгээнээс бага зэрэг дээгүүр үнэлгээтэй байв. Тус аймгийнхны хамгийн их хүндрэлтэй гэсэн үнэлгээ өгсөн хэсэгт нийгмийн орчин үүнээс хээл хахууль, ядуурал, гэмт хэрэг орж байна. Харин мэдээлэл, холбооны хөгжил, цахилгаан хангамж, банкны зээл гэсэн үзүүлэлтүүдэд боломжийн гэсэн үнэлгээг өгчээ.

- Өөрийн хөрөнгө, банкны зээлээр дийлэнх нь үйл ажиллагаагаа эхлүүлсэн бөгөөд үйл ажиллагаагаа өргөжүүлэх, шинээр бизнес эрхлэхэд банкны зээл авсан байна.

- Зээлээ эргэн төлөхөд зээлийн хугацаа богино, хүүний төлбөр өндөр байсан нь хамгийн их хүндрэл учруулдаг гэжээ.

- Цаашид үйл ажиллагаагаа явуулахад санхүүжилт шаардлагатай гэж дийлэнх нь хариулсан ба бусад 5-10 сая, 10-50 сая төгрөг шаардлагатай гэж хариулжээ.

Дорноговь аймаг


1. Ерөнхий мэдээлэл

Дорноговь аймагт 2011 оны 1 дүгээр улирлын байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа 512³⁸ ААН-ээс санамсаргүй түүврийн аргаар 51 жижиг дунд бизнес эрхлэгчийг судалгаанд хамрууллаа. Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 53% нь ХХК, 39% нь иргэд байсан бөгөөд тэдгээрийн 80% нь дотоодын, 4% нь гадаад дотоодын холимог хөрөнгө оруулалттайгаар үйл ажиллагаагаа явуулдаг байна /16% нь уг асуултанд хариулаагүй/.

Дорноговь аймагт судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 44% нь худалдаа, 34% нь үйлчилгээ, 22% нь үйлдвэрлэл эрхэлдэг гэжээ. Бусад аймгуудын дундаж үзүүлэлттэй харьцуулбал үйлдвэрлэл эрхэлдэг ЖДҮ эрхлэгчдийн судалгаанд хамрагдсан хувь 18 нэгж хувиар бага, худалдааны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгчид 13 нэгж хувиар, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгчид 5 нэгж хувиар тус тус илүү байна.

Зураг 1 ЖДҮ эрхлэгчдийн үйл ажиллагааны чиглэл

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 33% нь 10-аас дээш жил, 27% нь 5-10 жил, 25% нь 1-5 жил, 14% нь 1 хүртэл жил үйл ажиллагаагаа эрхэлж байгаа бөгөөд 75% нь 10 хүртэл, 20% нь 10-49, 4% нь 50-99, 2% нь 100-149 ажиллагсадтай байна.

Дорноговь аймгийн судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн давхардсан тоогоор 55% нь нийслэл хотоос, 33% нь үйл ажиллагаа эрхэлж буй аймгаас, 27% нь гадаад улсаас түүхий эд, материалаа бэлтгэдэг гэж хариуллаа. Өөрийн аймгаас түүхий эд бэлтгэдэг гэсэн хариултын хувийн жин аймгуудын дунджаас 12 нэгж хувиар, бусад аймгаас гэсэн хариулт 4 нэгж хувиар тус тус бага байсан бол бусад

хариулт ойролцоо байв. Харин ЖДҮ эрхлэгчдийн 86% нь эцсийн бүтээгдэхүүнээ өөрийн аймагт нийлүүлдэг гэж хариулсан нь бусад аймгийн дунджаас 4 нэгж хувиар илүү үзүүлэлттэй байна.

Хүснэгт 1 Түүхий эд материалын бэлтгэл, бараа бүтээгдэхүүний борлуулалт

(Бусад аймаг болон УБ хоттой харьцуулсан дүн, давхардсан тоогоор, хувь)


Байршил	Түүхий эд бэлтгэл			Борлуулалт		
	Дорноговь	Аймгууд	УБ	Дорноговь	Аймгууд	УБ
Нийслэл хот	55	55	73	6	9	76
У/а эрхэлж буй аймаг	33	45	5	86	82	5
Бусад аймаг	4	8	6	6	13	4
Гадаад улс	27	27	30	0	3	5
Улсын хэмжээнд				2	6	19

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Дорноговь аймгийн судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 38% 10-50 сая, 28% 1-10 сая төгрөгийн жилийн орлоготой гэж хариулсан ба 10-50 сая гэсэн хариултын хувийн жин аймгууд, нийслэл хотын дундаж үзүүлэлтээс 11-12 нэгж хувиар их, 1-10 сая гэсэн хариулт Улаанбаатарынхаас 11 нэгж хувиар бага, аймгуудынхтай ойролцоо байв.

Зураг 2 ЖДҮ эрхлэгчдийн жилийн борлуулалтын орлого

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Түүвэр судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 73% нь тайлан тэнцэл гаргадаг гэсэн хариулт өгсөн нь аймгуудын дунджаас 6 нэгж хувиар илүү, Улаанбаатар хотынхоос 4 нэгж хувиар бага үзүүлэлттэй байна.

2. ЖДҮ-ийг дэмжих бодлогын арга хэмжээ

Дорноговь аймгаас санал асуулгад оролцсон ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх буюу 67% нь ЖДҮ-ийг хамгийн ихээр **арилжааны банк** дэмждэг гэж хариулжээ. Мөн орон нутгийн засаг захиргаа гэсэн хариултыг бусад хариултаас илүү сонгосон байна. Уг үр дүнг аймгуудын дундаж үзүүлэлттэй харьцуулахад хариултуудын хандлага ерөнхийдөө ижил байлаа.

³⁸ Бизнес регистрийн санд бүртгэлтэй

Зураг 3 ЖДҮ эрхлэгчдийг хамгийн ихээр дэмждэг байгууллага

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Дорноговь аймгийн ЖДҮ эрхлэгчид дээрх байгууллагуудаас санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгосон, сургалт зөвлөгөө явуулсан, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах байдлаар дэмжлэг үзүүлсэн гэж хариулжээ.

Зураг 4 ЖДҮ-д ямар дэмжлэг үзүүлсэн

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Цаашид татварын таатай орчинг бүрдүүлэх, төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох, үндэсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хувийн хэвшил олон нийтийн оролцоог бизнесийн шийдвэр гаргалтанд нэмэгдүүлэх, хөнгөлөлттэй санхүүгийн эх үүсвэр бий болгох, хүртээмжийг нэмэгдүүлэх, зөвшөөрөл лицензийн тоог багасгах, авлигыг бууруулах, дэд бүтцийг сайжруулах зэрэг арга хэмжээнүүдийг нэн түрүүн авбал зохистой гэж бусад аймгууд, Улаанбаатар хотын адил үзсэн байна. Татварын таатай орчинг бүрдүүлэх, хувийн хэвшил олон нийтийн оролцоог бизнесийн шийдвэр гаргалтанд

нэмэгдүүлэх гэсэн хариулт нийслэл, аймгийн дунджаас илүү байгаа бол санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгох, шинэ технологи нэвтрүүлэгч ААН-д дэмжлэг үзүүлэх гэсэн хариулт аймгуудын дунджаас, хууль эрх зүйн орчныг сайжруулах гэсэн хариулт Улаанбаатар хотынхоос тус тус бага байлаа.

Зураг 5 Цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

3. Макро эдийн засгийн орчин

Манай улсад ЖДҮ хөгжих эдийн засгийн таатай орчин хангалттай бус байна гэж Дорноговь аймгийн судалгаанд оролцогчдын дийлэнх буюу 71% үзэж байгаа нь аймгуудын дундажтай ижил түвшинд, Улаанбаатарынхаас 10 нэгж хувиар илүү байна.

Хүснэгт 2 ЖДҮ хөгжих эдийн засгийн таатай орчин бүрдсэн эсэх

(Бусад аймаг болон УБ хоттой харьцуулсан дүн, давхардсан тоогоор, хувь)

ЖДҮ хөгжих орчин	Дорноговь	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Бүрдсэн	4	10	8
Хангалттай бус	71	71	61
Огт бүрдээгүй	14	12	23
Мэдэхгүй	12	6	9

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Дорноговь аймагт үйл ажиллагаа эрхлэгч ЖДҮ эрхлэгчид эдийн засгийн өсөлт өөрсдийн бизнест эерэгээр болон сөргөөр нөлөөлж байгаа гэж 29, 29 хувьтайгаар ижилхэн хариулжээ. Эдийн засгийн өсөлт нөлөөлөөгүй, эерэгээр нөлөөлсөн гэсэн хариулт аймгуудын дунджаас 5-9 нэгж хувиар бага байхад сөргөөр нөлөөлсөн, мэдэхгүй гэсэн хариулт 7-8 нэгж хувиар илүү байлаа. Улаанбаатар хотынхтой харьцуулбал эерэгээр нөлөөлнө гэсэн хариулт 11 нэгж хувиар илүү, сөргөөр, нөлөөлөөгүй гэсэн хариулт 7-14 нэгж хувиар бага байв.

Хүснэгт 3 ЖДҮ хөгжилд эдийн засгийн өсөлтийн үзүүлж буй нөлөө

(Бусад аймаг болон УБ хоттой харьцуулсан дүн, давхардсан тоогоор, хувь)

Эдийн засгийн өсөлт танай бизнест	Дорноговь	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Эергээр	29	24	20
Сөргөөр	29	22	43
Нөлөөлөөгүй	14	19	21
Мэдэхгүй	24	16	18

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Инфляцийн түвшин, төгрөгийн бусад валюттай харьцах ханш тогтвортой байх нь өөрсдийн бизнест сайн гэж ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх (53-57%) бусад аймгууд, нийслэлийнхэнтэй адил үзжээ.

4. Бизнесийн орчин

Дорноговь аймгийн судалгаанд оролцсон ЖДҮ эрхлэгчдийн бизнесийн орчинд бусад аймгуудтай адил ерөнхийдөө сөрөг үнэлгээг өгчээ. Гэсэн хэдий ч хэсэг бүрийн үнэлгээний дундаж аймгуудын дунджаас дээгүүр буюу бага зэрэг сайн үнэлгээтэй байв.

Дорноговь аймгийнхны санхүүжилтийн орчинд өгсөн үнэлгээ бусад аймгуудынхтай ойролцоо, Улаанбаатар хотынхоос дээгүүр байлаа. Тус аймгийнхны хамгийн бэрхшээлтэй нь ОУ-ын болон ЗГ-ын хөнгөлөлттэй зээлийн олдоц муу гэж бусад аймгууд болон нийслэлийнхний нэг адил үзжээ. Санхүүжилтийн хүү, хугацаа, хэмжээ зэрэг бусад асуултанд боломжийн, муу гэсэн хариултыг түлхүү өгсөн бөгөөд аймгуудын дундаж, Улаанбаатар хотынхны өгсөн үнэлгээнээс боломжийн гэсэн үнэлгээ арай их байв.

Хүснэгт 4 Санхүүжилтийн орчин

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Санхүүжилтийн орчин	Дорноговь	Аймгуудын дундаж	Улаанбаатар
ОУ-ын байгууллагын хөнгөлөлттэй зээлийн олдоц	-1.16	-1.01	-1.02
ЗГ-ын газрын хөнгөлөлттэй зээлийн олдоц	-1.00	-0.93	-1.01
Санхүүжилтийн хүү	-0.55	-0.63	-0.67
Санхүүжилтийн хугацаа	-0.45	-0.52	-0.57
Хөрөнгийн зах зээлээс санхүүжилт авах	-0.41	-0.55	-0.61
Санхүүжилтийн барьцаа хөрөнгө	-0.41	-0.41	-0.56
Өөрийн хөрөнгийн хүрэлцээ	-0.35	-0.40	-0.43
Банк бус санхүүгийн байгууллагын зээл	-0.33	-0.32	-0.48
Санхүүжилтийн хэмжээ	-0.33	-0.47	-0.51
Зээлийн батлан даалт	-0.29	-0.29	-0.49
Зээл олгох үйл ажиллагаа	-0.12	-0.16	-0.53
Банкны зээл	0.16	0.04	-0.49

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Хууль, эрх зүй, зохицуулалтын орчин ерөнхийдөө боломжийн үнэлгээг түлхүү өгсөн бөгөөд энэ нь бусад аймаг, Улаанбаатар хотынхоос илүү байлаа. Ялангуяа гадаад худалдаа хийх нөхцөл, хяналт шалгалтын тогтолцоо боломжийн гэсэн үнэлгээтэй

илүү ойрхон байв. Харин татварын тогтолцоонд өгсөн үнэлгээ бага зэрэг муу тал руугаа үнэлэгдсэн байгаа нь бусад аймгуудынхаас илүү муу, Улаанбаатарынхнаас бага зэрэг муу үнэлгээтэй байна.

Хүснэгт 5 Хууль эрх зүйн орчин

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Хууль, эрх зүйн зохицуулалтын орчин	Дорноговь	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Татварын тогтолцоо	-0.63	-0.43	-0.56
Төрийн байгууллагын үйлчилгээ	-0.43	-0.57	-0.75
Хууль, эрх зүйн орчин	-0.41	-0.44	-0.65
Газар эзэмших	-0.35	-0.31	-0.60
Гадаад худалдаа хийх нөхцөл	-0.22	-0.48	-0.43
Хяналт, шалгалтын тогтолцоо	-0.18	-0.32	-0.52

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Зах зээлийн орчныг ерөнхийд нь боломжийн гэж үнэлсэн нь бусад аймгууд, Улаанбаатар хотынхтой ойролцоо үнэлгээтэй байна. Технологийн дэвшилд хамгийн сайн үнэлгээг өгсөн нь Улаанбаатар, аймгуудын дунджаас сайн үнэлгээтэй байлаа.

Хүснэгт 6 Зах зээлийн орчин

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Зах зээлийн орчин	Дорноговь	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Даатгалын үйлчилгээ	-0.37	-0.40	-0.37
Зах зээлийн багтаамж	-0.33	-0.40	-0.37
Шударга өрсөлдөөн	-0.33	-0.40	-0.44
Хэрэглэгчдийн худалдан авах чадвар	-0.25	-0.43	-0.36
Технологийн дэвшил	-0.18	-0.34	-0.20

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Дорноговь аймгийнхан дэд бүтцийн байдалд боломжийн гэсэн үнэлгээг түлхүү өгчээ. Зам тээврийн хөгжил, дулаан, усан хангамжийг боломжийн, муу гэсэн үнэлгээний дунджаар дүгнэсэн нь аймгуудын дундажтай ижил, Улаанбаатарынхнаас зам тээврийн хөгжлийн үнэлгээ нь бага зэрэг илүү, дулаан, усан хангамжийн үнэлгээ нь бага зэрэг доогуур байв. Харин мэдээлэл холбооны хөгжил, цахилгаан хангамжинд боломжийн сайн гэсэн үнэлгээг түлхүү өгсөн ба эдгээр нь Улаанбаатар хотын үзүүлэлтээс дээгүүр, цахилгаан хангамж нь аймгуудын дунджаас дээгүүр үнэлгээг авчээ. Мэдээлэл холбооны хөгжлийн хувьд аймгуудын дунджаас бага зэрэг доогуур үнэлгээтэй байв.

Хүснэгт 7 Дэд бүтэц

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Зах зээлийн орчин	Дорноговь	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Даатгалын үйлчилгээ	-0.37	-0.40	-0.37
Зах зээлийн багтаамж	-0.33	-0.40	-0.37
Шударга өрсөлдөөн	-0.33	-0.40	-0.44
Хэрэглэгчдийн худалдан авах чадвар	-0.25	-0.43	-0.36
Технологийн дэвшил	-0.18	-0.34	-0.20

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

5. Дотоод орчин

Дорноговь аймгийн ЖДҮ эрхлэгчид өөрсдийн дотоод орчиндоо ерөнхийдөө бага хүндрэлтэй гэсэн үнэлгээг өгсөн бөгөөд хүний нөөцийн удирдлага, ажилчдын чадвар эдгээрээс арай илүү хүндрэлтэй гэгджээ. Бусад аймгуудад ч ерөнхийдөө ийм хандлагатай байв.

Хүснэгт 8 Дотоод орчин

(Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4)

Дотоод орчин	Дорноговь	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Хүний нөөцийн удирдлага	-1.49	-1.33	-1.38
Ажилчдын чадвар	-1.29	-1.31	-1.13
Тоног төхөөрөмжийн чанар	-1.06	-1.28	-1.20
Түүхий эдийн чанар	-0.92	-1.12	-1.30

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

6. Зардлын байдал

Дорноговь аймгийн судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчид зардлуудад ерөнхийд нь хүндрэлтэй, бага хүндрэлтэй гэсэн үнэлгээг өгчээ. Хамгийн хүндрэлтэй зардлуудад зээлийн хүүний, шимтгэл хураамжийн төлбөр, дулаан, усны, түүхий эдийн, зам тээвэр, эрчим хүч, цахилгаан, тоног төхөөрөмжийн зардлуудыг оруулсан нь бусад аймгууд, Улаанбаатар хотынхны хандлагатай ерөнхийдөө ижил байна. Харин дулаан усны зардал аймгуудын дундаж, Улаанбаатарынхаас илүү хүндрэлтэй гэсэн үнэлгээг авсан бол ажиллах хүчний өртөг, зар сурталчилгаа, харилцаа холбооны зардлыг арай бага хүндрэлтэй гэжээ.

Хүснэгт 9 Зардлын байдал

(Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4)

Зардлын байдал	Дорноговь	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Зээлийн хүүний зардал	-1.80	-1.82	-1.89
Шимтгэл, хураамжийн төлбөр	-1.78	-1.71	-1.78
Дулаан, усны зардал	-1.73	-1.51	-1.49
Түүхий эдийн зардал	-1.59	-1.59	-1.62
Зам, тээврийн зардал	-1.55	-1.58	-1.62
Эрчим хүч, цахилгааны зардал	-1.51	-1.50	-1.48
Тоног төхөөрөмжийн зардал	-1.51	-1.62	-1.62
Түрээсийн зардал	-1.41	-1.47	-1.74
Захиргаа, үйл ажиллагааны зардал	-1.31	-1.24	-1.42
Ажиллах хүчний өртөг	-1.08	-1.37	-1.41
Зар сурталчилгааны зардал	-0.98	-1.10	-1.57
Харилцаа холбооны зардал	-0.76	-0.92	-1.25

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

7. Нийгмийн орчин

Тус аймгынхны хамгийн ихээр сөрөг үнэлгээ өгсөн хэсэгт нийгмийн орчин орж байгаа ба үүнээс ажилгүйдэл, ядуурал, хээл хахууль, улс төрийн байдалд илүү хүндрэлтэй гэсэн үнэлгээг өгсөн нь бусад аймгууд, Улаанбаатар хотынхтой адил байна.

Харин гэмт хэргийн байдлыг бусад аймаг, Улаанбаатарынхнаас бага хүндрэлтэй гэсэн байна.

Хүснэгт 10 Нийгмийн орчин

(Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4)

Нийгмийн орчин	Дорноговь	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Ядуурал	-2.25	-2.48	-2.77
Ажилгүйдэл	-2.22	-2.49	-2.75
Хээл хахууль	-2.12	-2.27	-2.72
Улс төрийн байдал	-2.00	-2.08	-2.46
Гэмт хэрг	-1.75	-2.13	-2.67
Хувийн хэвшил, иргэдийн оролцоо	-1.39	-1.48	-1.91
Мэдэрлийн хүртээмж	-1.37	-1.53	-1.78
Харилцагчийн ёс суртахуун	-1.35	-1.65	-2.00


Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

8. Санхүүжилт

Дорноговь аймгийн судалгаанд оролцогчдын дийлэнх банкны зээл, өөрийн хөрөнгөөр санхүүжигдэн үйл ажиллагаагаа эхлүүлж байжээ. Мөн гэр бүлийн хамтын хөрөнгөөр 21.6% нь санхүүжигдсэн гэж хариулсан байна. Энэ нь бусад аймгуудтай харьцуулахад ерөнхий хандлага ижил байгаа ба банкны зээл ашигласан байдал бага зэрэг илүү, гэр бүлийн хамтын хөрөнгөөр үйл ажиллагаагаа эхлүүлсэн нь бага зэрэг бага байна. Улаанбаатарынхаас өөрийн хөрөнгөөр үйл ажиллагаагаа эхлүүлсэн байдал нь бага, харин банкны зээл авсан нь илүү байна.

Зураг 6 Анхдагч санхүүжилт

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Үйл ажиллагаагаа өргөжүүлэх, шинээр бизнес эрхлэхэд судалгаанд хамрагдагсдын дийлэнх бусад аймгуудтай адил (Улаанбаатарчуудын хувьд дийлэнх нь зээл аваагүй гэж хариулсан) санхүүжилт авч байсан гэж хариулсан бөгөөд тэдгээрийн 80 гаруй хувь нь банкны зээл авсан гэжээ. Зээлээ эргэн төлөхөд хүүний төлбөр өндөр, хугацаа богино, үндсэн хэмжээ богино зэрэг нь хамгийн их хүндрэл учруулсан гэж хариулжээ. Гэсэн хэдий ч эдгээр нь аймгуудын дунджаас (3-7 нэгж хувиар) бага хувьтай

байгаа ба хүндрэл тулгараагүй гэсэн хариулт аймгуудын дунджаас 8 нэгж хувиар илүү байв. Харин Улаанбаатартай харьцуулбал хүүний төлбөр өндөр, хугацаа богино, үндсэн хэмжээ богино гэсэн хариулт 7-11 нэгж хувиар илүү байна. Гэхдээ Улаанбаатарчуудын ердөө 54% нь уг асуултанд хариулсан байв.



Цаашид үйл ажиллагаагаа явуулахад санхүүжилт авах хэрэгцээтэй гэж Дорноговь аймгийн судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх (86%) нь бусад аймгуудтай ижил хариулсан бөгөөд тэдгээрийн 36% нь 10-50 сая, 30% нь 100-500 сая, 20% нь 50-100 сая төгрөгийн санхүүжилт шаардлагатай гэж үзжээ. Эдгээрийг аймгуудын дундаж, Улаанбаатарын үзүүлэлттэй харьцуулбал 100-500 сая гэсэн хариулт харьцангуй илүү бусад нь ойролцоо байна.



Дүгнэлт

- Судалгаанд хамрагдсан Дорноговь аймгийн 51 ЖДҮ эрхлэгчид олон жилийн туршлагатай, цөөн тооны ажиллагсадтай бөгөөд худалдааны чиглэлээр түлхүү үйл ажиллагаа эрхэлдэг. Түүхий эд материалаа нийслэл, өөрийн аймгаасаа голчлон бэлтгэн, аймагтаа борлуулалтаа хийдэг гэжээ.
- ААН-ийн орлогоороо бусад аймгууд, Улаанбаатар хотын дунджаас өндөр (10-50, 1-10 сая) байгаа бөгөөд дийлэнх нь тайлан тэнцэл гаргадаг юм байна.
- Бусад аймгууд, нийслэл хотын судалгааны дүнтэй адил арилжааны банкныг хамгийн их ЖДҮ эрхлэгчдийг дэмждэг гэжээ. Дэмжлэг үзүүлэгч байгууллагуудаас санхүүгийн эх үүсвэрийг бий болгосон, сургалт зөвлөгөө явуулсан, үзэсгэлэн худалдаа зохион байгуулсан байна.
- Татварын таатай орчинг бүрдүүлэх, төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох, үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх арга хэмжээг нэн түрүүнд авах шаардлагатай гэж үзжээ.
- Бусад аймаг, нийслэлчүүдийн адил судалгаанд оролцогчдын дийлэнх нь ЖДҮ хөгжих эдийн засгийн таатай орчин хангалттай бус байна гэж дүгнэсэн байна. Мөн инфляци, ханш тогтвортой байх нь бизнест нь сайн гэж хариулсан байна.
- Бизнесийн орчинд ерөнхийдөө сөрөг үнэлгээг өгсөн ч аймгуудын дундажтай харьцуулахад дээгүүр үзүүлэлттэй байна. Тус аймгийнхны хамгийн их сөрөг буюу хүндрэлтэй гэсэн үнэлгээ өгсөн хэсэгт нийгмийн орчин үүнээс ажилгүйдэл, ядуурал, хээл хахууль, улс төрийн байдал, Зардлын хэсэг үүнээс зээлийн хүү, шимтгэл хураамжийн зардал орж байна. Харин мэдээлэл, холбооны хөгжил, цахилгаан хангамж, банкны зээл гэсэн үзүүлэлтүүд боломжийн гэсэн үнэлгээг авчээ.
- Өөрийн хөрөнгө, банкны зээлээр дийлэнх нь үйл ажиллагаагаа эхлүүлсэн бөгөөд үйл ажиллагаагаа өргөжүүлэх, шинээр бизнес эрхлэхэд банкны зээл авсан байна.
- Зээлээ эргэн төлөхөд зээлийн хүүний төлбөр өндөр, хугацаа богино байсан нь хамгийн их хүндрэлтэй гэжээ. Цаашид үйл ажиллагаагаа явуулахад санхүүжилт шаардлагатай гэж дийлэнх нь хариулсан ба бусад аймаг, Улаанбаатарынхаас шаардлагатай санхүүжилтийн хэмжээ нь өндөр байв.

Дундговь аймаг


1. Ерөнхий мэдээлэл

Дундговь аймагт 2011 оны 1 дүгээр улирлын байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа 404³⁹ ААН-ээс санамсаргүй түүврийн аргаар 50 жижиг дунд бизнес эрхлэгчийг судалгаанд хамрууллаа. Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 72% нь ХХК, 12% нь ХК, 8% нь иргэд, 6% нь хоршоо байсан бөгөөд бүгд дотоодын хөрөнгө оруулалттайгаар үйл ажиллагаагаа явуулдаг байна.

Дундговь аймагт судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 42% нь үйлдвэрлэл, 34% нь худалдаа, 24% нь үйлчилгээ эрхэлдэг гэжээ. Энэ нь бусад аймгуудын дундаж үзүүлэлттэй харьцангуй ойролцоо хувьтай байна.

Зураг 1 ЖДҮ эрхлэгчдийн үйл ажиллагааны чиглэл

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 38% нь 5-10 жил, 32% нь 10-аас дээш жил, 20% нь 1-5 жил, 6% нь 1 хүртэл жил үйл ажиллагаагаа эрхэлж байгаа бөгөөд 68% нь 10 хүртэл, 26% нь 10-49, 6% нь 50-99 ажиллагсадтай байна.

Дундговь аймгийн судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн давхардсан тоогоор 74% нь нийслэл хотоос, 40% нь үйл ажиллагаа эрхэлж буй аймгаас, 36% нь гадаад улсаас түүхий эд, материалаа бэлтгэдэг гэж хариуллаа. Нийслэл хотоос түүхий эд бэлтгэдэг гэсэн хариултын хувийн жин аймгуудын дунджаас 19 нэгж хувиар, гадаадаас гэсэн хариулт 9 нэгж хувиар тус тус их байв. Мөн ЖДҮ эрхлэгчдийн 94% нь эцсийн бүтээгдэхүүнээ өөрийн аймагт нийлүүлдэг гэж хариулсан нь бусад аймгийн дунджаас 12 нэгж хувиар илүү үзүүлэлттэй байгаа ба 22% нь бусад аймагт бүтээгдэхүүнээ борлуулдаг гэж хариулсан нь 9 нэгж хувиар илүү байв.

³⁹ Бизнес регистрийн санд бүртгэлтэй

Хүснэгт 1 Түүхий эд материалын бэлтгэл, бараа бүтээгдэхүүний борлуулалт

(Бусад аймаг болон УБ хоттой харьцуулсан дүн, давхардсан тоогоор, хувь)


Байршил	Түүхий эд бэлтгэл			Борлуулалт		
	Дундговь	Аймгууд	УБ	Дундговь	Аймгууд	УБ
Нийслэл хот	74	55	73	0	9	76
У/а эрхэлж буй аймаг	40	45	5	94	82	5
Бусад аймаг	4	8	6	22	13	4
Гадаад улс	36	27	30	0	3	5
Улсын хэмжээнд				4	6	19

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Дундговь аймгийн судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 24% 1-10 сая, 18% 10-50 сая, 18% нь 50-100 сая төгрөгийн жилийн орлоготой гэж хариулсан ба 10-50 сая гэсэн хариултын хувийн жин аймгууд, нийслэл хотын дундаж үзүүлэлтээс илүү, 1-10, 10-50 сая гэсэн хариултынх бага байв.

Зураг 2 ЖДҮ эрхлэгчдийн жилийн борлуулалтын орлого

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Түүвэр судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 84% нь тайлан тэнцэл гаргадаг гэсэн хариулт өгсөн нь аймгуудын дунджаас 19 нэгж хувиар, Улаанбаатар хотынхоос 7 нэгж хувиар илүү байна.

2. ЖДҮ-ийг дэмжих бодлогын арга хэмжээ

Дундговь аймгаас санал асуулгад оролцсон ЖДҮ эрхлэгчдийн 50% арилжааны банк, 44% Засгийн газар ЖДҮ-ийг хамгийн их дэмждэг гэж хариулжээ. Мөн орон нутгийн засаг захиргаа, ТББ, ОУ-ын байгууллага гэсэн хариултыг (22-26%) бусад хариултаас илүү сонгосон байна. Бусад аймгуудтай харьцуулахад Засгийн газар, ТББ гэсэн хариулт аймгуудын дунджаас илүү, арилжааны банк гэсэн хариулт бага сонгогдсон байв.

Зураг 3 ЖДҮ эрхлэгчдийг хамгийн ихээр дэмждэг байгууллага

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Дундговь аймгийн ЖДҮ эрхлэгчид дээрх байгууллагаас санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгосон, үзэсгэлэн худалдаа зохион байгуулсан, сургалт зөвлөгөө явуулах байдлаар дэмжлэг үзүүлсэн гэж хариулжээ. Бусад аймгууд, Улаанбаатартай харьцуулбал дээрх их сонгогдсон хариултаас гадна НӨАТ-аас чөлөөлсөн, инкубатор төв байгуулсан, эрх зүйн орчныг сайжруулсан зэрэг хариултуудын хувийн жин ерөнхийдөө илүү байлаа.

Зураг 4 ЖДҮ-д ямар дэмжлэг үзүүлсэн

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Цаашид хөнгөлөлттэй санхүүгийн эх үүсвэр бий болгох, татварын таатай орчинг бүрдүүлэх, төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох, үндэсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хувийн хэвшил олон нийтийн оролцоог бизнесийн шийдвэр гаргалтанд нэмэгдүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх, авлигыг бууруулах зэрэг арга хэмжээнүүдийг нэн түрүүн авбал зохистой гэж Дундговьчууд бусад аймгууд,

Улаанбаатар хотынхонтой адил үзсэн байна. Хөнгөлөлттэй санхүүгийн эх үүсвэр бий болгох, татварын таатай орчинг бүрдүүлэх, хувийн хэвшил олон нийтийн оролцоог бизнесийн шийдвэр гаргалтанд нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох гэсэн хариулт нийслэл, аймгийн дунджаас нэлээд илүү байгаа бол үндэсний үйлдвэрлэлээ дэмжих гэсэн хариулт Улаанбаатарынхаас, авлигыг бууруулах, хууль эрх зүйн орчныг сайжруулах гэсэн хариулт аймгуудын дунджаас илүү байлаа.

Зураг 5 Цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

3. Макро эдийн засгийн орчин

Манай улсад ЖДҮ хөгжих эдийн засгийн таатай орчин хангалттай бус байна гэж Дундговь аймгийн судалгаанд оролцогчдын дийлэнх буюу 86% үзэж байгаа нь аймгуудын дунджаас 15 нэгж хувь, Улаанбаатарынхаас 25 нэгж хувиар илүү байна.

Хүснэгт 2 ЖДҮ хөгжих эдийн засгийн таатай орчин бүрдсэн эсэх

(Бусад аймаг болон УБ хөтөй харьцуулсан дүн, давхардсан тоогоор, хувь)

ЖДҮ хөгжих орчин	Дундговь	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Бүрдсэн	0	10	8
Хангалттай бус	86	71	61
Огт бүрдээгүй	12	12	23
Мэдэхгүй	2	6	9

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Дундговь аймагт үйл ажиллагаа эрхлэгч ЖДҮ эрхлэгчид эдийн засгийн өсөлт өөрсдийн бизнест эерэгээр нөлөөлж байгаа гэж 34%, сөргөөр гэж 22% хариулжээ. Мөн тэдгээрийн 24% нөлөөлөөгүй, 20% мэдэхгүй гэсэн хариултыг өгсөн байна. Ерөнхийдөө аймгуудын хариултуудтай төстэй байлаа.

Хүснэгт 3 ЖДҮ хөгжилд эдийн засгийн өсөлтийн үзүүлж буй нөлөө

(Бусад аймаг болон УБ хоттой харьцуулсан дүн, давхардсан тоогоор, хувь)

Эдийн засгийн өсөлт танай бизнест	Дундговь	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Эергээр	34	38	18
Сөргөөр	22	22	43
Нөлөөлөөгүй	24	19	21
Мэдэхгүй	20	16	18

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Инфляцийн түвшин, төгрөгийн бусад валюттай харьцах ханш тогтвортой байх нь өөрсдийн бизнест сайн гэж ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх (70%) бусад аймгууд, нийслэлийнхэнтэй адил үзжээ.

4. Бизнесийн орчин

Дундговь аймгийн судалгаанд оролцсон ЖДҮ эрхлэгчид бизнесийн орчинд бусад аймгуудтай адил сөрөг үнэлгээг өгсний дээр хэсэг бүрийн үнэлгээний дундаж аймгуудын дунджаас доогуур буюу бага зэрэг муу үнэлгээг өгчээ.

Дундговь аймгийнхны санхүүжилтийн орчинд өгсөн үнэлгээ бусад аймгуудын дундаж, Улаанбаатар хотынхны үнэлгээнээс доогуур байлаа. Тус аймгийнхны хамгийн бэрхшээлтэй нь ЗГ-ын болон ОУ-ын хөнгөлөлттэй зээлийн олдоц муу гэж бусад аймгууд болон нийслэлийнхний нэг адил үзжээ. Мөн санхүүжилтийн хүү, хугацаа, хэмжээ, барьцаа хөрөнгө муу гэж дүгнэсэн нь аймгуудын дунджаас доогуур үзүүлэлттэй байна. Энэ хэсгээс хамгийн эерэг үнэлгээг банкны зээлд өгсөн үнэлгээ боломжийн байв.

Хүснэгт 4 Санхүүжилтийн орчин

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Санхүүжилтийн орчин	Дундговь	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн олдоц	-1.10	-0.93	-1.01
ОУ-ын байгууллагын хөнгөлөлттэй зээлийн олдоц	-0.98	-1.01	-1.02
Санхүүжилтийн хүү	-0.92	-0.63	-0.67
Санхүүжилтийн хугацаа	-0.80	-0.52	-0.57
Санхүүжилтийн хэмжээ	-0.62	-0.47	-0.51
Санхүүжилтийн барьцаа хөрөнгө	-0.62	-0.41	-0.56
Хөрөнгийн зах зээлээс санхүүжилт авах	-0.60	-0.55	-0.61
Зээл олгох үйл ажиллагаа	-0.52	-0.16	-0.53
Зээлийн батлан даалт	-0.50	-0.29	-0.49
Өөрийн хөрөнгийн хүрэлцээ	-0.50	-0.40	-0.43
Банк бус санхүүгийн байгууллагын зээл	-0.36	-0.32	-0.48
Банкны зээл	-0.10	0.04	-0.49

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Хууль, эрх зүй, зохицуулалтын орчны ерөнхий үнэлгээ ерөнхийдөө муу, боломжийн гэсэн үнэлгээний хооронд байв. Эдгээрээс хууль, эрх зүйн орчин, газар эзэмших байдалд боломжийн гэж дүгнэсэн нь аймаг, Улаанбаатарын дунджаас илүү

байхад төрийн байгуулалтын үйлчилгээ, татварын тогтолцоо, хяналт шалгалтын тогтолцоонд муу гэсэн үнэлгээ нь илүү өгөгджээ.

Хүснэгт 5 Хууль эрх зүйн орчин

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Хууль, эрх зүйн зохицуулалтын орчин	Дундговь	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Төрийн байгууллагын үйлчилгээ	-0.80	-0.57	-0.75
Татварын тогтолцоо	-0.68	-0.43	-0.56
Хяналт, шалгалтын тогтолцоо	-0.64	-0.32	-0.52
Гадаад худалдаа хийх нөхцөл	-0.50	-0.48	-0.43
Хууль, эрх зүйн орчин	-0.38	-0.44	-0.65
Газар эзэмших	-0.26	-0.31	-0.60

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Зах зээлийн орчинд муу, боломжийн гэсэн үнэлгээг түлхүү өгсөн ба бусад аймгууд, Улаанбаатар хоттой харьцуулбал хэрэглэгчийн худалдан авах чадвар, технологийн дэвшил, зах зээлийн багтаамжаараа илүү муу үнэлгээтэй байна. Даатгалын үйлчилгээнд өгсөн үнэлгээ бага зэрэг сайн байв.

Хүснэгт 6 Зах зээлийн орчин

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Зах зээлийн орчин	Дундговь	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Хэрэглэгчийн худалдан авах чадвар	-0.74	-0.43	-0.36
Технологийн дэвшил	-0.64	-0.34	-0.20
Зах зээлийн багтаамж	-0.56	-0.40	-0.37
Шуудрага өрсөлдөөн	-0.42	-0.40	-0.44
Даатгалын үйлчилгээ	-0.24	-0.40	-0.37

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Дундговь аймгынхан зам тээврийн хөгжилд муу үнэлгээг өгсөн нь аймаг, Улаанбаатарынхнаас илүү муу үнэлгээтэй байна. Дулаан, усан хангамжийг боломжийн, муу гэсэн үнэлгээний дунджаар үнэлсэн нь аймгуудын дунджаас бага зэрэг доогуур үнэлэгдсэн байв. Харин цахилгаан хангамж, мэдээлэл холбооны хөгжилд боломжийн сайн гэсэн үнэлгээг түлхүү өгсөн ба эдгээр нь Улаанбаатар, аймгуудын дунджаас дээгүүр үнэлгээтэй байна.

Хүснэгт 7 Дэд бүтэц

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Дэд бүтцийн байдал	Дундговь	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Зам, тээврийн хөгжил	-1.18	-0.54	-0.68
Дулаан, усан хангамж	-0.54	-0.40	-0.25
Цахилгаан хангамж	0.36	-0.02	-0.10
Мэдээлэл холбооны хөгжил	0.50	0.32	0.15

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

5. Дотоод орчин

Дундговь аймгийн ЖДҮ эрхлэгчид өөрсдийн дотоод орчиндоо ерөнхийдөө бага хүндрэлтэй, хүндрэлтэй гэсэн үнэлгээг өгчээ. Эдгээрээс ажилчдын чадвар арай илүү хүндрэлтэй үнэлгээг авсан нь аймаг,

нийслэлийн дунджаас илүү хүндрэлтэй үнэлгээтэй байв.

Хүснэгт 8 Дотоод орчин			
(Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4)			
Дотоод орчин	Дундговь	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Ажилчдын чадвар	-1.62	-1.31	-1.13
Тоног төхөөрөмжийн чанар	-1.32	-1.28	-1.20
Хүний нөөцийн удирдлага	-1.20	-1.33	-1.38
Түүхий эдийн чанар	-1.12	-1.12	-1.30

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

6. Зардлын байдал

Дундговь аймгийн судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчид зардлуудад хүндрэлтэй, бага хүндрэлтэй гэсэн үнэлгээг түлхүү өгчээ. Хамгийн хүндрэлтэй зардлуудад зээлийн хүүний, шимтгэл хураамжийн төлбөр, тоног төхөөрөмжийн зардал, эрчим хүч, цахилгааны, түүхий эдийн, зам тээврийн, дулаан, усны зардлуудыг оруулсан нь бусад аймгууд, Улаанбаатар хотынхны хандлагатай ерөнхийдөө ижил байна. Зээлийн хүүний, шимтгэл хураамжийн төлбөр, тоног төхөөрөмжийн зардал, эрчим хүч, цахилгааны зардалд өгсөн үнэлгээ аймаг нийслэлийн дунджаас доогуур байв. Харин захиргаа, үйл ажиллагааны, зар сурталчилгаа, харилцаа холбооны зардалд өгсөн үнэлгээ аймаг, нийслэлийн дундаж үнэлгээнээс дээгүүр байлаа.

Хүснэгт 9 Зардлын байдал			
(Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4)			
Зардлын байдал	Дундговь	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Зээлийн хүүний зардал	-2.10	-1.82	-1.89
Шимтгэл, хураамжийн төлбөр	-2.06	-1.71	-1.78
Тоног төхөөрөмжийн зардал	-1.92	-1.62	-1.62
Эрчим хүч, цахилгааны зардал	-1.76	-1.50	-1.48
Түүхий эдийн зардал	-1.68	-1.59	-1.62
Зам, тээврийн зардал	-1.64	-1.58	-1.62
Дулаан, усны зардал	-1.52	-1.51	-1.49
Түрээсийн зардал	-1.46	-1.47	-1.74
Ажиллах хүчний өртөг	-1.32	-1.37	-1.41
Захиргаа, үйл ажиллагааны зардал	-0.96	-1.24	-1.42
Зар сурталчилгааны зардал	-0.82	-1.10	-1.57
Харилцаа холбооны зардал	-0.60	-0.92	-1.25

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

7. Нийгмийн орчин

Тус аймгынхны хамгийн ихээр сөрөг үнэлгээ өгсөн хэсэгт нийгмийн орчин орж байгаа ба үүнээс ажилгүйдэл, ядууралд их хүндрэлтэй гэсэн хариултыг түлхүү өгсөн нь аймгуудын дунджаас доогуур, Улаанбаатарыхантай ойролцоо байна. Мөн хээл хахууль, улс төрийн байдалд хүндрэлтэй гэсэн үнэлгээг өгсөн нь бусад аймгуудтай адил байна.

Хүснэгт 10 Нийгмийн орчин

(Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4)

Нийгмийн орчин	Дундговь	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Ажилгүйдэл	-2.70	-2.49	-2.75
Ядуурал	-2.60	-2.48	-2.77
Хээл хахууль	-2.38	-2.27	-2.72
Улс төрийн байдал	-2.08	-2.08	-2.46
Гэмт хэрэг	-1.86	-2.13	-2.67
Харилцагчийн ёс суртахуун	-1.84	-1.65	-2.00
Мэдээллийн хүртээмж	-1.60	-1.53	-1.78
Хувийн хэвшил, иргэдийн оролцоо	-1.18	-1.48	-1.91


Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

8. Санхүүжилт

Дундговь аймгийн судалгаанд оролцогчдын 62% нь өөрийн хөрөнгөөр, 38% нь банкны зээлээр, 32% нь гэр бүлийн хамтын хөрөнгөөр санхүүжүүлэн үйл ажиллагаагаа эхлүүлж байжээ. Өөрийн хөрөнгөөр санхүүжигдсэн гэсэн хариултын хувийн жин Улаанбаатартай ижил, аймгуудын дунджаас илүү, банкны зээлээр гэсэн хариулт аймгуудынхаас бага, Улаанбаатарынхаас илүү, гэр бүлийн хамтын хөрөнгөөр гэсэн хариулт аймаг нийслэлээс илүү хувийн жинтэй байлаа.

Зураг 6 Анхдагч санхүүжилт

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Үйл ажиллагаагаа өргөжүүлэх, шинээр бизнес эрхлэхэд судалгаанд хамрагдагсдын дийлэнх бусад аймгуудтай адил (Улаанбаатарчуудын хувьд дийлэнх нь зээл аваагүй гэж хариулсан) санхүүжилт авч байсан гэж хариулсан бөгөөд тэдгээрийн 80 гаруй % нь банкны зээл авсан гэжээ. Зээлээ эргэн төлөхөд зээлийн хугацаа богино, хүүний төлбөр өндөр, үндсэн хэмжээ богино зэрэг нь хамгийн их хүндрэл учруулсан гэж хариулсан бөгөөд тус хариултын хувийн жин бусад аймаг, нийслэлийн дунджаас нэлээд илүү байв.

Зураг 7 Зээлийн эргэн төлөлтийн бэрхшээл

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Цаашид үйл ажиллагаагаа явуулахад бусад аймгуудтай ижил Дундговь аймгийн судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх (90%) судалгаанд хамрагдагсдын дийлэнх нь санхүүжилт авах хэрэгцээтэй гэжээ. Тэдгээрийн 44% нь 10-50 сая, 24% нь 50-100 сая төгрөгийн санхүүжилт шаардлагатай гэж хариулсан нь аймаг, Улаанбаатарын дунджаас илүү байна. Харин 100-500 сая гэсэн хариулт аймаг, нийслэлийн хариулттай ойролцоо 15 орчим % байлаа.

Зураг 8 Шаардлагатай санхүүжилт

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Дүгнэлт

- Судалгаанд хамрагдсан Дундговь аймгийн 50 ЖДҮ эрхлэгчид олон жилийн туршлагатай, цөөн тооны ажиллагсадтай бөгөөд худалдаа, үйлдвэрлэлийн чиглэлээр түлхүү үйл ажиллагаа эрхэлдэг. Түүхий эд материалаа нийслэл, өөрийн аймгаасаа голчлон бэлтгэн, аймагтаа борлуулалтаа хийдэг гэжээ.

- Борлуулалтын жилийн орлогоо 50 саяас дээш гэж хариулсан ЖДҮ эрхлэгчдийн хувийн жин нь Улаанбаатар хот, бусад аймгуудын дунджаас илүү байна. Судалгаанд оролцогчдын дийлэнх нь тайлан тэнцэл гаргадаг байна.

- Бусад аймгууд, нийслэл хотын судалгааны дүнтэй адил арилжааны банкныг хамгийн их ЖДҮ эрхлэгчдийг дэмждэг гэжээ. Мөн Засгийн газар, орон нутгийн засаг захиргаа, ТББ, ОУ-ын байгууллагыг дэмжлэг үзүүлдэг гэж хариулсан нь бусад аймгууд, Улаанбаатар хотынхны өгсөн хариултаас илүү хувийн жинтэй байлаа. Дэмжлэг үзүүлэгч байгууллагуудаас санхүүгийн эх үүсвэрийг бий болгосон, үзэсгэлэн худалдаа зохион байгуулсан, сургалт зөвлөгөө явуулсан байна.

- Хөнгөлөлттэй санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгох, татварын таатай орчинг бүрдүүлэх, төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох, үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх арга хэмжээг нэн түрүүнд авах шаардлагатай гэж үзжээ.

- Бусад аймаг, нийслэлчүүдийн адил ЖДҮ хөгжих эдийн засгийн таатай орчин хангалттай бус байна гэж дийлэнх нь дүгнэсэн байна. Мөн инфляци, ханш тогтвортой байх нь бизнест нь сайн гэж үзжээ.

- Бизнесийн орчинд ерөнхийдөө сөрөг үнэлгээг өгсөн бөгөөд аймгуудын дундажтай харьцуулахад доогуур үзүүлэлттэй байна. Тус аймгийнхны хамгийн их сөрөг үнэлгээ өгсөн хэсэгт нийгмийн орчин үүнээс ажилгүйдэл, ядууралд их хүндрэлтэй, Зардлын хэсгээс зээлийн хүү, шимтгэл хураамж, тоног төхөөрөмжийн зардал хүндрэлтэйд орж байна. Харин мэдээлэл, холбооны хөгжил, цахилгаан хангамж, банкны зээл гэсэн үзүүлэлтүүд боломжийн гэсэн үнэлгээг авчээ.

- Өөрийн хөрөнгө, банкны зээл, гэр бүлийн хамтын хөрөнгөөр дийлэнх нь үйл ажиллагаагаа эхлүүлсэн бөгөөд үйл ажиллагаагаа өргөжүүлэх, шинээр бизнес эрхлэхэд банкны зээл авсан байна.

- Зээлээ эргэн төлөхөд зээлийн хугацаа богино, хүүний төлбөр өндөр байсан нь хамгийн их бэрхшээл болдог гэжээ. Цаашид үйл ажиллагаагаа явуулахад санхүүжилт шаардлагатай гэж дийлэнх нь хариулсан ба бусад аймаг, Улаанбаатарынхаас шаардлагатай санхүүжилтийн хэмжээ нь бага байв.

Завхан аймаг


1. Ерөнхий мэдээлэл

Завхан аймагт 2011 оны 1 дүгээр улирлын байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа 513⁴⁰ ААН-ээс санамсаргүй түүврийн аргаар 50 жижиг дунд бизнес эрхлэгчийг судалгаанд хамрууллаа. Завхан аймгаас санал асуулгад оролцсон жижиг дунд бизнес эрхлэгчдийн 42% нь ХХК, 37% нь иргэд байсан бөгөөд дийлэнх нь дотоодын хөрөнгө оруулалттайгаар үйл ажиллагаагаа явуулдаг байна.

Үйл ажиллагааны чиглэлээр нь авч үзвэл судалгаанд оролцсон ЖДҮ эрхлэгчдийн 45% нь үйлдвэрлэл, 33% нь үйлчилгээ, 19% нь худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байна. Аймгуудын дундаж үзүүлэлтээс үйлдвэрлэл 8 нэгж хувиар илүү, худалдаа 12 нэгж хувиар бага, нийслэлээс үйлдвэрлэл 16 нэгж хувиар илүү, худалдаа 14 нэгж хувиар, үйлчилгээ 12 нэгж хувиар бага байв.

Зураг 1 ЖДҮ эрхлэгчдийн үйл ажиллагааны чиглэл

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 34% нь 10-аас дээш жил, 34% нь 1-5 жил, 24% нь 5-10 жил, 8% нь 1 хүртэл жил үйл ажиллагаагаа эрхэлж байгаа бөгөөд 60% нь 10 хүртэл, 36% нь 10-49, 4% нь 50-99 ажиллагсадтай ЖДҮ-үүд байна.

Давхардсан дүнгээр түүхий эд материалаа 46% нь нийслэл хотоос, 44% нь үйл ажиллагаа эрхэлж буй аймгаасаа, 20% нь гадаад орноос, 14% нь бусад аймгуудаас бэлтгэж, бүтээгдэхүүн, үйлчилгээгээ 94% өөрийн үйл ажиллагаа явуулж буй аймагтаа борлуулдаг гэжээ. Нийслэлээс түүхий эд бэлтгэдэг байдал аймгуудын дунджаас бага үзүүлэлттэй байгаа бол нийслэл, өөрсдийн аймагтаа бараа бүтээгдэхүүнээ борлуулдаг байдал аймгуудын дунджаас илүү хувийн жинтэй байна.

⁴⁰ Бизнес регистрийн санд бүртгэлтэй

Хүснэгт 1 Түүхий эд материалын бэлтгэл, бараа бүтээгдэхүүний борлуулалт

(Бусад аймаг болон УБ хоттой харьцуулсан дүн, давхардсан тоогоор, хувь)


Байршил	Түүхий эд бэлтгэл			Борлуулалт		
	Завхан	Аймгууд	УБ хот	Завхан	Аймгууд	УБ хот
Нийслэл хот	46	55	78	14	9	81
У/а эрхэлж буй аймаг	44	45		94	82	
Бусад аймаг	14	8	6	14	13	4
Гадаад улс	20	27	30	2	3	5
Улсын хэмжээнд				6	6	19

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн 28% нь 1-10 сая, 22% нь 10-50 сая, 18% нь 100-250 сая, 12% нь 50-100 сая, 8% нь 250-500 сая төгрөгийн орлоготой гэж хариулсан ба бусад аймгууд, нийслэл хотын дундаж үзүүлэлтээс 100-250 сая гэсэн хариулт 9-14 нэгж хувиар илүү, 1-10 сая гэсэн хариулт нийслэлийнхнээс 19 нэгж хувиар бага, аймгуудынхтай ойролцоо байлаа.

Зураг 2 ЖДҮ эрхлэгчдийн жилийн борлуулалтын орлого

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн


ЖДҮ эрхлэгчдийн 58% нь тайлан тэнцэл гаргадаг гэсэн хариулт өгсөн нь аймгуудын дунджаас 7 нэгж хувиар, Улаанбаатар хотынхоос 19 нэгж хувиар бага байна.

2. ЖДҮ-ийг дэмжих бодлогын арга хэмжээ

Асуулгад оролцсон ЖДҮ эрхлэгчдийн (давхардсан дүнгээр) 84% нь арилжааны банк, 36% нь Засгийн газар, 20% нь олон улсын байгууллагууд ЖДҮ-ийг хамгийн их дэмждэг гэж хариулжээ. Нийслэл болон бусад аймгуудтай харьцуулахад арилжааны банк, Засгийн газар, олон улсын байгууллагууд гэсэн байгууллагууд нь илүү сонгогдсон байна.

Зураг 3 ЖДҮ эрхлэгчдийг хамгийн ихээр дэмжлэг байгууллага

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Эдгээр байгууллагаас санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгох, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, сургалт зөвлөгөө явуулах, инкубатор төвүүдийг байгуулах байдлаар дэмжлэг үзүүлсэн гэж хариулсан нь аймгуудын дундаж болон Улаанбаатараас илүү байв.

Зураг 4 ЖДҮ-д ямар дэмжлэг үзүүлсэн

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Цаашид төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох, үндэсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, дэд бүтцийг сайжруулах, татварын таатай орчинг бүрдүүлэх, хувийн хэвшил олон нийтийн оролцоог бизнесийн шийдвэр гаргалтанд нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг нэн түрүүн авах шаардлагатай гэжээ.

Зураг 5 Цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

3. Макро эдийн засгийн орчин

Манай улсад ЖДҮ хөгжих эдийн засгийн таатай орчин хангалттай бус байна гэж Завхан аймгийн судалгаанд оролцогчдын дийлэнх буюу 80% нь үзэж байгаа бөгөөд аймгуудын дунджаас 10 нэгж хувиар бага, Улаанбаатар хотоос 19 нэгж хувиар их байна. Харин эдийн засгийн таатай орчин бүрдсэн гэж үзэж байгаа нь 10% байгаа нь аймгуудын дундажтай адил байна.

Хүснэгт 2 ЖДҮ хөгжих эдийн засгийн таатай орчин бүрдсэн эсэх

(Бусад аймаг болон УБ хоттой харьцуулсан дүн, давхардсан тоогоор, хувь)

ЖДҮ хөгжих орчин	Завхан	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Бүрдсэн	10	10	8
Хангалттай бус	80	71	61
Огт бүрдээгүй	6	12	23
Мэдэхгүй	4	6	9

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Эдийн засгийн өсөлт өөрсдийн бизнест эерэгээр нөлөөлж байгаа гэж 56% нь хариулсан бөгөөд аймгуудын дунджаас 18 нэгж хувиар, Улаанбаатар хотоос 38 нэгж хувиар илүү байв. Мөн нөлөөлгүй 12%, сөргөөр нөлөөлсөн 12% гэж тус тус хариулсан ба сөргөөр нөлөөлсөн гэсэн хариулт нь аймгуудын дунджаас 10 нэгж хувиар бага байна.

Хүснэгт 3 ЖДҮ хөгжилд эдийн засгийн өсөлтийн үзүүлж буй нөлөө

(Бусад аймаг болон УБ хоттой харьцуулсан дүн, давхардсан тоогоор, хувь)

Эдийн засгийн өсөлт	Завхан	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Эергээр	56	24	20
Сөргөөр	12	22	43
Нөлөөлөөгүй	12	19	21
Мэдэхгүй	12	16	18

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Инфляцийн түвшин, төгрөгийн ханш тогтвортой байх нь өөрсдийн бизнест сайн гэж ЖДҮ эрхлэгчдийн 52% нь хариулсан нь бусад аймгуудтай харьцуулахад 5-6 нэгж хувиар бага байна.

4. Бизнесийн орчин

Завхан аймгийн судалгаанд оролцогсон ЖДҮ эрхлэгчид дэд бүтцийн байдал, хууль эрх зүй, санхүүжилт, зах зээлийн орчинд муу болон боломжийн гэсэн үнэлгээг, өөрсдийн зардлын байдалд хүндрэлтэй, бага хүндрэлтэй гэсэн үнэлгээг, нийгмийн орчинд хүндрэлтэй, их хүндрэлтэй гэсэн үнэлгээг түлхүү өгсөн байна.

Санхүүжилтийн хувьд аймгуудын дундаж болон Улаанбаатартай харьцуулахад боломжийн гэсэн хариулт илүү байна. Завхан аймгийн ЖДҮ эрхлэгчид

ОУ-ын болон ЗГ-ын хөнгөлөлттэй зээлийн олдоц муу гэж бусад аймгууд, нийслэлийхний нэг адил үзжээ. Санхүүжилтийн хүү, хугацаа, хэмжээ зэрэг бусад үзүүлэлтийг муу боломжийн гэж үнэлсэн бөгөөд боломжийн үнэлгээ нь арай илүү өгөгджээ. Мөн аймгуудын дундаж, Улаанбаатар хотынхны өгсөн үнэлгээнээс арай дээгүүр үнэлгээтэй байв.

Хүснэгт 4 Санхүүжилтийн орчин

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Санхүүжилтийн орчин	Завхан	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн олдоц	-0.90	-0.93	-1.01
ОУ-ын байгууллагын хөнгөлөлттэй зээлийн олдоц	-0.90	-1.01	-1.02
Санхүүжилтийн барьцаа хөрөнгө	-0.56	-0.41	-0.56
Хөрөнгийн зах зээлээс санхүүжилт авах	-0.52	-0.55	-0.61
Санхүүжилтийн хэмжээ	-0.44	-0.47	-0.51
Санхүүжилтийн хүү	-0.40	-0.63	-0.67
Санхүүжилтийн хугацаа	-0.38	-0.52	-0.57
Өөрийн хөрөнгийн хүрэлцээ	-0.36	-0.40	-0.43
Зээлийн батлан даалт	-0.30	-0.29	-0.49
Банк бус санхүүгийн байгууллагын зээл	-0.20	-0.32	-0.48
Зээл олгох үйл ажиллагаа	-0.10	-0.16	-0.53
Банкны зээл	0.18	0.04	-0.49

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Судалгаанд оролцогсод хууль, эрх зүй, зохицуулалтын орчинг ерөнхийд нь боломжийн гэж дүгнэсэн ба хууль эрх зүйн орчин, татварын тогтолцоо, төрийн байгууллагын үйлчилгээ зэрэг хэсэгт өгсөн үнэлгээ бусад аймгууд, Улаанбаатарын дундажаас илүү боломжийн гэсэн үнэлгээтэй байна.

Хүснэгт 5 Хууль эрх зүйн орчин

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Хууль, эрх зүйн зохицуулалтын орчин	Завхан	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Гадаад худалдаа хийх нөхцөл	-0.56	-0.48	-0.43
Төрийн байгууллагын үйлчилгээ	-0.50	-0.57	-0.75
Татварын тогтолцоо	-0.36	-0.43	-0.56
Газар эзэмших	-0.36	-0.31	-0.60
Хяналт, шалгалтын тогтолцоо	-0.36	-0.32	-0.52
Хууль, эрх зүйн орчин	-0.32	-0.44	-0.65

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Зах зээлийн орчныг ерөнхийд нь муу, боломжийн гэж үнэлсэн бөгөөд бусад аймгууд, Улаанбаатарын үнэлгээнээс бага зэрэг муу байна.

Хүснэгт 6 Зах зээлийн орчин

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Зах зээлийн орчин	Завхан	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Зах зээлийн багтаамж	-0.58	-0.40	-0.37
Даатгалын үйлчилгээ	-0.50	-0.40	-0.37
Технологийн дэвшил	-0.46	-0.34	-0.20
Хэрэглэгчдийн худалдан авах чадвар	-0.62	-0.43	-0.36
Шударга өрсөлдөөн	-0.44	-0.40	-0.44

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Дэд бүтцийн байдалд ерөнхийд нь муу гэсэн үнэлгээг өгсөн нь бусад аймгууд, нийслэл хоттой харьцуулахад илүү муу үнэлгээтэй байна. Ялангуяа зам тээврийн хөгжил, цахилгаан, дулаан, усан хангамжинд муу гэсэн үнэлгээг түлхүү өгчээ. Харин мэдээлэл холбооны хөгжлийг боломжийн гэж дүгнэсэн байна.

Хүснэгт 7 Дэд бүтэц

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Дэд бүтцийн байдал	Завхан	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Зам, тээврийн хөгжил	-1.00	-0.54	-0.68
Цахилгаан хангамж	-0.74	-0.02	-0.10
Дулаан, усан хангамж	-0.62	-0.40	-0.25
Мэдээлэл холбооны хөгжил	0.14	0.32	0.15

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

5. Дотоод орчин

ЖДҮ эрхлэгчид өөрсдийн дотоод орчиндоо ерөнхийдөө бага хүндрэлтэй, хүндрэлтэй гэсэн үнэлгээг өгсөн бөгөөд тоног төхөөрөмжийн чанар, түүхий эдийн чанар бусад хүчин зүйлээсээ арай илүү хүндрэлтэй гэжээ. Мөн бусад аймгуудаас дээрх үзүүлэлтүүд нь муу үнэлгээтэй байв.

Хүснэгт 8 Дотоод орчин

(Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4)

Дотоод орчин	Завхан	УБ хот	Аймгуудын дундаж
Тоног төхөөрөм-жийн чанар	-1.54	-1.20	-1.33
Түүхий эдийн чанар	-1.38	-1.30	-1.28
Ажилчдын чадвар	-1.30	-1.13	-1.31
Хүний нөөцийн удирдлага	-1.12	-1.38	-1.12

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

6. Зардлын байдал

Завхан аймгийн ЖДҮ эрхлэгчид зардлуудад ерөнхийд нь хүндрэлтэй, бага хүндрэлтэй гэсэн үнэлгээг өгчээ. Завхан аймгийн ЖДҮ эрхлэгчдийн хувьд хүндрэлтэй зардлуудад зээлийн хүү, зам тээвэр, эрчим хүч, цахилгаан, түүхий эдийн зардлуудыг оруулсан байгаа нь бусад аймгууд, Улаанбаатар хотынхны үнэлгээнээс илүү хүндрэлтэй байна. Харин шимтгэл, хураамж, дулаан, ус, ажиллах хүчний зардлуудад өгсөн үнэлгээ аймгуудын дундаж, Улаанбаатарынхаас арай бага хүндрэлтэй үнэлгээтэй байна.

Хүснэгт 9 Зардлын байдал

(Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4)

Зарлын байдал	Завхан	УБ хот	Аймгуудын дундаж
Зээлийн хүү	-2.02	-1.89	-1.82
Зам, тээвэр	-1.76	-1.62	-1.58
Эрчим хүч, цахилгаан	-1.76	-1.48	-1.50
Түүхий эд	-1.70	-1.62	-1.59
Тоног төхөөрөмж	-1.66	-1.20	-1.62
Шимтгэл, хураамж	-1.58	-1.78	-1.71
Түрээс	-1.46	-1.74	-1.47
Захиргаа, үйл ажиллагаа	-1.42	-1.42	-1.24
Дулаан, ус	-1.34	-1.49	-1.51
Ажиллах хүч	-1.28	-1.41	-1.37
Зар сурталчилгаа	-1.06	-1.57	-1.10
Харилцаа холбоо	-1.06	-1.25	-0.92

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

7. Нийгмийн орчин

Судалгаанд оролцогчдын дийлэнх нь нийгмийн орчинд их хүндрэлтэй, хүндрэлтэй гэж хариулсан нь аймгуудын дунджаас хүндрэлтэй, Улаанбаатарыхнаас хүндрэл багатай байна. Завхан аймгийхан ажилгүйдэл, ядуурал зэрэг нь их хүндрэлтэй гэж үзэж байгаа ба бусад аймгуудтай харьцуулахад илүү хүндрэлтэй үнэлгээтэй байна. Харин Улаанбаатар хотын үнэлгээтэй харьцуулахад нийгмийн орчин ерөнхийдөө хүндрэл багатай гэж үнэлэгджээ.

Хүснэгт 10 Нийгмийн орчин

(Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4)

Нийгмийн орчин	Завхан	УБ хот	Аймгуудын дундаж
Ядуурал	-2.74	-2.77	-2.48
Ажилгүйдэл	-2.60	-2.75	-2.49
Хээл хахууль	-2.32	-2.72	-2.27
Улс төрийн байдал	-2.24	-2.46	-2.08
Гэмт хэрэг	-2.14	-2.67	-2.13
Харилцагчийн ёс суртахуун	-1.86	-2.00	-1.65
Хувийн хэвшил, иргэдийн оролцоо	-1.72	-1.91	-1.48
Мэдээллийн хүртээмж	-1.54	-1.78	-1.53

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

8. Санхүүжилт

Судалгаанд оролцсон ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх давхардсан дүнгээр 60% нь банкны зээлээр, 58% нь өөрийн хөрөнгөөр үйл ажиллагаагаа санхүүжүүлж бизнесээ эхлүүлж байжээ. Аймгуудын дундажтай харьцуулахад банкны зээлээр гэсэн хариултын хувийн жин 13 нэгж хувиар, өөрийн хөрөнгөөр гэсэн хариулт 7 нэгж хувиар илүү, гэр бүл, найз нөхдийн хамтын хөрөнгөөр үйл ажиллагаагаа эхлүүлсэн нь бага зэрэг бага байв. Улаанбаатарыхнаас банкны зээл авсан байдал нэлээд илүү байна.

Зураг 6 Анхдагч санхүүжилт

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Өнгөрсөн хугацаанд үйл ажиллагаагаа өргөжүүлэх, шинээр бизнес эрхлэхэд зээл авч байсан уу гэсэн асуултанд судалгаанд хамрагдагсдын 76% нь (Улаанбаатарчуудын хувьд 62% нь зээл аваагүй гэж хариулсан) санхүүжилт авч байсан гэж хариулсан бөгөөд тэдгээрийн давхардсан дүнгээр 90% нь банкны зээл, 21% нь хөнгөлөлттэй зээл авч байжээ.

Зээлээ эргэн төлөхөд 32% нь хугацаа богино, 20% нь зээлийн хүүний төлбөр өндөр байгаа нь хамгийн их бэрхшээл учруулдаг гэж хариулсан бол 30% нь хүндрэл учраагүй гэжээ. Аймгуудын дунджаас хүндрэл тулгараагүй гэсэн хариулт 14 нэгж хувиар илүү, гол хүндрэлтэй гэсэн хариултууд ойролцоо байв. Харин Улаанбаатартай харьцуулбал зээлийн хугацаа богино гэсэн хариулт 17 нэгж хувиар илүү байна. Гэхдээ Улаанбаатарчуудын ердөө 54% нь уг асуултанд хариулсан байна.

Зураг 7 Зээлийн эргэн төлөлтийн бэрхшээл

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Цаашид үйл ажиллагаагаа явуулахад санхүүжилт авах хэрэгцээтэй гэж 80% нь хариулсан байгаа ба тэдгээрийн 40% нь 1-5 сая, 20% нь 5-10 сая, 18% нь 1

сая хүртэлх, 15% нь 10-50 сая төгрөгийн санхүүжилт шаардлагатай гэж хариулжээ. Аймгуудын дундаж, Улаанбаатарын үзүүлэлттэй харьцуулбал 1-5 сая төгрөгийн санхүүжилт шаардлагатай гэсэн хариулт нэлээд илүү, 10-500 сая гэсэн хариулт бага байв.



Дүгнэлт

- Судалгаанд оролцсон Завхан аймгийн 51 ЖДҮ эрхлэгчид олон жилийн туршлагатай, цөөн тооны ажиллагсадтай бөгөөд йлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр түлхүү үйл ажиллагаа эрхэлдэг.
- Түүхий эд материалаа нийслэл хотоос болон өөрийн аймгаасаа голчлон бэлтгэж дийлэнх нь өөрийн аймагтаа борлуулалт хийдэг байна.
- Завхан аймгийн судалгаанд оролцсон ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх нь жилдээ дунджаар 1-10 сая, 10-50 сая, 100-250 сая төгрөгийн орлого олдог гэжээ.
- Бусад аймгууд, нийслэл хотын судалгааны дүнтэй адил арилжааны банкныг хамгийн их ЖДҮ эрхлэгчдийг дэмждэг гэжээ. Мөн Засгийн газар, ОУ-ын байгууллага дэмждэг гэсэн хариулт багагүй хувьтай байв. Эдгээр байгууллагаас санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгосон, үзэсгэлэн худалдаа зохион байгуулсан, сургалт зөвлөгөө явуулсан, инкубатор төвийг байгуулсан гэжээ.
- Завхан аймгийн судалгаанд оролцогсод цаашид төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох, үндэсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, дэд бүтцийг сайжруулах, татварын таатай орчинг бүрдүүлэх зэрэг арга хэмжээг нэн түрүүнд авах шаардлагатай гэж үзжээ.
- Бусад аймаг, нийслэлчүүдийн адил ЖДҮ хөгжих эдийн засгийн таатай орчин хангалттай бус байна гэж дийлэнх нь дүгнэсэн байна. Мөн инфляци, ханш тогтвортой байх нь бизнест нь сайн гэж үзжээ.

- Бизнесийн орчин ерөнхийдөө бусад аймгууд болон Улаанбаатартай харьцуулахад ижил байгаа бөгөөд дийлэнх нь муугаас боломжийн гэсэн үнэлгээг өгсөн байна. Тус аймгаас хамгийн их сөрөг үнэлгээ өгсөн нь нийгмийн орчин үүнээс ажилгүйдэл, ядуурал зэргийг нь их хүндрэлтэй гэжээ.
- Өөрийн хөрөнгө, банкны зээлээр дийлэнх нь үйл ажиллагаагаа эхлүүлсэн бөгөөд үйл ажиллагаагаа өргөжүүлэх, шинээр бизнес эрхлэхэд банкны зээл авсан байна. Тэдгээрийн 30% нь зээлээ эргэн төлөхөд хүндрэл учраагүй гэжээ. Харин хүндрэлтэй гэж үзсэн ЖДҮ эрхлэгчид хугацаа богино, зээлийн хүүний төлбөр өндөр байгаа нь бэрхшээл учруулдаг гэжээ.
- Цаашид үйл ажиллагаагаа явуулахад санхүүжилт шаардлагатай гэж дийлэнх нь хариулсан ба шаардлагатай санхүүжилтийн хэмжээ нь аймгуудын дундаж, Улаанбаатар хотынхоос арай бага дүнтэй байна.

Орхон аймаг

1. Ерөнхий мэдээлэл

Орхон аймагт 2011 оны 1 дүгээр улирлын байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа 1344⁴¹ ААН-ээс санамсаргүй түүврийн аргаар 101 жижиг дунд бизнес эрхлэгчийг судалгаанд хамрууллаа. Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 76% нь ХХК, 17% нь иргэд, 2% нь ХК, 2% нь бусад, 1% нь хоршоо дийлэнх нь дотоодын хөрөнгө оруулалттайгаар үйл ажиллагаагаа явуулдаг байна. Орхон аймагт судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 42% нь үйлдвэрлэл, 30% нь үйлчилгээ, 28% нь худалдаа эрхэлдэг гэж хариулсан нь бусад аймгуудын дундаж үзүүлэлттэй ойролцоо хувьтай байлаа.

Зураг 1 ЖДҮ эрхлэгчдийн үйл ажиллагааны чиглэл

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Орхон аймгийн судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 34% нь 1-5 жил, 31% нь 5-10 жил, 23% нь 10-аас дээш жил, 10% нь 1 хүртэл жил үйл ажиллагаагаа эрхэлж байгаа бөгөөд 68% нь 10 хүртэл, 25% нь 10-49, 3% нь 50-99, 2% нь 100-149 ажиллагсадтай байна. хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 44% нь 1-5 жил, 24% нь 5-10 жил, 20% нь 10-аас дээш жил, 10% нь 1 хүртэл жил үйл ажиллагаагаа эрхэлж байгаа бөгөөд 60% нь 10 хүртэл, 24% нь 10-49, 4% нь 100-149, 2% нь 50-99 ажиллагсадтай байна.

Орхон аймгийн судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн давхардсан тоогоор 49% нь нийслэл хотоос, 50% нь үйл ажиллагаа эрхэлж буй аймгаас, 36% нь гадаад улсаас түүхий эд, материалаа бэлтгэдэг гэж хариуллаа. Нийслэл хотоос түүхий эд бэлтгэдэг гэсэн хариултын хувийн жин аймгуудын дунджаас 6 нэгж хувиар бага байсан бол өөрийн аймгаас гэсэн хариулт 5 нэгж хувиар, гадаадаас гэсэн хариулт 9 нэгж хувиар тус тус их байв. Мөн ЖДҮ эрхлэгчдийн 84% нь эцсийн бүтээгдэхүүнээ өөрийн

аймагт нийлүүлдэг гэж хариулсан нь бусад аймгийн дундажтай ойролцоо хувьтай байлаа.

Хүснэгт 1 Түүхий эд материалын бэлтгэл, бараа бүтээгдэхүүний борлуулалт

(Бусад аймаг болон УБ хоттой харьцуулсан дүн, давхардсан тоогоор, хувь)

Байршил	Түүхий эд бэлтгэл			Борлуулалт		
	Орхон	Аймгууд	УБ	Орхон	Аймгууд	УБ
Нийслэл хот	49	55	73	5	9	76
Үйл ажиллагаа эрхэлж буй	50	45	5	84	82	5
Бусад аймаг	11	8	6	13	13	4
Гадаад улс	36	27	30	3	3	5
Улсын хэмжээнд				8	6	19

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Орхон аймгийн судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 33% 10-50 сая, 23% 1-10, 16% 50-100 сая төгрөгийн жилийн орлоготой гэж хариулсан ба бусад аймгууд, нийслэл хотын дундаж үзүүлэлтээс 10-50 сая, 50-100 сая гэсэн хариултуудын хувийн жин илүү, 1-10 сая гэсэн хариултынх бага байв.

Зураг 2 ЖДҮ эрхлэгчдийн жилийн борлуулалтын орлого

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Түүвэр судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 83% нь тайлан тэнцэл гаргадаг гэсэн хариулт өгсөн нь аймгуудын дунджаас 18 нэгж хувиар, Улаанбаатар хотынхоос 6 нэгж хувиар илүү байна.

2. ЖДҮ-ийг дэмжих бодлогын арга хэмжээ

Асуулгад оролцсон ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх буюу 67% нь арилжааны банк ЖДҮ-ийг хамгийн их дэмждэг гэж хариулсан бөгөөд аймгуудын дундажтай харьцангуй ойролцоо хувьтай байв. Мөн Засгийн газар, Худалдаа аж үйлдвэрийн танхим, орон нутгийн засаг захиргаа гэсэн хариултыг (санал асуулгад оролцогчдын 17-24%) бусад хариултаас илүү сонгосон байна. Ерөнхийдөө аймгуудын дундажтай хандлага нь төстэй байв.

⁴¹ Бизнес регистрийн санд бүртгэлтэй

Зураг 3 ЖДҮ эрхлэгчдийг хамгийн ихээр дэмждэг байгууллага

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Дээрх байгууллагуудаас санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгосон, үзэсгэлэн худалдаа зохион байгуулсан, сургалт зөвлөгөө явуулах байдлаар ЖДҮ-т дэмжлэг үзүүлсэн гэсэн хариулт хамгийн их сонгогджээ. Бусад аймгуудтай харьцуулахад хандлага нь ижил байв.

Зураг 4 ЖДҮ-д ямар дэмжлэг үзүүлсэн

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Цаашид төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох, татварын таатай орчинг бүрдүүлэх, үндэсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хөнгөлөлттэй санхүүгийн эх үүсвэр бий болгох, авлигыг бууруулах, зөвшөөрөл лицензийн тоог багасгах зэрэг арга хэмжээнүүдийг нэн түрүүн авбал зохистой гэж Орхон аймгийн ЖДҮ эрхлэгчид үзсэн байна. Аймгууд, Улаанбаатартай харьцуулбал төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох, татварын таатай орчинг бүрдүүлэх авлигыг бууруулах, зөвшөөрөл

лицензийн тоог багасгах гэсэн хариултуудын хувийн жин илүү байв.

Зураг 5 Цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

3. Макро эдийн засгийн орчин

Манай улсад ЖДҮ хөгжих эдийн засгийн таатай орчин хангалттай бус байна гэж Орхон аймгийн судалгаанд оролцогчдын дийлэнх буюу 68% үзэж байгаа нь аймгуудын дундажтай ойролцоо, Улаанбаатарынхаас бага зэрэг илүү хариулт байлаа.

Хүснэгт 2 ЖДҮ хөгжих эдийн засгийн таатай орчин бүрдсэн эсэх

(Бусад аймаг болон УБ хоттой харьцуулсан дүн, давхардсан тоогоор, хувь)

ЖДҮ хөгжих орчин	Орхон	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Бүрдсэн	8	10	8
Хангалттай бус	68	71	61
Огт бүрдээгүй	16	12	23
Мэдэхгүй	7	6	9

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Орхон аймагт үйл ажиллагаа эрхлэгч ЖДҮ эрхлэгчдийн 33% эдийн засгийн өсөлт өөрсдийн бизнест эерэгээр, 20% сөргөөр нөлөөлж байна гэж хариулсан нь аймгуудын дундажтай ойролцоо хувьтай хариулт байв. Харин Улаанбаатартай харьцуулахад өөрсдийн бизнест эдийн засгийн өсөлт эерэгээр нөлөөлсөн гэсэн хариултууд илүү хувийн жинтэй байв.

Хүснэгт 3 ЖДҮ хөгжилд эдийн засгийн өсөлтийн үзүүлж буй нөлөө

(Бусад аймаг болон УБ хоттой харьцуулсан дүн, давхардсан тоогоор, хувь)

Эдийн засгийн өсөлт танай бизнест	Орхон	Аймгуудын дундаж	Улаан- баатар
Эергээр	33	38	18
Сөргөөр	20	22	43
Нөлөөлөөгүй	24	19	21
Мэдэхгүй	18	16	18

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Инфляцийн түвшин тогтвортой байх нь өөрсдийн бизнест сайн гэж Орхон аймгийн судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн тал хувь, инфляцийн түвшин буурвал сайн гэж 30-аад % нь хариулсан нь инфляцийн түвшин тогтвортой байх нь сайн гэсэн хариултын хувийн жин Улаанбаатарынхаас 7 нэгж хувиар илүү, аймгуудын дунджаас 8 нэгж хувиар бага, инфляцийн түвшин буурвал сайн гэсэн хариултын хувийн жин аймгуудынхаас 9 нэгж хувиар илүү байна. Төгрөгийн бусад валюттай харьцах ханш тогтвортой байх нь өөрсдийн бизнест сайн гэж ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх бусад аймгууд, нийслэлийнхэнтэй адил үзжээ.

4. Бизнесийн орчин

Орхон аймгийн судалгаанд оролцсон ЖДҮ эрхлэгчид дэд бүтцийн байдалд дунджаар боломжийн, хууль эрх зүй, санхүүжилт, зах зээлийн орчинд муу боломжийн гэсэн үнэлгээний дунджаар, дотоод орчин, зардлын байдалд хүндрэлтэй, бага хүндрэлтэй гэсэн хариултын дундуур, нийгмийн орчинд хүндрэлтэй гэсэн хариултуудыг тус тус өгсөн байна.

Санхүүжилтийн хувьд Орхон аймгийнхан санхүүжилтийн хүүнд муу үнэлгээг өгсөн нь бусад аймгууд, Улаанбаатар хотынхоос муу үнэлгээтэй байлаа. Мөн ОУ-ын байгууллагын хөнгөлөлттэй зээлийн олдцыг муу гэж дүгнэсэн нь бусад аймаг, Улаанбаатарынхантай ижил байв. Хөрөнгийн зах зээлээс санхүүжилт авах, барьцаа хөрөнгө, зээл олгох явц зэрэгт боломжийноос муу тал руу үнэлгээг өгсөн нь Улаанбаатар, аймгуудын дунджаас бага зэрэг муу үнэлгээтэй байна. Бусад асуултууд муугаас боломжийн гэж дүгнэгджээ. Энэ хэсгээс хамгийн эерэг үнэлгээг санхүүжилтийн хугацаанд өгсөн үнэлгээ боломжийн талдаа байв.

Хүснэгт 4 Санхүүжилтийн орчин

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Санхүүжилтийн орчин	Орхон	Аймгуудын дундаж	Улаан- баатар
Санхүүжилтийн хүү	-1.12	-0.63	-0.67
ОУ-ын байгууллагын хөнгөлөлттэй зээлийн олдц	-1.04	-1.01	-1.02
Хөрөнгийн зах зээлээс санхүүжилт авах	-0.78	-0.55	-0.61
Санхүүжилтийн барьцаа хөрөнгө	-0.62	-0.41	-0.56
Зээл олгох үйл ажиллагаа	-0.59	-0.16	-0.53
Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн олдц	-0.43	-0.93	-1.01
Зээлийн батлан даалт	-0.40	-0.29	-0.49
Өөрийн хөрөнгийн хүрэлцээ	-0.33	-0.40	-0.43
Банкны зээл	-0.27	0.04	-0.49
Санхүүжилтийн хэмжээ	-0.21	-0.47	-0.51
Банк бус санхүүгийн байгууллагын зээл	-0.19	-0.32	-0.48
Санхүүжилтийн хугацаа	-0.02	-0.52	-0.57

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Хууль, эрх зүй, зохицуулалтын орчны ерөнхий үнэлгээ муу, боломжийн гэсэн үнэлгээний хооронд байв. Эдгээрээс газар эзэмшихээс бусад үзүүлэлтүүдэд муу гэсэн үнэлгээг илүү өгсөн байна. Бусад аймгуудтай харьцуулахад ерөнхийдөө аймгуудын дунджаас илүү муу үнэлгээтэй байлаа.

Хүснэгт 5 Хууль эрх зүйн орчин

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Хууль, эрх зүйн зохицуулалтын орчин	Орхон	Аймгуудын дундаж	Улаан- баатар
Төрийн байгууллагын үйлчилгээ	-0.74	-0.57	-0.75
Татварын тогтолцоо	-0.64	-0.43	-0.56
Хууль, эрх зүйн орчин	-0.52	-0.44	-0.65
Гадаад худалдаа хийх нөхцөл	-0.42	-0.48	-0.43
Хяналт, шалгалтын тогтолцоо	-0.37	-0.32	-0.52
Газар эзэмших	-0.36	-0.31	-0.60

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Зах зээлийн орчинг боломжийн, муу гэсэн үнэлгээний хооронд дүгнэсэн бөгөөд үнэлгээ нь илүү боломжийн тал руугаа байв. Даатгалын үйлчилгээ, шударга өрсөлдөөнд өгсөн үнэлгээ Улаанбаатар, аймгуудын дунджаас доогуур байгаа бол хэрэглэгчийн худалдан авах чадвар, зах зээлийн багтаамж, технологийн дэвшилээрээ бусад аймгуудаас илүү боломжийн үнэлгээтэй байв.

Хүснэгт 6 Зах зээлийн орчин

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Зах зээлийн орчин	Орхон	Аймгуудын дундаж	Улаан- баатар
Даатгалын үйлчилгээ	-0.55	-0.40	-0.37
Шударга өрсөлдөөн	-0.46	-0.40	-0.44
Хэрэглэгчдийн худалдан авах чадвар	-0.38	-0.43	-0.36
Зах зээлийн багтаамж	-0.25	-0.40	-0.37
Технологийн дэвшил	-0.15	-0.34	-0.20

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Орхон аймгынхан дэд бүтэцдээ үзүүлэлт тус бүрээрээ боломжийн гэсэн үнэлгээг түлхүү өгсөн ба хамгийн өндөр үнэлгээг мэдээлэл холбооны хөгжил, хамгийн доогуур үнэлгээг зам тээврийн хөгжилд

өгчээ. Бусад аймаг, Улаанбаатар хотынхоос үзүүлэлт бүрээрээ дээгүүр үнэлгээтэй байна.

Хүснэгт 7 Дэд бүтэц

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Дэд бүтцийн байдал	Орхон	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Зам, тээврийн хөгжил	-0.33	-0.54	-0.68
Дулаан, усан хангамж	-0.01	-0.40	-0.25
Цахилгаан хангамж	0.14	-0.02	-0.10
Мэдээлэл холбооны хөгжил	0.43	0.32	0.15

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

5. Дотоод орчин

Орхон аймгийн ЖДҮ эрхлэгчид өөрсдийн дотоод орчиндоо ерөнхийдөө бага хүндрэлтэй гэсэн үнэлгээг өгчээ. Эдгээрээс ажилчдын чадвар, хүний нөөцийн удирдлага арай илүү хүндрэлтэй үнэлгээг авчээ. Үзүүлэлт бүрийн үнэлгээ аймаг, нийслэлийн дундажтай ойролцоо үнэлгээтэй байв.

Хүснэгт 8 Дотоод орчин

(Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4)

Дотоод орчин	Орхон	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Ажилчдын чадвар	-1.25	-1.31	-1.13
Хүний нөөцийн удирдлага	-1.21	-1.33	-1.38
Тоног төхөөрөмжийн чанар	-1.11	-1.28	-1.20
Түүхий эдийн чанар	-1.10	-1.12	-1.30

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

6. Зардлын байдал

Орхон аймгийн судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчид зардлуудад бага хүндрэлтэй, хүндрэлтэй гэсэн үнэлгээг түлхүү өгчээ. Хамгийн хүндрэлтэй зардлуудад зээлийн хүүний, шимтгэл хураамжийн төлбөр, түрээсийн, эрчим хүч, цахилгааны, дулаан, усны, түүхий эдийн, тоног төхөөрөмжийн зардлуудыг оруулсан нь бусад аймгууд, Улаанбаатар хотынхны хандлагатай ерөнхийдөө төстэй байна. Гэхдээ ихэнх зардуудад өгсөн үнэлгээ нийслэл, аймгуудын дунджаас дээгүүр /сайн/ үнэлгээтэй байлаа. Харин түрээс, эрчим хүч, цахилгаан, дулаан усны зардал аймгуудын дунджаас доогуур үнэлгээтэй байв.

Хүснэгт 9 Зардлын байдал

(Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4)

Зардлын байдал	Орхон	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Зээлийн хүүний зардал	-1.71	-1.82	-1.89
Шимтгэл, хураамжийн төлбөр	-1.67	-1.71	-1.78
Түрээсийн зардал	-1.63	-1.47	-1.74
Эрчим хүч, цахилгааны зардал	-1.62	-1.50	-1.48
Дулаан, усны зардал	-1.60	-1.51	-1.49
Түүхий эдийн зардал	-1.58	-1.59	-1.62
Тоног төхөөрөмжийн зардал	-1.55	-1.62	-1.62
Зам, тээврийн зардал	-1.40	-1.58	-1.62
Ажиллах хүчний өртөг	-1.37	-1.37	-1.41
Захиргаа, үйл ажиллагааны зардал	-1.20	-1.24	-1.42
Зар сурталчилгааны зардал	-1.15	-1.10	-1.57
Харилцаа холбооны зардал	-0.94	-0.92	-1.25

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

7. Нийгмийн орчин

Тус аймгынхны хамгийн ихээр сөрөг үнэлгээ өгсөн хэсэгт нийгмийн орчин орж байгаа ба үүнээс ажилгүйдэл, хээл хахууль, ядууралд их хүндрэлтэй, гэмт хэрэг, улс төрийн байдал, харилцагчийн ёс суртахуунд хүндрэлтэй, хувийн хэвшлийн оролцоо, мэдээллийн хүртээмжинд бага хүндрэлтэй гэсэн хариултыг түлхүү өгчээ. Ерөнхийдөө бусад аймгууд, Улаанбаатартай хариултууд төстэй байлаа.

Хүснэгт 10 Нийгмийн орчин

(Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4)

Нийгмийн орчин	Орхон	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Ажилгүйдэл	-2.65	-2.49	-2.75
Хээл хахууль	-2.59	-2.27	-2.72
Ядуурал	-2.58	-2.48	-2.77
Гэмт хэрэг	-2.31	-2.13	-2.67
Улс төрийн байдал	-2.11	-2.08	-2.46
Харилцагчийн ёс суртахуун	-1.79	-1.65	-2.00
Хувийн хэвшил, иргэдийн оролцоо	-1.51	-1.48	-1.91
Мэдээллийн хүртээмж	-1.40	-1.53	-1.78


Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

8. Санхүүжилт

Судалгаанд оролцогчдын дийлэнх өөрийн хөрөнгө, банкны зээлээр санхүүжигдэн үйл ажиллагаагаа эхлүүлж байжээ. Мөн судалгаанд оролцогчдын 30-аад % нь гэр бүлийн хамтын хөрөнгөөр үйл ажиллагаа эхлүүлсэн байна. Өөрийн хөрөнгөөр санхүүжигдсэн гэсэн хариулт Улаанбаатартай ижил, аймгуудын дунджаас илүү, банкны зээлээр гэсэн хариулт аймгуудтай ойролцоо, Улаанбаатарынхаас илүү, гэр бүлийн хамтын хөрөнгөөр гэсэн хариулт аймаг нийслэлтэй ойролцоо хувийн жинтэй байлаа.

Зураг 6 Анхдагч санхүүжилт

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Үйл ажиллагаагаа өргөжүүлэх, шинээр бизнес эрхлэхэд судалгаанд хамрагдагсдын дийлэнх бусад аймгуудтай адил (Улаанбаатарчуудын хувьд дийлэнх нь зээл аваагүй гэж хариулсан) санхүүжилт авч байсан гэж хариулсан бөгөөд тэдгээрийн 90-ээд % банкны зээл авсан гэжээ. Зээлээ эргэн төлөхөд хүүний төлбөр өндөр, хугацаа богино байгаа нь хамгийн их хүндрэл учруулсан гэж хариулсан бөгөөд бусад аймаг, нийслэлийн дунджаас илүү хувийн жинтэй байв.

Зураг 7 Зээлийн эргэн төлөлтийн бэрхшээл

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Орхон аймгаас судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх /80%/ цаашид үйл ажиллагаагаа явуулахад бусад аймгуудтай ижил санхүүжилт авах хэрэгцээтэй гэжээ. Тэдгээрийн 32% нь 10-50 сая, 24% нь 50-100 сая, 19% нь 100-500 сая, 14% нь 5-10 сая төгрөгийн санхүүжилт шаардлагатай гэжээ. 10-50 сая гэсэн хариултын хувийн жин аймгуудын дунджаас ялимгүй бага, Улаанбаатарынхаас ялимгүй их байна. 50-100 сая, 100-500 сая гэсэн хариулт аймаг, нийслэлийн хариултаас илүү, 5-10 сая гэсэн хариулт нийслэл, аймгуудын дундажтай ойролцоо байв.

Зураг 8 Шаардлагатай санхүүжилт

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Дүгнэлт

- Судалгаанд хамрагдсан Орхон аймгийн 101 ЖДҮ эрхлэгчид олон жилийн туршлагатай, цөөн тооны ажиллагсадтай бөгөөд үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр түлхүү үйл ажиллагаа эрхэлдэг.
- Түүхий эд материалаа нийслэл, өөрийн аймгаасаа голчлон бэлтгэн, аймагтаа борлуулалтаа хийдэг гэжээ.
- Борлуулалтын жилийн орлогоороо бусад аймгууд, Улаанбаатар хотын дунджаас илүү байгаа бөгөөд дийлэнх нь тайлан тэнцэл гаргадаг гэжээ.
- Бусад аймгууд, нийслэл хотын судалгааны дүнтэй адил арилжааны банкныг хамгийн их ЖДҮ эрхлэгчдийг дэмждэг бөгөөд санхүүгийн эх үүсвэрийг бий болгосон гэжээ.
- Төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох, татварын таатай орчинг бүрдүүлэх, үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгох, авлигыг бууруулах, зөвшөөрөл лицензийн тоог багасгах арга хэмжээг нэн түрүүнд авах шаардлагатай гэж үзжээ.
- Бусад аймаг, нийслэлчүүдийн адил дийлэнх нь ЖДҮ хөгжих эдийн засгийн таатай орчин хангалттай бус байна гэж дүгнэсэн байна. Мөн инфляци, ханш тогтвортой байх нь бизнест нь сайн гэжээ.
- Бизнесийн орчинд ерөнхийдөө сөрөг үнэлгээг өгсөн байна. Тус аймгийнхны хамгийн их хүндрэлтэй гэсэн үнэлгээ өгсөн хэсэгт нийгмийн орчин үүнээс ажилгүйдэл, хээл хахууль, ядуурал, гэмт хэрэг орж байна. Харин мэдээлэл, холбооны хөгжил, цахилгаан хангамж, санхүүжилтийн хугацаа гэсэн үзүүлэлтүүдэд боломжийн гэсэн үнэлгээг өгчээ.
- Өөрийн хөрөнгө, банкны зээлээр дийлэнх нь үйл ажиллагаагаа эхлүүлсэн бөгөөд үйл ажиллагаагаа өргөжүүлэх, шинээр бизнес эрхлэхэд банкны зээл авсан байна.

- Зээлээ эргэн төлөхөд зээлийн хүүний төлбөр өндөр, хугацаа богино байсан нь хамгийн их хүндрэл учруулдаг гэжээ.
- Цаашид үйл ажиллагаагаа явуулахад санхүүжилт шаардлагатай гэж дийлэнх нь хариулсан ба бусад аймаг, Улаанбаатарынхаас шаардлагатай санхүүжилтийн хэмжээ нь өндөр байв.

Өвөрхангай аймаг


1. Ерөнхий мэдээлэл

Өвөрхангай аймагт 2011 оны 1 дүгээр улирлын байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа 647⁴² ААН-ээс санамсаргүй түүврийн аргаар 50 жижиг дунд бизнес эрхлэгчийг судалгаанд хамрууллаа. Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 54% нь ХХК, 28% нь иргэд, 10% нь ХК, 4% нь нөхөрлөл, 2% нь хоршоо байсан бөгөөд тэдгээрийн 80% нь дотоодын хөрөнгө оруулалттайгаар үйл ажиллагаагаа явуулдаг байна.

Өвөрхангай аймагт судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 52% нь үйлдвэрлэл, 20% нь үйлчилгээ, 28% нь худалдаа эрхэлдэг гэжээ. Дээрх үзүүлэлтүүдийг аймгуудын дундаж үзүүлэлттэй харьцуулбал, үйлдвэрлэл 20 нэгж хувиар илүү, худалдаа болон үйлчилгээ харгалзан 4, 16 нэгж хувиар бага байна.

Зураг 1 ЖДҮ эрхлэгчдийн үйл ажиллагааны чиглэл

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийг үйл ажиллагаа эрхэлж буй хугацаагаар нь авч үзвэл 36% нь 10-аас дээш жил, 28% нь 5-10 жил, 26% нь 1-5 жил, 8% нь 1 жил хүртэл хугацаанд үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд тэдгээрийн 68% нь 1-9, 26% нь 10-49 ажиллагсадтай ЖДҮ-үүд байна.

Өвөрхангай аймгийн хувьд түүвэр судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн давхардсан тоогоор 70% нь нийслэл хотоос, 46% нь үйл ажиллагаа эрхэлж буй аймгаас түүхий эд, материалаа бэлтгэдэг гэж хариуллаа. Тус үзүүлэлтийг аймгуудын дундаж үзүүлэлттэй харьцуулбал, нийслэл хотоос худалдаж авдаг гэсэн хариулт 15 нэгж хувь, үйл ажиллагаа эрхэлж буй аймгаас гэсэн хариулт 1 нэгж хувиар илүү байна. ЖДҮ эрхлэгчдийн 76% нь эцсийн бүтээгдэхүүнээ өөрийн аймагт нийлүүлдэг гэж

хариулсан нь бусад аймгийн дунджаас 6 нэгж хувиар бага үзүүлэлттэй байна. Мөн улсын хэмжээ болон нийслэл хотод эцсийн бүтээгдэхүүнээ борлуулдаг гэж хариулсан хариултын хувь 16%-тай байгаа нь бусад аймгийн дунджаас 1 нэгж хувиар их байна.

Хүснэгт 1 Түүхий эд материалын бэлтгэл, бараа бүтээгдэхүүний борлуулалт

(Бусад аймаг болон УБ хоттой харьцуулсан дүн, давхардсан тоогоор, хувь)

Байршил	Түүхий эд бэлтгэл			Борлуулалт		
	Өвөрхангай	Аймгууд	УБ	Өвөрхангай	Аймгууд	УБ
Нийслэл хот	70	55	73	4	9	76
У/а эрхэлж буй аймаг	46	45	5	76	82	5
Бусад аймаг	4	8	6	12	13	4
Гадаад улс	16	27	30	2	3	5
Улсын хэмжээнд				12	6	19

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Өвөрхангай аймгийн судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 36% нь 1-10 сая, 26% нь 10-50 сая төгрөгийн жилийн борлуулалтын орлоготой гэж хариуллаа. Үүнийг бусад аймгуудын дундаж үзүүлэлттэй харьцуулахад 1-10 сая төгрөгийн жилийн борлуулалтын орлоготой гэсэн хариулт бусад аймгуудын дунджаас 6 нэгж хувиар илүү, 10-50 сая төгрөг гэсэн хариултын хувь 2 нэгж хувиар бага үзүүлэлттэй байна.

Зураг 2 ЖДҮ эрхлэгчдийн жилийн борлуулалтын орлого

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Түүнчлэн түүвэр судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 72% нь тайлан тэнцэл гаргадаг гэсэн хариулт өгсөн нь аймгуудын дунджаас 7 нэгж хувиар их, Улаанбаатар хотынхоос 5 нэгж хувиар бага байна.

2. ЖДҮ-ийг дэмжих бодлогын арга хэмжээ


ЖДҮ эрхлэгчдийн бизнесийг хамгийн их дэмждэг байгууллагыг нэрлэнэ үү гэсэн асуултанд арилжааны банк (54%), худалдаа аж үйлдвэрийн тэнхим (38%) засгийн газар (28%), орон нутгийн засаг захиргаа (22%), олон улсын байгууллагууд (18%), зөвлөгөө өгдөг, байгууллага, төвүүд (8%) төрийн бус байгууллагууд (18%) гэж хариулжээ. Уг үзүүлэлтийн үр дүнг аймгуудын дундаж үзүүлэлттэй харьцуулахад арилжааны банкууд дэмждэг гэсэн хариулт 9 нэгж хувиар бага, засгийн газар, худалдаа

⁴² Бизнес регистрийн санд бүртгэлтэй

аж үйлдвэрийн тэнхим, ОУ-ын байгууллага, зөвлөгөө өгдөг байгууллагууд дэмждэг гэсэн хариулт харгалзан 4, 23, 6, 3 нэгж хувиар тус тус их байна.

Зураг 3 ЖДҮ эрхлэгчдийг хамгийн ихээр дэмждэг байгууллага

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Ямар дэмжлэг үзүүлснийг асуухад санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгосон (56%), сургалт, зөвлөгөөн зохион байгуулсан (36%), үзэсгэлэн худалдаа зохион байгуулсан (40%), эрх зүйн орчинг сайжруулсан (14%) гэж хариулсан байна.

Зураг 4 ЖДҮ-д ямар дэмжлэг үзүүлсэн

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Мөн ЖДҮ-ийг хөгжүүлэхэд үндэсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох, татварын таатай орчинг бүрдүүлэх, бизнестэй холбоотой шийдвэрт хувийн хэвшил, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгох, сургалт зөвлөгөөг нэмэгдүүлэх арга хэмжээг нэн түрүүнд авах шаардлагатай гэж хариулсан байна.

Зураг 5 Цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

3. Макро эдийн засгийн орчин

Эдийн засгийн таатай орчин бүрдсэн эсэх талаар асуухад санал асуулгад оролцогчдын 82% нь хангалттай бус, 6% нь огт бүрдээгүй, 6% нь бүрдсэн гэж үзжээ.

Хүснэгт 2 ЖДҮ хөгжих эдийн засгийн таатай орчин бүрдсэн эсэх

(Бусад аймаг болон УБ хоттой харьцуулсан дүн, давхардсан тоогоор, хувь)

ЖДҮ хөгжих орчин	Өвөрхангай	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Бүрдсэн	6	10	8
Хангалттай бус	82	71	61
Огт бүрдээгүй	6	12	23
Мэдэхгүй	6	6	9

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Харин эдийн засгийн өсөлт ЖДҮ эрхлэгчдийн бизнест хэрхэн нөлөөлж байгаа эсэхийг асуухад 32% нь эерэгээр, 30% нь сөргөөр, 18% нь нөлөөлөөгүй гэж хариулжээ. Аймгуудын дундажтай харьцуулахад ЭЗ-ийн өсөлт өөрсдийн бизнест эерэгээр нөлөөлсөн гэсэн хариулт 6 нэгж хувиар бага байсан бол сөргөөр гэсэн хариулт 8 нэгж хувиар илүү байна.

Хүснэгт 3 ЖДҮ хөгжилд эдийн засгийн өсөлтийн үзүүлж буй нөлөө

(Бусад аймаг болон УБ хоттой харьцуулсан дүн, давхардсан тоогоор, хувь)

Эдийн засгийн өсөлт танай бизнест	Өвөрхангай	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Эергээр	32	38	18
Сөргөөр	30	22	43
Нөлөөлөөгүй	18	19	21
Мэдэхгүй	14	16	18

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Санал асуулгад оролцогчдын дийлэнх хувь нь бусад аймгуудын адил инфляци болон төгрөгийн ханш тогтвортой байвал эрхэлж буй бизнест нь сайн гэж үзсэн байна.

4. Бизнесийн орчин

Өвөрхангай аймгийн судалгаанд оролцсон ЖДҮ эрхлэгчид бизнесийн орчинд бусад аймгуудтай адил ерөнхийдөө сөрөг үнэлгээг өгчээ.

Санхүүжилтийн орчинд боломжийн муу гэсэн үнэлгээг түлхүү өгсөн бөгөөд ерөнхий хандлага нь аймгуудын дундаж үнэлгээтэй төстэй байв. Тус аймгийнхны хамгийн бэрхшээлтэй нь ОУ-ын байгууллагын болон Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн олдоц гэж үзсэн ба эдгээрт муу гэсэн үнэлгээг өгчээ. Санхүүжилтийн хүү, хугацаа, барьцаа хөрөнгө, хөрөнгийн зах зээлээс санхүүжилт авах, санхүүжилтийн хэмжээг муу, боломжийн гэсэн үнэлгээний дундуур үнэлжээ. Бусад үзүүлэлтүүдэд боломжийн гэсэн үнэлгээг түлхүү өгчээ. Хамгийн боломжийн үнэлгээг бусад аймгуудын адил банкны зээл, зээл олгох үйл ажиллагаанд өгчээ.

Хүснэгт 4 Санхүүжилтийн орчин

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Санхүүжилтийн орчин	Өвөрхангай	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Олон улсын байгууллагын хөнгөлөлттэй зээлийн о	-0.94	-1.01	-1.02
Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн олдоц	-0.86	-0.93	-1.01
Санхүүжилтийн хүү	-0.68	-0.63	-0.67
Санхүүжилтийн хугацаа	-0.58	-0.53	-0.57
Санхүүжилтийн барьцаа хөрөнгө	-0.58	-0.42	-0.56
Хөрөнгийн зах зээлээс санхүүжилт авах	-0.58	-0.55	-0.61
Санхүүжилтийн хэмжээ	-0.52	-0.47	-0.51
Өөрийн хөрөнгийн хүрэлцээ	-0.42	-0.40	-0.43
Банк санхүүгийн байгууллагын зээл	-0.40	-0.33	-0.48
Зээлийн батлан даалт	-0.34	-0.30	-0.49
Зээл олгох үйл ажиллагаа	-0.14	-0.18	-0.53
Банкны зээл	0.02	0.02	-0.49

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Хууль, эрх зүйн зохицуулалтын орчноос төрийн байгууллагуудын үйлчилгээнд арай илүү муу гэсэн үнэлгээг түлхүү өгсөн ч Улаанбаатарчуудын өгсөн үнэлгээнээс бага зэрэг дээгүүр, аймгуудынхтай ойролцоо байв. Бусад үзүүлэлтүүдэд бусад аймгуудтай адил боломжийн үнэлгээг түлхүү өгчээ. Татварын тогтолцоог илүү боломжийн гэж дүгнэсэн нь нийслэл, аймгуудын үнэлгээнээс дээгүүр байлаа.

Хүснэгт 5 Хууль эрх зүйн орчин

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Хууль, эрх зүйн зохицуулалтын орчин	Өвөрхангай	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Төрийн байгууллагын үйлчилгээ	-0.64	-0.58	-0.75
Хяналт, шалгалтын тогтолцоо	-0.42	-0.33	-0.52
Хууль, эрх зүйн орчин	-0.36	-0.45	-0.65
Гадаад худалдаа хийх нөхцөл	-0.34	-0.48	-0.43
Газар эзэмших	-0.30	-0.32	-0.60
Татварын тогтолцоо	-0.14	-0.44	-0.56

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Өвөрхангай аймгийн ЖДҮ эрхлэгчид зах зээлийн орчинг бусад аймаг, нийслэлчүүдийн адил ерөнхийдөө боломжийн гэж үзжээ. Энэ хэсгээс шударга өрсөлдөөнд хамгийн боломжийн үнэлгээг өгсөн нь бусад аймаг, Улаанбаатарынхаас дээгүүр үнэлгээтэй байв.

Хүснэгт 6 Зах зээлийн орчин

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Зах зээлийн орчин	Өвөрхангай	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Даатгалын үйлчилгээ	-0.44	-0.40	-0.37
Хэрэглэгчдийн худалдан авах чадвар	-0.42	-0.43	-0.36
Зах зээлийн багтаамж	-0.36	-0.40	-0.37
Технологийн дэвшил	-0.28	-0.33	-0.20
Шударга өрсөлдөөн	-0.26	-0.40	-0.44

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Дэд бүтцийн байдлыг Өвөрхангай аймгийн судалгаанд оролцогчид бусад аймаг, нийслэлчүүдийн адил мөн л боломжийн гэж үзжээ. Энэ хэсгээс дулаан, усан хангамжинд хамгийн доогуур үнэлгээг өгсөн бол мэдээлэл холбооны хөгжилд хамгийн сайн үнэлгээг өгчээ.

Хүснэгт 7 Дэд бүтэц

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Дэд бүтцийн байдал	Өвөрхангай	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Дулаан, усан хангамж	-0.36	-0.39	-0.25
Цахилгаан хангамж	-0.08	-0.03	-0.10
Зам, тээврийн хөгжил	-0.02	-0.55	-0.68
Мэдээлэл холбооны хөгжил	0.44	0.31	0.15

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

5. Дотоод орчин

Өвөрхангай аймгийн ЖДҮ эрхлэгчид өөрсдийн дотоод орчиндоо ерөнхийдөө бага хүндрэлтэй гэсэн үнэлгээг өгчээ. Эдгээрээс хүний нөөцийн удирдлага, ажилчдын чадвар арай илүү хүндрэлтэй үнэлгээг авчээ. Үзүүлэлт бүрийн үнэлгээ аймаг, нийслэлийн дундажтай ерөнхийдөө ойролцоо үнэлгээтэй байв.

Хүснэгт 8 Дотоод орчин

(Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4)

Дотоод орчин	Өвөрхангай	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Хүний нөөцийн удирдлага	-1.42	-1.33	-1.38
Түүхий эдийн чанар	-1.02	-1.13	-1.30
Тоног төхөөрөмжийн чанар	-1.12	-1.27	-1.20
Ажилчдын чадвар	-1.26	-1.31	-1.13

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

6. Зардлын байдал

Өвөрхангай аймгийн судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчид зардлуудад ерөнхийд нь хүндрэлтэй, бага хүндрэлтэй гэсэн үнэлгээг өгчээ. Хамгийн хүндрэлтэй зардлуудад зээлийн хүүний, шимтгэл

хураамжийн төлбөр, түрээсийн зардлуудыг оруулсан нь бусад аймгууд, Улаанбаатар хотынхны хандлагатай ерөнхийдөө ижил байна. Харин харилцаа холбооны, зар сурталчилгааны, захиргаа, үйл ажиллагааны, зам тээврийн зардыг бага хүндрэлтэй гэж үзсэн нь аймгуудын дундаж, Улаанбаатарынхаас бага зэрэг дээгүүр үнэлгээтэй байлаа.

Хүснэгт 9 Зардлын байдал

(Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4)

Зарлын байдал	Өвөрхангай	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Эзэлийн хүүний зардал	-1.84	-1.82	-1.89
Шимтгэл, хураамжийн төлбөр	-1.74	-1.72	-1.78
Түрээсийн зардал	-1.50	-1.48	-1.74
Эрчим хүч, захилааны зардал	-1.36	-1.50	-1.48
Дулаан , усны зардал	-1.32	-1.51	-1.49
Тоног төхөөрөмжийн зардал	-1.28	-1.62	-1.62
Ажилдах хүчний өртөг	-1.28	-1.38	-1.41
Түүхий эдийн зардал	-1.20	-1.59	-1.62
Зам, тээврийн зардал	-1.12	-1.58	-1.62
Захиргаа, үйл ажилдлагааны зардал	-1.06	-1.25	-1.42
Зар сурталчилгааны зардал	-1.02	-1.12	-1.57
Харишгаа холбооны зардал	-0.82	-0.93	-1.25

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

7. Нийгмийн орчин

Нийгмийн орчны талаар санал асуулгад оролдогчоос асуухад ажилгүйдэл, хээл хахууль, ядуурал, улс төрийн байдал, гэмт хэрэг хүндрэл ихтэй гэж хариулсан байна. Ерөнхийдөө бусад аймгууд, Улаанбаатартай хариултууд төстэй байлаа.

Хүснэгт 10 Нийгмийн орчин

(Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4)

Нийгмийн орчин	Өвөрхангай	Аймгуудын	Улаанбаатар
Ажилгүйдэл	-2.52	-2.50	-2.75
Хэзэл хатууль	-2.34	-2.29	-2.72
Ядуурал	-2.28	-2.50	-2.77
Улс төрийн байдал	-2.04	-2.09	-2.46
Гэмт хэрэг	-1.96	-2.15	-2.67
Харицагчийн ёс суртахуун	-1.68	-1.67	-2.00
Хувийн ховшил, иргэдийн оролцоо	-1.58	-1.50	-1.91
Мэдээллийн хүртээмж	-1.54	-1.54	-1.78


Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

8. Санхүүжилт

Үйл ажиллагаагаа эхлүүлэхдээ анх ямар эх үүсвэрээр санхүүжсэнийг асуухад 62% нь өөрийн хөрөнгөөр, 48% нь банкны зээлээр, 24% нь гэр, бүл найз нөхдийн хөрөнгөөр, 12% нь хөнгөлөлттэй зээлд хамрагдах замаар санхүүжсэн байна. Өнгөрсөн хугацаанд үйл ажиллагаагаа өрөгжүүлэх, шинээр бизнес эрхлэхдээ 56% нь зээлд хамрагдаж байсан ба тэдгээрийн дийлэнх буюу 82% нь банкнаас зээл авсан байна.

Зураг 6 Анхдагч санхүүжилт

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Зээл эргэн төлөхөд ямар хүндрэл учирч байна вэ гэсэн асуултанд 30% нь зээлийн хүүний төлбөр өндөр, 32% зээлийн хугацаа богино, 16% нь зээлийн хэмжээ бага гэсэн бол 10% нь хүндрэл тулгараагүй гэж хариулсан байна.

Зураг 7 Зээлийн эргэн төлөлтийн бэрхшээл

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Цаашид үйл ажиллагаагаа явуулахад (78%) нь санхүүжилт авах хэрэгцээтэй гэжээ. Тэдгээрийн 26% нь 10-50 сая, 16% нь 100-500 сая төгрөгийн санхүүжилт шаардлагатай гэжээ. 10-50 сая гэж хариулсан хариултын хувийн жин нь бусад аймгуудын дунджаас бага, 100-500 сая гэсэн хариултын хувийн жин аймгуудын дунджаас илүү байна.

Зураг 8 Шаардлагатай санхүүжилт

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Дүгнэлт

- Судалгаанд хамрагдсан Өвөрхангай аймгийн 50 ЖДҮ эрхлэгчид олон жилийн туршлагатай, цөөн тооны ажиллагсадтай бөгөөд үйлдвэрлэлийн чиглэлээр түлхүү үйл ажиллагаа эрхэлдэг.
- Түүхий эд материалаа нийслэл, өөрийн аймгаасаа голчлон бэлтгэн, аймагтаа борлуулалтаа хийдэг гэжээ.
- Борлуулалтын жилийн орлогоороо бусад аймгууд, Улаанбаатар хотын дунджаас бага байгаа бөгөөд дийлэнх нь тайлан тэнцэл гаргадаг гэжээ.
- Бусад аймгууд, нийслэл хотын судалгааны дүнтэй адил арилжааны банкиг хамгийн их ЖДҮ эрхлэгчдийг дэмждэг гэжээ. Мөн худалдаа ажи үйлдвэрийн танхим, ЗГ, орон нутгийн засаг захиргаа, ОУ-ын байгууллагуудыг дэмждэг гэж багагүй хувь хариулжээ. Эдгээр байгууллагаас санхүүгийн эх үүсвэрийг бий болгох, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, сургалт зөвлөгөө явуулах байдлаар дэмжлэг үзүүлсэн гэжээ.
- Төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох, санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгох, татварын таатай орчинг бүрдүүлэх, үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, хувийн хэвшил олон нийтийн оролцоог бизнесийн шийдвэр гаргалтанд нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээг нэн түрүүнд авах шаардлагатай гэж үзжээ.
- Бусад аймаг, нийслэлчүүдийн адил дийлэнх нь ЖДҮ хөгжих эдийн засгийн таатай орчин хангалттай бус байна гэж дүгнэсэн байна. Мөн инфляци, ханш тогтвортой байх нь бизнест нь сайн гэжээ.
- Бизнесийн орчинд ерөнхийдөө сөрөг үнэлгээг өгсөн байна. Тус аймгийнхны хамгийн их хүндрэлтэй гэсэн үнэлгээ өгсөн хэсэгт нийгмийн орчин үүнээс ажилгүйдэл, гэмт хэрэг, ядуурал, улс төрийн байдал орж байна. Харин мэдээлэл, холбооны хөгжил, банкны зээл, зам тээврийн хөгжил, цахилгаан хангамж гэсэн үзүүлэлтүүдэд боломжийн гэсэн үнэлгээг өгчээ.
- Өөрийн хөрөнгө, банкны зээлээр дийлэнх нь үйл ажиллагаагаа эхлүүлсэн бөгөөд үйл ажиллагаагаа өргөжүүлэх, шинээр бизнес эрхлэхэд банкны зээл авсан байна.
- Зээлээ эргэн төлөхөд зээлийн хугацаа богино, хүүний төлбөр өндөр байсан нь хамгийн их хүндрэл учруулдаг гэжээ.
- Цаашид үйл ажиллагаагаа явуулахад санхүүжилт шаардлагатай гэж дийлэнх нь хариулсан ба бусад аймаг, Улаанбаатарынхаас шаардлагатай санхүүжилтийн хэмжээ нь өндөр байв.

Өмнөговь аймаг


1. Ерөнхий мэдээлэл

Өмнөговь аймагт 2011 оны 1 дүгээр улирлын байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа 682⁴³ ААН-ээс санамсаргүй түүврийн аргаар 50 жижиг дунд бизнес эрхлэгчийг судалгаанд хамрууллаа. Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 48% нь ХХК, 46% нь иргэд, 4% нь хоршоо, 2% нь ХК байсан бөгөөд 48 нь дотоодын, 2 нь дотоод, гадаадын холимог хөрөнгө оруулалттайгаар үйл ажиллагаагаа явуулдаг байна.

Өмнөговь аймагт судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 68% нь үйлдвэрлэл, 22% нь үйлчилгээ, 10% нь худалдаа эрхэлдэг гэж хариулсан нь үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ЖДҮ эрхлэгч санал асуулганд түлхүү оролцсоноороо бусад аймгуудын бүтцээс ихээхэн ялгаатай байв.

Зураг 1 ЖДҮ эрхлэгчдийн үйл ажиллагааны чиглэл

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Өмнөговь аймгийн судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 44% нь 1-5 жил, 24% нь 5-10 жил, 20% нь 10-аас дээш жил, 10% нь 1 хүртэл жил үйл ажиллагаагаа эрхэлж байгаа бөгөөд 60% нь 10 хүртэл, 24% нь 10-49, 4% нь 100-149, 2% нь 50-99 ажиллагсадтай байна.

Өмнөговь аймгийн судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн давхардсан тоогоор 56% нь нийслэл хотоос, 60% нь үйл ажиллагаа эрхэлж буй аймгаас, 16% нь гадаад улсаас түүхий эд, материалаа бэлтгэдэг гэж хариуллаа. Нийслэл хотоос түүхий эд бэлтгэдэг гэсэн хариултын хувийн жин аймгуудын дундажтай ойролцоо, өөрийн аймгаас гэсэн хариулт 15 нэгж хувиар илүү байгаа бол гадаадаас гэсэн хариулт 9 нэгж хувиар бага байв. Мөн ЖДҮ эрхлэгчдийн 92% нь эцсийн бүтээгдэхүүнээ өөрийн аймагт нийлүүлдэг гэж хариулсан нь бусад аймгийн дунджаас 10 нэгж хувиар илүү үзүүлэлттэй байлаа.

⁴³ Бизнес регистрийн санд бүртгэлтэй

Хүснэгт 1 Түүхий эд материалын бэлтгэл, бараа бүтээгдэхүүний борлуулалт

(Бусад аймаг болон УБ хоттой харьцуулсан дүн, давхардсан тоогоор, хувь)


Байршил	Түүхий эд бэлтгэл			Борлуулалт		
	Өмнөговь	Аймгууд	УБ	Өмнөговь	Аймгууд	УБ
Нийслэл хот	56	55	73	4	9	76
Үйл ажиллагаа эрхэлж буй	60	45	5	92	82	5
Бусад аймаг	10	8	6	4	13	4
Гадаад улс	18	27	30	2	3	5
Улсын хэмжээнд				4	6	19

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Өмнөговь аймгийн судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн тал нь 1-10 сая төгрөгийн орлоготой гэж хариулсан нь бусад аймгууд, нийслэл хотын дундаж үзүүлэлтээс нэлээд илүү байна. Харин 10-50 сая гэсэн хариултын хувийн жин бага байв.

Зураг 2 ЖДҮ эрхлэгчдийн жилийн борлуулалтын орлого

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн


Түүвэр судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 64% нь тайлан тэнцэл гаргадаг гэсэн хариулт өгсөн нь аймгуудын дундажтай ойролцоо, Улаанбаатар хотынхоос 13 нэгж хувиар бага байна.

2. ЖДҮ-ийг дэмжих бодлогын арга хэмжээ

Асуулгад оролцсон ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх буюу 80% нь арилжааны банк ЖДҮ-ийг хамгийн их дэмждэг гэж хариулсан бөгөөд аймгуудын дунджаас 17 нэгж хувиар илүү байв.

Зураг 3 ЖДҮ эрхлэгчдийг хамгийн ихээр дэмждэг байгууллага

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгох байдлаар ЖДҮ-т дэмжлэг үзүүлсэн гэж дийлэнх буюу 76% нь хариулсан нь нийслэл, аймгуудын дунджаас илүү хувийн жинтэй байв. Бусад хариултууд харьцангуй бага сонгогдсон байна.

Зураг 4 ЖДҮ-д ямар дэмжлэг үзүүлсэн

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Цаашид хөнгөлөлттэй санхүүгийн эх үүсвэр бий болгох, татварын таатай орчинг бүрдүүлэх, төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох, үндэсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг нэн түрүүн авбал зохистой гэж бусад аймгууд, Улаанбаатар хотын адил Өмнөговийн ЖДҮ эрхлэгчид үзсэн байна. Санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгох гэсэн хариулт Улаанбаатар, аймгуудын дунджаас нэлээд илүү, татварын таатай орчинг бүрдүүлэх гэсэн хариулт бага зэрэг илүү байв. Харин төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох гэсэн хариулт нийслэл, аймгийн дунджаас бага зэрэг бага, үндэсний үйлдвэрлэлээ дэмжих гэсэн хариулт аймгуудынхаас бага, Улаанбаатарынхаас бага зэрэг илүү байлаа.

Зураг 5 Цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

3. Макро эдийн засгийн орчин

Манай улсад ЖДҮ хөгжих эдийн засгийн таатай орчин хангалттай бус байна гэж Өмнөговь аймгийн судалгаанд оролцогчдын дийлэнх буюу 70% үзэж байгаа нь аймгуудын дундажтай ижил, Улаанбаатарынхаас 9 нэгж хувиар илүү байна.

Хүснэгт 2 ЖДҮ хөгжих эдийн засгийн таатай орчин бүрдсэн эсэх

(Бусад аймаг болон УБ хоттой харьцуулсан дүн, давхардсан тоогоор, хувь)

ЖДҮ хөгжих орчин	Өмнөговь	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Бүрдсэн	10	10	8
Хангалттай бус	70	71	61
Огт бүрдээгүй	18	12	23
Мэдэхгүй	2	6	9

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Өмнөговь аймагт үйл ажиллагаа эрхлэгч ЖДҮ эрхлэгчдийн 62% эдийн засгийн өсөлт өөрсдийн бизнест эерэгээр нөлөөлж байна гэж хариулсан бөгөөд нийслэл Улаанбаатарын уг хариултаас нэлээд их хувьтай байна.

Хүснэгт 3 ЖДҮ хөгжилд эдийн засгийн өсөлтийн үзүүлж буй нөлөө

(Бусад аймаг болон УБ хоттой харьцуулсан дүн, давхардсан тоогоор, хувь)

Эдийн засгийн өсөлт танай бизнест	Өмнөговь	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Эергээр	62	38	18
Сөргөөр	14	22	43
Нөлөөлөөгүй	16	19	21
Мэдэхгүй	6	16	18

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Инфляцийн түвшин, төгрөгийн бусад валюттай харьцах ханш тогтвортой байх нь өөрсдийн бизнест сайн гэж ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх (62-76%) бусад аймгууд, нийслэлийнхэнтэй адил үзжээ.

4. Бизнесийн орчин

Өмнөговь аймгийн судалгаанд оролцсон ЖДҮ эрхлэгчид бизнесийн орчинд бусад аймгуудтай адил

сөрөг үнэлгээг өгсний зэрэгцээ санхүүжилт, хууль эрх зүй, дэд бүтцийн байдал илүү доогуур үнэлгээтэй, бусад үзүүлэлтүүдийнх бага зэрэг дээгүүр байв.

Өмнөговь аймгийнхан санхүүжилтийн орчноос санхүүжилтийн хүү, ОУ-ын хөнгөлөлттэй зээлийн олдцонд муу гэсэн үнэлгээ өгсөн бөгөөд санхүүжилтийн хүүний үнэлгээ аймгууд, нийслэлийн дунджаас доогуур үнэлгээтэй байгаа бол ОУ-ын хөнгөлөлттэй зээлийн олдц ойролцоо үнэлгээтэй байв. Бусад үзүүлэлтийн хувьд муу, боломжийн гэсэн үнэлгээг түлхүү өгчээ. Энэ хэсгээс банк бус санхүүгийн байгууллагын зээл, санхүүжилтийн хугацаа боломжийн гэж үнэлэгдсэн нь хамгийн эерэг үнэлгээ байлаа.

Хүснэгт 4 Санхүүжилтийн орчин

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Санхүүжилтийн орчин	Өмнөговь	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Санхүүжилтийн хүү	-1.18	-0.63	-0.67
ОУ-ын байгууллагын хөнгөлөлттэй зээлийн олдц	-1.10	-1.01	-1.02
Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн олдц	-0.78	-0.93	-1.01
Өөрийн хөрөнгийн хүрэлцээ	-0.68	-0.40	-0.43
Банкны зээл	-0.64	0.04	-0.49
Зээлийн батлан даалт	-0.58	-0.29	-0.49
Санхүүжилтийн барьцаа хөрөнгө	-0.58	-0.41	-0.56
Зээл олгох үйл ажиллагаа	-0.56	-0.16	-0.53
Санхүүжилтийн хэмжээ	-0.54	-0.47	-0.51
Хөрөнгийн зах зээлээс санхүүжилт авах	-0.38	-0.55	-0.61
Санхүүжилтийн хугацаа	0.02	-0.52	-0.57
Банк бус санхүүгийн байгууллагын зээл	0.06	-0.32	-0.48

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Хууль, эрх зүй, зохицуулалтын орчны ерөнхий үнэлгээ ерөнхийдөө муу, боломжийн гэсэн үнэлгээтэй байв. Эдгээрээс газар эзэмшихээс бусад үзүүлэлтүүдэд муу гэсэн үнэлгээг илүү өгсөн байна. Бусад аймгуудтай харьцуулахад ерөнхийдөө дунджаас илүү муу үнэлгээтэй байлаа.

Хүснэгт 5 Хууль эрх зүйн орчин

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Хууль, эрх зүйн зохицуулалтын орчин	Өмнөговь	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Хууль, эрх зүйн орчин	-0.72	-0.44	-0.65
Төрийн байгууллагын үйлчилгээ	-0.70	-0.57	-0.75
Татварын тогтолцоо	-0.62	-0.43	-0.56
Хяналт, шалгалтын тогтолцоо	-0.56	-0.32	-0.52
Гадаад худалдаа хийх нөхцөл	-0.52	-0.48	-0.43
Газар эзэмших	-0.34	-0.31	-0.60

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Зах зээлийн орчинг боломжийн, муу гэсэн үнэлгээний хооронд дүгнэсэн бөгөөд үнэлгээ нь илүү боломжийн тал руугаа байв. Нийслэл, аймгуудын

дундажтай ерөнхийдөө ойролцоо үнэлгээтэй байгаа ч бага зэрэг дээгүүр үнэлгээтэй байлаа. Ялангуяа хэрэглэгчийн худалдан авах чадвар, технологийн дэвшлийг боломжийн гэж үзсэн байна.

Хүснэгт 6 Зах зээлийн орчин

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Зах зээлийн орчин	Өмнөговь	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Зах зээлийн багтаамж	-0.38	-0.40	-0.37
Шударга өрсөлдөөн	-0.36	-0.40	-0.44
Даатгалын үйлчилгээ	-0.34	-0.40	-0.37
Технологийн дэвшил	-0.24	-0.34	-0.20
Хэрэглэгчдийн худалдан авах чадвар	-0.20	-0.43	-0.36

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Өмнөговь аймгийн ЖДҮ эрхлэгчид мэдээлэл холбооны хөгжлийг Улаанбаатар, бусад аймгуудын адил боломжийн сайн гэж дүгнэжээ. Бусад үзүүлэлтүүдийн хувьд муу гэж үнэлэгдсэн ба нийслэл, аймгуудын дундажтай харьцуулахад муу үнэлгээтэй байна.

Хүснэгт 7 Дэд бүтэц

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Дэд бүтцийн байдал	Өмнөговь	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Цахилгаан хангамж	-1.10	-0.02	-0.10
Зам, тээврийн хөгжил	-1.04	-0.54	-0.68
Дулаан, усан хангамж	-0.90	-0.40	-0.25
Мэдээлэл холбооны хөгжил	0.22	0.32	0.15

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

5. Дотоод орчин

Өмнөговь аймгийн ЖДҮ эрхлэгчид өөрсдийн дотоод орчиндоо бага хүндрэлтэй гэсэн үнэлгээг өгсөн бөгөөд Улаанбаатар, аймгуудын дунджаас арай дээгүүр үнэлгээтэй байна.

Хүснэгт 8 Дотоод орчин

(Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4)

Дотоод орчин	Өмнөговь	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Хүний нөөцийн удирдлага	-1.10	-1.33	-1.38
Тоног төхөөрөмжийн чанар	-1.04	-1.28	-1.20
Ажилчдын чадвар	-0.96	-1.31	-1.13
Түүхий эдийн чанар	-0.94	-1.12	-1.30

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

6. Зардлын байдал

Өмнөговь аймгийн судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчид зардлуудад хүндрэлтэй, бага хүндрэлтэй гэсэн үнэлгээг түлхүү өгчээ. Хамгийн хүндрэлтэй зардлуудад зээлийн хүүний, эрчим хүч, цахилгааны,

зам тээврийн, түүхий эдийн, дулаан, усны, шимтгэл хураамжийн төлбөрийг оруулсан нь бусад аймгууд, Улаанбаатар хотынхны хандлагатай ерөнхийдөө ижил байна. Харин харилцаа холбоо, захиргаа, үйл ажиллагааны, зар сурталчилгааны зардалд бага хүндрэлтэй, хүндрэлгүй гэсэн үнэлгээг өгсөн бөгөөд аймаг, нийслэлийн дундаж үнэлгээнээс дээгүүр үнэлгээтэй байлаа.

Хүснэгт 9 Зардлын байдал

(Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4)

Зардлын байдал	Өмнөговь	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Зээлийн хүүний зардал	-1.60	-1.82	-1.89
Эрчим хүч, цахилгааны зардал	-1.54	-1.50	-1.48
Зам, тээврийн зардал	-1.50	-1.58	-1.62
Түүхий эдийн зардал	-1.42	-1.59	-1.62
Дулаан, усны зардал	-1.38	-1.51	-1.49
Шимтгэл, хураамжийн төлбөр	-1.38	-1.71	-1.78
Ажиллах хүчний өртөг	-1.32	-1.37	-1.41
Түрээсийн зардал	-1.32	-1.47	-1.74
Тоног төхөөрөмжийн зардал	-1.32	-1.62	-1.62
Зар сурталчилгааны зардал	-0.94	-1.10	-1.57
Захиргаа, үйл ажиллагааны зардал	-0.84	-1.24	-1.42
Харилцаа холбооны зардал	-0.74	-0.92	-1.25

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

7. Нийгмийн орчин

Тус аймгынхны хамгийн ихээр сөрөг үнэлгээ өгсөн хэсэгт нийгмийн орчин орж байгаа ба үүнээс ядуурал, хээл хахууль, гэмт хэрэг, улс төрийн байдал, ажилгүйдэлд хүндрэлтэй гэсэн хариултыг, харилцагчийн ёс суртахуун, хувийн хэвшил, иргэдийн оролцоо, мэдээллийн хүртээмжид бага хүндрэлтэй гэсэн хариултыг түлхүү өгчээ. Гэсэн хэдий ч нийслэл, аймгуудын дунджаас үзүүлэлт бүрээрээ дээгүүр үнэлгээтэй байна.

Хүснэгт 10 Нийгмийн орчин

(Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4)

Нийгмийн орчин	Өмнөговь	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Ядуурал	-2.02	-2.48	-2.77
Хээл хахууль	-1.86	-2.27	-2.72
Гэмт хэрэг	-1.82	-2.13	-2.67
Улс төрийн байдал	-1.80	-2.08	-2.46
Ажилгүйдэл	-1.80	-2.49	-2.75
Харилцагчийн ёс суртахуун	-1.34	-1.65	-2.00
Хувийн хэвшил, иргэдийн оролцоо	-1.26	-1.48	-1.91
Мэдээллийн хүртээмж	-1.20	-1.53	-1.78


Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

8. Санхүүжилт

Өөрийн хөрөнгө, банкны зээлээр санхүүжигдэн үйл ажиллагаагаа эхлүүлж байсан гэсэн хариулт уг асуултанд хариулсан хариултуудаас хамгийн их сонгогджээ. Тус аймгийн судалгаанд оролцогчдын 46% нь уг асуултанд хариулаагүйн улмаас бусад аймаг, нийслэлийн хариултаас эрс ялгаатай харагдаж байна.

Зураг 6 Анхдагч санхүүжилт

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Үйл ажиллагаагаа өргөжүүлэх, шинээр бизнес эрхлэхэд судалгаанд хамрагдагсдын 51% нь зээл аваагүй, 46% нь авсан гэж хариулжээ.


Зээлээ эргэн төлөхөд ямар хүндрэл гардаг вэ гэсэн асуултанд судалгаанд оролцогчдын ердөө 20% хариулсан нь аймгуудын дунджаас ялгаатай харагдаж байна. Зээлийн хүүний төлбөр өндөр, хүндрэл тулгараагүй, хугацаа богино гэсэн хариултуудыг уг асуултанд хариулсан ЖДҮ эрхлэгчид илүү сонгосон байна.

Зураг 7 Зээлийн эргэн төлөлтийн бэрхшээл

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Өмнөговь аймгаас судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 72% нь цаашид үйл ажиллагаагаа явуулахад санхүүжилт авах шаардлагагүй гэж хариулсан нь бусад аймгуудаас ялгаатай байв. Ердөө 26% нь цаашид санхүүжилт авах хэрэгцээтэй гэж хариулсан бөгөөд тэдгээрийн 31% нь 1-5 сая, 23% нь 10-50 сая, 23% нь 50-100 сая, 15% нь 5-10 сая төгрөгийн санхүүжилт шаардлагатай гэжээ.



Сүхбаатар аймаг


1. Ерөнхий мэдээлэл

Сүхбаатар аймагт 2011 оны 1 дүгээр улирлын байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа 421⁴⁴ ААН-ээс санамсаргүй түүврийн аргаар 49 жижиг дунд бизнес эрхлэгчдийг судалгаанд хамрууллаа. Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 51% нь ХХК, 41% нь иргэд байсан бөгөөд дийлэнх нь дотоодын хөрөнгө оруулалттайгаар үйл ажиллагаагаа явуулдаг байна.

Сүхбаатар аймагт судалгаанд судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 43% нь үйлдвэрлэл, 35% нь үйлчилгээ, 22% нь худалдааны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг байна. Үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг ЖДҮ эрхлэгчдийн судалгаанд хамрагдсан хувь аймгуудын дунджаас тус бүр 4 нэгж хувиар илүү харин худалдаа чиглэлээрээ үйл ажиллагаа эрхлэгчид 9 нэгж хувиар бага сонгогдсон байна.

Зураг 1 ЖДҮ эрхлэгчдийн үйл ажиллагааны чиглэл

(Санал асуулгад оролцогчдын эзлэх %, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийг үйл ажиллагаа эрхэлж буй хугацаагаар нь авч үзвэл 43% нь 10-аас дээш жил, 20% нь 5-10 жил, 29% нь 1-5 жил, 8% нь 1 хүртэл жил байгаа бөгөөд тэдгээрийн 68% нь 10 хүртэл, 27% нь 10-49, 3% нь 50-99, 1% нь 150-199 ажиллагсадтай байна.

Сүхбаатар аймгийн хувьд түүвэр судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн (давхардсан дүнгээр) 63% нийслэл хотоос, 59% нь үйл ажиллагаа эрхэлж буй аймгаасаа түүхий эд материалаа бэлддэг гэж хариулжээ. Энэ нь аймгуудын дунджаас харгалзан 8,

14 нэгж хувиар илүү байна. Харин эдгээр ЖДҮ эрхлэгчдийн 90% нь бүтээгдэхүүнээ өөрийн аймагтаа нийлүүлдэг гэж хариулсан нь аймгуудын дунджаас 8 нэгж хувиар илүү үзүүлэлттэй байна.

Хүснэгт 1 Түүхий эд материалын бэлтгэл, бараа бүтээгдэхүүний борлуулалт

(Бусад аймаг болон УБ хоттой харьцуулсан дүн, давхардсан тоогоор, %)


Байршил	Түүхий эд бэлтгэл			Борлуулалт		
	Сүхбаатар	Аймгууд	УБ	Сүхбаатар	Аймгууд	УБ
Нийслэл хот	63	55	73	0	9	76
У/а эрхэлж буй аймаг	59	45	5	90	82	5
Бусад аймаг	2	8	6	2	13	4
Гадаад улс	31	27	30	0	3	5
Улсын хэмжээнд				2	6	19

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн 31% нь 1-10 сая, 31% нь 10-50 сая төгрөгийн жилийн орлоготой гэж хариулсан ба бусад аймгууд, нийслэл хотын дундаж үзүүлэлтээс 10-50 сая гэсэн хариулт 3 нэгж хувиар илүү, 1-10 сая гэсэн хариулт Улаанбаатарынхаас 8 нэгж хувиар бага, аймгуудынхтай ойролцоо байна.

Зураг 3 ЖДҮ эрхлэгчдийн жилийн борлуулалтын орлого

(Санал асуулгад оролцогчдын эзлэх %, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

ЖДҮ эрхлэгчдийн 55% нь тайлан тэнцэл гаргадаг гэсэн хариулт өгсөн нь аймгуудын дунджаас 10 нэгж хувиар, Улаанбаатар хотынхоос 22 нэгж хувиар бага байна.

2. ЖДҮ-ийг дэмжих бодлогын арга хэмжээ

Сүхбаатар аймгаас санал асуулгад оролцсон ЖДҮ эрхлэгчдийн давхардсан тоогоор 53% нь арилжааны банк, 39% нь орон нутгийн засаг захиргаа ЖДҮ-ийг хамгийн их дэмждэг гэж хариулжээ. Бусад аймгуудтай харьцуулахад орон нутгийн засаг захиргаа, Худалдаа аж үйлдвэрийн танхим, ОУ-ын байгууллага гэсэн хариулт аймгуудын дунджаас олон сонгогдсон байлаа.

⁴⁴ Бизнес регистрийн санд бүртгэлтэй

үйлчилгээг чирэгдэлгүй болгох, үндэсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, татварын таатай орчинг бүрдүүлэх, хувийн хэвшил олон нийтийн оролцоог бизнесийн шийдвэр гаргалтанд нэмэгдүүлэх, зөвшөөрөл лицензийн тоог багасгах, авлигыг бууруулах зэрэг арга хэмжээнүүдийг нэн түрүүн авах шаардлагатай гэжээ. Санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгох, үндэсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хувийн хэвшил олон нийтийн оролцоог бизнесийн шийдвэр гаргалтанд нэмэгдүүлэх гэсэн хариулт нийслэлээс илүү, аймгуудын дундажтай ойролцоо байгаа бол төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох, татварын таатай орчинг бүрдүүлэх, зөвшөөрөл лицензийн тоог багасгах гэсэн хариулт аймгуудын дундаж, Улаанбаатар хотынхоос бага байлаа.

Зураг 4 ЖДҮ эрхлэгчдийг хамгийн ихээр дэмждэг байгууллага



Эдгээр байгууллагаас санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгосон, сургалт зөвлөгөө явуулсан, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах байдлаар дэмжлэг үзүүлсэн гэж хариулсан нь бусад аймгуудын хариулттай ерөнхийдөө адилхан байв.

Зураг 5 ЖДҮ-д ямар дэмжлэг үзүүлсэн



Сүхбаатар аймгийн ЖДҮ эрхлэгчид цаашид санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгох, төрийн

Зураг 6 Цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ



3. Макро эдийн засгийн орчин

Манай улсад ЖДҮ хөгжих эдийн засгийн таатай орчин хангалттай бус байна гэж Сүхбаатар аймгийн судалгаанд оролцогчдын дийлэнх буюу 65% үзжээ. Энэ нь аймгуудын дунджаас 5 нэгж хувиар бага, Улаанбаатар хотоос 4 нэгж хувиар их байна.

Хүснэгт 2 ЖДҮ хөгжих эдийн засгийн таатай орчин бүрдсэн эсэх

(Бусад аймаг болон УБ хоттой харьцуулсан дүн, давхардсан тоогоор, %)

ЖДҮ хөгжих орчин	Сүхбаатар	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Бүрдсэн	25	10	8
Хангалттай бус	65	71	61
Огт бүрдээгүй	2	12	23
Мэдэхгүй	8	6	9

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Мөн судалгаанд хамрагсадын 57% нь эдийн засгийн өсөлт өөрсдийн бизнест эерэгээр, 18% нь сөргөөр, 14% нь нөлөөлөөгүй, 10% нь мэдэхгүй гэж хариулсан бөгөөд эерэгээр нөлөөлж байна гэсэн хариулт аймгуудын дунджаас 19 нэгж хувиар, Улаанбаатар хотоос 39 нэгж хувиар илүү байв.

Хүснэгт 3 ЖДҮ хөгжилд эдийн засгийн өсөлтийн үзүүлж буй нөлөө

(Бусад аймаг болон УБ хоттой харьцуулсан дүн, давхардсан тоогоор, %)

Эдийн засгийн өсөлт танай бизнест	Сүхбаатар	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Эергээр	57	24	20
Сөргөөр	18	22	43
Нөлөөлөөгүй	14	19	21
Мэдэхгүй	10	16	18

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Инфляцийн түвшин, төгрөгийн ханш тогтвортой байх нь өөрсдийн бизнест сайн гэж талаас дээш буюу 53-59% нь үзжээ.

4. Бизнесийн орчин

Сүхбаатар аймгийн судалгаанд оролцсон ЖДҮ эрхлэгчид дэд бүтцийн байдалд дунджаар боломжийн, хууль эрх зүй, санхүүжилт, зах зээлийн орчинд боломжийноос муу гэсэн үнэлгээний хооронд үнэлсэн байна.

Санхүүжилтийн орчноос ОУ-ын болон ЗГ-ын хөнгөлөлттэй зээлийн олдцыг муу гэж дүгнэсэн нь хамгийн муу үнэлгээ байсан бөгөөд бусад аймгууд, нийслэлд ч мөн адилхан байв. Санхүүжилтийн барьцаа, хүүнд муу боломжийн үнэлгээний бага зэрэг муу тал руу нь үнэлсэн нь барьцаа хөрөнгийн үнэлгээ аймгуудын дунджаас арай доогуур, Улаанбаатартай ойролцоо байв. Харин санхүүжилтийн хүүний үнэлгээ аймаг нийслэлийнхээс бага зэрэг сайн байлаа. Бусад үзүүлэлтүүдийн хувьд боломжийн үнэлгээг түлхүү өгсөн бөгөөд аймгуудын хандлагатай төстэй байв. Ялангуяа банкны зээл, зээл олгох явцыг хамгийн боломжийн гэж дүгнэжээ.

Хүснэгт 4 Санхүүжилтийн орчин

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Санхүүжилтийн орчин	Сүхбаатар	Аймгуудын дундаж	Улаанбаатар
ОУ-ын байгууллагын хөнгөлөлттэй зээлийн олоц	-1.06	-1.01	-1.02
Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн олоц	-1.02	-0.93	-1.01
Санхүүжилтийн барьцаа хөрөнгө	-0.59	-0.41	-0.56
Санхүүжилтийн хүү	-0.55	-0.63	-0.67
Өөрийн хөрөнгийн хүрэлцээ	-0.45	-0.40	-0.43
Хөрөнгийн зах зээлээс санхүүжилт авах	-0.39	-0.55	-0.61
Санхүүжилтийн хэмжээ	-0.29	-0.47	-0.51
Банк бус санхүүгийн байгууллагын зээл	-0.24	-0.32	-0.48
Зээлийн батлан даалт	-0.12	-0.29	-0.49
Санхүүжилтийн хугацаа	-0.04	-0.52	-0.57
Зээл олгох үйл ажиллагаа	0.00	-0.16	-0.53
Банкны зээл	0.31	0.04	-0.49

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Хууль, эрх зүй, зохицуулалтын орчноос гадаад худалдаа хийх нөхцлөөс бусад үзүүлэлтийг боломжийн гэж дүгнэсэн бөгөөд нийслэл, аймгийн дундаж үзүүлэлтээс сайн үнэлгээтэй байв. Харин гадаад худалдаа хийх нөхцөлд муу гэсэн үнэлгээ өгсөн бөгөөд бусад аймгууд, Улаанбаатарын дунджаас доогуур үнэлгээтэй байна.

Хүснэгт 5 Хууль эрх зүйн орчин

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Хууль, эрх зүйн зохицуулалтын орчин	Сүхбаатар	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Гадаад худалдаа хийх нөхцөл	-0.94	-0.48	-0.43
Газар эзэмших	0.04	-0.31	-0.60
Татварын тогтолцоо	-0.27	-0.43	-0.56
Төрийн байгууллагын үйлчилгээ	-0.37	-0.57	-0.75
Хууль, эрх зүйн орчин	-0.31	-0.44	-0.65
Хяналт, шалгалтын тогтолцоо	-0.22	-0.32	-0.52

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Зах зээлийн орчныг ерөнхийд нь боломжийн гэж үнэлсэн нь бусад аймгууд, Улаанбаатар хотынхтой ойролцоо үнэлгээтэй байна. Хэрэглэгчдийн худалдан авах чадвар, шударга өрсөлдөөнд өгсөн үнэлгээ бусад аймгууд болон Улаанбаатартай харьцуулахад дээгүүр үнэлгээтэй байв.

Хүснэгт 6 Зах зээлийн орчин

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Зах зээлийн орчин	Сүхбаатар	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Зах зээлийн багтаамж	-0.41	-0.40	-0.37
Даатгалын үйлчилгээ	-0.35	-0.40	-0.37
Технологийн дэвшил	-0.37	-0.34	-0.20
Хэрэглэгчдийн худалдан авах чадвар	-0.18	-0.43	-0.36
Шударга өрсөлдөөн	-0.22	-0.40	-0.44

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Ерөнхийдөө дэд бүтцийн байдлаа боломжийн сайн гэж үнэлсэн нь аймгуудын дундаж, Улаанбаатартай харьцуулахад сайн үнэлгээтэй байна. Мэдээлэл холбооны хөгжилд сайн, цахилгаан хангамжинд боломжийн, харин дулаан, усан хангамжид боломжийн муу гэсэн үнэлгээний дунджаар үнэлжээ.

Хүснэгт 7 Дэд бүтэц

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Дэд бүтцийн байдал	Сүхбаатар	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Дулаан, усан хангамж	-0.51	-0.40	-0.25
Зам, тээврийн хөгжил	-0.04	-0.54	-0.68
Мэдээлэл холбооны хөгжил	0.76	0.32	0.15
Цахилгаан хангамж	0.22	-0.02	-0.10

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

5. Дотоод орчин

ЖДҮ эрхлэгчид өөрсдийн дотоод орчиндоо ерөнхийдөө бага хүндрэлтэй гэсэн үнэлгээг өгсөн бөгөөд хүний нөөцийн удирдлага, ажилчдын чадвар бусад хүчин зүйлээсээ арай илүү хүндрэлтэй гэжээ.

Хүснэгт 8 Дотоод орчин

(Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4)

Дотоод орчин	Сүхбаатар	УБ хот	Аймгуудын
Ажилчдын чадвар	-1.16	-1.13	-1.31
Хүний нөөцийн удирдлага	-1.04	-1.38	-1.12
Тоног төхөөрөмжийн чанар	-0.86	-1.20	-1.33
Түүхий эдийн чанар	-0.55	-1.30	-1.28

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

6. Зардлын байдал

Зардлуудад ерөнхийд нь хүндрэлтэй, бага хүндрэлтэй гэсэн үнэлгээг өгч, хүндрэлтэй зардлуудад дулаан, усны, зээлийн хүүний, эрчим хүч, цахилгааны, шимтгэл хураамжийн төлбөрийн, зам тээврийн зардлуудыг оруулсан байна.

Хүснэгт 9 Зардлын байдал

(Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4)

Зардлын байдал	Сүхбаатар	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Дулаан, усны зардал	-1.82	-1.51	-1.49
Зээлийн хүүний зардал	-1.76	-1.82	-1.89
Эрчим хүч, цахилгааны зардал	-1.63	-1.50	-1.48
Шимтгэл, хураамжийн төлбөр	-1.41	-1.71	-1.78
Зам, тээврийн зардал	-1.37	-1.58	-1.62
Түүхий эдийн зардал	-1.18	-1.59	-1.62
Ажиллах хүчний өртөг	-1.10	-1.37	-1.41
Тоног төхөөрөмжийн зардал	-1.04	-1.62	-1.62
Захиргаа, үйл ажиллагааны зардал	-0.80	-1.24	-1.42
Түрээсийн зардал	-0.76	-1.47	-1.74
Зар сурталчилгааны зардал	-0.43	-1.10	-1.57
Харилцаа холбооны зардал	-0.35	-0.92	-1.25

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Дээрх үзүүлэлт нь бусад аймгууд, Улаанбаатар хотынхны хандлагатай ерөнхийдөө ижил байна.

Харин дулаан усны зардал аймгуудын дундаж, Улаанбаатарынхаас илүү хүндрэлтэй гэсэн үнэлгээг авсан бол түрээс, зар сурталчилгаа, харилцаа холбооны зардлыг арай бага хүндрэлтэй гэжээ.

7. Нийгмийн орчин

Судалгаанд оролцсон аймгийнхан ерөнхийдөө нийгмийн орчин бага хүндрэлтэй, хүндрэлтэй гэсэн хариултыг өгсөн бөгөөд үүнээс ажилгүйдэл, ядуурал, хээл хахууль илүү хүндрэлтэй гэсэн нь бусад аймгууд, Улаанбаатар хотынхтой адил байна. Харин гэмт хэрэг, улс төрийн байдалд өгсөн үнэлгээ бусад аймаг, Улаанбаатарынхнаас бага хүндрэлтэй гэгджээ.

Хүснэгт 10 Нийгмийн орчин

(Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4)

Нийгмийн орчин	Сүхбаатар	Аймгуудын	Улаанбаатар
Ажилгүйдэл	-2.06	-2.49	-2.75
Ядуурал	-1.94	-2.48	-2.77
Хээл хахууль	-1.65	-2.27	-2.72
Гэмт хэрэг	-1.49	-2.13	-2.67
Улс төрийн байдал	-1.41	-2.08	-2.46
Хувийн хэвшил, иргэдийн оролцоо	-1.24	-1.48	-1.91
Харилцагчийн ёс суртахуун	-0.96	-1.65	-2.00
Мэдээллийн хүртээмж	-0.65	-1.53	-1.78


Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

8. Санхүүжилт

Судалгаанд оролцсон ЖДҮ эрхлэгчдийн 63% нь өөрийн хөрөнгөөр, 59% банкны зээлээр, 20% нь гэр бүлийн хамтын хөрөнгөөр санхүүжүүлэн үйл ажиллагаагаа эхлүүлж байжээ. Аймгуудын дундажтай харьцуулахад банкны зээл ашигласан байдал 12 нэгж хувиар илүү, гэр бүл хамтын хөрөнгөөр үйл ажиллагаагаа эхлүүлсэн нь 6 нэгж хувиар бага байна. Улаанбаатарынхаас өөрийн хөрөнгөөр үйл ажиллагаагаа эхлүүлсэн нь 6 нэгж хувиар, банкны зээл ашигласан нь нэлээд илүү байна.

Зураг 7 Анхдагч санхүүжилт

(Санал асуулгад оролцогчдын эзлэх %, давхардсан тоогоор)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Өнгөрсөн хугацаанд үйл ажиллагаагаа өргөжүүлэх, шинээр бизнес эрхлэхэд зээл авч байсан уу гэсэн асуултанд судалгаанд хамрагдагсдын 88% нь санхүүжилт авч байсан гэж хариулсан бөгөөд тэдгээрийн 79% нь банкны зээл авсан гэжээ.

Зээлээ эргэн төлөхөд тулгарсан бэрхшээл гэсэн асуултанд 39% нь зээлийн хугацаа богино, 25% хүүний төлбөр өндөр байгаа нь хамгийн их хүндрэл учруулсан гэжээ. Мөн 33% нь хүндрэл учраагүй гэж хариулсан байна. Аймгуудын дундажтай харьцуулбал хүндрэлийн байдал ойролцоо, харин хүндрэл тулгараагүй гэсэн хариулт аймгуудын дунджаас 14 нэгж хувиар илүү байв. Улаанбаатарынхаас хүүний төлбөр өндөр, хугацаа богино, үндсэн хэмжээ богино гэсэн хариулт 10-18 нэгж хувиар илүү байна. Гэхдээ Улаанбаатарчуудын 54% нь уг асуултанд хариулсан байв.

Зураг 8 Зээлийн эргэн төлөлтийн бэрхшээл

(Санал асуулгад оролцогчдын эзлэх %, давхардсан тоогоор)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Цаашид үйл ажиллагаагаа явуулахад санхүүжилт авах хэрэгцээтэй гэж 90% нь хариулсан байна. Тэдгээрийн 39% нь 10-50 сая, 23% нь 5-10 сая, 19% нь 100-500 сая төгрөгийн санхүүжилт шаардлагатай гэж үзжээ. Эдгээрийг аймгуудын дундаж, Улаанбаатарын үзүүлэлттэй харьцуулбал 10-50 сая, 5-10 сая гэсэн хариулт харьцангуй илүү байна.

Зураг 9 Шаардлагатай санхүүжилт

(Санал асуулгад оролцогчдын эзлэх %, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Дүгнэлт

- Судалгаанд хамрагдсан Сүхбаатар аймгийн 49 ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх нь 10-аас дээш жил үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр түлхүү үйл ажиллагаагаа явуулдаг байна. Түүхий эд материалаа нийслэл хотоос голчлон бэлтгэж, өөрийн аймагтаа борлуулалтаа хийдэг гэжээ.
- Судалгаанд оролцсон ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх нь 1-50 сая төгрөгийн жилийн орлоготой бөгөөд 50 гаруй хувь нь тайлан гаргадаг байна.
- Үйл ажиллагаанд нь арилжааны банк, орон нутгийн засаг захиргааг хамгийн их дэмжлэг үзүүлдэг гэжээ. Мөн ОУ-ын байгууллага, Засгийн газар, ХАҮТ дэмждэг гэж багагүй хувь нь хариулсан байна. Эдгээр байгууллагаас санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгосон, сургалт зөвлөгөө явуулсан, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах байдлаар дэмжлэг үзүүлсэн байна.
- Сүхбаатарчууд санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгох, төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох, үндэсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээг нэн түрүүн авах шаардлагатай гэсэн байна.
- Бизнесийн орчин ерөнхийдөө сөрөг үнэлгээтэй байгаа ч бусад аймгууд болон Улаанбаатартай харьцуулахад илүү сайн үнэлгээтэй байна. Дэд бүтцийн хувьд зам тээврийн хөгжил бусад аймгууд болон нийслэл хотоос илүү сайн үнэлгээтэй байна.

Зардлын хувьд дулаан, усны зардал, зээлийн хүүний зардал хүндрэлтэйд орж байна.

- ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх өөрийн хөрөнгө болон банкны зээлээр санхүүжигдэн үйл ажиллагаагаа эхлүүлсэн байгаа бөгөөд үйл ажиллагаагаа өргөжүүлэх, шинээр бизнес эрхлэхэд банкны зээл авсан байна.
- Зээлээ эргэн төлөхөд хүүний төлбөр өндөр хугацаа богино зэрэг нь хүндрэл учруулж байсан гэсэн бол гуравны нэг хэсэг нь зээл эргэн төлөхөд хүндрэл тулгараагүй гэжээ.
- Цаашид бизнесийн үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд дийлэнх нь 10-50 сая төгрөгийн санхүүжилт шаардлагатай гэжээ.



Сэлэнгэ аймаг

1. Ерөнхий мэдээлэл

Сэлэнгэ аймагт 2011 оны 1 дүгээр улирлын байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа 1509⁴⁵ ААН-ээс санамсаргүй түүврийн аргаар 101 жижиг дунд бизнес эрхлэгчийг судалгаанд хамрууллаа.

Судалгаанд оролцсон жижиг дунд бизнес эрхлэгчдийн 49% нь ХХК, 40% нь иргэд байсан бөгөөд дийлэнх нь дотоодын хөрөнгө оруулалттайгаар үйл ажиллагаагаа явуулдаг байна.

Тус аймагт судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 40% нь үйлдвэрлэл, 38% нь худалдаа, 22% нь үйлчилгээ эрхэлдэг байна. Дээрх үзүүлэлтийг аймгуудын дундаж үзүүлэлттэй харьцуулбал худалдаа 7 нэгж хувиар илүү, үйлчилгээ 7 нэгж хувиар бага байна.

Зураг 2 ЖДҮ эрхлэгчдийн үйл ажиллагааны чиглэл

(Санал асуулгад оролцогчдын эзлэх %, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 40% нь 5-10 жил, 29% нь 1-5 жил, 23% нь 10-аас дээш жил, 4% нь 1 хүртэл жил үйл ажиллагаагаа эрхэлж байгаа бөгөөд 67% нь 10 хүртэл, 22% нь 10-49 ажиллагсадтай байна.

⁴⁵ Бизнес регистрийн санд бүртгэлтэй

Сэлэнгэ аймгийн хувьд түүхий эд материалаа давхардсан дүнгээр 39% нь үйл ажиллагаа эрхэлж буй аймгаасаа, 38% нь нийслэл хотоос, 31% нь гадаад орнуудаас бэлтгэж, 73% нь бүтээгдэхүүн, үйлчилгээгээ үйл ажиллагаа эрхэлж буй аймагтаа, 16% нь улсын хэмжээнд, 16% нь нийслэл хотод, 12% нь бусад аймгуудад борлуулдаг гэжээ. Үйл ажиллагаа эрхэлж буй аймаг, нийслэл хотоос түүхий эд бэлтгэх байдал аймгуудын дундажтай харьцуулахад арай бага үзүүлэлттэй, бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалтын хувьд өөрсдийн аймагтаа борлуулах хувь нь дунджаас бага, улсын хэмжээнд борлуулах нь дунджаас илүү байв.

Хүснэгт 1Түүхий эд материалын бэлтгэл, бараа бүтээгдэхүүний борлуулалт

Бусад аймаг болон УБ хоттой харьцуулсан дүн, давхардсан тоогоор, %


Байршил	Түүхий эд бэлтгэл			Борлуулалт		
	Сэлэнгэ	Аймгууд	УБ хот	Сэлэнгэ	Аймгууд	УБ хот
Нийслэл хот	38	55	78	16	9	81
У/а эрхэлж буй аймаг	39	45		73	82	
Бусад аймаг	12	8	6	12	13	4
Гадаад улс	31	27	30	2	3	5
Улсын хэмжээнд				16	6	19

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн 31% нь 10-50 сая, 25% нь 1-10 сая, 13% нь 100-250 сая, 11% нь 50-100 сая төгрөгийн орлоготой гэж хариулсан ба бусад аймгууд, нийслэл хотын дундаж үзүүлэлтээс 10-50 сая гэсэн хариулт харьцангуй илүү, 1-10 сая гэсэн хариулт бага байв.

Зураг 3 ЖДҮ эрхлэгчдийн жилийн борлуулалтын орлого

(Санал асуулгад оролцогчдын эзлэх %, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн


ЖДҮ эрхлэгчдийн 55% нь тайлан тэнцэл гаргадаг гэсэн хариулт өгсөн нь аймгуудын дунджаас 9 нэгж хувиар, Улаанбаатар хотынхоос 22 нэгж хувиар бага байна.

2. ЖДҮ-ийг дэмжих бодлогын арга хэмжээ

Асуулгад оролцсон ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх нь буюу 71% нь арилжааны банк ЖДҮ-ийг хамгийн их дэмждэг гэж хариулжээ. Мөн орон нутгийн засаг захиргаа, Засгийн газар гэсэн хариултыг бусад байгууллагуудаас илүү сонгосон байна.

Зураг 4 ЖДҮ эрхлэгчдийг хамгийн ихээр дэмждэг байгууллага

(Санал асуулгад оролцогчдын эзлэх %, давхардсан тоогоор)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Эдгээр байгууллагаас санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгосон, сургалт зөвлөгөө явуулсан, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах байдлаар дэмжлэг үзүүлсэн гэж хариулжээ. Харин судалгаанд хамрагдагсадын 12% нь дэмжлэг үзүүлдэггүй, 9% нь мэдэхгүй гэж хариулжээ.

Зураг 5 ЖДҮ-д ямар дэмжлэг үзүүлсэн

(Санал асуулгад оролцогчдын эзлэх %, давхардсан тоогоор)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Цаашид санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгох, үндэсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, татварын таатай орчинг бүрдүүлэх, төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох, зөвшөөрөл лицензийн тоог багасгах, авлигыг бууруулах, хууль эрх зүйн орчинг сайжруулах зэрэг арга хэмжээнүүдийг нэн түрүүн авбал зохистой гэж үзсэн байна. Авлигыг бууруулах,

төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох гэсэн хариулт нийслэл, аймгийн дунджаас аль алианаас нь бага байгаа бол санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгох, үндэсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх гэсэн хариулт аймгуудын дунджаас, зөвшөөрөл, лицензийн тоог багасгах, төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох гэсэн хариулт Улаанбаатар хотынхоос бага байлаа.

Зураг 6 Цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ

(Санал асуулгад оролцогчдын эзлэх %, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

3. Макро эдийн засгийн орчин

Манай улсад ЖДҮ хөгжих эдийн засгийн таатай орчин хангалттай бус байна гэж аймгийн судалгаанд оролцогчдын дийлэнх буюу 68% үзэж байгаа бол хангалттай орчин бүрдсэн гэж 17% нь хариулжээ. Аймгуудын дундажтай харьцуулбал ЖДҮ хөгжих эдийн засгийн таатай орчин хангалттай бус гэсэн хариулт ижил түвшинд, Улаанбаатарынхаас 8 нэгж хувиар илүү байна.

Хүснэгт 2 ЖДҮ хөгжих эдийн засгийн таатай орчин бүрдсэн эсэх

(Бусад аймаг болон УБ хоттой харьцуулсан дүн, давхардсан тоогоор, %)

ЖДҮ хөгжих орчин	Сэлэнгэ	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Бүрдсэн	17	10	8
Хангалттай бус	66	71	61
Огт бүрдээгүй	12	12	23
Мэдэхгүй	2	6	9

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Эдийн засгийн өсөлт өөрсдийн бизнест эерэгээр нөлөөлсөн гэж судалгаанд оролцогчдын 42%, сөргөөр гэж 21%, нөлөөлөөгүй гэж 20% нь үзсэн ба аймгуудын дундажтай харьцуулахад хандлага нь ерөнхийдөө адил, Улаанбаатартай харьцуулахад эерэгээр нөлөөлсөн гэж хариулсан нь 23 нэгж хувиар илүү байлаа.

Хүснэгт 3 ЖДҮ хөгжилд эдийн засгийн өсөлтийн үзүүлж буй нөлөө

Бусад аймаг болон УБ хөтгөй харьцуулсан дүн, давхардсан тоогоор, %)

Эдийн засгийн өсөлт танай бизнест	Сэлэнгэ	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Эергээр	41	24	20
Сөргөөр	20	22	43
Нөлөөлөөгүй	19	19	21
Мэдэхгүй	16	16	18

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Инфляцийн түвшин, төгрөгийн ханш тогтвортой байх нь өөрсдийн бизнест сайн гэж ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх буюу 46-52% нь үзэж байгаа бөгөөд бусад аймгуудтай ойролцоо байна.

4. Бизнесийн орчин

Сэлэнгэ аймгийн судалгаанд оролцсон ЖДҮ эрхлэгчид дэд бүтцийн байдалд дунджаар боломжийн, хууль эрх зүй, санхүүжилт, зах зээлийн орчинд муу болон боломжийн гэсэн үнэлгээний хооронд үнэлгээг өгсөн байна.

Санхүүжилтийн хувьд тус аймгийнхан ОУ-ын болон ЗГ-ын хөнгөлөлттэй зээлийн олдоц, муу гэж үзсэн нь бусад аймгууд болон нийслэлийхний адил байна. Мөн санхүүжилтийн барьцаа хөрөнгө, Хөрөнгийн зах зээлээс санхүүжилт авах байдалд муу үнэлгээг түлхүү өгсөн нь нийслэл, аймгуудын дундаж үнэлгээнээс доогуур үзүүлэлттэй байв. Харин санхүүжилтийн хүү, хугацаа, хэмжээ, өөрийн хөрөнгийн хүрэлцээ, зээл олгох явц зэрэгт боломжийн үнэлгээг муу үнэлгээнээс илүү өгсөн бөгөөд нийслэл, аймгуудын дундажтай харьцуулахад дээгүүр үнэлгээтэй байлаа. Банкны зээлд бусад аймгуудын адил хамгийн сайн үнэлгээг өгчээ.

Хүснэгт 4 Санхүүжилтийн орчин

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Санхүүжилтийн орчин	Сэлэнгэ	Аймгуудын дундаж	Улаанбаатар
ОУ-ын байгууллагын хөнгөлөлттэй зээлийн олдоц	-1.17	-1.01	-1.02
Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн олдоц	-0.94	-0.93	-1.01
Санхүүжилтийн барьцаа хөрөнгө	-0.72	-0.41	-0.56
Хөрөнгийн зах зээлээс санхүүжилт авах	-0.70	-0.55	-0.61
Санхүүжилтийн хүү	-0.43	-0.63	-0.67
Санхүүжилтийн хугацаа	-0.43	-0.52	-0.57
Банк бус санхүүгийн байгууллагын зээл	-0.39	-0.32	-0.48
Санхүүжилтийн хэмжээ	-0.38	-0.47	-0.51
Зээлийн батлан даалт	-0.34	-0.29	-0.49
Өөрийн хөрөнгийн хүрэлцээ	-0.15	-0.40	-0.43
Зээл олгох үйл ажиллагаа	-0.06	-0.16	-0.53
Банкны зээл	0.09	0.04	-0.49

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Хууль эрх зүй, зохицуулалтын орчинд боломжийн муу үнэлгээг түлхүү өгчээ. Татварын тогтолцоо, төрийн байгууллагын үйлчилгээнд өгсөн үнэлгээ бусад аймгуудынхаас илүү муу, Улаанбаатарынхнаас төрийн байгууллагын үйлчилгээ, хяналт шалгалтын тогтолцоо, хууль эрх зүйн орчин бага зэрэг сайн гэсэн үнэлгээтэй байна.

Хүснэгт 5 Хууль эрх зүйн орчин

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Хууль, эрх зүйн зохицуулалтын орчин	Сэлэнгэ	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Төрийн байгууллагын үйлчилгээ	-0.64	-0.57	-0.75
Татварын тогтолцоо	-0.62	-0.43	-0.56
Гадаад худалдаа хийх нөмцөл	-0.58	-0.48	-0.43
Хууль, эрх зүйн орчин	-0.48	-0.44	-0.65
Хяналт, шалгалтын тогтолцоо	-0.45	-0.32	-0.52
Газар эзэмших	-0.24	-0.31	-0.60

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Зах зээлийн орчныг ерөнхийд нь боломжийн гэж үнэлсэн нь бусад аймгууд, Улаанбаатар хотынхтой ойролцоо үнэлгээтэй байна. Гэсэн хэдий ч даатгалын үйлчилгээнд өгсөн үнэлгээ нийслэл, аймгуудын дунджаас бага зэрэг муу гэж үзүүлэлттэй байв.

Хүснэгт 6 Зах зээлийн орчин

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Зах зээлийн орчин	Сэлэнгэ	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Даатгалын үйлчилгээ	-0.46	-0.40	-0.37
Шударга өрсөлдөөн	-0.41	-0.40	-0.44
Зах зээлийн багтаамж	-0.37	-0.40	-0.37
Технологийн дэвшил	-0.37	-0.34	-0.20
Хэрэгслэгчдийн худалдан авах чадвар	-0.33	-0.43	-0.36

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Дэд бүтцийн хувьд боломжийн гэсэн үнэлгээг өгсөн бөгөөд бусад аймгууд, нийслэлтэй харьцуулахад харьцангуй сайн байна.

Хүснэгт 7 Дэд бүтэц

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Дэд бүтцийн байдал	Сэлэнгэ	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Дулаан, усан хангамж	-0.13	-0.40	-0.25
Зам, тээврийн хөгжил	0.01	-0.54	-0.68
Цахилгаан хангамж	0.03	-0.02	-0.10
Мэдээлэл холбооны хөгжил	0.28	0.32	0.15

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

5. Дотоод орчин

ЖДҮ эрхлэгчид өөрсдийн дотоод орчиндоо ерөнхийдөө бага хүндрэлтэй, хүндрэлтэй гэсэн үнэлгээг өгсөн бөгөөд тоног төхөөрөмжийн чанар, түүхий эдийн чанар Улаанбаатар хотоос арай илүү хүндрэлтэй гэжээ. Бусад аймгуудтай харьцуулахад хүний нөөцийн удирдлага илүү хүндрэлтэй байв.

Хүснэгт 8 Дотоод орчин

(Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4)

Дотоод орчин	Сэлэнгэ	УБ хот	Аймгуудын дундаж
Ажилчдын чадвар	-1.30	-1.13	-1.31
Тоног төхөөрөмжийн чанар	-1.31	-1.20	-1.33
Түүхий эдийн чанар	-1.31	-1.30	-1.28
Хүний нөөцийн удирдлага	-1.28	-1.38	-1.12

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

6. Зардлын байдал

Зардлуудад ерөнхийд нь хүндрэлтэй, бага хүндрэлтэй гэсэн үнэлгээг өгсөн нь бусад аймгуудын хандлагатай ерөнхийдөө адил, Улаанбаатарын дунджаас бага хүндрэлтэй гэсэн хариулт нь илүү байна. Хамгийн хүндрэлтэй зардлуудад тоног төхөөрөмжийн, түүхий эдийн, зээлийн хүүний, шимтгэл хураамжийн зардлуудыг оруулсан байна. Шимтгэл хураамж, эрчим хүч цахилгаан, дулаан, усны зардал зэрэг нь аймгуудын дундажтай харьцуулахад хүндрэл багатай байна. Харин зээлийн хүү, шимтгэл хураамж, түрээсийн зардлууд нь Улаанбаатартай харьцуулахад хүндрэл багатай гэжээ.

Хүснэгт 9 Зардлын байдал

(Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4)

Зардлын байдал	Сүхбаатар	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Тоног төхөөрөмжийн зардал	-1.67	-1.62	-1.62
Түүхий эдийн зардал	-1.60	-1.59	-1.62
Зээлийн хүүний зардал	-1.58	-1.82	-1.89
Шимтгэл, хураамжийн төлбөр	-1.55	-1.71	-1.78
Түрээсийн зардал	-1.39	-1.47	-1.74
Эрчим хүч, цахилгааны зардал	-1.38	-1.50	-1.48
Дулаан, усны зардал	-1.35	-1.51	-1.49
Захиргаа, үйл ажиллагааны зардал	-1.30	-1.24	-1.42
Ажиллах хүчний өртөг	-1.24	-1.37	-1.41
Зам, тээврийн зардал	-1.23	-1.58	-1.62
Зар сурталчилгааны зардал	-1.13	-1.10	-1.57
Харилцаа холбооны зардал	-0.97	-0.92	-1.25

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

7. Нийгмийн орчин

Бусад аймгуудтай харьцуулахад тус аймгийхны хамгийн ихээр сөрөг үнэлгээ өгсөн хэсэгт нийгмийн орчин орж байгаа ба үүнээс ажилгүйдэл, хээл хахууль, ядуурал, улс төрийн байдалд илүү хүндрэлтэй гэсэн үнэлгээг өгсөн нь бусад аймгууд, Улаанбаатар хотынхтой адил байна.

Хүснэгт 10 Нийгмийн орчин

(Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4)

Нийгмийн орчин	Сүхбаатар	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Ажилгүйдэл	-2.56	-2.49	-2.75
Хээл хахууль	-2.56	-2.27	-2.72
Ядуурал	-2.47	-2.48	-2.77
Улс төрийн байдал	-2.29	-2.08	-2.46
Гэмт хэрэг	-2.24	-2.13	-2.67
Харилцагчийн ёс суртахуун	-1.89	-1.65	-2.00
Хувийн хэвшид, иргэдийн оролцоо	-1.74	-1.48	-1.91
Мэдээллийн хүртээмж	-1.71	-1.53	-1.78


Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

8. Санхүүжилт

Сэлэнгэ аймгийн судалгаанд оролцсон ЖДҮ эрхлэгчдийн (давхардсан дүнгээр) 56% нь банкны зээлээр, 48% нь өөрийн хөрөнгөөр, 34% нь гэр бүл найз нөхдийн хөрөнгөөр санхүүжүүлэн үйл ажиллагаагаа эхлүүлж байжээ. Энэ нь бусад аймгуудтай харьцуулахад ерөнхий хандлага ижил байгаа ба банкны зээл ашигласан байдал 10 нэгж хувиар илүү байна. Улаанбаатарынхаас өөрийн хөрөнгөөр үйл ажиллагаагаа эхлүүлсэн байдал нь 12 нэгж хувиар бага, харин банкны зээл авсан нь 39 нэгж хувиар илүү байна.

Зураг 7 Анхдагч санхүүжилт

Санал асуулгад оролцогчдын эзлэх %, давхардсан тоогоор)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Үйл ажиллагаагаа өргөжүүлэх, шинээр бизнес эрхлэхэд судалгаанд хамрагдагсдын 82% нь (Улаанбаатарчуудын хувьд 62% нь зээл аваагүй гэж хариулсан) санхүүжилт авч байсан гэж хариулсан бөгөөд тэдгээрийн 79% нь банкны зээл, 23% нь хөнгөлөлттэй зээл авсан гэжээ.

Зээлээ эргэн төлөхөд хүүний төлбөр өндөр (38%), хугацаа богино (26%) зэрэг нь хамгийн их хүндрэл учруулсан гэж хариулжээ. Мөн хүндрэл учраагүй гэж 32% нь хариулсан нь аймгуудын дунджаас 12.6 нэгж хувь, нийслэл хотын дунджаас 20 нэгж хувиар илүү байна (Улаанбаатарчуудын 54% нь уг асуултанд хариулсан).

Зураг 8 Зээлийн эргэн төлөлтийн бэрхшээл

(Санал асуулгад оролцогчдын эзлэх %, давхардсан тоогоор)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Цаашид үйл ажиллагаагаа явуулахад санхүүжилт авах хэрэгцээтэй гэж дийлэнх нь буюу 71% нь хариулсан бөгөөд тэдгээрийн 38% нь 10-50 сая, 21% нь 5-10 сая, 21% нь 50-100 сая төгрөгийн санхүүжилт шаардлагатай гэж хариулжээ. Улаанбаатарын үзүүлэлттэй харьцуулбал 10-50 сая гэсэн хариулт нь 9 нэгж хувиар илүү, 5-10 сая төгрөгийн санхүүжилт шаардлагатай гэж хариулсан нь аймгуудын дундаж, Улаанбаатар хотоос 6 нэгж хувиар илүү байна.

Зураг 8 Шаардлагатай санхүүжилт

(Санал асуулгад оролцогчдын эзлэх %, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Дүгнэлт

- Сэлэнгэ аймгаас судалгаанд оролцсон 101 ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх нь 5-10 жил үйл ажиллагаа явуулсан туршлагатай, цөөн тооны ажиллагсадтай үйл ажиллагаа явуулж ирсэн бөгөөд дийлэнх нь худалдаа, хөдөө аж ахуйн чиглэлийн бизнес эрхэлдэг байна. Түүхий эд материалаа нийслэл хотоос, үйл ажиллагаа эрхэлж буй аймгаасаа, гадаад орнуудаас бэлтгэж өөрийн аймагтаа борлуулалт хийдэг гэжээ.
- Дийлэнх нь жилийн орлогоо 10-50 сая төгрөг гэж хариулжээ.
- Арилжааны банк хамгийн их дэжлэг үзүүлдэг гэсэн байна. Мөн орон нутгийн засаг захиргаа, Засгийн газрыг дэмждэг гэсэн хариулт багагүй хувьтай байв. Эдгээр байгууллагаас санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгосон, сургалт зөвлөгөө явуулсан, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах байдлаар дэмжжээ.
- Цаашид санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгох, үндэсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, татварын таатай орчинг бүрдүүлэх, төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох, зөвшөөрөл лицензийн тоог багасгах зэрэг арга хэмжээг авах шаардлагатай гэжээ.
- Бусад аймаг, нийслэлчүүдийн адил ЖДҮ хөгжих эдийн засгийн таатай орчин хангалттай бус байна гэж дийлэнх нь дүгнэсэн бөгөөд эдийн засгийн өсөлт нь өөрийн бизнест эерэгээр нөлөөлж байна гэжээ. Мөн инфляци, ханш тогтвортой байх нь өөрсдийн бизнест сайн гэж үзжээ.
- Бизнесийн орчин ерөнхийдөө бусад аймгуудтай харьцуулахад бага зэрэг доогуур үнэлэгдсэн байгаа ба тэр дундаа санхүүжилтийн хувьд олон улсын байгууллагын хөнгөлөлттэй зээлийн олдоц, төрийн байгууллагын үйлчилгээ, даатгалын үйлчилгээ бусдаасаа муу гэсэн байна. Харин дэд бүтцийн хувьд аймгууд болон нийслэлтэй харьцуулахад бага зэрэг

сайн үнэлгээтэй байгаа бөгөөд тэр дундаа зам тээврийн хөгжлийг боломжийн гэсэн байна.

- ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх өөрийн хөрөнгө болон банкны зээл, гэр бүлийн хамтын хөрөнгөөр дийлэнх нь үйл ажиллагаагаа эхлүүлсэн бөгөөд үйл ажиллагаагаа өргөжүүлэх, шинээр бизнес эрхлэхэд банкны зээл авсан байна.

- Зээлээ эргэн төлөхөд зээлийн хугацаа богино, хүүний төлбөр өндөр байсан нь хамгийн их бэрхшээл болдог гэжээ.

- Цаашид үйл ажиллагаа явуулахад санхүүжилт шаардлагатай гэж дийлэнх нь хариулсан бөгөөд дийлэнх нь 10-50 сая төгрөгийн санхүүжилт шаардлагатай гэжээ.

Төв аймаг

1. Ерөнхий мэдээлэл

Төв аймагт 2011 оны 1 дүгээр улирлын байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа 649⁴⁶ ААН-ээс санамсаргүй түүврийн аргаар 51 жижиг дунд бизнес эрхлэгчийг судалгаанд хамрууллаа.

Төв аймгаас судалгаанд оролцсон жижиг дунд бизнес эрхлэгчдийн 88% нь ХХК, 10% нь иргэд байсан бөгөөд ихэнх нь дотоодын хөрөнгө оруулалттайгаар үйл ажиллагаагаа явуулдаг байна.

Үйл ажиллагааны чиглэлээр нь авч үзвэл 47% нь үйлчилгээ, 29% нь худалдаа, 24% нь үйлдвэрлэл эрхэлдэг ба аймгуудын дундаж үзүүлэлтээс үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг ЖДҮ эрхлэгчид 18 нэгж хувиар илүү, үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг нь 16 нэгж хувиар аймгуудын дунджаас цөөн байна.

Зураг 1 ЖДҮ эрхлэгчдийн үйл ажиллагааны

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 35% нь 1-5 жил, 29% нь 10-аас дээш жил, 26% нь 5-10 жил, 10% нь 1 хүртэл жил үйл ажиллагаагаа эрхэлж байгаа бөгөөд 67% нь 10 хүртэл, 26% нь 10-49, 6% нь 50-99 ажиллагдсадтай байна.

Түүхий эд материалаа давхардсан дүнгээр 84% нь нийслэл хотоос, 20% нь гадаад улс орноос бэлтгэн, бараа үйлчилгээгээ 53% нь нийслэл хотод, 22% нь улсын хэмжээнд, 18% нь өөрийн аймагтаа борлуулдаг гэжээ. Аймгуудын дундажтай харьцуулахад нийслэл хотоос түүхий эд бэлтгэх байдал 29 нэгж хувиар илүү, өөрийн аймгаас бэлтгэх байдал 37 нэгж хувиар бага байгаа бол бараа бүтээгдэхүүний борлуулалтын хувьд өөрсдийн

аймагтаа борлуулах нь аймгуудын дунджаас 64 нэгж хувиар бага, нийслэл хотод борлуулах нь 44 нэгж хувиар илүү байв.

Хүснэгт 1 Түүхий эд материалын бэлтгэл, бараа бүтээгдэхүүний борлуулалт

(Бусад аймаг болон УБ хоттой харьцуулсан дүн, давхардсан тоогоор, хувь)


Байршил	Түүхий эд бэлтгэл			Борлуулалт		
	Төв	Аймгууд	УБ хот	Төв	Аймгууд	УБ хот
Нийслэл хот	84	55	78	53	9	81
У/а эрхэлж буй аймаг	8	45		18	82	
Бусад аймаг	8	8	6	22	13	4
Гадаад улс	20	27	30	4	3	5
Улсын хэмжээнд				22	6	19

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн дийлэнх жилдээ 10-50 сая, 1-10 сая төгрөгийн орлоготой гэж хариулсан ба бусад аймгууд, нийслэл хотын дундаж үзүүлэлтээс 10-50 сая гэсэн хариулт бага зэрэг илүү, 1-10 сая гэсэн хариулт Улаанбаатарынхаас бага, аймгуудынхтай ойролцоо байв.

Зураг3 ЖДҮ эрхлэгчдийн жилийн борлуулалтын орлого

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

ЖДҮ эрхлэгчдийн 90% нь тайлан тэнцэл гаргадаг гэсэн хариулт өгсөн нь аймгуудын дунджаас 25 нэгж хувиар, Улаанбаатар хотынхоос 13 нэгж хувиар илүү байна.


2. ЖДҮ-ийг дэмжих бодлогын арга хэмжээ

Судалгаанд оролцсон ЖДҮ эрхлэгчдийн 41% нь Улаанбаатарчуудын адилаар мэдэхгүй гэсэн хариултыг өгчээ. Харин 26% нь арилжааны банк, 18% нь Засгийн газар, 10% нь Худалдаа аж үйлдвэрийн танхимыг ЖДҮ-ийг дэмждэг гэж хариулжээ.

⁴⁶ Бизнес регистрийн санд бүртгэлтэй

Зураг 3 ЖДҮ эрхлэгчдийг хамгийн ихээр дэмждэг байгууллага

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Бусад аймгуудтай харьцуулбал мэдэхгүй, дэмжлэг үзүүлдэггүй гэсэн хариулт дийлэнх буюу 71% нь хариулсан нь дунджаас 49 нэгж хувиар илүү байгаа бол санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгосон, татварыг хөнгөлсөн, үзэсгэлэн худалдаа зохион байгуулсан гэсэн хариулт 16-31 нэгж хувиар бага байна.

Зураг 4 ЖДҮ-д ямар дэмжлэг үзүүлсэн

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Цаашид төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох, татварын таатай орчинг бүрдүүлэх, санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгох, авлигыг бууруулах, үндэсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хувийн хэвшил олон нийтийн оролцоог бизнесийн шийдвэр гаргалтанд нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг нэн түрүүн авбал зохистой гэж үзсэн байна.

Зураг 5 Цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

3. Макро эдийн засгийн орчин

Манай улсад ЖДҮ хөгжих эдийн засгийн таатай орчин хангалттай бус гэж судалгаанд оролцогчдын дийлэнх буюу 69% нь үзэж байгаа бөгөөд 16% нь огт бүрдээгүй гэж дүгнэсэн нь нийслэл хотоос 7 нэгж хувиар их байна.

Хүснэгт 2 ЖДҮ хөгжих эдийн засгийн таатай орчин бүрдсэн эсэх

(Бусад аймаг болон УБ хоттой харьцуулсан дүн, давхардсан тоогоор, хувь)

ЖДҮ хөгжих орчин	Төв	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Бүрдсэн	6	10	8
Хангалттай бус	69	71	61
Огт бүрдээгүй	16	12	23
Мэдэхгүй	10	6	9

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Эдийн засгийн өсөлт өөрсдийн бизнест сөргөөр нөлөөлсөн гэж судалгаанд оролцогчдын 37%, эерэгээр гэж 12% нь хариулав. Тухайн дүнг харьцуулбал аймгуудын дундажтай харьцуулбал эерэгээр нөлөөлж буй нь 12 нэгж хувиар бага, сөргөөр нөлөөлж байгаа нь 16 нэгж хувиар илүү байна.

Хүснэгт 3 ЖДҮ хөгжилд эдийн засгийн өсөлтийн үзүүлж буй нөлөө

(Бусад аймаг болон УБ хоттой харьцуулсан дүн, давхардсан тоогоор, хувь)

Эдийн засгийн өсөлт танай бизнест	Төв	Аймгуудын дундаж	Улаан- баатар
Эергээр	12	24	20
Сөргөөр	37	22	43
Нөлөөлөөгүй	18	19	21
Мэдэхгүй	33	16	18

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Инфляцийн түвшин, төгрөгийн ханш тогтвортой байх нь өөрсдийн бизнест сайн гэж ЖДҮ эрхлэгчдийн 51-53% нь хариулжээ. Мэдэхгүй гэж 29% нь хариулсан байна.

4. Бизнесийн орчин

Судалгаанд оролцсон ЖДҮ эрхлэгчдийн бизнесийн орчинд бусад аймгуудтай адил ерөнхийдөө боломжийноос муу гэсэн үнэлгээг өгчээ. Хэсэг бүрийг тус бүрт авч үзье.

Санхүүжилтийн хувьд ОУ-ын болон ЗГ-ын хөнгөлөлттэй зээлийн олдоц гэж бусад аймгууд болон нийслэлийнхний нэг адил үзжээ. Хөрөнгийн зах зээлээс санхүүжилт авах, барьцаа хөрөнгө, санхүүжилтийн хугацааг муу боломжийн үнэлгээний бага зэрэг муу тал руу нь үнэлсэн нь бусад аймаг, нийслэлтэй ойролцоо үнэлгээтэй байна. Бусад үзүүлэлтүүдийг боломжийн муу үнэлгээнээс бага зэрэг боломжийн тал руу нь үнэлсэн ба санхүүжилтийн хүүнээс бусад үнэлгээ нь аймгуудын дундаж үнэлгээнээс бага зэрэг доогуур үзүүлэлттэй байлаа.

Хүснэгт 4 Санхүүжилтийн орчин

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Санхүүжилтийн орчин	Төв	Аймгуудын дундаж	Улаан- баатар
Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн олдоц	-0.94	-0.93	-1.01
ОУ-ын байгууллагын хөнгөлөлттэй зээлийн олдоц	-0.92	-1.01	-1.02
Хөрөнгийн зах зээлээс санхүүжилт авах	-0.57	-0.55	-0.61
Санхүүжилтийн барьцаа хөрөнгө	-0.55	-0.41	-0.56
Санхүүжилтийн хугацаа	-0.55	-0.52	-0.57
Зээл олгох үйл ажиллагаа	-0.47	-0.16	-0.53
Санхүүжилтийн хүү	-0.45	-0.63	-0.67
Зээлийн батлан даалт	-0.41	-0.29	-0.49
Өөрийн хөрөнгийн хүрэлцээ	-0.39	-0.40	-0.43
Банк бус санхүүгийн байгууллагын зээл	-0.39	-0.32	-0.48
Санхүүжилтийн хэмжээ	-0.35	-0.47	-0.51
Банкны зээл	-0.25	0.04	-0.49

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Төв аймгийнхан хууль, эрх зүй, зохицуулалтын орчинд муу үнэлгээг боломжийн үнэлгээнээс арай түлхүү өгсөн бөгөөд төрийн байгууллагын үйлчилгээ, газар эзэмших нөхцөл, гадаад худалдаа хийх нөхцөл, хууль эрх зүйн орчин зэрэг нь

аймгуудынхаас илүү муу, Улаанбаатарынхнаас бага зэрэг муу гэсэн үнэлгээтэй байна.

Хүснэгт 5 Хууль эрх зүйн орчин

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Хууль, эрх зүйн зохицуулалтын орчин	Төв	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Төрийн байгууллагын үйлчилгээ	-0.80	-0.57	-0.75
Гадаад худалдаа хийх нөхцөл	-0.63	-0.48	-0.43
Хууль, эрх зүйн орчин	-0.63	-0.44	-0.65
Газар эзэмших	-0.59	-0.31	-0.60
Татварын тогтолцоо	-0.47	-0.43	-0.56
Хяналт, шалгалтын тогтолцоо	-0.45	-0.32	-0.52

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Зах зээлийн орчныг ерөнхийд нь боломжийн, муу гэж үнэлсэн нь бусад аймгууд, Улаанбаатар хотынхтой харьцуулахад бага зэрэг муу үнэлгээтэй байна. Шударга өрсөлдөөн, даатгалын үйлчилгээнд өгсөн үнэлгээ аймгуудын дунджаас муу байна.

Хүснэгт 6 Зах зээлийн орчин

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Зах зээлийн орчин	Төв	Аймгуудын дундаж	Улаан- баатар
Зах зээлийн багтаамж	-0.41	-0.40	-0.37
Даатгалын үйлчилгээ	-0.51	-0.40	-0.37
Технологийн дэвшил	-0.27	-0.34	-0.20
Хэрэглэгчдийн худалдан авах чадвар	-0.45	-0.43	-0.36
Шударга өрсөлдөөн	-0.47	-0.40	-0.44

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Төв аймгийнхан дэд бүтцийн байдлаас зам тээвэр, дулаан усан хангамжинд муу үнэлгээг боломжийн үнэлгээнээс илүү, цахилгаан хангамжинд боломжийн үнэлгээг түлхүү өгсөн байна. Мэдээлэл холбооны хөгжлийг боломжийн гэж үзжээ. Ерөнхийдөө нийслэл, аймгуудын дундаж үнэлгээтэй харьцуулахад доогуур үнэлгээтэй байна.

Хүснэгт 7 Дэд бүтэц

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Дэд бүтцийн байдал	Төв	Аймгуудын дундаж	Улаан- баатар
Дулаан, усан хангамж	-0.55	-0.40	-0.25
Зам, тээврийн хөгжил	-0.84	-0.54	-0.68
Мэдээлэл холбооны хөгжил	0.00	0.32	0.15
Цахилгаан хангамж	-0.29	-0.02	-0.10

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

5. Дотоод орчин

ЖДҮ эрхлэгчид өөрсдийн дотоод орчиндоо ерөнхийдөө бага хүндрэлтэй гэсэн үнэлгээг өгсөн бөгөөд хүний нөөцийн удирдлага, ажилчдын чадвар

эдгээрээс арай илүү хүндрэлтэй гэгджээ. Бусад аймгуудад ч ерөнхийдөө ийм хандлагатай байв.

Хүснэгт 8 Дотоод орчин

(Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4)

Дотоод орчин	Төв	УБ хот	Аймгуудын дундаж
Хүний нөөцийн удирдлага	-1.29	-1.38	-1.12
Ажилчдын чадвар	-1.27	-1.13	-1.31
Түүхий эдийн чанар	-1.18	-1.30	-1.28
Тоног төхөөрөмжийн чанар	-1.14	-1.20	-1.33

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

6. Зардлын байдал

Төв аймгийн ЖДҮ эрхлэгчид зардлын байдалдаа хүндрэлтэй, бага хүндрэлтэй үнэлгээг түлхүү өгсний зэрэгцээ аймгуудын дундаж болон Улаанбаатарын үнэлгээтэй харьцуулахад бараг бүх үзүүлэлтээрээ илүү муу үнэлгээтэй байна. Хамгийн хүндрэлтэй зардлуудад шимтгэл хураамжийн төлбөр, зээлийн хүүний, түүхий эдийн, дулаан, усны, тоног төхөөрөмжийн зардлуудыг оруулжээ. Харин хамгийн хүндрэл багатай зардалд харилцаа холбооны зардлыг оруулсан байна.

Хүснэгт 9 Зардлын байдал

(Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4)

Зардлын байдал	Төв	УБ хот	Аймгуудын дундаж
Шимтгэл, хураамж	-1.96	-1.78	-1.71
Зээлийн хүү	-1.94	-1.89	-1.82
Түүхий эд	-1.78	-1.62	-1.59
Дулаан, ус	-1.76	-1.49	-1.51
Зам, тээвэр	-1.75	-1.62	-1.58
Тоног төхөөрөмж	-1.71	-1.20	-1.62
Зар сурталчилгаа	-1.65	-1.57	-1.10
Эрчим хүч, цахилгаан	-1.65	-1.48	-1.50
Ажиллах хүч	-1.59	-1.41	-1.37
Захираа, үйл ажиллагаа	-1.57	-1.42	-1.24
Түрээс	-1.53	-1.74	-1.47
Харилцаа холбоо	-1.27	-1.25	-0.92

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

7. Нийгмийн орчин

Судалгаанд оролцогчид нийгмийн орчинг их хүндрэлтэй, хүндрэлтэй гэж дүгнэсэн бөгөөд тэр дундаа ядуурал, хээл хахууль, гэмт хэрэг, ажилгүйдэлд их хүндрэлтэй гэсэн үнэлгээг түлхүү өгсөн нь бусад аймгууд, Улаанбаатар хотын хандлагатай ижил байна.

Хүснэгт 10 Нийгмийн орчин

(Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4)

Нийгмийн орчин	Төв	УБ хот	Аймгуудын дундаж
Ядуурал	-2.76	-2.77	-2.48
Хээл хахууль	-2.67	-2.72	-2.27
Гэмт хэрэг	-2.59	-2.67	-2.13
Ажилгүйдэл	-2.59	-2.75	-2.49
Улс төрийн байдал	-2.47	-2.46	-2.08
Харилцагчийн ёс суртахуун	-2.04	-2.00	-1.65
Хувийн хэвшил, иргэдийн оролцоо	-2.04	-1.91	-1.48
Мэдээллийн хүртээмж	-2.02	-1.78	-1.53


Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

8. Санхүүжилт

Төв аймгийн судалгаанд оролцсон ЖДҮ эрхлэгчдийн 55% нь өөрийн хөрөнгөөр, 37% нь гэр бүл, найз нөхдийн хөрөнгөөр, 20% нь банкны зээлээр санхүүжигдан үйл ажиллагаа эхлүүлжээ. Улаанбаатартай харьцуулахад ерөнхий хандлага ижил байгаа ба гэр бүл, найз нөхдийн хөрөнгөөр гэсэн хариулт бага зэрэг илүү байна. Аймгуудын дунджаас өөрийн хөрөнгөөр үйл ажиллагаагаа эхлүүлсэн байдал нь 3 нэгж хувиар илүү, харин банкны зээл авсан нь 27 нэгж хувиар бага байна.

Зураг 7 Анхдагч санхүүжилт

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Зээлээ эргэн төлөхөд хүүний төлбөр өндөр, хугацаа богино зэрэг нь хамгийн их хүндрэл учруулсан гэж хариулжээ. Гэсэн хэдий ч эдгээр нь аймгуудын дунджаас (5-12 нэгж хувиар) бага хувьтай байна. Мөн хүндрэл тулгараагүй гэсэн хариулт аймгуудын дунджаас 7 нэгж хувиар бага байв. Харин Улаанбаатартай харьцуулбал хүүний төлбөр өндөр, хугацаа богино гэсэн хариулт 3-9 нэгж хувиар бага байна. (Улаанбаатарчуудын 54% нь уг асуултанд хариулсан)

Зураг 8 Зээлийн эргэн төлөлтийн бэрхшээл

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Үйл ажиллагаагаа өргөжүүлэх, шинээр бизнес эрхлэхэд судалгаанд хамрагдагсдын 47% нь санхүүжилт авч байсан гэж хариулсан нь аймгуудын хариултаас ялгаатай байна. Аймгуудын хувьд дийлэнх нь ямар нэг байдлаар санхүүжилт авсан гэжээ. Харин Төв аймгийнхны санхүүжилт авсан ЖДҮ эрхлэгчдийн 67% нь банкны зээл, 17% нь найз нөхөд, хамаатан садангаасаа зээл авсан гэжээ.

Цаашид үйл ажиллагаагаа явуулахад санхүүжилт авах хэрэгцээтэй гэж дийлэнх (65%) бусад аймгуудтай ижил хариулсан бөгөөд тэдгээрийн 39% нь 10-50 сая, 21% нь 50-100 сая, 18% нь 100-500 сая төгрөгийн санхүүжилт шаардлагатай гэж хариулжээ.

Зураг 9 Шаардлагатай санхүүжилт

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Дүгнэлт

- Төв аймгаас судалгаанд хамрагдсан 51 ЖДҮ эрхлэгчид худалдаа, үйлчилгээ, зочид буудал, нийтийн хоол, үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг гэжээ.
- Тэдгээрийн дийлэнх нь цөөн тооны ажиллагсадтай бөгөөд түүхий эд материалаа нийслэл хотоос, гадаад орнуудаас бэлтгэж, нийслэл хот болон улсын хэмжээнд борлуулдаг байна.

• Төв аймгийн санал асуулгад оролцсон ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх нь жилийн орлогоо 10-50 сая төгрөг гэж хариулсан ба 90 гаруй хувь нь тайлан тэнцэл гаргадаг байна.

• ЖДҮ эрхлэгчдийг хамгийн их ямар байгууллага дэмждэг вэ гэсэн асуултанд хамгийн их хариултыг мэдэхгүй гэсэн хариулт эзэлж байгаа нь бусад аймгуудын хариултаас ялгаатай, Улаанбаатар хотынхтой төстэй байв. Харин мэдэхгүй гэснээс өөрөөр хариулсан байдлыг үзвэл бусад аймгууд, нийслэл хотын судалгааны дүнтэй адил арилжааны банкныг хамгийн их ЖДҮ эрхлэгчдийг дэмждэг гэж үзжээ.

• Нэн түрүүнд төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох, татварын таатай орчинг бүрдүүлэх, санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгох, авлигыг бууруулах зэрэг арга хэмжээг авах шаардлагатай гэжээ.

• Бизнесийн орчинд ерөнхийдөө бусад аймгуудтай ижил сөрөг үнэлгээг өгсөн бөгөөд тус аймгийнхны бусад аймгуудаас илүү хамгийн их сөрөг үнэлгээ өгсөн хүчин зүйл нь төрийн байгууллагын үйлчилгээ, гадаад худалдаа хийх нөхцөл, зам тээврийн хөгжил зэрэг байна.

• Өөрийн хөрөнгө, банкны зээл болон гэр бүл, найз нөхдийн хамтын хөрөнгөөр дийлэнх нь үйл ажиллагаагаа эхлүүлсэн байна. Үйл ажиллагаагаа өргөжүүлэх, шинээр бизнес эрхлэхэд ихэнх аймгуудын судалгаанд оролцогчдын дийлэнх санхүүжилт авч байсан бол Төв аймгийн хувьд 47% нь л санхүүжилт авсан гэжээ. Гэхдээ тэдгээрийн дийлэнх нь бусад аймгуудын адил санхүүжилтээ банкнаас зээл хэлбэрээр авсан байна.

• Цаашид үйл ажиллагаагаа явуулахад санхүүжилт шаардлагатай гэж дийлэнх нь хариулсан ба 10-50 сая төгрөгийн санхүүжилт хэрэгцээтэй гэжээ.

Увс аймаг

1. Ерөнхий мэдээлэл

Увс аймагт 2011 оны 1 дүгээр улирлын байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа 643⁴⁷ ААН-ээс санамсаргүй түүврийн аргаар 51 жижиг дунд бизнес эрхлэгчийг судалгаанд хамрууллаа. Судалгаанд оролцсон Увс аймгийн жижиг дунд бизнес эрхлэгчдийн 41% нь ХХК, 33% нь иргэд байсан бөгөөд ихэнх нь дотоодын хөрөнгө оруулалттайгаар үйл ажиллагаагаа явуулдаг байна.

Үйл ажиллагааны чиглэлээр нь авч үзвэл 53% нь үйлдвэрлэл, 41% нь худалдаа, 6% нь үйлчилгээ эрхэлдэг байна. Аймгуудын дундаж үзүүлэлтээс үйлдвэрлэл эрхэлдэг ЖДҮ эрхлэгчид 13 нэгж хувиар илүү харин үйлчилгээ 23 нэгж хувиар, худалдаа 10 нэгж хувиар бага байна.

Зураг 1 ЖДҮ эрхлэгчдийн үйл ажиллагааны чиглэл

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 33% нь 10-аас дээш жил, 35% нь 5-10 жил, 28% нь 1-5 жил, 2% нь 1 хүртэл жил үйл ажиллагаагаа эрхэлж байгаа бөгөөд 75% нь 10 хүртэл, 22% нь 10-49 ажиллагсадтай байна.

Түүхий эд материалаа 55% нь өөрийн аймгаасаа, 47 нийслэл хотоос бэлтгэж, бараа үйлчилгээгээ 94% нь өөрийн аймагтаа борлуулдаг гэжээ. Өөрийн аймаг,

бусад аймгаас түүхий эд бэлтгэх байдал бусад аймгуудтай харьцуулахад 10 нэгж хувиар илүү байгаа бол бараа бүтээгдэхүүний борлуулалтын хувьд өөрсдийн аймагтаа борлуулах байдал нь 12 нэгж хувиар илүү байв.

Хүснэгт 1 Түүхий эд материалын бэлтгэл, бараа бүтээгдэхүүний борлуулалт

(Бусад аймаг болон УБ хоттой харьцуулсан дүн, давхардсан тоогоор, хувь)


Байршил	Түүхий эд бэлтгэл			Борлуулалт		
	Увс	Аймгууд	УБ хот	Увс	Аймгууд	УБ хот
Нийслэл хот	47	55	78	14	9	81
У/а эрхэлж буй аймаг	55	45		94	82	
Бусад аймаг	10	8	6	14	13	4
Гадаад улс	29	27	30	2	3	5
Улсын хэмжээнд				6	6	19
Нийт						

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн 20% нь 1-10 сая, 22% нь 10-50 сая, 18% нь 50-100 сая, 24% нь 100-500 сая төгрөгийн орлоготой гэж хариулсан ба бусад аймгууд, нийслэл хотын дундаж үзүүлэлтээс 100-500 сая гэсэн хариулт харьцангуй их байв.

Зураг 3 ЖДҮ эрхлэгчдийн жилийн борлуулалтын орлого

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Судалгаанд оролцсон ЖДҮ эрхлэгчдийн 65% нь тайлан тэнцэл гаргадаг гэсэн хариулт өгсөн нь аймгуудын дунджаас ойролцоо, Улаанбаатар хотынхоос 12 нэгж хувиар бага үзүүлэлттэй байна.


⁴⁷ Бизнес регистрийн санд бүртгэлтэй

2. ЖДҮ-ийг дэмжих бодлогын арга хэмжээ

Давхардсан дүнгээр суудалгаанд оролцсон ЖДҮ эрхлэгчдийн 92% нь арилжааны банк ЖДҮ-ийг их дэмждэг гэж хариулжээ. Харин Засгийн газар, ОУ-ын байгууллага, орон нутгийн засаг захиргаа, төрийн бус байгууллага, Худалдаа аж үйлдвэрийн танхим гэсэн хариулт аймгуудын дундажтай ойролцоо сонгогдсон байв.

Зураг 3 ЖДҮ эрхлэгчдийг хамгийн ихээр дэмждэг байгууллага

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Эдгээр байгууллагаас санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгосон (76%), үзэсгэлэн худалдаа зохион байгуулсан, сургалт зөвлөгөө явуулах байдлаар дэмжлэг үзүүлсэн гэж хариулжээ. Бусад аймгуудтай харьцуулбал санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгосон 18 нэгж хувиар илүү байв.

Зураг 4 ЖДҮ-д ямар дэмжлэг үзүүлсэн

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Цаашид санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгох, үндэсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, татварын таатай орчинг бүрдүүлэх, төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох, хувийн хэвшил олон нийтийн оролцоог бизнесийн шийдвэр гаргалтанд нэмэгдүүлэх, зөвшөөрөл лицензийн тоог багасгах зэрэг арга хэмжээнүүдийг нэн түрүүн авбал зохистой гэж үзсэн байна.

Зураг 5 Цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

3. Макро эдийн засгийн орчин

Манай улсад ЖДҮ хөгжих эдийн засгийн таатай орчин хангалттай бус байна гэж Увс аймгийн судалгаанд оролцогчдын 61%, хангалттай бүрдсэн гэж 26% нь үзжээ. Аймгуудын дундажтай харьцуулахад хангалттай бус гэсэн хариулт 10 нэгж хувиар бага, хангалттай бүрдсэн гэж 15 нэгж хувиар илүү байна.

Хүснэгт 2 ЖДҮ хөгжих эдийн засгийн таатай орчин бүрдсэн эсэх

(Бусад аймаг болон УБ хоттой харьцуулсан дүн, давхардсан тоогоор, хувь)

ЖДҮ хөгжих орчин	Увс	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Бүрдсэн	25	10	8
Хангалттай бус	61	71	61
Огт бүрдээгүй	10	12	23
Мэдэхгүй	4	6	9

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Эдийн засгийн өсөлт өөрсдийн бизнест эерэгээр нөлөөлж байна гэж дийлэнх нь (69%) нь хариулжээ.

Хүснэгт 3 ЖДҮ хөгжилд эдийн засгийн өсөлтийн үзүүлж буй нөлөө

(Бусад аймаг болон УБ хоттой харьцуулсан дүн, давхардсан тоогоор, хувь)

Эдийн засгийн өсөлт танай бизнест	Увс	Аймгуудын дундаж	Улаан- баатар
Эергээр	69	24	20
Сөргөөр	6	22	43
Нөлөөлөөгүй	18	19	21
Мэдэхгүй	6	16	18

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

4. Бизнесийн орчин

Увс аймгийн судалгаанд оролцсон ЖДҮ эрхлэгчид дэд бүтэц, хууль эрх зүй, санхүүжилт, зах зээлийн орчинг муугаас боломжийн үнэлгээний хооронд үнэлжээ.

Увс аймгийнхны санхүүжилтийн орчинд өгсөн үнэлгээнээс барьцаа хөрөнгөнд өгсөн үнэлгээ Улаанбаатар хот, аймгуудын дундаж үнэлгээнээс доогуур, ББСБ-ын зээлд өгсөн үнэлгээ Улаанбаатартай ижил, аймгуудынхаас доогуур үнэлгээтэй байв. Харин бусад үзүүлэлтүүдийн хувьд аймаг нийслэлийн дундаж үнэлгээнээс сайн үнэлгээтэй байлаа. Тус аймгийнхны хамгийн бэрхшээлтэй нь ОУ-ын байгууллагын хөнгөлөлттэй зээл, Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн олдоц гэж үзсэн байна. Энэ хэсгээс хамгийн эерэг буюу боломжийн үнэлгээг банкны зээлд өгчээ.

Хүснэгт 4 Санхүүжилтийн орчин

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Санхүүжилтийн орчин	Увс	Аймгуудын дундаж	Улаан- баатар
ОУ-ын байгууллагын хөнгөлөлттэй зээлийн олдоц	-1.08	-1.01	-1.02
Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн олдоц	-1.02	-0.93	-1.01
Санхүүжилтийн барьцаа хөрөнгө	-0.71	-0.41	-0.56
Банк бус санхүүгийн байгууллагын зээл	-0.49	-0.32	-0.48
Хөрөнгийн зах зээлээс санхүүжилт авах	-0.49	-0.55	-0.61
Санхүүжилтийн хүү	-0.47	-0.63	-0.67
Санхүүжилтийн хэмжээ	-0.45	-0.47	-0.51
Өөрийн хөрөнгийн хүрэлцээ	-0.33	-0.40	-0.43
Зээлийн батлан даалт	-0.27	-0.29	-0.49
Санхүүжилтийн хутагаа	-0.20	-0.52	-0.57
Зээл олгох үйл ажиллагаа	-0.02	-0.16	-0.53
Банкны зээл	0.08	0.04	-0.49

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Хууль, эрх зүй үзүүлэлтийн хувьд боломжийн, муу гэсэн үнэлгээ зонхилж байгаа бөгөөд гадаад худалдаа хийх нөхцөлд муу боломжийн үнэлгээний дундаж үнэлгээнээс доогуур үнэлгээтэй байв. Бусад үзүүлэлтүүдийн хувьд боломжийн үнэлгээ нь муугаасаа түлхүү өгөгджээ. Ялангуяа газар эзэмшлийн эрх зүйн орчин гэсэн үзүүлэлт бусад аймгууд болон нийслэлтэй харьцуулахад илүү боломжийн гэсэн үнэлгээтэй байв.

Хүснэгт 5 Хууль эрх зүйн орчин

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Хууль, эрх зүйн зохицуулалтын орчин	Увс	Аймгуудын дундаж	Улаан- баатар
Гадаад худалдаа хийх нөхцөл	-0.65	-0.48	-0.43
Төрийн байгууллагын үйлчилгээ	-0.47	-0.57	-0.75
Татварын тогтолцоо	-0.45	-0.43	-0.56
Хууль, эрх зүйн орчин	-0.41	-0.44	-0.65
Хяналт, шалгалтын тогтолцоо	-0.31	-0.32	-0.52
Газар эзэмших	-0.08	-0.31	-0.60

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Зах зээлийн орчныг ерөнхийд нь боломжийн гэж үнэлжээ. Хамгийн сайн үнэлгээг зах зээлийн багтаамж авсан бөгөөд аймаг, нийслэлийн үнэлгээнээс дээгүүр үзүүлэлт байв. Шударга өрсөлдөөнд энэ бүлгээс хамгийн бага үнэлгээг өгчээ.

Хүснэгт 6 Зах зээлийн орчин

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Зах зээлийн орчин	Увс	Аймгуудын дундаж	Улаан- баатар
Зах зээлийн багтаамж	-0.18	-0.40	-0.37
Даатгалын үйлчилгээ	-0.27	-0.40	-0.37
Технологийн дэвшил	-0.39	-0.34	-0.20
Хэрэглэгчдийн худалдан авах чадвар	-0.31	-0.43	-0.36
Шударга өрсөлдөөн	-0.43	-0.40	-0.44

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Дэд бүтцийн байдалд өгсөн үнэлгээ аймгууд болон Улаанбаатар хоттой харьцуулахад муу үнэлгээтэй байгаа бөгөөд тэр дундаа зам тээврийн хөгжил, дулаан усан хангамж муу гэж үнэлэгджээ. Харин мэдээлэл холбооны хөгжил, цахилгаан хангамжинд боломжийн гэсэн үнэлгээг өгчээ.

Хүснэгт 7 Дэд бүтэц

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Дэд бүтцийн байдал	Увс	Аймгуудын дундаж	Улаан- баатар
Дулаан, усан хангамж	-0.96	-0.40	-0.25
Зам, тээврийн хөгжил	-0.90	-0.54	-0.68
Мэдээлэл холбооны хөгжил	0.18	0.32	0.15
Цахилгаан хангамж	0.00	-0.02	-0.10

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

5. Дотоод орчин

Судалгаанд ЖДҮ эрхлэгчид өөрсдийн дотоод орчиндоо ерөнхийдөө бага хүндрэлтэй гэсэн үнэлгээг өгсөн бөгөөд түүхий эдийн чанар арай илүү хүндрэлтэй үнэлгээтэй байна.

Хүснэгт 8 Дотоод орчин

(Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4)

Дотоод орчин	Увс	УБ хот	Аймгуудын дундаж
Ажилчдын чадвар	-1.08	-1.13	-1.31
Тоног төхөөрөм-жийн чанар	-1.10	-1.20	-1.33
Түүхий эдийн чанар	-1.41	-1.30	-1.28
Хүний нөөцийн удирдлага	-0.92	-1.38	-1.12

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

6. Зардлын байдал

Зардлуудад судалгаанд ороолцогсдын дийлэнх нь хүндрэлтэй, бага хүндрэлтэй гэсэн үнэлгээг өгчээ. Хамгийн хүндрэлтэй зардлуудад зам тээвэр, зээлийн хүүний, тоног төхөөрөмж, шимтгэл хураамжийн төлбөр, түүхий эдийн зардлуудыг оруулсан нь бусад аймгууд, Улаанбаатар хотынхны хандлагатай ерөнхийдөө ижил байна. Харин зам тээвэр, тоног төхөөрөмжийн зардал аймгуудын дундаж болон Улаанбаатарынхаас илүү хүндрэлтэй гэсэн үнэлгээг авсан бол эрчим хүч цахилгаан, зар сурталчилгаа, түрээсийн зардлуудыг арай бага хүндрэлтэй гэжээ.

Хүснэгт 9 Зардлын байдал

(Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4)

Зардлын байдал	Увс	УБ хот	Аймгуудын дундаж
Зам, тээвэр	-1.90	-1.62	-1.58
Зээлийн хүү	-1.90	-1.89	-1.82
Тоног төхөөрөмж	-1.80	-1.20	-1.62
Шимтгэл, хураамж	-1.71	-1.78	-1.71
Түүхий эд	-1.59	-1.62	-1.59
Ажиллах хүч	-1.37	-1.41	-1.37
Дулаан, ус	-1.35	-1.49	-1.51
Түрээс	-1.25	-1.74	-1.47
Захиргаа, үйл ажиллагаа	-1.16	-1.42	-1.24
Эрчим хүч, цахилгаан	-1.14	-1.48	-1.50
Зар сурталчилгаа	-0.96	-1.57	-1.10
Харицаа холбоо	-0.82	-1.25	-0.92

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

7. Нийгмийн орчин

Тус аймгынхан бусад аймгууд, нийлэл хоттой адил нийгмийн орчинд их хүндрэлтэйгээс хүндрэлтэй гэсэн үнэлгээг их өгсөн ба үүнээс ядуурал, ажилгүйдэл, хээл хахууль, улс төрийн байдал их хүндрэлтэй гэж дүгнэсэн нь бусад аймгууд, Улаанбаатар хотынхтой ойролцоо байна.

Хүснэгт 10 Нийгмийн орчин

(Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4)

Нийгмийн орчин	Увс	УБ хот	Аймгуудын дундаж
Ядуурал	-2.63	-2.77	-2.48
Ажилгүйдэл	-2.53	-2.75	-2.49
Хээл хахууль	-2.39	-2.72	-2.27
Улс төрийн байдал	-2.25	-2.46	-2.08
Гэмт хэрэг	-2.24	-2.67	-2.13
Мэдээллийн хүртээмж	-1.84	-1.78	-1.53
Хувийн хэвшил, иргэдийн оролцоо	-1.53	-1.91	-1.48
Харицагчийн ёс суртахуун	-1.51	-2.00	-1.65

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн


8. Санхүүжилт

Судалгаанд оролцогчдын дийлэнх нь давхардсан дүнгээр банкны зээл (80%) болон өөрийн хөрөнгөөр (55%) санхүүжигдан үйл ажиллагаагаа эхлүүлж байжээ. Мөн гэр бүлийн хамтын хөрөнгөөр 20% нь санхүүжигдсан гэж хариулсан байна. Энэ нь бусад аймгуудтай харьцуулахад банкны зээл ашигласан

байдал 33 нэгж хувиар илүү, гэр бүл, найз нөхдийн хөрөнгөөр үйл ажиллагаагаа эхлүүлсэн нь 12 нэгж хувиар бага байна. Улаанбаатарынхаас өөрийн хөрөнгөөр үйл ажиллагаагаа эхлүүлсэн байдал 5 нэгж хувиар бага, харин банкны зээл авсан нь 63 нэгж хувиар илүү байна.

Зураг 6 Анхдагч санхүүжилт

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Үйл ажиллагаагаа өргөжүүлэх, шинээр бизнес эрхлэхэд судалгаанд хамрагдагсдын 90% нь (Улаанбаатарчуудын хувьд 62% нь зээл аваагүй гэж хариулсан) санхүүжилт авч байсан гэж хариулсан бөгөөд тэдгээрийн 96% нь банкны зээл авч байжээ.

Зээлээ эргэн төлөхөд хүүний төлбөр өндөр (41%), хугацаа богино (24%) байгаа нь хүндрэл учруулдаг гэж хариулжээ. Зээлийн хугацаа богино гэсэн хариулт нийслэлийн хариултаас 9 нэгж хувиар илүү, аймгуудын дунджаас 5 нэгж хувиар бага, зээлийн хүүний төлбөр өндөр гэсэн хариулт аймгуудынхаас 5 нэгж хувиар, нийслэлийнхээс 20 нэгж хувиар илүү байв. Харин хүндрэл тулгараагүй гэж 19% нь хариулсан байгаа нь аймгуудын дундажтай ойролцоо, нийслэлээс 7 нэгж хувиар илүү байна.



Цаашид үйл ажиллагаагаа явуулахад санхүүжилт авах хэрэгцээтэй гэж 94% нь бусад аймгуудтай адил хариулсан (Улаанбаатараас 35 нэгж хувиар илүү) бөгөөд тэдгээрийн 50% нь 10-50 сая, 17% нь 100-500 сая, 17% нь 50-100 сая төгрөгийн санхүүжилт шаардлагатай гэж үзжээ. Эдгээрийг аймгуудын дундаж, Улаанбаатарын үзүүлэлттэй харьцуулбал 10-50 сая төгрөг гэсэн хариулт харьцангуй илүү, 5-10 сая төгрөг гэсэн нь бага байна.



Дүгнэлт

- Увс аймгийн судалгаанд хамрагдсан 51 ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх 10 хүртэлх ажиллагсадтайгаар 5

буюу түүнээс дээш жил үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд үйлдвэрлэл, худалдааны чиглэлээр үйл ажиллагаа түлхүү эрхэлдэг байна.

- Түүхий эд материалаа бусад аймгуудын адил нийслэл хот, өөрийн аймгаасаа бэлтгэн, бараа үйлчилгээгээ өөрийн аймагтаа борлуулдаг.

- Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх нь жилдээ 50-100 сая төгрөгийн орлого олдог бөгөөд 60 гаруй хувь нь тайлан тэнцэл гаргадаг байна.

- ЖДҮ-ийн үйл ажиллагаанд нь арилжааны банк хамгийн их дэжлэг үзүүлдэг гэжээ. Мөн Засгийн газар, ОУ-ын байгууллага, орон нутгийн засаг захиргаа дэмжлэг үзүүлдэг гэж багагүй хувь хариулжээ. Эдгээр байгууллагуудаас санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгосон, үзэсгэлэн худалдаа зохион байгуулсан, сургалт зөвлөгөө явуулах байдлаар дэмжлэг үзүүлжээ.

- Увс аймгийнхан санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгох, үндэсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, татварын таатай орчинг бүрдүүлэх, төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох, хувийн хэвшил олон нийтийн оролцоог бизнесийн шийдвэр гаргалтанд нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээг нэн түрүүнд авах шаардлагатай гэж үзжээ.

- Бизнесийн орчинд ерөнхийдөө бусад аймгуудтай харьцуулахад бага зэрэг доогуур түвшинд үнэлэгдсэн бөгөөд хамгийн их сөрөг үнэлгээтэй нь дулаан, ус хангамж, зам тээврийн хөгжил орж байна. Зардлуудаас зам тээвэр, зээлийн хүү, тоног төхөөрөмжийн зардлыг хамгийн хүндрэлтэй, нийгмийн орчноос ядуурал, ажилгүйдлийг их хүндрэлтэй гэж үзжээ.

- ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх өөрийн хөрөнгө болон банкны зээлээр үйл ажиллагаагаа санхүүжүүлж бизнесээ эхлүүлсэн бөгөөд үйл ажиллагаа өргөжүүлэхдээ дахин санхүүжилт авсан байна.

- Зээлээ эргэн төлөхөд зээлийн хугацаа богино, хүүний төлбөр өндөр байсан нь хамгийн их бэрхшээл болдог гэжээ.

- Дийлэнх нь цаашид үйл ажиллагаагаа өргөжүүлэхдээ санхүүжилт авах шаардлагатай гэсэн бөгөөд 10-50 сая төгрөгийн санхүүжилт шаардлагатай байна гэжээ.

Ховд аймаг


1. Ерөнхий мэдээлэл

Ховд аймагт 2011 оны 1 дүгээр улирлын байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа 1074⁴⁸ ААН-ээс санамсаргүй түүврийн аргаар 49 жижиг дунд бизнес эрхлэгчийг судалгаанд хамрууллаа. Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 41% нь иргэд, 39% нь ХХК, 10% нь ХК, 8% нь нөхөрлөл, 2% нь хоршоо байсан бөгөөд тэдгээрийн 82% нь дотоодын хөрөнгө оруулалттайгаар үйл ажиллагаагаа явуулдаг гэжээ.

Ховд аймагт судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 47% нь худалдаа, 35% нь үйлчилгээ, 18% нь үйлдвэрлэл эрхэлдэг гэжээ. Дээрх үзүүлэлтүүдийг аймгуудын дундаж үзүүлэлттэй харьцуулбал, худалдаа 15 нэгж хувиар илүү, үйлчилгээ болон үйлдвэрлэл харгалзан 2, 13 нэгж хувиар бага сонгогдсон байна.

Зураг 1 ЖДҮ эрхлэгчдийн үйл ажиллагааны чиглэл

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийг үйл ажиллагаа эрхэлж буй хугацаагаар нь авч үзвэл 47% нь 5-10 жил, 33% нь 1-5 жил, 12% нь 10-аас дээш жил, 4% нь 1 хүртэл жил үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд тэдгээрийн 67% нь 10 хүртэл, 27% нь 10-49, 2% нь 50-99 ажиллагсадтай ЖДҮ-үүд байв.

Ховд аймгийн хувьд түүвэр судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн давхардсан тоогоор 57% нь нийслэл хотоос, 37% нь үйл ажиллагаа эрхэлж буй аймгаас түүхий эд, материалаа бэлтгэдэг гэж хариуллаа. Тус үзүүлэлтийг аймгуудын дундаж үзүүлэлттэй харьцуулбал, нийслэл хотоос бэлтгэдэг гэсэн ойролцоо, үйл ажиллагаа эрхэлж буй аймгаас гэсэн хариулт бага зэрэг бага байв. ЖДҮ эрхлэгчдийн 82% нь эцсийн бүтээгдэхүүнээ өөрийн

аймагт, 16% нь улсын хэмжээнд болон нийслэл хотод борлуулдаг гэж хариулсан нь аймгуудын дундажтай ойролцоо үзүүлэлттэй байна.

Хүснэгт 1 Түүхий эд материалын бэлтгэл, бараа бүтээгдэхүүний борлуулалт

(Бусад аймаг болон УБ хоттой харьцуулсан дүн, давхардсан тоогоор, хувь)

Газар	Түүхий эд бэлтгэл			Борлуулалт		
	Ховд	Аймгууд	УБ	Ховд	Аймгууд	УБ
Нийслэл хот	57	55	73	12	9	76
Үйл ажиллагаа эрхэлж буй	37	45	5	82	82	5
Бусад аймаг	6	8	6	22	13	4
Гадаад улс	33	27	30	6	3	5
Улсын хэмжээнд				4	6	19
Нийт	133	136	115	127	113	109

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Ховд аймгийн судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 33% нь 1-10 сая, 27% нь 10-50 сая, 14 хувь нь 50-100 сая төгрөгийн жилийн борлуулалтын орлоготой гэж хариулсан нь аймгуудын дундаж үзүүлэлттэй ойролцоо байлаа. Харин Улаанбаатар хотынхоос 1-10 сая төгрөгийн жилийн борлуулалтын орлоготой гэсэн хариултын хувийн жин бага, 50-100 сая төгрөг гэсэн хариултын хувийн жин бага зэрэг их байв.

Зураг 2 ЖДҮ эрхлэгчдийн жилийн борлуулалтын орлого

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Түүвэр судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 53% нь тайлан тэнцэл гаргадаг гэсэн хариулт өгсөн нь аймгуудын дунджаас 12 нэгж хувь, Улаанбаатар хотынхоос 24 нэгж хувиар тус тус бага үзүүлэлттэй байна.

2. ЖДҮ-ийг дэмжих бодлогын арга хэмжээ

ЖДҮ эрхлэгчдийн бизнесийг хамгийн их дэмждэг байгууллагыг нэрлэнэ үү гэсэн асуултанд арилжааны банк (59%), засгийн газар (22%), орон нутгийн засаг захиргаа (18%), олон улсын байгууллагууд (14%), зөвлөгөө өгдөг, байгууллага, төвүүд (12%) төрийн бус байгууллагууд (10%) гэж хариулсан бөгөөд аймгуудын дундаж үзүүлэлттэй харьцуулахад ойролцоо байлаа.

⁴⁸ Бизнес регистрийн санд бүртгэлтэй

Зураг 3 ЖДҮ эрхлэгчдийг хамгийн ихээр дэмжлэг байгууллага

(Санал асуулгад оролцогчдын эзтх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Дээрх байгууллагаас ямар дэмжлэг үзүүлснийг асуухад санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгосон (55%), технологийн ололт дэвшилтийг нэвтрүүлсэн (35%), татварыг хөнгөлсөн (31%), үзэсгэлэн худалдаа зохион байгуулсан байгуулсан (27%) гэж хариулсан байна.

Зураг 4 ЖДҮ-д ямар дэмжлэг үзүүлсэн

(Санал асуулгад оролцогчдын эзтх хувь, давхардсан тоогоор)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

ЖДҮ-ийг хөгжүүлэхэд үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, бизнестэй холбоотой шийдвэрт хувийн хэвшил, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, татварын таатай орчинг бүрдүүлэх, хөнгөлөлттэй санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгох, хүртээмжийг нэмэгдүүлэх, дэд бүтцийг сайжруулах, сургалт зөвлөгөөг нэмэгдүүлэх арга хэмжээг нэн түрүүнд авах шаардлагатай гэж үзжээ. Энэхүү үр дүнг аймгууд болон Улаанбаатар хотын нэгдсэн дүнтэй харьцуулахад татварын таатай орчинг бүрдүүлэх, хувийн хэвшил, олон нийтийг оролцоог нэмэгдүүлэх, сургалт, зөвлөгөөн зохион байгуулах, дэд бүтцийг сайжруулах гэсэн хариултууд Улаанбаатар хот болон аймгуудын дундаж үзүүлэлтээс их байна.

Зураг 5 Цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ

(Санал асуулгад оролцогчдын эзтх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

3. Макро эдийн засгийн орчин

Эдийн засгийн таатай орчин бүрдсэн эсэх талаар асуухад санал асуулгад оролцогчдын 63% нь хангалттай бус, 16% нь огт бүрдээгүй, 10% нь бүрдсэн гэж үзжээ.

Хүснэгт 2 ЖДҮ хөгжих эдийн засгийн таатай орчин бүрдсэн эсэх

(Бусад аймаг болон УБ хоттой харьцуулсан дүн, давхардсан тоогоор, хувь)

ЖДҮ хөгжих орчин	Ховд	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Бүрдсэн	10	10	8
Хангалттай бус	63	71	61
Огт бүрдээгүй	16	12	23
Мэдэхгүй	8	6	9

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Харин эдийн засгийн өсөлт ЖДҮ эрхлэгчдийн бизнест хэрхэн нөлөөлж байгаа эсэхийг асуухад 43% нь эерэгээр, 31% нь сөргөөр нөлөөлсөн, 18% нь нөлөөлөөгүй, 6% нь мэдэхгүй гэж хариулжээ. Аймгуудын дундажтай харьцуулахад ЭЗ-ийн өсөлт өөрсдийн бизнест эерэгээр нөлөөлсөн гэсэн хариулт 5 нэгж хувиар, сөргөөр гэсэн хариулт 9 нэгж хувиар тус тус их байлаа.

Хүснэгт 3 ЖДҮ хөгжилд эдийн засгийн өсөлтийн үзүүлж буй нөлөө

(Бусад аймаг болон УБ хоттой харьцуулсан дүн, давхардсан тоогоор, хувь)

Эдийн засгийн өсөлт танай бизнест	Ховд	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Эергээр	43	38	18
Сөргөөр	31	22	43
Нөлөөлөөгүй	18	19	21
Мэдэхгүй	6	16	18

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Санал асуулгад оролцогчдын дийлэнх хувь нь инфляци болон төгрөгийн ханш тогтвортой байвал

эрхэлж буй бизнест нь сайн гэж бусад аймаг, Улаанбаатарчуудын адил үзсэн байна.

4. Бизнесийн орчин

Ховд аймгийн судалгаанд оролцсон ЖДҮ эрхлэгчдийн бизнесийн орчин бусад аймгуудтай адил ерөнхийдөө сөрөг үнэлгээг өгсний зэрэгцээ хууль эрх зүй, зохицуулалтын орчноос бусад бүлгүүдийн үнэлгээ аймгуудын дундаж үнэлгээнээс ч илүү муу үнэлгээтэй байлаа. Ялангуяа, дотоод орчин, зардлын байдлын үнэлгээ аймгуудын дундаж үнэлгээнээс илүү муу байв. Мөн нийгмийн орчинг бусад аймгуудын дундажтай адил хүндрэлтэй, их хүндрэлтэй гэж дүгнэжээ. Дэд бүтэц, зах зээлийн орчин, санхүүжилтийн байдлыг муу, боломжийн үнэлгээний хооронд үнэлсэн бөгөөд муу тал руугаа үнэлэгджээ.

Санхүүжилтийн хувьд ОУ-ын байгууллагын хөнгөлөлттэй зээл, ЗГ-ын хөнгөлөлттэй зээлийн олдцыг бусад аймаг, нийслэлийнхний адил муу гэж дүгнэснээс гадна санхүүжилтийн хугацаа, санхүүжилтийн хэмжээ, хүү, хөрөнгийн зах зээлээс санхүүжилт авахыг мөн муу гэсэн үнэлсэн нь аймгуудын дундаж, нийслэлийн үнэлгээнээс доогуур муу үзүүлэлт байлаа. Энэ бүлгээс банкны зээл, өөрийн хөрөнгийн хүрэлцээнд хамгийн сайн үнэлгээг өгсөн бөгөөд муу, боломжийн үнэлгээний дундуур, арай боломжийн тал руу дүгнэгдсэн байна. Үзүүлэлт бүрээрээ аймаг, нийслэлийн үнэлгээнээс муу үнэлгээтэй байв.

Хүснэгт 4 Санхүүжилтийн орчин

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Санхүүжилтийн орчин	Ховд	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Олон улсын байгууллагын хөнгөлөлттэй зээлийн о	-1.06	-1.01	-1.02
Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн олдц	-1.00	-0.93	-1.01
Санхүүжилтийн хугацаа	-1.00	-0.53	-0.57
Санхүүжилтийн хэмжээ	-0.94	-0.47	-0.51
Санхүүжилтийн хүү	-0.94	-0.63	-0.67
Хөрөнгийн зах зээлээс санхүүжилт авах	-0.88	-0.55	-0.61
Банк санхүүгийн байгууллагын зээл	-0.80	-0.33	-0.48
Санхүүжилтын барьцаа хөрөнгө	-0.76	-0.42	-0.56
Зээл олгох үйл ажиллагаа	-0.67	-0.18	-0.53
Зээлийн батлан даалт	-0.63	-0.30	-0.49
Өөрийн хөрөнгийн хүрэлцээ	-0.49	-0.40	-0.43
Банкны зээл	-0.47	0.02	-0.49

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Хууль, эрх зүйн зохицуулалтын орчинд боломжийн муу үнэлгээг өгсөн бөгөөд боломжийн үнэлгээг түлхүү өгчээ. Тус бүлгийн дундаж үнэлгээ нийслэл, аймгуудын дундаж үнэлгээнээс арай сайн үзүүлэлттэй байв. Тухайлбал татварын тогтолцоо, зах зээлийн багтаамж, төрийн байгууллагын үйлчилгээнд өгсөн үнэлгээ нийслэл, аймгуудын дундаж үзүүлэлтээс сайн үзүүлэлттэй байна. Хяналт шалгалтын тогтолцоо, газар эзэмшихэд өгсөн

үнэлгээ аймгуудтай ижил, Улаанбаатарынхаас бага зэрэг сайн үнэлгээтэй байв. Харин хууль эрх зүйн орчинд өгсөн үнэлгээ бусад аймгуудын дундаж, нийслэлийнхээс доогуур байв.

Хүснэгт 5 Хууль эрх зүйн орчин

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Хууль, эрх зүйн зохицуулалтын орчин	Ховд	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Хууль, эрх зүйн орчин	-0.57	-0.45	-0.65
Төрийн байгууллагын үйлчилгээ	-0.45	-0.58	-0.75
Хяналт, шалгалтын тогтолцоо	-0.35	-0.33	-0.52
Газар эзэмших	-0.35	-0.32	-0.60
Гаднал худалдаа хийх нөхцөл	-0.33	-0.48	-0.43
Татварын тогтолцоо	-0.27	-0.44	-0.56

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Зах зээлийн орчноос даатгалын үйлчилгээг муу гэж үнэлсэн нь нийслэл, аймгуудын дунджаас нэлээд муу үнэлгээ байв. Бусад үзүүлэлтүүдийн хувьд ч аймаг, нийслэлийн дунджаас бага зэрэг муу үнэлгээтэй байсан бөгөөд муу, боломжийн үнэлгээний хооронд дүгнэгджээ.

Хүснэгт 6 Зах зээлийн орчин

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Зах зээлийн орчин	Ховд	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Даатгалын үйлчилгээ	-0.98	-0.40	-0.37
Шударга өрсөлдөөн	-0.61	-0.40	-0.44
Хэрэглэгчдийн худалдан авах чадвар	-0.51	-0.43	-0.36
Зах зээлийн багтаамж	-0.51	-0.40	-0.37
Технологийн дэвшил	-0.49	-0.33	-0.20

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Дэд бүтцээс зам, тээврийн хөгжилд муу үнэлгээг өгсөн нь нийслэл, аймгийн дунджаас илүү муу үнэлгээг авчээ. Мөн дулаан, ус хангамжинд муу боломжийн үнэлгээний хооронд муу тал руу нь дүгнэсэн бол цахилгаан хангамжийг муу боломжийн үнэлгээний дундуур үнэлсэн байна. Эдгээр нь мөн л бусад аймаг, Улаанбаатарчуудын үнэлгээнээс муу үзүүлэлттэй байлаа. Харин мэдээлэл холбооны хөгжилд харьцангуй боломжийн үнэлгээг түлхүү өгсөн ч мөн л аймгууд, нийслэлийнхнээс доогуур үнэлгээтэй байв.

Хүснэгт 7 Дэд бүтэц

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Дэд бүтцийн байдал	Ховд	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Зам, тээврийн хөгжил	-0.94	-0.55	-0.68
Дулаан, усан хангамж	-0.76	-0.39	-0.25
Цахилгаан хангамж	-0.53	-0.03	-0.10
Мэдээлэл холбооны хөгжил	-0.18	0.31	0.15

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

5. Дотоод орчин

Ховд аймгийн судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчид өөрсдийн дотоод орчиндоо хүндрэлтэй, их хүндрэлтэй үнэлгээг өгсөн нь бусад аймаг,

Дотоод орчин	Ховд	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Хүний нөөцийн удирдлага	-2.20	-1.33	-1.38
Тонот төхөөрөмжийн чанар	-2.20	-1.27	-1.20
Ажилчдын чадвар	-2.18	-1.31	-1.13
Түүхий эдийн чанар	-2.02	-1.13	-1.30

Эх үүсвэр: Монголбанк, ЖЗУ эрхлэгчдийн түгээвэр сүлдсгааны үр дүн

Ховд аймгийнхан зардлын байдалдаа хүндрэлтэй, их хүндрэлтэй үнэлгээг түлхүү өгчээ. Зээлийн хүү, шитгэл хураамж, ажиллах хүч, түрээс, зам тээвэр, зар сурталчилгаа, тоног төрөөрөмжийн зардлуудыг хамгийн их хүндрэлтэй гэж үзсэн байгаа нь бусад аймгууд, нийслэлчүүдийн хандлагатай төстэй байгаагийн зэрэгцээ илүү муу үнэлгээтэй байна. Бусад зардлуудын хувьд ч бусад аймгууд, нийслэлчүүдээс илүү мүү мүү үнэлгээтэй байлаа.

(Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4)

Заралын байдал	Ховд	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Эзэлийн хүүний зардал	-2.63	-1.82	-1.89
Шин пгэл, хураамжийн төлбөр	-2.49	-1.72	-1.78
Ажилдах хүчний өртөг	-2.41	-1.38	-1.41
Түрээсийн зардал	-2.33	-1.48	-1.74
Зам, тээврийн зардал	-2.33	-1.58	-1.62
Зар сурталчилгааны зардал	-2.29	-1.12	-1.57
Тонот төхөөрөмжийн зардал	-2.20	-1.62	-1.62
Харилцаа холбооны зардал	-2.18	-0.93	-1.25
Түүхий эдийн зардал	-2.14	-1.59	-1.62
Дулаан , усны зардал	-2.12	-1.51	-1.49
Эрчим хүч, цахилгааны зардал	-2.12	-1.50	-1.48
Замлалга, үйл ажиллагааны зардал	-2.00	-1.25	-1.42

Нийгмийн орчинд тус аймгийнхан хамгийн муу үнэлгээг өгсөн бөгөөд хамгийн муу үнэлгээг ажилгүйдэл, хээл хахууль, гэмт хэрэг, ядуурал, улс төрийн байдалд өгчээ. Тэдгээрийг их хүндрэлтэй, хүндрэлтэй гэсэн үнэлгээний их хүндрэлтэй тал руу нь үнэлсэн бол мэдээллийн хүртээмж, харилцагчийн ёс суртахуун, хувийн хэвшил иргэдийн оролцоог хүндрэлтэй, их хүндрэлтэй үнэлгээний хооронд хүндрэлтэй үнэлгээг түлхүү өгсөн байна. Үзүүлэлт бүрээр нь авч үзвэл, ажилгүйдэлд өгсөн үнэлгээ Улаанбаатарынхаас бага зэрэг дээгүүр үнэлгээтэй байгаа бол аймгуудынхаас доогуур байв. Бусад бүх үзүүлэлтүүдийн үнэлгээ нийслэл, аймгуудын дундаж үнэлгээнээс муу байлаа.

(Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4)

Нийгмийн орчин	Ховд	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Ажилгүйдэл	-2.69	-2.49	-2.75
Хээл хажууль	-2.61	-2.27	-2.72
Гэмт хэрэг	-2.59	-2.13	-2.67
Ядуурал	-2.55	-2.48	-2.77
Улс төрийн байдал	-2.53	-2.08	-2.46
Мэдээллийн хүртээмж	-2.24	-1.53	-1.78
Харицлагчийн ёс суртахуун	-2.16	-1.65	-2.00
Хувийн хэвшил, иргэдийн оролцоо	-1.94	-1.48	-1.91

Үйл ажиллагаагаа эхлүүлэхдээ анх ямар эх үүсвэрээр санхүүжсэнийг асуухад 41% нь өөрийн хөрөнгөөр, 37% нь банкны зээлээр, 20% нь гэр, бүлийн хамтын хөрөнгөөр, 18% нь найз нөхдийн хамтын хөрөнгөөр, 14% нь хөнгөлөлттэй зээлд хамрагдах замаар санхүүжсэн байна. Бусад аймгууд, Улаанбаатар хоттой харьцуулахад дээрх гол санхүүжилтүүдийн хувийн жин бага, харин найз нөхөд хамтын хөрөнгөөр, ББСБ-ын зээл, гадаадын хөрөнгө оруулалтаар, хувьчлалаар зэрэг хариултуудынх илүү байна.


(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Өнгөрсөн хугацаанд үйл ажиллагаагаа өрөгжүүлэх, шинээр бизнес эрхлэхдээ 45% нь санхүүжилт авч байсан гэж хариулсан нь бусад аймгуудын хариултаас (ихэнх аймгуудын судалгаанд оролцогчдын дийлэнх санхүүжилт авч байсан) ялгаатай байв. Санхүүжилт авч байсан ЖДҮ эрхлэгчдийн 73% нь уг санхүүжилтээ банкнаас авсан байна. Зээлээ эргэн төлөхөд ямар хүндрэл учирч байна вэ гэсэн асуултанд 22% нь зээлийн хүүний төлбөр өндөр, 16% зээлийн хугацаа богино, 6% нь зээлийн хэмжээ бага гэсэн бол 4% нь хүндрэл тулгараагүй гэж хариулсан байна.

Зураг 7 Зээлийн эргэн төлөлтийн бэрхшээл

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Цаашид үйл ажиллагаагаа явуулахад (43%) нь санхүүжилт авах хэрэгцээтэй гэж хариулсан нь бусад аймгуудын хариултаас (ихэнх аймгуудын судалгаанд оролцогчдын дийлэнх цаашид зээл авах шаардлагатай гэж хариулсан) ялгаатай байна. Тэдгээрийн 33% нь 1-5 сая, 29% нь 10-50 сая, 19% нь 50-100 сая, 14% нь 100-500 сая төгрөгийн санхүүжилт шаардлагатай гэжээ. 1-5 сая гэж хариулсан хариултын хувийн жин нь нийслэл, аймгуудын дунджаас нэлээд их, 5-10 сая гэсэн хариулт бага байна.

Зураг 8 Шаардлагатай санхүүжилт

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Дүгнэлт

- Судалгаанд хамрагдсан Ховд аймгийн 49 ЖДҮ эрхлэгчид олон жилийн туршлагатай, цөөн тооны ажиллагсадтай бөгөөд худалдааны чиглэлээр түлхүү үйл ажиллагаа эрхэлдэг гэжээ.
- Түүхий эд материалаа нийслэл, өөрийн аймгаасаа голчлон бэлтгэн, аймагтаа борлуулалтаа хийдэг гэжээ. ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх жилдээ 1-10 сая, 10-50 сая төгрөгийн орлого олдог гэжээ.
- Бусад аймаг, нийслэл хотын судалгааны дүнтэй адил арилжааны банкныг хамгийн их ЖДҮ эрхлэгчдийг дэмждэг гэжээ. Мөн Засгийн газар, орон нутгийн засаг захиргаа, ОУ-ын байгууллага, Худалдаа аж үйлдвэрийн танхим дэмждэг гэж багагүй хувь хариулжээ. Эдгээр байгууллагуудаас санхүүгийн эх үүсвэрийг бий болгосон, дэд бүтцийг сайжруулсан, сургалт зөвлөгөө явуулсан,

технологийн ололт, дэвшлийг нэвтрүүлсэн, тоног төхөөрөмжийг НӨАТ-аас чөлөөлсөн, үзэсгэлэн худалдаа зохион байгуулсан байна.

- Үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, бизнестэй холбоотой шийдвэрт хувийн хэвшил, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, татварын таатай орчинг бүрдүүлэх, хөнгөлөлттэй санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгох, хүртээмжийг нэмэгдүүлэх, дэд бүтцийг сайжруулах, сургалт зөвлөгөөг нэмэгдүүлэх арга хэмжээг нэн түрүүнд авах шаардлагатай гэж үзжээ.

- ЖДҮ хөгжих эдийн засгийн таатай орчин хангалттай бус байна гэж дийлэнх нь бусад аймаг, нийслэлчүүдтэй адил дүгнэсэн байна.

- Бизнесийн орчин бусад аймгуудтай адил ерөнхийдөө сөрөг үнэлгээг өгснөөс гадна хууль эрх зүй, зохицуулалтын орчноос бусад бүлгүүдийн үнэлгээ аймгуудын дундаж үнэлгээнээс ч илүү муу үнэлгээтэй байлаа. Нийгмийн орчин, зардлын байдал, дотоод орчинд хамгийн их сөрөг үнэлгээг өгчээ. Ялангуяа, нийгмийн орчноос ядуурал, ажилгүйдэл, хээл хахууль, гэмт хэрэг, улс төрийн байдал, Зардлын хэсгээс зээлийн хүү, шимтгэл хураамж, ажиллах хүчний өртөг, түрээс, зам тээвэр, зар сурталчилгааны зардлууд, дотоод орчноос хүний нөөцийн удирдлага, тоног төхөөрөмжийн чанар, ажилчдын чадвар хамгийн их хүндрэлтэй муу үнэлгээг авчээ.

- Өөрийн хөрөнгө, банкны зээлээр дийлэнх нь үйл ажиллагаагаа эхлүүлжээ. Мөн гэр бүлийн хамтын хөрөнгө, найз нөхөд хамтын хөрөнгө, ББСБ-ын зээл, гадаадын хөрөнгө оруулалт, хувьчлалаар бизнесээ эхлүүлсэн гэсэн хариултыг бусад аймгуудаас илүү өгсөн байна.

- Үйл ажиллагаагаа өргөжүүлэх, шинээр бизнес эрхлэхэд 45% хувь нь санхүүжилт авсан нь бусад аймгуудаас ялгаатай байв. Ихэнх аймгуудын судалгаанд оролцогчдын дийлэнх санхүүжилт авсан байна.

- Зээлээ эргэн төлөхөд зээлийн үндсэн хэмжээ багаас үйл ажиллагаагаа хүссэн хэмжээнд явуулж чадаагүй, зээлийн хүүний төлбөр өндөр, хугацаа богино байсан нь хамгийн их бэрхшээл учруулдаг гэжээ.

Цаашид үйл ажиллагаагаа явуулахад санхүүжилт шаардлагатай гэж дийлэнх нь хариулсан ба 10-50 сая, 5-10 сая, 50-100 сая төгрөг шаардлагатай гэсэн хариулт давамгайлж байв.

Хөвсгөл аймаг


1. Ерөнхий мэдээлэл

Хөвсгөл аймагт 2011 оны 1 дүгээр улирлын байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа 555⁴⁹ ААН-ээс санамсаргүй түүврийн аргаар 48 жижиг дунд бизнес эрхлэгчийг судалгаанд хамрууллаа. Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 88% нь ХХК, 6% нь иргэд, 2% нь ХК байсан бөгөөд тэдгээрийн 86% нь дотоодын хөрөнгө оруулалттайгаар үйл ажиллагаагаа явуулдаг байна.

Хөвсгөл аймагт судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 46% нь үйлдвэрлэл, 28% нь үйлчилгээ, 24% нь худалдаа эрхэлдэг гэжээ. Дээрх үзүүлэлтүүдийг аймгуудын дундаж үзүүлэлттэй харьцуулбал, үйлдвэрлэл 15 нэгж хувиар илүү, худалдаа болон үйлчилгээ харгалзан 7, 8 нэгж хувиар бага сонгогдсон байна.

Зураг 1 ЖДҮ эрхлэгчдийн үйл ажиллагааны чиглэл

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийг үйл ажиллагаа эрхэлж буй хугацаагаар нь авч үзвэл 36% нь 10-аас дээш жил, 32% нь 5-10 жил, 30% нь 1-5 жил үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд тэдгээрийн 56% нь 10-49, 42% нь 1-9 ажиллагсадтай ЖДҮ-үүд байна.

Хөвсгөл аймгийн хувьд түүвэр судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн давхардсан тоогоор 62% нь нийслэл хотоос, 54% нь үйл ажиллагаа эрхэлж буй аймгаас түүхий эд, материалаа бэлтгэдэг гэж хариуллаа. Тус үзүүлэлтийг аймгуудын дундаж үзүүлэлттэй харьцуулбал, нийслэл хотоос худалдаж авдаг гэсэн хариулт 7 нэгж хувь, үйл ажиллагаа эрхэлж буй аймгаас гэсэн хариулт 9 нэгж хувиар илүү байна. ЖДҮ эрхлэгчдийн 76% нь эцсийн бүтээгдэхүүнээ өөрийн аймагт нийлүүлдэг гэж хариулсан нь бусад аймгийн дунджаас 6 нэгж хувиар бага үзүүлэлттэй байна. Мөн улсын хэмжээ болон нийслэл хотод эцсийн бүтээгдэхүүнээ борлуулдаг гэж хариулсан хариултын хувь 18%-тай байгаа нь бусад аймгуудын дундажтай ойролцоо байна.

Хүснэгт 1 Түүхий эд материалын бэлтгэл, бараа бүтээгдэхүүний борлуулалт

(Бусад аймаг болон УБ хоттой харьцуулсан дүн, давхардсан тоогоор, хувь)

Байршил	Түүхий эд бэлтгэл			Борлуулалт		
	Хөвсгөл	Аймгууд	УБ	Хөвсгөл	Аймгууд	УБ
Нийслэл хот	62	55	73	12	9	76
Үйл ажиллагаа эрхэлж бу	54	45	5	76	82	5
Бусад аймаг	4	8	6	14	13	4
Гадаад улс	30	27	30	0	3	5
Улсын хэмжээнд				4	6	19

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Хөвсгөл аймгийн судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 28% нь 10-50 сая, 22% нь 50-100 сая, 18% нь 1-10 сая төгрөгийн жилийн борлуулалтын орлоготой гэж хариуллаа. Үүнийг бусад аймгуудын дундаж үзүүлэлттэй харьцуулахад 10-50 сая төгрөгийн жилийн борлуулалтын орлоготой гэсэн хариулт бусад аймгуудын дундажтай ижил түвшинд, 50-100 сая төгрөг гэсэн хариултын хувь 9 нэгж хувиар илүү, 1-10 сая гэсэн хариулт 12 нэгж хувиар бага үзүүлэлттэй байна.

Зураг 2 ЖДҮ эрхлэгчдийн жилийн борлуулалтын орлого

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Түүвэр судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 90% нь тайлан тэнцэл гаргадаг гэсэн хариулт өгсөн нь аймгуудын дунджаас 25 нэгж хувь, Улаанбаатар хотынхоос 20 нэгж хувиар тус тус илүү байна.


2. ЖДҮ-ийг дэмжих бодлогын арга хэмжээ

ЖДҮ эрхлэгчдийн бизнесийг хамгийн их дэмждэг байгууллагыг нэрлэнэ үү гэсэн асуултанд арилжааны банк (68%), засгийн газар (22%), орон нутгийн засаг захиргаа (22%), олон улсын байгууллагууд (8%), зөвлөгөө өгдөг, байгууллага, төвүүд (6%), төрийн бус байгууллагууд (6%) гэж хариулжээ. Уг үзүүлэлтийн үр дүнг аймгуудын дундаж үзүүлэлттэй харьцуулахад арилжааны банкууд дэмждэг гэсэн хариулт 5 нэгж хувиар их, засгийн газар, ОУ-ын байгууллага, төрийн бус байгууллагууд дэмждэг гэсэн хариулт харгалзан 2, 4, 2 нэгж хувиар тус тус бага байна.

⁴⁹ Бизнес регистрийн санд бүртгэлтэй

Зураг 3 ЖДҮ эрхлэгчдийг хамгийн ихээр дэмждэг байгууллага

(Санал асуулгад оролцогчдын эзтх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Дэмжлэг үзүүлсэн байгууллагуудаас санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгосон (52%), эрх зүйн таатай орчин бүрдүүлсэн (12%), татварыг хөнгөлсөн (10%), үзэсгэлэн худалдаа зохион байгуулсан байгуулсан (26%) гэжээ.

Зураг 4 ЖДҮ-д ямар дэмжлэг үзүүлсэн

(Санал асуулгад оролцогчдын эзтх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

ЖДҮ-ийг хөгжүүлэхэд төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох, авилгалыг бууруулах, татварын таатай орчинг бүрдүүлэх, бизнестэй холбоотой шийдвэрт хувийн хэвшил, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгох, сургалт зөвлөгөөг нэмэгдүүлэх арга хэмжээг нэн түрүүнд авах шаардлагатай гэж үзжээ.

Зураг 5 Цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ

(Санал асуулгад оролцогчдын эзтх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

3. Макро эдийн засгийн орчин

Эдийн засгийн таатай орчин бүрдсэн эсэх талаар асуухад санал асуулгад оролцогчдын 82% нь хангалттай бус, 8% нь огт бүрдээгүй, 2% нь бүрдсэн гэж үзжээ.

Хүснэгт 2 ЖДҮ хөгжих эдийн засгийн таатай орчин бүрдсэн эсэх

(Бусад аймаг болон УБ хөттэй харьцуулсан дүн, давхардсан тоогоор, хувь)

ЖДҮ хөгжих орчин	Хөвсгөл	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Бүрдсэн	2	10	8
Хангалттай бус	82	71	61
Огт бүрдээгүй	8	12	23
Мэдэхгүй	6	6	9

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Харин эдийн засгийн өсөлт ЖДҮ эрхлэгчдийн бизнест хэрхэн нөлөөлж байгаа эсэхийг асуухад 44% нь эергээр, 16% нь сөргөөр нөлөөлсөн, 22% нь нөлөөлөөгүй гэж хариулжээ. Аймгуудын дундажтай харьцуулахад ЭЗ-ийн өсөлт өөрсдийн бизнест эергээр нөлөөлсөн гэсэн хариулт 6 нэгж хувиар их байлаа.

Хүснэгт 3 ЖДҮ хөгжилд эдийн засгийн өсөлтийн үзүүлж буй нөлөө

(Бусад аймаг болон УБ хөттэй харьцуулсан дүн, давхардсан тоогоор, хувь)

Эдийн засгийн өсөлт танай бизнест	Хөвсгөл	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Эергээр	44	38	18
Сөргөөр	16	22	43
Нөлөөлөөгүй	22	19	21
Мэдэхгүй	12	16	18

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Санал асуулгад оролцогчдын дийлэнх хувь нь бусад аймгуудын адил инфляци болон төгрөгийн ханш тогтвортой байвал эрхэлж буй бизнест нь сайн гэж үзсэн байна.

4. Бизнесийн орчин

Хөвсгөл аймгийн судалгаанд оролцсон ЖДҮ эрхлэгчдийн бизнесийн орчин бусад аймгуудтай ижил сөрөг үнэлгээг өгчээ.

Санхүүжилтийн орчинг боломжийн муу гэсэн үнэлгээний хооронд дүгнэсэн нь бусад аймгуудын хандлагатай ижил байлаа. ЗГ-ын болон ОУ-ын байгууллагын хөнгөлөлттэй зээлийн олдоц муу гэж бусад аймаг, нийслэлчүүдийн адил үзжээ. Санхүүжилтийн хүү, хугацаа, хөрөнгийн зах зээлээс санхүүжилт авах, санхүүжилтийн хэмжээнд муу боломжийн үнэлгээний дундуур үнэлгээг өгсөн бол бусад үзүүлэлтүүдэд боломжийн үнэлгээг илүү өгсөн байна.

Хүснэгт 4 Санхүүжилтийн орчин

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Санхүүжилтийн орчин	Хөвсгөл	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн олдоц	-1.08	-0.93	-1.01
Олон улсын байгууллагын хөнгөлөлттэй зээлийн о	-1.04	-1.01	-1.02
Санхүүжилтийн хүү	-0.72	-0.63	-0.67
Санхүүжилтийн хугацаа	-0.62	-0.53	-0.57
Хөрөнгийн зах зээлээс санхүүжилт авах	-0.58	-0.55	-0.61
Санхүүжилтийн хэмжээ	-0.56	-0.47	-0.51
Банк санхүүгийн байгууллагын зээл	-0.28	-0.33	-0.48
Өөрийн хөрөнгийн хүрэлцээ	-0.24	-0.40	-0.43
Санхүүжилтийн барьцаа хөрөнгө	-0.20	-0.42	-0.56
Зээл олгох үйл ажиллагаа	-0.12	-0.18	-0.53
Зээлийн батлан даалт	-0.08	-0.30	-0.49
Банкны зээл	0.10	0.02	-0.49

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Хууль, эрх зүйн зохицуулалтын орчинг мөн боломжийн муу гэсэн үнэлгээний хооронд дүгнэжээ. Эдгээрээс төрийн байгууллагуудын үйлчилгээнд муу үнэлгээг түлхүү өгсөн нь аймгуудын дунджаас бага зэрэг доогуур үнэлгээ байлаа. Бусад үзүүлэлтүүдэд боломжийн муу үнэлгээний хооронд дүгнэсэн ба татварын тогтолцоо, газар эзэмших, хяналт шалгалтын тогтолцоонд боломжийн үнэлгээг түлхүү өгчээ. Бусад аймгуудын үнэлгээний хандлага ойролцоо байв.

Хүснэгт 5 Хууль эрх зүйн орчин

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Хууль, эрх зүйн зохицуулалтын орчин	Хөвсгөл	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Төрийн байгууллагын үйлчилгээ	-0.70	-0.58	-0.75
Хууль, эрх зүйн орчин	-0.52	-0.45	-0.65
Гадаад худалдаа хийх нөхцөл	-0.50	-0.48	-0.43
Татварын тогтолцоо	-0.36	-0.44	-0.56
Газар эзэмших	-0.30	-0.32	-0.60
Хяналт, шалгалтын тогтолцоо	-0.30	-0.33	-0.52

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Зах зээлийн орчинд ерөнхийдөө боломжийн үнэлгээг түлхүү өгсөн байна. Шударга өрсөлдөөнийг муу боломжийн үнэлгээний дунджаар үнэлсэн нь бусад аймаг, нийслэлийн үнэлгээнээс бага зэрэг доогуур байв. Бусад үзүүлэлтүүдэд боломжийн үнэлгээг түлхүү өгсөн нь аймгууд, Улаанбаатарчуудтай ойролцоо байв.

Хүснэгт 6 Зах зээлийн орчин

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Зах зээлийн орчин	Хөвсгөл	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Шударга өрсөлдөөн	-0.54	-0.40	-0.44
Хэрэглэгчдийн худалдан авах чадвар	-0.44	-0.43	-0.36
Даатгалын үйлчилгээ	-0.40	-0.40	-0.37
Технологийн дэвшил	-0.36	-0.33	-0.20
Зах зээлийн багтаамж	-0.20	-0.40	-0.37

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Дэд бүтцийн талаар асуухад зам, тээврийн хөгжил, дулаан, усан хангамжинд өгсөн үнэлгээ муу тал руугаа байсан нь аймаг, нийслэлийнхээс доогуур үзүүлэлттэй байв. Харин мэдээлэл холбоо, цахилгаан хангамжийг боломжийн гэж дүгнэсэн нь аймаг, нийслэлтэй ижил байлаа.

Хүснэгт 7 Дэд бүтэц

(Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2)

Дэд бүтцийн байдал	Хөвсгөл	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Зам, тээврийн хөгжил	-0.88	-0.55	-0.68
Дулаан, усан хангамж	-0.70	-0.39	-0.25
Цахилгаан хангамж	0.10	-0.03	-0.10
Мэдээлэл холбооны хөгжил	0.30	0.31	0.15

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

5. Дотоод орчин

Хөвсгөл аймгийн ЖДҮ эрхлэгчид өөрсдийн дотоод орчинг ерөнхийдөө бага хүндрэлтэй гэж үзсэн нь аймаг, нийслэлийнхний үнэлгээтэй төстэй байв. Тоног төхөөрөмж, түүхий эдийн чанар, ажилчдын чадвар нь арай илүү хүндрэлтэй, хүний нөөцийн удирдлагыг арай бага хүндрэлтэй гэж хариулжээ.

Хүснэгт 8 Дотоод орчин

(Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4)

Дотоод орчин	Хөвсгөл	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Тоног төхөөрөмжийн чанар	-1.22	-1.27	-1.20
Түүхий эдийн чанар	-1.18	-1.13	-1.30
Ажилчдын чадвар	-1.18	-1.31	-1.13
Хүний нөөцийн удирдлага	-0.96	-1.33	-1.38

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

6. Зардлын байдал

Зээлийн хүү, шитгэл хураамж, ажиллах хүч, түрээс, зам тээвэрт, тоног төрөөрөмжинд зардал их гаргадаг гэж хариулжээ. Хөвсгөл аймгийн судалгаанд

хамрагдсан ЖДҮ эрхлэгчид зардлуудад ерөнхийд нь бага хүндрэлтэй, хүндрэлгүй гэсэн үнэлгээг өгчээ. Хамгийн хүндрэлтэй зардлуудад шимтгэл хураамжийн төлбөр, түрээс, тоног төхөөрөмж, зам тээврийн, түүхий эдийн, ажиллах хүчний зардлуудыг оруулсан нь бусад аймгууд, Улаанбаатар хотынхны хандлагатай ерөнхийдөө ижил байна. Харин дулаан усны, зээлийн хүүний, захиргаа үйл ажиллагааны, зар сурталчилгааны, харилцаа холбооны, зардал аймгуудын дундаж, Улаанбаатарынхаас бага хүндрэлтэй гэсэн үнэлгээг авсан бол эрчим хүч, цахилгааны зардлыг хүндрэлгүй гэжээ.

Хүснэгт 9 Зардлын байдал

(Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4)

Зардлын байдал	Хөвсгөл	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Шимтгэл, хураамжийн төлбөр	-1.08	-0.93	-1.01
Түрээсийн зардал	-1.04	-1.01	-1.02
Тоног төхөөрөмжийн зардал	-0.72	-0.63	-0.67
Зам, тээврийн зардал	-0.62	-0.53	-0.57
Түүхий эдийн зардал	-0.58	-0.55	-0.61
Ажиллах хүчний өртөг	-0.56	-0.47	-0.51
Дулаан, усны зардал	-0.28	-0.33	-0.48
Зээлийн хүүний зардал	-0.24	-0.40	-0.43
Захиргаа, үйл ажиллагааны зардал	-0.20	-0.42	-0.56
Зар сурталчилгааны зардал	-0.12	-0.18	-0.53
Харилцаа холбооны зардал	-0.08	-0.30	-0.49
Эрчим хүч, цахилгааны зардал	0.10	0.02	-0.49

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

7. Нийгмийн орчин

Тус аймгынхны хамгийн ихээр сөрөг үнэлгээ өгсөн хэсэгт нийгмийн орчин орж байгаа ба үүнээс ажилгүйдэл, ядууралд их хүндрэлтэй гэсэн хариултыг түлхүү өгсөн нь аймгуудын дундажтай ойролцоо, Улаанбаатарынхнаас бага зэрэг дээгүүр үзүүлэлттэй байна. Мөн хээл хахууль, гэмт хэрэг, улс төрийн байдалд хүндрэлтэй гэсэн үнэлгээг өгсөн нь бусад аймгуудтай адил, Улаанбаатарынхнаас дээгүүр байна.

Хүснэгт 10 Нийгмийн орчин

(Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4)

Нийгмийн орчин	Хөвсгөл	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Ажилгүйдэл	-2.56	-2.49	-2.75
Ядуурал	-2.50	-2.48	-2.77
Хээл хахууль	-2.24	-2.27	-2.72
Гэмт хэрэг	-2.12	-2.13	-2.67
Улс төрийн байдал	-2.04	-2.08	-2.46
Харилцагчийн ёс суртахуун	-1.64	-1.65	-2.00
Хувийн хэвшил, иргэдийн оролцоо	-1.60	-1.48	-1.91
Мэдээллийн хүртээмж	-1.38	-1.53	-1.78

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн


8. Санхүүжилт

Үйл ажиллагаагаа эхлүүлэхдээ анх ямар эх үүсвэрээр санхүүжсэнийг асуухад 80% нь өөрийн хөрөнгөөр, 42% нь банкны зээлээр, 34% нь гэр, бүл найз нөхдийн хөрөнгөөр, 10% нь найз нөхдийн хамтын

хөрөнгөөр, 6% нь хөнгөлөлттэй зээлд хамрагдах замаар санхүүжсэн байна. Бусад аймгуудтай харьцуулбал өөрийн хөрөнгө, гэр бүлийн хамтын хөрөнгөөр санхүүжсэн байдал илүү, банкны зээлээр санхүүжсэн нь ойролцоо байв.

Зураг 6 Анхдагч санхүүжилт

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Өнгөрсөн хугацаанд үйл ажиллагаагаа өрөгжүүлэх, шинээр бизнес эрхлэхдээ 72% нь зээлд хамрагдаж байсан ба тэдгээрийн дийлэнх (80%) нь банкны зээл авсан гэжээ. Зээлээ эргэн төлөхөд ямар хүндрэл учирч байна вэ гэсэн асуултанд 50% нь зээлийн хүүний төлбөр өндөр, 40% зээлийн хугацаа богино, 26% нь зээлийн хэмжээ бага гэсэн бол 14% нь хүндрэл тулгараагүй гэж хариулсан байна.

Зураг 7 Зээлийн эргэн төлөлтийн бэрхшээл

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Цаашид үйл ажиллагаагаа явуулахад (82%) нь санхүүжилт авах хэрэгцээтэй гэжээ. Тэдгээрийн 30% нь 50-100 сая, 22% нь 10-50 сая, 16% нь 100-500 сая төгрөгийн санхүүжилт шаардлагатай гэжээ. 50-100 сая гэж хариулсан хариултын хувийн жин нь бусад аймгуудын дунджаас нилээд их, 10-50 сая гэсэн хариулт аймгуудын дунджаас бага байна.

Зураг 8 Шаардлагатай санхүүжилт

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Дүгнэлт

- Судалгаанд хамрагдсан Хөвсгөл аймгийн 48 ЖДҮ эрхлэгчид олон жилийн туршлагатай, цөөн тооны ажиллагсадтай бөгөөд үйлдвэрлэлийн чиглэлээр түлхүү үйл ажиллагаа эрхэлдэг. Түүхий эд материалаа нийслэл, өөрийн аймгаасаа голчлон бэлтгэн, аймагтаа борлуулалтаа хийдэг гэжээ.
- Борлуулалтын жилийн орлогоороо бусад аймгуудын дундаж орлогоос өндөр байгаа бөгөөд 10-50 сая, 50-100 сая, 1-10 сая гэж дийлэнх нь хариулжээ. Судалгаанд оролцогчдын 90% нь тайлан тэнцэл гаргадаг гэж хариулсан аймаг нийслэлтэй харьцуулахад нэлээд өндөр үзүүлэлттэй байна.
- Бусад аймгууд, нийслэл хотын судалгааны дүнтэй адил арилжааны банкны хамгийн их ЖДҮ эрхлэгчдийг дэмждэг гэжээ. Мөн Засгийн газар, орон нутгийн засаг захиргааг дэмжлэг үзүүлдэг гэсэн хариулт бусад хариултаас илүү байв. Эдгээр байгууллагуудаас санхүүгийн эх үүсвэрийг бий болгосон, үзэсгэлэн худалдаа зохион байгуулсан байна.
- Төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох, хувийн хэвшил, олон нийтийн оролцоог бизнесийн шийдвэр гаргалтанд нэмэгдүүлэх, татварын таатай орчинг бүрдүүлэх, санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгох, авлигыг бууруулах, үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх арга хэмжээг нэн түрүүнд авах шаардлагатай гэж үзжээ.
- Бусад аймаг, нийслэлчүүдийн адил ЖДҮ хөгжих эдийн засгийн таатай орчин хангалттай бус байна гэж дийлэнх нь дүгнэсэн байна. Мөн инфляци, ханш тогтвортой байх нь бизнест нь сайн гэж үзжээ.
- Бизнесийн орчинд Хөвсгөл аймгийн ЖДҮ эрхлэгчид ерөнхийдөө сөрөг үнэлгээг өгсөн бөгөөд аймгуудын дундажтай харьцуулахад ойролцоо үзүүлэлттэй байв. Харин зардлын байдалд өгсөн үнэлгээ аймгуудын дунджаас бага зэрэг сайн үзүүлэлттэй байлаа. Хамгийн их сөрөг үнэлгээ өгсөн хэсэгт нийгмийн орчин бөгөөд үүнээс ажилгүйдэл, ядуурлыг их хүндрэлтэй гэж үзжээ. Харин мэдээлэл, холбооны хөгжил, цахилгаан хангамж, банкны зээл,

зээлийн батлан даалт, эрчим хүч цахилгаан, харилцаа холбооны зардал хүндрэлгүй, боломжийн гэсэн үнэлгээг авчээ.

- Өөрийн хөрөнгөөр дийлэнх нь үйл ажиллагаагаа эхлүүлсэн бөгөөд бусад аймгуудын уг хариултаас нэлээд их хувьтай байв. Мөн банкны зээл, гэр бүлийн хамтын хөрөнгөөр багагүй хувь нь бизнесээ эхлүүлсэн гэжээ.
- Үйл ажиллагаагаа өргөжүүлэх, шинээр бизнес эрхлэхэд дийлэнх нь банкны зээл авсан бөгөөд зээлээ эргэн төлөхөд зээлийн хүүний төлбөр өндөр, хугацаа богино байсан нь хамгийн их бэрхшээл болдог гэжээ. Цаашид үйл ажиллагаагаа явуулахад санхүүжилт шаардлагатай гэж дийлэнх нь хариулсан ба бусад аймаг, Улаанбаатарынхаас шаардлагатай санхүүжилтийн хэмжээ нь өндөр байв.

Хэнтий аймаг


1. Ерөнхий мэдээлэл

Хэнтий аймаг 80.3 мянган км² нутаг дэвсгэртэй, Дорнод, Сүхбаатар, Дорноговь, Говьсүмбэр, Төв, Сэлэнгэ аймагтай, хойд талаараа ОХУ-тай хиллэдэг. Хэнтий аймаг 67.7 мянган хүн амтай. Тус аймгийн төв Өндөрхаан хот нь улсын нийслэл Улаанбаатараас 330 км алслагдсан. Хэнтий аймагт газар тариалан хөгжсөн, жилдээ 247.5 мянган га тариалангийн талбайгаас нэг мянган тонн үр тариа хураан авдаг. 2010 онд аймгийн ДНБ 54.8 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 92.7 сая төгрөгөөр өсч, нэг хүнд ногдох ДНБ /2000 оны зэрэгцүүлэх үнээр/ 781.3 мянган төгрөгт хүрчээ.

Хэнтий аймагт 2011 оны 1 дүгээр улирлын байдлаар 594⁵⁰ ААН үйл ажиллагаа эрхэлж байгаагаас 17 хувиараа аж ахуй эрхлэгч, 25 ХХК, 2 ХК, 2 нөхөрлөл, 1 хоршоо, 2 бусад буюу нийт 51 ЖДҮ санал асуулгад оролцлоо. Тэдгээр ЖДҮ эрхлэгчдийн 78% нь дотоодын хөрөнгө оруулалттай байв. Санал асуулгад оролцсон ЖДҮ эрхлэгчдийн үйл ажиллагааны чиглэл нь бусад орон нутгаас эрс ялгаатай байна. Олон аймгууд, түүнээс гадна Орос улстай хиллэдэг онцлог байдал нь худалдаа, үйлчилгээний салбарыг түлхүү хөгжүүлсэн байх үндэслэлтэй юм.

Зураг 1 ЖДҮ эрхлэгчдийн үйл ажиллагааны чиглэл

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Хэнтий аймагт үйл ажиллагаа явуулж буй ЖДҮ-ийн 92.2% нь аймагтаа бараа, бүтээгдэхүүн борлуулдаг. ОН-ын дундаж үзүүлэлтээс энэ нь 10 гаруй нэгж хувиар илүү үзүүлэлт юм.

Зураг 2 Түүхий эд материалын борлуулалт

(Бусад аймаг болон УБ хоттой харьцуулсан дүн, давхардсан тоогоор, хувь)



50 Бизнес регистрийн санд бүртгэлтэй


Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Тус аймагт үйл ажиллагаа явуулж байгаа ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх нь (74.5%) 1-9 ажилтантай жилийн 1-10 сая (31.4%) төгрөгийн борлуулалтын орлоготой байна.

Хэнтий аймгийн бизнесийн үйл ажиллагааг бусад аймаг, хотуудтай харьцуулахад харьцангуй хараат байна. Бараа үйлчилгээний түүхий эд, материалын дийлэнх буюу 68.6 хувийг нийслэлээс татдаг гэж хариулжээ.

Зураг 3 ЖДҮ эрхлэгчдийн түүхий эдийн таталт

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн


Тус аймгаас санал асуулгад оролцсон ЖДҮ эрхлэгчдийн 54.9% нь тайлан тэнцэл гаргадаг байна.

2. ЖДҮ-ийг дэмжих бодлогын арга хэмжээ

ЖДҮ эрхлэгчдийг хамгийн сайн дэмждэг байгууллагыг арилжааны банкууд, харин орон нутгийн засаг захиргаа, засгийн газар, үйлдвэр эрхлэгчдийн холбоо зэргийг тодорхой хэмжээнд дэмждэг хэмээн Хэнтийгийнхэн нэрлэжээ. Үйлдвэр эрхлэгчдийн холбоо 16 хувьтай байгаа хотоос 10 нэгж хувь, ОН-ын дунджаас 11 нэгж хувиар их байна.

Зураг 4 ЖДҮ эрхлэгчдийг хамгийн ихээр дэмждэг байгууллага

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Дээрх ЖДҮ-ийг дэмждэг байгууллагуудын туслалцааны дийлэнх нь эх үүсвэрийг бий болгосон гэж хариулжээ. Тус хариулт нь хотынхоос 18 нэгжээр илүү, орон нутгийн дунджаас 13 нэгж хувиар дутуу байна. Эндээс, Хэтий аймгаас санал асуулгад оролцсон ЖДҮ-ийн 45 орчим% нь их бага тодорхой хэмжээгээр санхүүжилтэнд хамрагдсан гэх дүгнэлтийг гаргаж болохоор байна. Оролцогчдын зөвхөн 14% нь дэмжлэг үзүүлдэггүй гэж хариулсан нь Улаанбаатараас 27 нэгж хувиар бага үзүүлэлт юм.

Зураг 5 ЖДҮ-д ямар дэмжлэг үзүүлсэн

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Цаашид төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох, үндэсний үйлдвэрлэл дэмжих, авилгалыг бууруулах, эх үүсвэр бий болгох зэрэг арга хэмжээнүүдийг нэн түрүүн авбал зохистой гэж Хэнтий аймгийнхан хариулжээ. Төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох асуудал хамгийн их буюу 49 хувийн санал авчээ. Харин Үндэсний үйлдвэрлэл дэмжих 43%, авилгалыг бууруулах, эх үүсвэрийг бий болгох хариултууд тус бүр 41 хувийн санал авсан байна.

Зураг 6 Цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

3. Макро эдийн засгийн орчин

ЖДҮ-ийн хөгжүүлэх эдийн засгийн орчинг сайжруулах шаардлагатай гэдэг нь ЖДҮ эрхлэгчид нийтлэгээр түгсэн ойлголт. Тэр дундаа Хэнтийд бусдаас илүү түгжээ. Хангалттай бус, огт бүрэлдээгүй гэсэн хариултуудын нийлбэр 90 орчим% байгаа нь Улаанбаатар ба ОН-ын дунджийн аль алинаас нь олон хувиар давсан хариулт байв.

Зураг 7 ЖДҮ хөгжих эдийн засгийн таатай орчин бүрдсэн эсэх

(Бусад аймаг болон УБ хоттой харьцуулсан дүн, давхардсан тоогоор, хувь)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Эдийн засгийн өсөлтийн ЖДҮ-т үзүүлж буй нөлөө сөрөг гэх хандлага Хэнтийд аймагт зонхилж байгаа бол тус хариултаас бага хувьтайгаар эерэгээр, мэдэхгүй гэх хариултыг ижил түвшинд өгчээ. Бусад аймгуудад эдийн засгийн өсөлтийг сайшаах хандлага байсан бол Хэнтийгийнхэн сөрөг гэж үзсэнээр бусдаас онцлог юм.

Зураг 8 ЖДҮ хөгжилд эдийн засгийн өсөлтийн үзүүлж буй нөлөө

(Бусад аймаг болон УБ хоттой харьцуулсан дүн, давхардсан тоогоор, хувь)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Инфляци, валютын ханш зэрэг эдийн засгийн үндсэн хүчин зүйлс тогтвортой байх нь эрхэлж буй бизнестээ сайн гэж үзсэн байна.

4. Бизнесийн орчин

Хууль эрх, зүйн зохицуулалтын орчинд хамааралтай хүчин зүйлсүүд ерөнхийдөө боломжийн ба муу гэсэн үнэлгээний дунд хэлбэлзэж байна. Хэнтий аймагт

хяналт, шалгалтын тогтолцоо боломжийн түвшинд үнэлэгдэж байгаа бол төрийн байгууллагын үйлчилгээ бусдаас муу гэсэн үнэлгээг авчээ.

Хүснэгт 1 Хууль эрх зүйн орчин			
Хууль, эрх зүйн зохицуулалтын орчин	Хэнтий	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Төрийн байгууллагын үйлчилгээ	-0.63	-0.75	-0.57
Хууль, эрх зүйн орчин	-0.47	-0.65	-0.44
Татварын тогтолцоо	-0.45	-0.56	-0.43
Гадаад худалдаа хийх нөхцөл	-0.41	-0.43	-0.48
Газар эзэмших	-0.33	-0.60	-0.31
Хяналт, шалгалтын тогтолцоо	-0.29	-0.52	-0.32
Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2			
Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн			

Хэнтийгийн зам, тээвэр бусад аймгаас харьцангуй сайн хөгжсөн учраас дулаан, ус хангамжаас бусад бүх дэд бүтцийн ангилалууд боломжийн гэсэн үнэлгээг өгчээ.

Хүснэгт 2 Дэд бүтэц			
Дэд бүтцийн байдал	Хэнтий	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Дулаан, усан хангамж	-0.35	-0.25	-0.40
Цахилгаан хангамж	-0.04	-0.10	-0.02
Зам, тээврийн хөгжил	0.04	-0.68	-0.54
Мэдээлэл холбооны хөгжил	0.08	0.15	0.32
Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2, жигнэж гаргасан			
Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн			

Зээл олгох үйл ажиллагаа, ББСБ-ын зээл, зээлийн хугацаа, өөрийн хөрөнгийн хүрэлцээ зэргийг муу хэмээн Хэнтий аймгийн ЖДҮ эрхлэгчид дүгнэжээ. Харин зээлийн батлан даалт, санхүүжилтийн хэмжээ, хөрөнгийн зах зээлээс санхүүжилт авах, банкны зээл зэргийг боломжийн гэж хариулсан байна. Эдгээр хариулт нь Улаанбаатар ба ОН дундажтай төстэй байна.

Хүснэгт 3 Санхүүжилтийн орчин			
Санхүүжилтийн орчин	Хэнтий	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Зээл олгох үйл ажиллагаа	-1.06	-0.53	-0.16
ББСБ-ын зээл	-1.04	-0.48	-0.32
Санхүүжилтийн хугацаа	-0.53	-0.57	-0.52
Өөрийн хөрөнгийн хүрэлцээ	-0.53	-0.43	-0.40
ЗГ-ын хөнгөлөлттэй зээлийн олдоц	-0.47	-1.01	-0.93
Банкны зээл	-0.43	-0.49	0.04
Санхүүжилтийн барьцаа хөрөнгө	-0.39	-0.56	-0.41
Санхүүжилтийн хэмжээ	-0.37	-0.51	-0.47
Санхилтын хүү	-0.33	-0.67	-0.63
ОУБ-ын хөнгөлөлттэй зээлийн олдоц	-0.31	-1.02	-1.01
ХЗЗ-ээс санхүүжилт авах	-0.18	-0.61	-0.55
Зээлийн батлан даалт	0.00	-0.49	-0.29
Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2			
Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн			

Зах зээлийн орчны талаар Хэнтий аймгийнхан бусдаас муу үнэлгээг түлхүү өгчээ. Даатгалын үйлчилгээг боломжийн түвшинд байна гэж хариулсан бол худалдан авах чадвар, технологийн дэвшил, шударга өрсөлдөөнийг муу түвшинд байна гэж дүгнэжээ.

Хүснэгт 4 Зах зээлийн орчин			
Зах зээлийн орчин	Хэнтий	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Технологийн дэвшил	-0.59	-0.20	-0.34
Шударга өрсөлдөөн	-0.59	-0.44	-0.40
Хэрэглэгчдийн худалдан авах чадвар	-0.53	-0.36	-0.43
Зах зээлийн багтаамж	-0.49	-0.37	-0.40
Даатгалын үйлчилгээ	-0.22	-0.37	-0.40
Боломжийн=0, маш муу=-2, муу=-1, сайн=1, маш сайн=2, жигнэж гаргасан			
Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн			

5. Дотоод орчин

Дотоод орчны талаар дорвитой арга хэмжээ авах болсон хэмээн Хэнтий аймгийнхан үзэж байна. Тоног төхөөрөмжийн чанар, хүний нөөцийн удирдлагыг маш муу, ажилчдын ур чадвар, түүхий эдийн чанарыг муу хэмээн дүгнэжээ.

Хүснэгт 5 Дотоод орчин			
Дотоод орчин	Хэнтий	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Тоног төхөөрөмжийн чанар	-1.88	-1.20	-1.28
Хүний нөөцийн удирдлага	-1.63	-1.38	-1.33
Ажилчдын чадвар	-1.49	-1.13	-1.31
Түүхий эдийн чанар	-1.37	-1.30	-1.12
Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4			
Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн			

6. Зардлын байдал

Хэнтий аймгийнхан тоног төхөөрөмж, ажиллах хүчний зардлыг их хүндрэлтэй зардлуудаар нэрлэсэн байна. Түүний араас захиргаа, үйл ажиллагаа, түүхий эд, шимтгэл хураамж, зар сурталчилгаа зэрэг зардлуудыг оруулсан байна. Харин хүндрэл багатай зардлуудад зам тээвэр, холбоо зэргийг нэрлэсэн байна.

Хүснэгт 6 Зардлын байдал			
Зардлын байдал	Хэнтий	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Тоног төхөөрөмжийн зардал	-1.90	-1.62	-1.62
Ажиллах хүчний өртөг	-1.80	-1.41	-1.37
Зээлийн хүний зардал	-1.78	-1.89	-1.82
Түүхий эдийн зардал	-1.73	-1.62	-1.59
Шимтгэл, хураамжийн төлбөр	-1.71	-1.78	-1.71
Эрчим хүч, захилааны зардал	-1.67	-1.48	-1.50
Түрээсийн зардал	-1.63	-1.74	-1.47
Дулаан, усны зардал	-1.59	-1.49	-1.51
Зар сурталчилгааны зардал	-1.47	-1.57	-1.10
Захиргаа, үйл ажил-ны зардал	-1.43	-1.42	-1.24
Зам, тээврийн зардал	-1.37	-1.62	-1.58
Харилцаа холбооны зардал	-1.08	-1.25	-0.92
Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4			
Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн			

7. Нийгмийн орчин

Нийгмийн орчин нь бусад бүлгүүдээс хамгийн муу үнэлгээтэйгээр дүгнэгдсэн. Харилцагчийн ёс суртахуун, хувийн хэвшлийн оролцоо, мэдээллийн хүртээмжийн талаарх асуултууд их хүндрэлтэй гэсэн хариултыг авсан бол бусад нь маш их хүндрэлтэй гэсэн үнэлгээг авчээ. Зөвхөн Хэнтийд ч биш Улаанбаатар, бусад орон нутгууд нийгмийн орчинд муу үнэлгээг өгчээ.

Хүснэгт 7 Нийгмийн орчин

Нийгмийн орчин	Хэнтий	Аймгуудын дундаж	Улаанбаатар
Ажилгүйдэл	-2.76	-2.75	-2.49
Ядуурал	-2.65	-2.77	-2.48
Хээл хатууль	-2.37	-2.72	-2.27
Гэмт хэрэг	-2.31	-2.67	-2.13
Улс төрийн байдал	-2.18	-2.46	-2.08
Хариуцагчийн ёс сурт.	-1.75	-2.00	-1.65
Мэдээллийн хүртээмж	-1.57	-1.78	-1.53
ХХэвшил, иргэд оролцоо	-1.55	-1.91	-1.48

Хүндрэлгүй=0, бага хүндрэлтэй=-1, хүндрэлтэй=-2, их хүндрэлтэй=-3, маш их хүндрэлтэй=-4


Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

8. Санхүүжилт

Хэнтий аймгийн дийлэнх ЖДҮ банкны зээлээр гараагаа эхэлсэн гэж хариулжээ. Улаанбаатар ба бусад аймгууд харин өөрийн хөрөнгөөр ихэвчлэн эхэлсэн үзүүлэлттэй байна. Хэнтий аймгийн хувьд үүнээс гадна өөрийн хөрөнгөөр эхэлсэн тохиолдол бага бус (49%) үзүүлэлттэй байна.

Зураг 9 Анхдагч санхүүжилт

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Зээлийн өргөжилт хийх төлөвлөгөөтэй байгаа ЖДҮ эрхлэгчид 76.5 хувьтай байна. Өөрөөр хэлбэл Хэнтий аймагт ЖДҮ эрхлэгчдэд зах зээлийн орон зай байгааг ийнхүү харуулж байна.

Зураг 10 Дахин санхүүжилт

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Харин өргөжих санхүүгийн эх үүсвэрийг банкны зээлээс бий болгоно гэж санал асуулгад оролцогчдын 47.1% хариулжээ. Харин зээл авахад хамгийн хүндрэлтэй байдаг асуудлыг зээлийн хугацаа, хүү хоёрыг нэрлэсэн байна.

ЖДҮ-ийг үүсгэн байгуулахад, эсвэл өргөжүүлэхэд 10-50 сая төгрөгийн санхүүжилт хэрэгтэй байдаг гэсэн хариултыг 37.3% өгсөн бол 5-10 сая төгрөг хэмээн 13.7% хариулжээ.

Зураг 11 Шаардлагатай санхүүжилт

(Санал асуулгад оролцогчдын эзлэх, давхардсан тоогоор)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Дүгнэлт

- Судалгаанд хамрагдсан Хэнтий аймгийн 51 ЖДҮ эрхлэгчид худалдааны чиглэлээр түлхүү үйл ажиллагаа эрхэлдэг.
- Түүхий эд материалаа нийслэл, өөрийн аймгаасаа голчлон бэлтгэн, аймагтаа борлуулалтаа хийдэг гэжээ.
- ААН-ийн орлогоороо бусад аймгууд, Улаанбаатар хотын дунджаас өндөр (10-50, 1-10 сая) байгаа бөгөөд дийлэнх нь тайлан тэнцэл гаргадаг юм байна.
- Бусад аймгууд, нийслэл хотын судалгааны дүнтэй адил арилжааны банкныг хамгийн их ЖДҮ эрхлэгчдийг дэмждэг гэжээ. Дэмжлэг үзүүлэгч байгууллагуудаас санхүүгийн эх үүсвэрийг бий болгосон, сургалт зөвлөгөө явуулсан, үзэсгэлэн худалдаа зохион байгуулсан байна.
- Татварын таатай орчинг бүрдүүлэх, төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох, үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх арга хэмжээг нэн түрүүнд авах шаардлагатай гэж үзжээ.
- ЖДҮ хөгжих эдийн засгийн таатай орчин хангалттай бус байна гэж дийлэнх нь дүгнэсэн байна. Бусад аймаг, нийслэлчүүдийн адил дийлэнх нь инфляци, ханш тогтвортой байх нь бизнест нь сайн гэж хариулсан байна.

- Бизнесийн орчинд ерөнхийдөө сөрөг үнэлгээг өгсөн ч аймгуудын дундажтай харьцуулахад дээгүүр үзүүлэлттэй байна. Тус аймгийнхны хамгийн их сөрөг буюу хүндрэлтэй гэсэн үнэлгээ өгсөн хэсэгт нийгмийн орчин үүнээс ажилгүйдэл, ядуурал, хээл хахууль, улс төрийн байдал, Зардлын хэсэг үүнээс зээлийн хүү, шимтгэл хураамжийн зардал орж байна. Харин мэдээлэл, холбооны хөгжил, цахилгаан хангамж, банкны зээл гэсэн үзүүлэлтүүд эерэг боломжийн гэсэн үнэлгээг авчээ.
- Өөрийн хөрөнгө, банкны зээлээр дийлэнх нь үйл ажиллагаагаа эхлүүлсэн бөгөөд үйл ажиллагаагаа өргөжүүлэх, шинээр бизнес эрхлэхэд банкны зээл авсан байна.
- Зээлээ эргэн төлөхөд зээлийн хүүний төлбөр өндөр, хугацаа богино байсан нь хамгийн их хүндрэлтэй гэжээ. Цаашид үйл ажиллагаагаа явуулахад санхүүжилт шаардлагатай гэж дийлэнх нь хариулсан ба бусад аймаг, Улаанбаатарынхаас шаардлагатай санхүүжилтийн хэмжээ нь өндөр байв.